



ХУУЛЬ САХИУЛАХЫН  
ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН  
ХОЛБОО

# ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН  
УГИРАЛ ТУТМЫН СЭТГЭҮЛ

2018 №4 (66) 16 дахь жилдээ

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

### ЭРХЛЭГЧ

**Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

### ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

**Батбуян БАТ-ЭРДЭНЭ**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Бөхчулуун Бат-Эрдэнэ**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Бадам БАТЗОРИГ**  
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Баатар БОЛДБААТАР**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Насанжаргал ГАНБАДРАЛ**  
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Жамсран ДОЛГОРСҮРЭН**  
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

**Наваанпэрэнлэй ЖАНЦАН**  
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Авирмэд ЛХАГВА**  
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Ганбат ЭРДЭНЭБАТ**  
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН  
ШАДАР ЗӨВЛӨХ

**Батзэвэг ЭНХБОЛД**  
ДОКТОР (Ph.D)

### НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

**Сэнгээ ГАНТУЛГА**  
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

### ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

**Сэнгээ ГАНТУЛГА**  
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

### ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН

**Х.БАДНААЖОНОН**

## ГАРЧИГ

### КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Гэмт хэргийн статистик зүй: онол, хэрэглээний асуудал.....Б.Мөнхдорж	3
“Хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй хэрхэн үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх вэ?” цахим судалгааны үр дүн.....Б.Алтансүх, О.Уулзахжаргал, М.Отгонбаатар	22
Тамхины гаж нөлөө ба хяналтыг сайжруулахад анхаарах асуудал.....А.Амарсайхан, Ө.Хэрлэн	30
Хорих ял ба амиа хорлолт (Ялтны сэтгэл зүйн онцлог).....С.Эрдэнэболор, Б.Досжан	38
Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгтэй тэмцэх замаар эдийн засгийн аюулгүй байдлыг хангах боломж.....Э.Өлзийжаргал	42
Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга болох нь.....Б.Оюунболд	46
Нийслэлд үйлдэгдсэн хулгайлах төрлийн гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ.....Д.Цэдэвсүрэн	50

### ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хулгайлах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал.....О.Амарсайхан	58
Хулгайлах гэмт хэрэг, түүний зүйлчлэлийн зарим асуудал.....Т.Мөнхдалай	62
Хүн барьцаалах гэмт хэргийг Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилж ирсэн байдал, харьцуулсан судалгаа.....Д.Сундуйсүрэн	66
Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээх хуулийн этгээд, түүний төлөөллийн асуудал.....Б.Одонгэрэл	76
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт.....Б.Баярмаа	80

### ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Цагдаагийн хэсгийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтын загвар.....Б.Баянмөнх	84
Цагдаагийн алба хаагчаас галт зэвсэг хэрэглэх эрх зүйн зохицуулалт, анхаарах зарим асуудал.....Ш.Чулуун	94

### ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Монгол Улсын Үндсэн хууль дахь зөвшилцөх тухай зохицуулалтыг бусад хуульд хэрхэн хэрэглэсэн талаар.....Б.Түвшинтөгс	97
Төр, сүм хийдийн харилцааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.....О.Хишигмөнх	103

# КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК ЗҮЙ: ОНОЛ, ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛ

Б.Мөнхдорж

*Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн  
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), цагдаагийн хошууч*

### I. УДИРТГАЛ

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй, үр ашигтай зохион байгуулахын тулд үйлдэгдсэн гэмт хэрэг бүрийг шинжлэх ухааны арга зүйгээр зөв бүртгэж, бодитой хэмжих, шалтгаан, нөхцөлийг нарийн тогтооход статистикийн шинжлэх ухаан чухал үүрэгтэй.

Гэмт хэргийн статистик зүйн үзэл баримтлал, арга зүй, түүний хэрэглээ, тогтолцоо, эрх зүйн зохицуулалт зэргийг судалж, тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх үндэслэл, шаардлагыг дор дурьдсан хүчин зүйлсээр тайлбарлагдана. Үүнд:

- Аливаа улс, салбарын хөгжлийг хэмжих шалгуур үзүүлэлт бол статистикийн судалгаа, мэдээллийн үнэн бодит байдал юм.

- Төрийн эрүүгийн бодлого, гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэмжих үзүүлэлтийн нэг нь гэмт хэргийн статистикийн үзүүлэлт мөн.

- Одоогоор гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг эрхлэх оновчтой тогтолцоо бүрдээгүй, арга зүй уялдаагүй, нэгдсэн аргачлал байхгүй.

- Гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх, статистикийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин ч учир дутагдалтай байна.

- Монгол Улсын хөгжлийн зарим бодлогыг тодорхойлох, түүний хэрэгжилтийг хэмжих, олон улсын түвшинд улсын хөгжил, аюулгүй байдлын түвшинг харьцуулахад гэмт хэргийн статистикийн үзүүлэлтийг хэрэглэгдэж байна.

- Монгол Улсын гэмт хэргийн статистикийн үзүүлэлт олон улсын хэмжээнд бүрэн харьцуулагдахгүй байна.

Судлагдсан байдлыг авч үзвэл, гадаад улсын эрдэмтэн, судлаачдаас Карр-Хилл<sup>1</sup>, Дегрүт Моррис<sup>2</sup>, Вито Женнаро<sup>3</sup>, Бехмэн Ронет<sup>4</sup>, Волкер Жеффри<sup>5</sup>, Дэвид Вэйсборд<sup>6</sup> нар гэмт хэргийг судлахад статистикийн арга зүйг ашиглах асуудлыг тусгасан бүтээл туурвижээ. ОХУ-ын эрдэмтэн Ю.Д.Блувштейн<sup>7</sup>, АНУ-ын Дэвид Гринбэрг<sup>8</sup> нарын эрдэмтэн криминологийн шинжлэх ухаанд математик, магадлалын онол, статистикийн арга зүйг хэрэглэх талаар эрдэм шинжилгээний бүтээл туурвиж, эрдмийн зэрэг хамгаалсан байдаг.

ОХУ-ын хувьд гэмт хэргийн статистикийн онол, арга зүйг боловсруулж, хууль зүйн салбарын практикт нэвтрүүлсэн эрдэмтдийн төлөөлөл бол акад. А.Н.Радищев, К.Герман нар юм<sup>9</sup>. А.Н.Радищевын хувьд гэмт хэргийн статистикийн үүрэг, ач холбогдлыг тодорхойлж, түүний үр дүнг хууль тогтоох болон хууль санаачлах ажиллагаанд ашиглах арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулжээ. Мөн эрдэмтэн К.Герман энэ чиглэлд анхны цогц судалгаа хийсэн байна. Эдгээр эрдэмтэд статистикийг гол төлөв ёс зүйн онол, арга зүйд тулгуурлан судалж, гэмт хэргийн статистикийг салбарын шинжлэх ухааны түвшинд хөгжүүлэх, үр дүнг практикт нэвтрүүлэхээр санал, дүгнэлт дэвшүүлж байсан.

<sup>1</sup> R.A.Carr-Hill. Crime, The police and criminal statistics. 1979.

<sup>2</sup> DeGroot, Morris H. Statistics and the law. 1986.

<sup>3</sup> Vito, Gennaro F. Statistical analysis in criminal justice and criminology. 2002.

<sup>4</sup> Bachman, Ronet. Statistics for criminology and criminal justice. 2004.

<sup>5</sup> Walker, Jeffery T. Statistics in criminology and criminal justice. 2005.

<sup>6</sup> David Weisburd. Statistics in Criminal Justice. 2007.

<sup>7</sup> Ю.Д.Блувштейн. Методологическая проблеммы изучения преступности и личности преступника (логико-математический аспект). Диссертация на соискание ученой степени доктора юридических наук. М., 1974.

<sup>8</sup> David F. Greenberg. Mathematical Criminology. New Jersey. USA., 1979.

<sup>9</sup> Тарновский Е.Н. Влияние хлебных цен и урожая на движение преступлений против собственности в России. Журнал министерства юстиции. 1898. №8. С.102.

Монгол Улсын хувьд судлаач Я.Баатар, Д.Тархаашин нар “Гэмт хэрэг судлах статистик арга зүй” гарын авлага, доктор (Sc.D) С.Жанцан, судлаач П.Ихзаяа, Б.Мөнхдорж нар “Гэмт хэргийн статистик” нэг сэдэвт бүтээл эрхлэн гаргасан ба эдгээр бүтээлд гэмт явдал, гэмт хэрэг, статистикийн уялдаа холбоо, статистикийн арга зүйг гэмт явдлыг судлахад хэрэглэх талаар дурьдсан байдаг. Доктор (Ph.D) Ч.Нямсүрэн гэмт хэргийн виктимологид статистикийн арга зүйг ашиглах, гэмт хэргийн хохирлын талаархи тоо бүртгэлийг авч үзжээ<sup>10</sup>.

Акад. С.Нарангэрэл<sup>11</sup>, доктор (Sc.D) Ж.Авхиа<sup>12</sup>, Г.Совд<sup>13</sup>, С.Жанцан<sup>14</sup>, Ж.Долгорсүрэн<sup>15</sup>, Ж.Болдбаатар<sup>16</sup>, доктор (Ph.D) Н.Жанцан<sup>17</sup>, Н.Баатаржав<sup>18</sup>, Б.Пүрэв<sup>19</sup>, А.Лхагва<sup>20</sup>, Л.Батжав<sup>21</sup>, Б.Болдбаатар<sup>22</sup>, Ц.Цэлмэг<sup>23</sup>, Б.Батзориг<sup>24</sup>, Ч.Нямсүрэн<sup>25</sup>, Б.Энхболд<sup>26</sup> нарын эрдэмтэн, судлаач эрдэм шинжилгээний бүтээлдээ хууль зүй, криминологид математик, статистикийн арга зүйг хэрэглэх талаар дурьджээ.

Математик, статистикийн шинжлэх ухааны онол, арга зүйн чиглэлээр Л.Дуламсүрэн<sup>27</sup>, П.Жасрай<sup>28</sup>, Ч.Авдай<sup>29</sup>, Я.Базарсад<sup>30</sup>, Р.Энхбат<sup>31</sup>, Г.Элдэв-Очир<sup>32</sup>, Ц.Батсүх, Л.Эрдэнэсүвд<sup>33</sup>, Р.Оюунбилэг<sup>34</sup>, нийгмийн шинжлэх ухаанд математикийн онол, арга зүйг ашиглах чиглэлээр С.Төмөр-Очир<sup>35</sup> нарын эрдэмтэн, судлаач эрдэм шинжилгээний бүтээл эрхлэн гаргаснаас гадна статистикийн төв байгууллага, салбарын их, дээд сургуулиас эрдэм шинжилгээний бүтээл, ном, эмхэтгэл гаргасан байна.

Харин гэмт хэргийн статистик зүйн үзэл баримтлал, онол, арга зүйг судалсан, өнөөгийн байдал, тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, арга зүйн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн, гэмт хэргийн статистик зүйн мэдлэгийн дэд салбарыг хөгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулсан эрдэм шинжилгээний бүтээл, суурь судалгааны ажил манай улсад өнөөг хүртэл хийгдээгүй байв.

Энэхүү судалгааны зорилго нь Үндсэн хуулийн хэрэгжилтийг хэмжих үзүүлэлтийн нэг болох гэмт хэргийн статистикийн тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд оршиж байв.

Тодруулбал, хууль зүй, криминологи, виктимологи, статистикийн шинжлэх ухааны уялдаа шүтэлцээнд хууль зүй, гэмт хэргийн статистикийг ангилан авч үзэж, гэмт хэргийн статистикийг онолын түвшинд тодорхойлж, түүний тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, арга зүй, хэрэглээг боловсронгуй болгох үндэслэл бүхий дүгнэлт, санал боловсруулж, дэвшүүлэхэд оршиж байгаа юм.

<sup>10</sup> Ч.Нямсүрэн, Гэмт хэргийн виктимологи. Уб., 2005.

<sup>11</sup> С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Уб., 2008.

<sup>12</sup> Ж.Авхиа. Гэмт явдал, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал. Уб., 1997, Ж.Авхиа, Г.Совд, Б.Даваасамбуу, Б.Ястребов, Л.Ринчин, Н.Баатаржав. Криминологи. Уб., 1975.

<sup>13</sup> Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. Уб., 1973, Криминологи. Уб., 1975.

<sup>14</sup> С.Жанцан. Гэмт явдал судлал. Уб., 1995, Гэмт хэргийн статистик. Уб., 2007, Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, шинэчлэлийн асуудал. Уб., 2007.

<sup>15</sup> Ж.Долгорсүрэн. Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. Уб., 2014.

<sup>16</sup> Ж.Болдбаатар, О.Нямдаваа. Криминологи. Уб., 2010.

<sup>17</sup> Н.Жанцан нар, Криминологи. Уб., 1986, Криминологи. Уб., 2004.

<sup>18</sup> Н.Баатаржав. Криминологи. Уб., 2001.

<sup>19</sup> Б.Пүрэв. Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх Цагдаагийн байгууллага. Уб., 2016.

<sup>20</sup> А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. Уб., 2009.

<sup>21</sup> Л.Батжав, Гэмт явдал, түүний шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал. Уб., 2002, Криминологийн зарим асуудал. Уб., 2003.

<sup>22</sup> Б.Болдбаатар. Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдлын шалтгаан судлалын асуудалд. Уб., 2004.

<sup>23</sup> Ц.Цэлмэг. Криминологи. Уб., 2005.

<sup>24</sup> Б.Батзориг. Криминологийн прогноз, төлөвлөлт. Уб., 1998, Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах аргачлал. Уб., 1999, Насанд хүрээгүй хүмүүсийн дунд криминологийн судалгаа явуулах аргачлал. Уб., 2004.

<sup>25</sup> Ч.Нямсүрэн, Гэмт хэргийн виктимологи. Уб., 2005.

<sup>26</sup> Б.Энхболд, Хотжилт ба гэмт хэрэг. Уб., 2011.

<sup>27</sup> Л.Дуламсүрэн. Статистикийн онол. Уб., 1980.

<sup>28</sup> П.Жасрай. Эдийн засгийн мэдээлэл, шинжилгээ. Уб., 2004.

<sup>29</sup> Ч.Авдай, Д.Энхтуяа, Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй. Уб., 2015.

<sup>30</sup> Я.Базарсад, Р.Энхбат. Магадлалын онол, математик статистикийн гарын авлага. Уб., 2002.

<sup>31</sup> Мөн бүтээл

<sup>32</sup> Ц.Цэрэндорж, Г.Элдэв-Очир, С.Хандсүрэн, Ч.Даваасүрэн, Г.Цагаан. Статистикийн онол. Уб., 2005.

<sup>33</sup> Л.Эрдэнэсүвд. Бизнесийн статистик. Уб., 2001, 2004, 2010.

<sup>34</sup> Р.Оюунбилэг. Математик статистик. Уб., 2009.

<sup>35</sup> С.Төмөр-Очир. Нийгмийн судалгаа, шинжилгээнд математик арга хэрэглэх онол, арга зүйн асуудал. Уб., 2012.

## II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ диалектикийн танин мэдэхүйн түгээмэл арга: ажиглалт, харьцуулалт, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, баримт бичигт дүн шинжилгээ хийх, системийн шинжилгээ, санал асуулга, математик-статистикийн аргыг өргөн хэрэглэсэн. Түүнчлэн, хууль зүй, криминологи, статистикийн шинжлэх ухаан болон гэмт хэргийн статистикийн тухай эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны үр дүн, эрх зүйн актад дүн шинжилгээ хийх зэрэг тусгай арга ашигласан болно.

Монгол Улс дахь статистик, түүний дотор гэмт хэргийн статистикийн түүхэн уламжлал, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын гэмт хэргийн тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлж, статистикийн үйл ажиллагаа явуулж ирсэн байдалд дүн шинжилгээ хийсэн.

Эрдэмтэн, судлаачдын гэмт хэргийн статистиктай холбоотой бүтээл, диссертаци, судалгааны тайлан зэргийг эх сурвалж болгон ашиглалаа. Судалгааны ажилтай холбогдуулан ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ, АНУ, Норвеги, Япон зэрэг улсын гэмт хэргийн статистикийн холбогдох эх сурвалжийг харьцуулан судлав.

Гэмт хэргийн статистикийн мэдээлэл ашигладаг эрдэмтэн, судлаач, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын гэмт хэргийн тоо бүртгэл, статистикийн мэдээлэл хариуцсан ажилтнуудаас социологийн судалгаа авч, SPSS программаар үр дүнг боловсруулж, тусгалаа.

## III. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

### 3.1. Онол, арга зүйн хэсэг

Германы эрдэмтэн Г.Ахенваль “статус” гэх латин үгнээс гаралтай “статистик”-ийг 1746 онд анх удаа “Хүн ам, эдийн засгийн хүчин зүйлс судлал” гэсэн үгний утгаар илтгэл, өгүүлэл бичиж, хичээл сургалтаар зааж<sup>36</sup> шинжлэх ухааны эргэлтэд оруулжээ.

“Статистик” хэмээх нэр томъёо нь “status” гэсэн латин үгээс гаралтай юмс үзэгдлийн төлөв байдал гэсэн утгатай. Орос хэлнээс “статистик” гэдгийг нь “тоо бүртгэгч, статистикч”, “статистика” гэдэг нь “тоо бүртгэлийн шинжлэх ухаан, статистик, тоо бүртгэл” гэж монгол хэлээр орчуулжээ.

Нийгэм, эдийн засгийн үзэгдэл, процессын тоо мэдээллийг шинжлэх ухааны үндэстэйгээр цуглуулж, боловсруулан шинжилгээ хийж, түүний зүй тогтол, харилцан хамаарлыг тооны аргаар нээж үнэлэлт, дүгнэлт гаргадаг шинжлэх ухааныг статистик<sup>37</sup> гэж эрдэмтэн, судлаачид тодорхойлсон байдаг.

Өнөө үед нийгэм, эдийн засгийн үзэгдлийн тоо мэдээллийг цуглуулах, эмхлэн цэгцэлж боловсруулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга зүйн суурь шинжлэх ухааныг статистик хэмээх ойлголт түгээмэл болж байна.

Статистикийг хэрэглээ талаас нь өгөгдлүүдийг зохион байгуулж, цэгцтэй хэлбэрт үзүүлж, шинжилгээ хийдэг шинжлэх ухааныг хэлнэ гэж өөр байдлаар тодорхойлжээ<sup>38</sup>.

Олон улсын хэмжээнд “статистик нь нийгэм, эдийн засгийн тоон мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлбарлах, танилцуулахтай холбоотой шинжлэх ухаан” хэмээн ойлгож, хөгжүүлдэг.

“Статистик нь нийгэм, эдийн засгийн юмс үзэгдлийн тоон илрэлийг чанартай нь холбон тэдгээрийн хөгжлийн зүй тогтлыг тодорхой орон зай, цаг хугацаанд судалдаг шинжлэх ухаан юм” гэснийг дэмжиж байна.

Зарим статистикийн судлаач “статистик бол үр ашигтай шийдвэр гаргахад шаардлагатай тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэх, дүн шинжилгээ хийх, тайлбарлах, танилцуулах арга зүйн тухай шинжлэх ухаан” гэж тодорхойлж буйтай санал нийлж байна.

Статистикийн шинжлэх ухаан нь бүтцийн хувьд нэгдүгээрт: статистикийн ерөнхий онол, хоёрдугаарт: эдийн засгийн статистик, гуравдугаарт: нийгмийн статистик болон салбарын статистик гэж хуваагдана.

Нийгмийн статистик болон салбарын статистикт тээвэр, холбоо, хүн ам, соёл, боловсрол, эрүүл мэнд, шүүх, гэмт хэргийн статистик зэрэг ордог.

<sup>36</sup> [https://en.wikipedia.org/wiki/Gottfried\\_Achenwall](https://en.wikipedia.org/wiki/Gottfried_Achenwall). 2018.05.09. (Gottfried Achenwall (20 October 1719 – 1 May 1772) was a German philosopher, ARA historian, economist, jurist and statistician. He is counted among the inventors of statistics. “Statistic, status” гэсэн нэршлийг шинжлэх ухаанд оруулсан түүхтэй)

<sup>37</sup> Л.Эрдэнэсүвд. Бизнесийн статистик. УБ., 2004. 9 дэх тал

<sup>38</sup> Д.Чимгээ. SPSS нийгмийн статистикийн шинжилгээ хийх, үр дүнг тайлбарлах нь. УБ., 2014. 8 дахь тал

Бидний анхааран судалж буй гэмт хэргийн статистик нь салбарын статистикт хамаарах бөгөөд тодруулбал нийгмийн статистик, хууль зүйн статистикт хамаарах юм.

### Хууль зүйн статистикийн ангилал

Гадаад орны, ялангуяа ОХУ-ын туршлагаас үзэхэд хууль зүйн статистикийг нэгдүгээрт: эрүүгийн эрх зүйн статистик, хоёрдугаарт: иргэний эрх зүйн статистик, гуравдугаарт: захиргааны эрх зүйн статистик гэж ангилж иржээ.

Зураг 1. Хууль зүйн статистикийн ангилал



Гэмт хэргийн статистик нь хууль зүйн статистикийн нэг төрөл юм.

Хууль зүйн статистикийг ОХУ-д ёс зүйн статистик, эрх зүйн статистик, Англи улсад шүүхийн статистик, Америкт гэмт хэргийн статистик, эрүүгийн хариуцлагын статистик, түүний дотор цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэрийн статистик гэх байдлаар ангилан авч үзэж байна.

Харин Монгол Улсын хувьд эрүүгийн тоо бүртгэл, гэмт хэргийн тоо бүртгэл, шүүхийн статистик, эрүүгийн хэргийн статистик, гэмт хэргийн статистик гэх мэтээр нэрлэж иржээ. Өнөөгийн практик, туршлагаас үзэхэд байгууллагаар нь цагдаагийн статистик, авлигатай тэмцэх байгууллагын статистик, прокурорын статистик, шүүхийн статистик, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик, шүүхийн шинжилгээний статистик гэх мэтчилэн ангилж байна.

Нийгмийн статистикийн нэг төрөл болох хууль зүйн статистикийг эрүүгийн эрх зүйн, захиргааны эрх зүйн, иргэний эрх зүйн статистик гэж ангилж, хууль зүйн статистик нь нөгөө талаас хууль зүйн шинжлэх ухааны нэг төрөл судлагдахуун гэж үзэж болно.

Эрүүгийн эрх зүйн статистикийн нэг хэсэг нь гэмт хэргийн статистик юм. Иймд “шүүхийн статистик” гэсэн бүлгийг “хууль зүйн статистик” гэж онолын үндсэн дээр өөрчлөн, хууль зүйн статистикийн ангилал, төрлийг шинэчлэх шаардлага байна гэж үзсэн.

Иймээс Монгол Улсад хууль зүйн статистикийг илүү өргөн хүрээнд судлан үзэх шаардлага улам бүр нэмэгдэж байгаа ба эрүүгийн эрх зүйн статистикт хамаарах гэмт хэргийн статистикийг нарийвчлан судлах шаардлага байв.

### Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал

НҮБ-ын ГХМБТГ-аас гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангиллын нэгдүгээр хувилбарыг 2015 оны 3 сард боловсруулан гаргасан. НҮБ-ын Нийгмийн комиссоос анх 1951 онд гэмт үйлдлийг ангилахын ач холбогдлыг цохон тэмдэглэсэн хэдий ч улс орон бүрийн хууль тогтоомж, статистикийн мэдээллийг тайлагнах системийн харилцан адилгүй байдлаас болж зогссон.

Эдгээр асуудлыг даван туулах, гэмт хэргийн ангиллыг хууль тогтоомжид гэхээсээ зан авирын дүрслэл түшсэн үндэс суурийг буй болгох ажлыг НҮБ-ын ГХМБТГ болон ЕЭЗК-ын хамтарсан ажлын хэсэг хамтран гүйцэтгэсэн. Ажлын хэсэг гэмт хэргийн олон улсын ангиллын анхны төслийг 2012 онд боловсруулж, Европын статистикчдын 60 дугаар нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

ГХСОУА гэж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт, тодорхойлолт, зарчимд суурилсан, гэмт хэргийн статистикийн олон улсын харьцуулалт, уялдаа холбоог сайжруулах, олон улсын болон үндэсний хэмжээнд дүн шинжилгээ хийх чадавхийг сайжруулах зорилгоор гэмт хэргийг ангилсан байдлыг ойлгодог<sup>39</sup>.

ГХСОУА-ын зорилго нь хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн өөр өөр байгууллагын статистикийн мэдээллийг системтэй бэлтгэх, харьцуулах үндэс суурийг бий болгоход чиглэгддэг.

"Монгол Улсын Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"<sup>40</sup>-ийн 2.6.1.11-д "гэмт хэргийн олон улсын ангиллыг үндэсний онцлогт тохируулан боловсруулж, мөрдүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах шаардлага байна.

### **Гэмт хэргийн статистикийн тодорхойлолт, судлах зүйл, арга зүй:**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хуульд гэмт хэргийн статистик гэсэн ойлголтыг хуульчлаагүй байв.

Гадаад улсын туршлагаас үзэхэд, "crime statistics", "mathematics, statistics and the law", "criminal justice statistics", "crime and mathematics", "quantitative criminology", "statistics for criminology and criminal justice", "правовая статистика", "юридическая статистика", "уголовная статистика", "судебная статистика" гэх зэрэг нэр томъёоны хүрээнд криминологийн шинжлэх ухаанд математик, статистикийн арга зүйг хэрэглэх, мөн ёс суртахуун, эрүүгийн эрх зүй, эрх зүй, хууль зүйн статистик, гэмт хэргийн статистик, шүүхийн статистик зэрэг ойлголтын хүрээнд судлагдаж байна.

Монгол Улсын хувьд 1988 онд судлаач Я.Баатар, Д.Тархаашин нарын "Гэмт хэрэг судлах статистик арга зүй" гарын авлага, 2007 онд доктор (Sc.D) С.Жанцан, судлаач П.Ихзаяа, Б.Мөнхдорж нарын "Гэмт хэргийн статистик" нэг сэдэвт бүтээлд "Гэмт хэргийн статистик бол шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулсан иж бүрэн программаар, гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой тоон мэдээллийг цуглуулан боловсруулж, дүн шинжилгээ хийх буюу өөрөөр хэлбэл тооны талыг чанартай нь нягт холбон тодорхой орон зай, цаг хугацаагаар нь судалдаг салбарын статистикийн нэг"<sup>41</sup> гэж тодорхойлж бичжээ.

Судлаач Я.Баатар, Д.Тархаашин нар "Гэмт хэргийн статистикийн арга гэж шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулсан иж бүрэн хөтөлбөрөөр гэмт хэрэгтэй холбоотой мэдээ цуглуулж, боловсруулан, дүн шинжилгээ хийх буюу өөрөөр хэлбэл гэмт хэргийн тооны талыг чанартай нь нягт холбон тодорхой орон зай цаг хугацаанд судалдаг салбарын статистикийн нэг"<sup>42</sup> гэж тодорхойлжээ.

Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь"-д "тооны бүртгэл" гэдгийг "бүртгэл, тооцоо, тооллого, малын тоо бүртгэл, хүн амын бүртгэл", "тоо бүртгэлийн судлал" гэдгийг "нийгмийн хөгжил, ардын аж ахуй дахь тооны хуваарилалтыг судлах ухаан", "тоо бүртгэгч" гэдэг нь "тоо бүртгэл эрхэлсэн хүн", "зүй" гэдэг нь "...ямар нэгэн сургаал, онол, арга зүй" гэж тус тус тайлбарлажээ.

Мөн "зүй" гэдэг үгийг "ямар нэгэн сургаал, онол" хэмээн ижил тайлбарлажээ<sup>43</sup>.

Эрүүгийн хуулийн<sup>44</sup> 2.1 дүгээр зүйлд гэмт хэргийн ойлголт, шинжийг тодорхойлсон бөгөөд мөн зүйлийн 1 дэх хэсэгт "Энэ хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно", мөн 2 дах хэсэгт "Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хохирол, хор уршиг учирсныг гэмт хэрэгт тооцно" хэмээн хуульчилсан.

Иймд гэмт хэргийн статистикийг онолын түвшинд судалж, хууль зүй, статистикийн шинжлэх ухааны мэдлэгийн дэд салбарын нэршлийг "гэмт хэргийн статистик зүй" гэж томъёолж болохоор байна.

Гэмт хэргийн статистик зүйг онолын түвшинд дараах байдлаар тодорхойлох нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

<sup>39</sup> Ш.Ариунболд, Б.Мөнхдорж. "Монгол Улсын гэмт хэргийн статистикийн үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэх асуудал" судалгааны тайлан. УБ., 2018

<sup>40</sup> УИХ-ын 2017 оны 38 дугаар тогтоолоор баталсан. "Төрийн мэдээлэл" эмхэтгэл. 2017. №26

<sup>41</sup> С.Жанцан, П.Ихзаяа, Б.Мөнхдорж. Гэмт хэргийн статистик. УБ., 2007. 13 дахь тал

<sup>42</sup> Я.Баатар, Д.Тархаашин. Гэмт хэрэг судлах статистикийн арга зүй. УБ., 1988. 4 дэх тал

<sup>43</sup> Н.Даш, А.Янжиндолгор, Монгол хэлний тайлбар толь (А-Р). 630 дахь тал

<sup>44</sup> "Төрийн мэдээлэл" эмхэтгэл. 2016. №07



- **“Гэмт хэргийн статистик зүй”** гэж хууль зүй, криминологи, виктимологи, статистикийн шинжлэх ухаанд тулгуурлан гэмт хэргийн талаархи мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийж, үр дүнг тархаах, ашиглах замаар гэмт хэргийн тоон мэдээллийг шалтгаан нөхцөл, шинж чанартай нь уялдуулан тодорхой орон зай, цаг хугацаанд судалдаг хууль зүй, статистикийн шинжлэх ухааны мэдлэгийн дэд салбар мөн.

Хууль зүй, эрүүгийн эрх зүй, гэмт хэргийн статистик нь дэлхий нийтэд үүсэн бий болсон цагаас онол, арга зүй, үзэл баримтлал, ялангуяа практик хэрэглээ нь хөгжсөөр ирсэн хэдий ч монголын хууль зүйн салбарт хуучин биш зүйл бөгөөд судлаачдын анхаарлын төвд байгаа билээ. Учир нь Монгол Улсад гэмт хэргийн статистик зүйн практикт тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны талаас шийдвэрлэх үүрэг, орон зай үгүйлэгдэж байгаа нь ажиглагдсан.

Гэмт хэргийн статистик зүй хэмээх мэдлэгийн дэд салбарыг практикт хэрэгжүүлэх цогц үйл ажиллагааны нэршлийг бид тодорхойлох шаардлагатай гэж үзэж, дараах тодорхойлолтыг санал болгож байна.

- **“Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаа”** гэж гэмт хэргийн талаархи бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийж, мэдээлэл, судалгааны үр дүнг хэрэглэгчдэд тархаах, хэвлэн нийтлэх, ашиглах, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, хадгалах бие даасан үйлдлүүдийн цогц юм.

Гэмт хэргийн статистик зүйг гэмт хэргийн талаархи мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тархаах, үр дүнг ашиглах гэсэн процессийн 5 үе шатад хуваан үйл ажиллагаагаар нь ангилах нь зүйтэй гэж, доорх загварыг судалгааны эргэлтэд оруулах санал болгож байна.

Зураг 2. Гэмт хэргийн статистик зүйн процессийн 5 үе шатны “Crime stats process” загвар



\* Эх сурвалж: Судалгааны үр дүнд үндэслэн Б.Мөнхдоржийн боловсруулсан загвар.

*Мэдээлэл цуглуулах шатанд:*

- Статистик ажиглалт, социологийн аргаар мэдээлэл цуглуулах;
- Тоо бүртгэл хөтлөх;
- Мэдээллийн сан бүрдүүлэх;

*Боловсруулалт хийх шатанд:*

- Цуглуулсан тоон мэдээллийг статистикийн аргыг ашиглан боловсруулах;
- Мэдээллийг тусгай программаар боловсруулах;
- Статистикийн мэдээлэл, судалгаа гаргах;

*Дүн шинжилгээ хийх шатанд:*

- Боловсруулсан тоон мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийх;
- Хэрэглэгчийн шаардлагад нийцсэн хэлбэрээр үр дүнг нэгтгэн, шинжилгээ хийх;
- Тайлан, танилцуулга бэлтгэн гаргах;

*Тархах шатанд:*

- Боловсруулсан, дүн шинжилгээ хийсэн статистикийн мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээний үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, хүргүүлэх;
- Нийтэд аливаа хэлбэрээр тархаах;

*Үр дүнг ашиглах шатанд:*

- Үр дүнг байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглах;
- Үр дүнг бодлого, үйл ажиллагаанд ашиглах;
- Академик зориулалтаар үр дүнг ашиглах зэргийг голчлон дурьдаж болно.

Гэмт хэргийн статистик зүйд гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн сангаас статистик мэдээллийг боловсруулан гаргах, үр дүнг тархаах, түүнд дүн шинжилгээг практиктай уялдуулан үр дүнтэй хийж, үр дүн бодлого, үйл ажиллагаандаа ашиглах үе шатыг хамааруулбал зохино.

Гэмт хэргийн албан ёсны статистик олон улсын хандлага, туршлагаас үзэхэд гэмт хэргийн талаархи захиргааны статистикийн тоон мэдээлэл болон чанарын судалгааг хамруулдаг байна.

Зураг 3. Гэмт хэргийн албан ёсны статистикийн агуулга



Тухайлбал, захиргааны статистикийн тоон мэдээлэлд практик байгууллагын гаргаж буй статистикийн тоон мэдээлэл, судалгаа, харин чанарын судалгаанд гэмт хэргийн бодит түвшин, шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилгоор явуулсан социологи, түүвэр зэрэг санал асуулга, анкет, баримт бичгийн зэрэг чанарын судалгааг оруулдаг, жишээ нь гэмт хэрэгт хохирох явдлын судалгааг оруулбал зохино.

Түүнчлэн, гэмт хэргийн статистик зүйг хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны удирдлага, төлөвлөлт, бодлого боловсруулалтын эх үүсвэр болохоос гадна үндэсний болон олон улсын байгууллагаас нийгмийн хөгжлийн түвшинг үнэлэх, хянах, бусад улс оронтой харьцуулахад чухал ач холбогдолтой салбарын статистик гэж ойлгож болно.

Хууль зүй, криминологи, виктимологи, статистикийн шинжлэх ухааны судлах зүйл, судалгааны арга зүйд тулгуурлан гэмт хэргийн статистик зүйн судлах зүйл, арга зүйг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Гэмт хэргийн статистик зүйн судлах зүйл гэж гэмт хэргийн гаралт, түвшин, тархалт, бүтэц, хөдөлгөөн, хандлага, шалтгаан, нөхцөл, гэмт хэрэгтэн хувь хүн, гэмт хэрэгт өртсөн хохирогч иргэн, байгууллагад учирсан хохирол, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулах бодлого, үйл ажиллагаа мөн.

- Гэмт хэргийн статистикийн зүйн арга зүй гэдэг гэмт хэргийн бүтэц, динамик болон хамаарлын зүй тогтлыг судлахад чиглэгдсэн арга, аргачлалын тогтолцоо мөн.

Түүхэн уламжлал талаас авч үзвэл, Монгол Улсын хувьд гэмт хэрэгтэй тэмцэх хууль цаазтай байж, гэмт хэрэг үйлдсэн этгээлийг ял шийтгэл хүлээлгэн, хариуцлага тооцдог байсан бөгөөд 1921 онд Ардын Засгийн үйл ажиллагаагаа идэвхжиж, 1926 онд Шүүх цаазын бичиг гарч хэрэгжих үеэс шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо бүртгэл хөтөлж, статистикийн мэдээлэл гаргаж байсан нь гэмт хэргийн статистик урт удаан хугацааны түүхэн уламжлалтай болохыг гэрчилж байна. Түүнээс хойш 1960 он хүртэл эрүүгийн хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдан гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн, бүтэц, хандлагад тухайн үеийн нийгэм, улс төр, эдийн засаг, улс орны бодлогоос хамааран хувьсан өөрчлөгдөж ирсэн байдаг ба гэмт хэргийн тоо бүртгэл хөтөлгөж, шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг, хорих ялаар шийтгүүлсэн ялтны тоо, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ зэрэг статистикийн үзүүлэлт гаргадаг байсан талаар эрдэмтдийн бүтээлд дурьдагджээ.

1960-аад оноос ОХУ-ын криминологийн шинжлэх ухааны хөгжил манай улсад түлхүү нэвтэрч, энэ нөлөөгөөр 1966 оноос гэмт хэрэгтэй тэмцэх, ялангуяа тоо бүртгэл, судалгаа, шинжлэх ухааны үндэслэлтэй гүн гүнзгий тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого төр засгаас хэрэгжүүлж эхэлсэнээр 1966 онд эрүүгийн гэмт хэргийн тоо бүртгэлийн тасгийг анх байгуулж, 1967 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс албан ёсоор тоо бүртгэл хуулийн байгууллагад хөтлөгдөж эхэлсэнээр гэмт хэргийн статистикийн тогтолцоо бүрдэх эхлэл тавигдсан байна.

Түүхийн хугацаанд гэмт хэргийн тоо бүртгэлийг боловсронгуй болгох статистикийн төв газар, байгууллагын нөлөө, үүрэг оролцоо асар их байсан байна. 1975 оноос гэмт хэргийн тоо бүртгэл цагдаагийн байгууллагад түлхүү явагдаж, прокурор, шүүх үйл ажиллагааны үр дүнг илэрхийлсэн үзүүлэлт гарган ашиглах байдлаар явж иржээ.

Криминологи, виктимологи, математик, статистикийн шинжлэх ухааны арга зүйн уялдаан дээр гэмт хэргийн статистикийн судалгааны арга зүй, аргачлал бий болж, ашиглагддаг. Нөгөө талаас социологийн шинжлэх ухааны тоон болон чанарын судалгааны арга зүй гэмт хэргийн статистикийн арга зүйн үндсийг бүрдүүлдэг.

Гэмт хэргийн статистикийн арга зүйг олон улсын хэмжээнд, үндэсний хэмжээнд, практик байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй арга зүй, академик хэрэглээн дэх арга зүй хэмжээн ангилан авч үзэх шаардлага байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн статистикийн арга зүй практик дээр тодорхой хэмжээнд хэрэгжиж байна гэж дүгнэж байна. Гэхдээ сайжруулах, хэрэглээг илүү нэмэгдүүлэх шаардлага байгаа нь судалгааны явцад тогтоогдож байв.

Цагдаа, авлигатай тэмцэх, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд өөр өөрийн хэрэгжүүлж буй чиг үүргийн онцлогоос хамааран үйл ажиллагааны үр дүнг илэрхийлсэн статистикийн мэдээллүүдийг эрхлэн гаргаж байна. Ингэж гаргахад өөр өөрийн онцлогт нийцсэн арга зүй, арга барил, үзүүлэлтээр статистик мэдээлэл эрхлэн гаргаж байна. Эдгээр байгууллагын мэдээллийг ҮСХ-нд улсын хэмжээнд нэгтгэн гаргадаг. Ингэж гаргахад боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарт мөрдөгддөг нэгэн адилаар нэгдсэн аргачлал манай хууль зүйн салбар, гэмт хэргийн статистикийн үзүүлэлт тооцох аргачлал одоогоор байхгүй байв. ҮСХ-ноос 2018 онд "Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал"-ыг батлав.

Мөн улс орны аюулгүй байдлыг илэрхийлэх үзүүлэлт болох эрүүгийн нөхцөл байдлыг илэрхийлсэн гэмт хэргийн статистик юм. Гэмт хэргийн статистикийн мэдээллийг олон улсын түвшинд харьцуулахад Монгол Улсаас хамаарах үзүүлэлтийг гаргаж өгөх хүндрэл учирч байна. Учир нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн зүйл, хэсэгт заасан гэмт хэрэг нь олон улсын ангиллын аль кодод заасан гэмт хэрэгт хамааруулах асуудлыг хуулийн болон статистикийн байгууллагууд хамтран хийж, тодорхой шийдвэр гаргаж, нэг мөр болгох шаардлагатай байна.

Тогтвортой хөгжлийн зорилтод тусгагдсан, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудаас хамааран гарах шаардлагатай статистикийн мэдээллийг гаргах мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлж, аргачлал, арга зүйг бий болгох нь зүйтэй.

## **3.2. Тулгамдсан асуудлыг тодорхойлсон судалгааны үр дүн**

Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох мэргэжлийн хүмүүсээс социологийн судалгаа, салбарын эрдэмтэн, судлаачдаас хэрэглэгчийн үнэлгээний судалгаа авч, мөн энэ чиглэлийн хүний нөөцийн байдлыг тодорхойлох судалгааг хийж, гэмт хэргийн статистикийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийн тулгамдсан асуудлыг нээн илрүүлж, шийдвэрлэх зарим арга замыг томъёолох, гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох, хөгжүүлэх асуудлыг хөндөв.

### **3.2.1. Социологийн судалгааны үр дүн:**

Цагдаагийн байгууллага, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, тагнуул, шүүх шинжилгээ, прокурорын байгууллага, шүүх дэх гэмт хэргийн статистик хариуцсан болон ажил үүргийн хувьд холбогддог албан хаагчдын дунд гэмт хэргийн статистикийн талаархи ойлголт, мэдлэг, хандлага, үйл ажиллагаандаа ашиглаж буй байдлыг

тодорхойлох, алба хаагчдыг чадавхжуулах, сургалтын хэрэгцээг тодорхойлох зорилгоор социологийн судалгааг явуулж, үр дүнг боловсруулсан<sup>45</sup>.

Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд анкетын аргаар 1000 гаруй алба хаагчдаас 2017 оны 4 сараас 10 сар хүртэлх хугацаанд улсын хэмжээнд судалгааг авч, чанарын шаардлага хангасан 948 анкетыг математик статистикийн SPSS программ дээр шивж оруулан, үр дүнг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийв.

Анкетын асуулга боловсруулж гэмт хэргийн статистик хариуцсан болон ажил үүргийн хувьд холбогддог албан хаагчдаас авахаар ШЕЗ, ЦЕГ, АТГ, ШШГЕГ, ШШҮХ-д албан бичгээр хүргүүлж, үр дүнг нэгтгэн авсан.

Энэ судалгаанд оролцсон албан хаагчдын 86.7%-ийг эрх зүйч мэргэжилтэй албан хаагчид эзэлж байна. Харин статистик мэргэжилтэй 19 албан хаагчийн 17 нь прокурорын байгууллагад, 1 нь цагдаагийн байгууллагад, 1 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж байна. Сонгох хариултад оноосноос өөр мэргэжилтэй албан хаагчдын тухайд инженер, орчуулагч, программист, эрүүл мэндийн мэдээллийн технологич мэргэжилтэй 8 албан хаагч байна. Энэ нь цаашид шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах салбарын статистикчдийн хувьд мэргэжлийн статистикч байх эсхүл мэргэшсэн сургалтад тогтмол хамрагдах, эрх зүйч-статистикч мэргэжилтэн бэлтгэх, хэрэгцээг байгааг илтгэж байв.

Алба хаагчдын хүний нөөцийн байдлаас үүдэн шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудаас гэмт хэргийн статистик эрхлэх үйл ажиллагааны анхдагч мэдээлэл болон процессын ажиллагааны гол бүрэлдэхүүн хэсэг цагдаагийн байгууллага, прокурорын байгууллагад хийгдэж, хөтлөгддөг нь ажиглагдав.

Албан хаагчдын ажлын туршлага болон тогтвор суурьшилтай байдал нь төрийн алба мэргэшсэн байх шалгуурт чухал нөлөөтэй бөгөөд гэмт хэргийн статистик эрхлэн гаргах, ажил үүргийн хувьд шууд холбогддог албан хаагчдын хувьд 10-с дээш жил ажилласан туршлагатай албан хаагчид 26.3%-ийг, 2-5 хүртэл жил ажилласан албан хаагчид 41.4%-ийг, 1 жил хүртэл ажилласан албан хаагчид 14%-ийг, 6-9 хүртэл жил ажилласан албан хаагчид 18.4-ийг тус тус эзэлж байгаа дүр зураг харагдаж байна. Нийт дүнгээр нь авч үзвэл 6-с дээш жил ажилласан алба хаагчид 44.7%-ийг эзэлж байх ба ажлын туршлага жилээс жилд нэмэгдэх боломжтой нь тодорхой байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 97% нь бакалавр болон магистр зэрэгтэй байв.

Алба хаагчдын гэмт хэргийн статистикийн ойлголт, төсөөллийн талаархи өөрийн үнэлэмж 43.8% нь сайн гэж, 51.6% нь дунд гэж, 4.6% нь муу гэж үнэлсэн байна. Өмнө дурдсан хариултаас үзэхэд тэдний 44.7% нь 6-с дээш жил ажиллаж байгаа хэдий ч дундаж мэдлэгтэй гэсэн хариулт өгсөн нь гэмт хэргийн статистикийн талаархи мэдлэг, сургалтыг тусгайлан олгох, давтан сургалт зохион байгуулах шаардлагатай гэж үзэж болно.

Гэмт хэргийн статистикт юуг хамааруулж ойлгодог вэ? гэхэд гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, сан бүрдүүлэх, мэдээ гаргах, тоо бүртгэл хөтлөх, маягт бичих, танилцуулга бэлтгэх зэрэг асуудлыг хамруулж ойлгодог талаар хариулснаас үзэхэд ойлголт, төсөөлөл мөн нээлттэй саналыг авахад прокурорын байгууллагаас ялын бодлого боловсруулах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулах, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болж байгаа хүчин зүйлүүдийг зөв тогтоож энэ талаар бодитой судалгаатай байх нь түүнийг арилгах арга хэмжээг олон нийтийн хэмжээнд авч ажиллахад тустай гэсэн саналыг гаргасан бол цагдаагийн байгууллагын төлөөлөл шалтгаан, нөхцөлийг үнэлэх дүн шинжилгээ хийх, тагнуулын байгууллагын төлөөлөл шийдвэр гаргахад урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой гэж үзжээ.

Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас программ хангамжийг шинэчлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлт, түүний ашиглалтыг сайжруулах, бие даасан бүтэц, тогтолцоог оновчтой бий болгон төлөвшүүлэх, алба хаагчдын орон тоог нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, чиг үүргийг тодорхой болгох, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, тэднийг мэргэшүүлэх сургалтад хамруулах, ном, сурах бичиг, гарын авлага бэлтгэн гаргах, аргачлал, зөвлөмжөөр хангах асуудал учир дутагдалтай байдаг зэрэг тулгамдсан асуудал байгааг судалгаагаар тогтоогдлоо.

<sup>45</sup> М.Эрдэнэбаяр (Судалгааны багийн ахлагч), Б.Мөнхдорж. Гэмт хэргийн статистикийн социологийн судалгааны тайлан. "Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал" шинжлэх ухаан, технологийн төсөл. 2017

Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын статистикийн үйл ажиллагаа хариуцсан алба хаагчид болон ажил үүргийн хувьд холбогддог ажилтнуудаас авсан судалгаанд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Статистикийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын бүтэц, орон тоо, алба хаагчдын талаар:

- Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын хэмжээнд гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаа эрхлэх бие даасан бүтэц, нэгжийн зохион байгуулалт, тогтолцоо харилцан адилгүй буюу байгууллагын онцлог, чиг үүргээс хамаарч "нэг ажилтнаас нэгжийн зохион байгуулалттай"-гаар явагдаж байна.

- Байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт, гэмт хэргийн статистик бүрдүүлэлтэд оролцож буй байдлаас хамаарч хууль сахиулах бүхий л байгууллагад бие даасан, мэргэжлийн чиг үүрэгтэй нэгж шаардлагатай байхын зэрэгцээ орон тоо нэмэгдүүлэх санал судалгаанд хамрагдсан бүх байгууллагад ижил байна.

- Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын хэмжээнд гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр ажилладаг алба хаагчдаас статистикч мэргэжилтэй албан хаагч 2%-ийг эзэлж байна. Үүнээс үзэхэд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад статистикч мэргэжилтэй хүний нөөцийн хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

- Судалгаанд оролцогчдын гэмт хэргийн статистикийн талаархи ойлголт, төсөөлөл учир дутагдалтай байх ба алба хаагчдын мэдлэг, хандлагын талаархи өөрийн үнэлэмж дундаж түвшинд байна.

- Гэмт хэргийн статистикийн чиглэлээр давтан болон мэргэшүүлэх сургалт тогтмол зохион байгуулагдахгүй байгаа нь алба хаагчдын мэдлэг, чадвар хангалтгүй байх магадлал өндөр байгааг нөхцөлдүүлж байна. Энэ нь сургалтын хэрэгцээ өндөр, давтамж маш бага байгаагийн илрэл болно.

- Алба хаагчдын ажлын ачааллаас хамаарч ажлын байрны сэтгэл ханамж өөрчлөгдөж байхын зэрэгцээ орон тоо хүрэлцээтэй, ажиллах орчин бүрдсэн нэгжийн алба хаагчдын сэтгэл ханамж харьцангуй тогтвортой байна. Мөн албан хаагчдын ажлын байрандаа тогтвор суурьшилтай ажиллах хүсэл эрмэлзэл ажилласан жил, ажлын ачаалал, сэтгэл ханамжаас шууд хамаарсан үзүүлэлттэй байх нийтлэг байдлаар дундаж түвшинд байна.

2. Гэмт хэргийн статистик бүрдүүлэлт, өнөөгийн нөхцөл байдлын талаар:

- Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын хэмжээнд статистикийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн, тусгай программ хангамж бүхий байгууллагуудын хувьд (цагдаа, прокурорын байгууллага) системийг илүү сайжруулах, хөгжүүлэлт, хурдыг нэмэгдүүлэх, үр дүнгийн олон загварт байдалд шилжих асуудлыг хөндөж байна.

- Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг цаасан суурьтай гүйцэтгэж буй байгууллагын хувьд (шүүх, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага) программ хангамжийг нэвтрүүлэх, туршилтын болон ашиглаж буй зарим программын хөгжүүлэлтийг сайжруулж, байгууллагын хэмжээнд хэрэглэх шаардлагатай гэж дүгнэв.

- Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын хэмжээнд хөтөлж буй гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаа нь давхардсан, статистик үзүүлэлт зөрүүтэй, бодит бус, харилцан адилгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт дутмагаас гадна нэгдсэн сан бий болгох шаардлагатай байгааг илэрхийлж байна.

Судалгааны үр дүнд үндэслэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх дараах зарим гарц байна гэж үзэв. Үүнд:

- Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг эрхлэн гаргадаг албан хаагчдад давтан болон мэргэшүүлэх сургалт тогтмол сургалт зохион байгуулах;

- Статистикч мэргэжилтэй, эрх зүйч-статистикч хос мэргэжилтэй хүний нөөцөөр гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаа эрхэлдэг чиг үүргийн алба хаагч, нэгжийн бүрэлдэхүүнийг бэхжүүлэх, шинээр бэлтгэх;

- Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг эрхлэн гаргах үйл ажиллагаанд ашиглахад зориулсан гарын авлага, зөвлөмжийг бий болгож, тархаах;

- Гэмт хэргийн статистикийн чиглэлээр ажиллах алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, үндсэн чиг үүргийн дагуу ажлыг хийх бололцоогоор хангах, бусад техникийн шинжтэй ажлаас салгах;

- Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаанд программ хангамж, мэдээллийн технологийн орчин үеийн дэвшлийг сайтар ашиглах, статистикийн дүн шинжилгээний аргуудыг статистикийн үйл ажиллагаанд өргөнөөр ашиглаж хэвших.

### **3.2.2. Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүн:**

Гэмт хэргийн статистикийн тоон мэдээллийн үнэн бодитой байдлыг хэрэглэгч эрдэмтэн, судлаач, докторант, магистрант, оюутан, сонсогч нараар үнэлүүлж, дүгнүүлэх зорилгоор гэмт хэргийн статистикийн хэрэглэгчийн үнэлгээг хийсэн<sup>46</sup>.

Гэмт хэргийн статистикийг гаргадаг шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шинжилгээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх байгууллагын статистикийн мэдээ, тайлан хэрэглэгчдэд хэрхэн, ямар эх сурвалжаас хүрдэг, эрэлт хэрэгцээнд нийцдэг эсэх, талаар судлахыг зорьсон. Судалгааны мэдээлэл цуглуулсан арга зүйн тухайд бол түүвэрлэлтийн магадлалт системчилсэн төрөл буюу гэмт хэргийн статистикийг хэрэглэдэг нь тодорхой байгууллагын албан хаагчдаас сонгосон, мөн магадлалт бус түүвэрлэлтийн тохиолдлын төрөл буюу фейсбүүк хуудаст асуулгыг байршуулан тохиолдлоор сонгосон.

Судалгааг цахим асуулгын (Google Forms ашиглан) аргаар 8 дугаар сарын 9-ний өдрөөс 9 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл авсан бөгөөд судалгаанд нийт 306 төрийн болон төрийн бус байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн эрдэмтэн, судлаачид хамрагдсан. Судалгааны асуулга, хариултыг SPSS программд шивж, боловсруулан, үр дүнг нэгтгэсэн.

Хамрах хүрээг тодруулбал, ШЕЗ-ийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, ЦЕГ, ШШГЕГ, ШШҮХ, ХЗҮХ, МУИС-ийн ХЗС, Отгонтэнгэр их сургууль, ИЗОУИС-ийн Хууль зүйн сургууль, Орхон их сургууль, “Шихихутаг” хууль зүйн дээд сургууль, МУИС-ийн Хууль зүйн удирдлагын сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургууль, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо зэрэг 15 байгууллагын албан хаагч, багш, судлаач нар судалгаанд хамрагдаж, асуултад хариулт өгсөн.

Судалгаанд хамрагдсан хэрэглэгчид нь нас, хүйс, эрдмийн зэрэг, ажил эрхлэлтийн хувьд жигд оролцсон ба нийслэл хот, хөдөө орон нутаг болон гадаадын зарим улсаас хамрагдсан. Энэ нь төрөл бүрийн секторын хэрэглэгчдийг төлөөлж чадаж байна гэж үзэв.

Хэрэглэгчид гэмт хэргийн статистикийн мэдээ, мэдээллийг тухайн байгууллагын цахим хуудсаас, байгууллагын тайлан мэдээнээс, олон нийтийн сүлжээнээс, мэргэжлийн байгууллагаас авч хэрэглэдэг бөгөөд энэ нь тэдний эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй, манай улсын гэмт хэргийн статистикийн түвшин хангалттай сайн түвшинд бус байгааг судалгаанаас дүгнэв.

Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн түвшинг хэрэглэгчдийн 73.2%, гэмт хэргийн статистикийн үзүүлэлтүүдээс өөрт хэрэгтэй мэдээ, мэдээллээ бүрэн авч чаддаггүй нь гэдэгт 72.0% нь тус тус дундаас доогуур үнэлж, 82.1% нь гэмт хэргийн бүртгэл, статистик мэдээг сайжруулах шаардлагатай гэж үзжээ.

Хэрэглэгчдийн 55% нь цагдаагийн байгууллага, 15% нь шүүх, 13% нь статистикийн байгууллага, 9% нь прокурорын байгууллага, 6% нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, 1% нь шүүхийн шинжилгээний байгууллага, 1% нь авлигатай тэмцэх байгууллагын гэмт хэргийн статистикийн мэдээ, мэдээллийг ашигладаг гэж хариулсан байна.

Хэрэглэгчид гэмт хэргийн статистик гаргадаг байгууллагуудад үнэлгээ өгсөн бөгөөд цагдаагийн байгууллагад 77.3, статистикийн байгууллагад 69.1, шүүхийн байгууллагад 68.2, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 64.3, прокурорын байгууллагад 63.3, шүүхийн шинжилгээний байгууллагад 62, авлигатай тэмцэх байгууллагад 59.3 зэрэг үнэлгээг тус тус өгчээ.

Судалгаанд оролцогчдоос эрүүгийн хэрэг үүсгээгүй шалгасан хэрэг, зөрчлийн мэдээг нийтэд нь гаргадаг болох; эксел файл, хүснэгт, график, дүрс нэмэх; гэмт хэргийн

---

<sup>46</sup> М.Эрдэнэбаяр (Судалгааны багийн ахлагч), Б.Мөнхдорж, О.Уулзахжаргал. “Гэмт хэргийн статистикийн хэрэглэгчийн үнэлгээ” судалгааны тайлан. “Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал” шинжлэх ухаан, технологийн төсөл. Уб., 2017.

статистикийн нэгдсэн сантай болох шаардлагатай, гэмт хэргийн шалтгаан буюу гэмт хэргийн хувирах шинжтэй холбоотойгоор мэдээлэл олддоггүй. Тухайлбал, цахим гэмт хэрэг, цахим сүлжээнээс үүсэх гэмт хэргийн төрлүүдтэй холбоотой мэдээлэл байдаггүй, гэмт хэргийн статистик гаргаж байгаа бол судалгаанд байгаа байгууллага харилцан уялдаатай гаргах хэрэгтэй гэсэн саналууд гарсан.

Түүнчлэн, гэмт хэргийн статистикийн тогтолцоог оновчтой болгох, статистикийн мэдээллийг нээлттэй болгох, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх шаардлагатай. Энэ талын онолын үндэслэлийг тодорхойлсон ном бүтээл гаргах нь зүйтэй; гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг зохицуулсан хуультай болох, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай; мэдээлэл нь маш цөөн ангилалтай, нарийвчилсан байдлаар хайлт хийхэд маш хангалтгүй байдаг. Гэмт хэргийн зүйл тус бүрээр, гэмт хэрэгтний хувийн байдал зэргийг нарийвчлан тусгасан мэдээлэл гаргадаг байх хэрэгтэй, ингэж байж түүнээс урьдчилан сэргийлэх, шалтгааныг нь тогтоох зэрэг ажил хийгдэх ёстой; Прокурор, Тагнуулын байгууллагын статистикийг ил болгох; Судалгаанд үндэслэгдсэн мэдээллийг тусгайлан боловсруулж, эх сурвалжтай, тодорхой баримт нотолгоотой хэвлүүлдэг байх хэрэгтэй байна; судлаачдад задгай дата, нарийвчлал бүхий мэдээлэл олддоггүй. Статистикийн мэдээлэл цуглуулахдаа зарим мэдээллийг орхигдуулсан байдаг. Жишээлбэл: Шүүхийн статистик маргааны үнийн дүн тодорхой байдаггүй зэрэг санал гарсан болно.

### **3.2.3. Хүний нөөцийн өнөөгийн байдлыг судалсан нь:**

Цагдаа, прокурор, шүүх шинжилгээ, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дахь дахь гэмт хэргийн тоо бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээлэл эрхлэн гаргах, түүнд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлж буй хүний нөөцийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор судалгааг явуулсан<sup>47</sup>.

Энэхүү ажлыг хийж гүйцэтгэхэд анкетын аргаар 500 алба хаагчдаас 2017 оны 10 сард улсын хэмжээнд судалгааг авч, чанарын шаардлага хангасан 454 анкетыг математик статистикийн SPSS программ дээр шивж оруулан, үр дүнг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийж бичив.

Анкетын асуулга боловсруулж гэмт хэргийн статистик хариуцсан албан хаагчдаас авахаар ШЕЗ, УЕПГ, ЦЕГ, ШШГЕГ, ШШҮХ-д албан бичгээр хүргүүлж, үр дүнг нэгтгэн авсан. Судалгаанд эдгээр байгууллагын гэмт хэргийн статистик хариуцсан алба хаагчдыг бүрэн хамруулсан. ТЕГ, АТГ-ын зарим мэдээлэл албаны нууцад хамаардаг тул энэ судалгаанд тусгаагүй болно.

Нийт 500 албан хаагчийг хамруулж санал асуулга авснаас 454 нь чанарын шаардлага хангасан бөгөөд эдгээрт үндэслэн дүн шинжилгээ хийлээ.

Судалгаанд оролцогчдын 84.4%-ийг 40-с доош насны залуу, идэр насны албан хаагчид эзэлж байв. Хүйсийн харьцааны хувьд прокурорын байгууллага, шүүхийн шинжилгээний байгууллагаас бусад байгууллагад гэмт хэргийн статистик эрхлэн гаргах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан хаагчдын бүрэлдэхүүнд эмэгтэй алба хаагчдын эзлэх хувь их өндөр (61.5%-88.9%) байна.

Судалгаанд оролцсон албан хаагчдын дийлэнх (80.4) хувийг эрх зүйч мэргэжилтэй албан хаагчид эзэлж байна. Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын хэмжээнд гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр статистикч мэргэжилтэй албан хаагч ердөө 3 байгаагийн 2 нь цагдаагийн байгууллагад, 1 нь шүүхийн шинжилгээний байгууллагад ажиллаж байна. Үүнээс үзэхэд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад статистикч мэргэжилтэй хүний нөөцийн хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын дийлэнх (96.2) хувь нь бакалавр болон магистр зэрэгтэй байна. Харин 3.7% буюу 17 албан хаагч бүрэн дунд боловсролтой гэж хариулсан нь анхаарал татаж байв.

Энэ чиглэлээр 10-с дээш жил ажилласан туршлагатай албан хаагчид 16.1%-ийг, 2-5 хүртэл жил ажилласан албан хаагчид 46.2%-ийг, 1 жил хүртэл ажилласан албан хаагчид 16.1%-ийг, 6-9 хүртэл жил ажилласан албан хаагчид 22.1%-ийг тус тус эзэлж байгаа нь харьцангуй тогтвортой үзүүлэлт юм.

<sup>47</sup> М.Эрдэнэбаяр (Судалгааны багийн ахлагч), Б.Мөнхдорж, Б.Мөнхсэргэлэн. “Гэмт хэргийн статистикийн хүний нөөцийн өнөөгийн байдал” судалгааны тайлан. “Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал” шинжлэх ухаан, технологийн төсөл. 2017.


Гэмт хэргийн статистик эрхлэн гаргах чиглэлийн сургалт үндсэндээ явагдахгүй байгаагаас сургалтын хэрэгцээ их өндөр, давтамж маш бага гэсэн үр дүнг харуулж байв.

Судалгааны үр дүнд үндэслэн орон нутагт нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг эрхлэн гаргадаг албан хаагчдад нэг дор сургалт зохион байгуулах; статистикч мэргэжилтэй, эрх зүйч-статистикч хос мэргэжилтэй хүний нөөцөөр гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаа эрхэлдэг чиг үүргийн алба хаагч, нэгжийн бүрэлдэхүүнийг бэхжүүлэх, шинээр бэлтгэх, гэмт хэргийн статистик эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан хаагчдын бүрэлдэхүүнд бүрэн дунд боловсролтой алба хаагчдын эзлэх хувийг эрс багасгах, цаашид ажлын байранд тавигдах шаардлагаар бүрэн дунд боловсролтой хүнийг томилгоо хийхгүй байх зэрэг санал гарсан болно.

#### 3.2.4. Гэмт хэргийн статистик дахь мэдээллийн технологийн хэрэглээ:

Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаанд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тусгайлан боловсруулсан өгөгдөл цуглуулах программ, судалгаа, шинжилгээний хийхэд зориулагдсан программ хэрэглэхээс гадна үр дүнг тархах вэб технологи болон бусад программыг хэрэглэж байна. Гэмт хэргийн статистик зүй дэх мэдээллийн технологийн хэрэглээг илүү ухаалаг болгох, энэ чиглэлийн мэдээллийн технологийн хөгжүүлэлт харилцан адилгүй, боловсронгуй бус, мэргэшсэн хүний нөөц дутагдалтай байна.

Зураг 4. Гэмт хэргийн статистик дахь мэдээллийн технологийн хэрэглээ.



\* Эх сурвалж: Судалгааны үр дүнд үндэслэн Б.Мөнхдоржийн боловсруулсан загвар.

Дээрх зураглалд харуулсаны дагуу гэмт хэргийн статистик зүй дэх мэдээллийн технологийн хэрэглээг ангилан авч үзэж, "Crime Stats-IT" хөгжүүлэлт, энэ чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх, одоо ажиллаж буй хүний нөөцийг бодлогоор чадавхжуулах шаардлагатай байна. Хууль сахиулах, статистикийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж буй мэдээллийн технологийн үйлчилгээг гадны байгууллагаас захиалгаар гүйцэтгүүлж байна.

#### 3.3. Гэмт хэргийн статистикийн тогтолцоог сайжруулах нь


Монгол Улсад гэмт хэргийн статистикийн тогтолцоо оновчтой бус, цагдаа, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэл, арга зүй уялдаагүй, гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэлийн аргачлал, статистик мэдээний нэгдмэл байдал хангагдахгүйгээс гэмт явдлын тоо бүртгэл бодитой бус байгаа нь төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод үр дүнтэйгээр нөлөөлж чадахгүй. Иймд гэмт хэргийн статистикийн тогтолцоог шинэчлэх шаардлага байна гэж үзсэн.

Монгол Улсад гэмт хэргийн талаархи мэдээллийн сан бүрдүүлэх, статистикийн мэдээг шүүх, прокурор, цагдаа, авлигатай тэмцэх, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эрхлэн гаргаж, ҮСХ-нд нэгтгэж, улсын хэмжээний нийгэм, эдийн засгийн



мэдээнд тусгаж байна. Эдгээр байгууллага мөн тус тусын үйл ажиллагааны хүрээнд статистик мэдээллийг нийтийн хүртээл болгож, үйл ажиллагаанд ашигладаг. Дээрх хууль сахиулах зарим байгууллагын аймаг, нийслэл, дүүрэг, сум дахь нэгжийн гэмт хэргийн статистик мэдээ нь тухай нутаг дэвсгэрийн төрийн захиргааны статистикийн нэгжийн эрхлэн гаргаж буй статистикийн мэдээнд хамрагдаж байдаг.

Зураг 6. Гэмт хэргийн статистикийн тогтолцооны өнөөгийн байдал



\* Эх сурвалж: Судалгааны үр дүнд үндэслэн Б.Мөнхдоржийн боловсруулсан загвар. *Монгол Улсад гэмт хэргийн статистикийн мэдээлэл эрхлэн гардаг оновчтой нэгдсэн тогтолцоо бүрдээгүй гэж дүгнэж байна.*

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчил, прокурорын байгууллага чиг үүргийн хүрээнд хяналт тавьсан эрүүгийн хэрэг, гомдол, мэдээлэл, шүүхэд шийдвэрлэгдсэн хэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистикийн мэдээллийг тус тус эрхлэн гаргадаг. Эдгээр статистик мэдээллийн анхан шатны бүртгэл болох бүртгэлийн маягт, мөн мэдээний маягт нь харилцан адилгүй байдаг.

Тагнуулын байгууллагын хувьд хуулиар харьяалуулсан гэмт хэрэг шалгаж, цагдаагийн байгууллагын мэдээллийн санд оруулдаг ч улсын хэмжээний гэмт хэргийн статистикийн мэдээнд тэр бүр тусгадаггүй. АТГ мөн хуулиар харьяалуулсан гэмт хэргийг бүртгэж, илрүүлж шалгадаг ба шалгаж буй гэмт хэргийн талаархи мэдээллийг цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгүүлж, улсын хэмжээний мэдээнд тусгагдаг ч албаны нууцлал гэх үүднээс гэмт хэрэг бүрийг мэдээллийн санд бүрэн оруулдаггүй, статистикийн мэдээнд тусгахгүй явдал байна. Мөн АТГ-ын Тусгай субъект мөрдөх хэлтэс (хуучнаар УЕПГ-ын Мөрдөх алба) харьяаллын дагуу шалгаж буй хэргийн талаархи мэдээллийг цагдаагийн байгууллагын мэдээллийн санд оруулдаг.

Өнөөгийн байдлаар цагдаагийн байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн талаархи гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, гэмт хэрэгт холбогдсон этгээд, хохирсон иргэн, байгууллага, хохирол, захиргааны зөрчил, түүнийг үйлдсэн этгээдийн талаархи мэдээллийн сан улсын хэмжээнд онлайн-аар бүрдэж, түүнээс статистикийн мэдээлэл гарч байна. Харин шүүх, прокурорын байгууллагын хувьд мэдээллийн сан бүрдүүлэх системээ хөгжүүлж байгаа бөгөөд статистик мэдээлэл эрхлэн гаргах, үндэсний статистикийн мэдээлэлд тусгагдах үйл явц төдийлөн шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газарт цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гэмт хэргийн талаархи статистик мэдээлэл нэгтгэгдэн гарч, улсын хэмжээний нийгэм, эдийн засгийн байдалд тусч, улмаар төр засгийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудын түвшинд танилцуулагдаж, НҮБ-ын статистикийн төв байгууллага зэрэг олон улсын байгууллагад хүргэдэг.

Монгол Улсад гэмт хэргийн статистикийн мэдээлэл эрхлэн гаргахад цагдаа, авлигатай тэмцэх, прокурор, шүүх, ХЗДХЯ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, статистикийн төв байгууллагууд чухал үүрэгтэй оролцож, тодорхой чиг үүрэг хэрэгжүүлж байна. Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг хангах, мэдээллийн бодит байдлыг сайжруулах, уялдаа холбоог хангахад гэмт хэргийн статистикийн тогтолцоо нь оновчтой бүрдээгүй гэж *дахин тодотгож дүгнэж байна.*

Цаашид Монгол Улсын гэмт хэргийн статистикийн тогтолцоог боловсронгуй болгон төлөвшүүлэх, тухайлбал, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, гэмт хэргийн статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, эрх зүйн актыг бий болгож, мөрдүүлэх, гэмт хэргийн статистикийн үндэсний үзүүлэлтийг олон улсын жишиг үзүүлэлтэд нийцүүлэх, ҮСХ-нд гэмт хэргийн статистик мэдээлэл хариуцсан нэгж үйл ажиллагаа явуулах нь үр дүнтэй гэж судлаачийн хувьд үздэг.


Зураг 7. Хууль зүйн цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт, ашиглалт



\* Эх сурвалж: Судалгааны үр дүнд үндэслэн Б.Мөнхдоржийн боловсруулсан загвар.

Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах төсөл хэрэгжээд дуусах шатандаа орж байна. Прокурорын байгууллагад мэдээллийн систем, мэдээллийн сан төвлөрөх нь зүйтэй. Харин ХЗДХЯ нь мэдээллийн сангийн ашиглалт, сайжруулалтыг салбарын хэмжээнд бодлого, үйл ажиллагаанд ашиглах эрх зүйн болон дэд бүтцийн орчинг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

Зураг 8. Гэмт хэргийн статистикийн тогтолцооны "Crime Stats" загвар



\* Эх сурвалж: Судалгааны үр дүнд үндэслэн Б.Мөнхдоржийн боловсруулсан загвар.

Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, криминологийн шинжлэх ухааныг олон улсын туршлагыг судлан хөгжүүлэх зорилгоор Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судлах судалгааны төв, эсхүл хүрээлэнг тусгайлан ажиллуулах хэрэгтэй.

Гадаад улсын туршлагыг авч үзэхэд, гэмт хэргийн статистикийн бодит байдлын үнэн бодит байдал, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийдэг тогтолцоо буюу хараат бус бие даасан байгууллага ажилладаг.

Мөн статистикийн төв байгууллагын дэргэд гэмт хэргийн статистикийн мэдээлэл, судалгаанд үндэслэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг институт ажилладаг туршлага байгаа нь манай улсад нийцтэй бус гэж үзэж байна.

Статистикийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дугаар зүйлд: “Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ. Яамд бүтцэдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна” гэж заасан нь шүүх, прокурор, цагдаа, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээ зэрэг байгууллага мэдээллийн сан бүрдүүлэх, тоо бүртгэл хөтлөх, статистикийн үйл ажиллагаа эрхлэх нэгж, эсхүл албан тушаалтныг бий болгон ажиллуулж байгаа ба АТГ-т энэ чиг үүргийг хариуцсан нэг албан тушаалтан ажилладаг, бусад байгууллагад тусгайлсан бүтэц, зохион байгуулалтын нэгж ажиллаж байна.

Дээрх заалтын дагуу ХЗДХЯ-ны дэргэд хууль зүй, гэмт хэргийн статистикийн мэдээллийг нэгтгэх, түүнд дүн шинжилгээ хийх, салбарын хэмжээнд статистикийн хууль тогтоомжийг мөрдүүлэх, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг холбогдох нэгжийн чиг үүрэгт нэмж тусгах нь зүйтэй.

Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, криминологийн шинжлэх ухааныг олон улсын туршлагыг судлан хөгжүүлэх зорилгоор Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судлах судалгааны институтийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эсхүл ГХУСАЗЗ-ийн дэргэд байгуулан, ажиллуулах, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудад гэмт явдлын шалтгаан нөхцөлийг судлах чиг үүрэгтэй нэгж ажиллах боломжийг хуулиар зохицуулах шаардлагатай байна.

Түүнчлэн, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх, прокурор, шүүхийн болон статистикийн байгууллагуудын үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл, туршлага, хүний нөөц солилцох арга хэмжээг тогтмолжуулах хэрэгцээ байна.

Гэмт хэргийн статистикийн чанарын судалгаа болох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд нуугдмал гэмт хэргийн түвшинг тооцоолох, иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэмт хэрэгт хохирох явдлын судалгааг (National Crime Victimization Survey)” 3 жил тутамд НҮБ-ын аргачлалын дагуу явуулж, нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлон, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд ашиглах, тайланг НҮБ-д хүргүүлдэг болох хэрэгтэй байна.

#### **3.4. Гэмт хэргийн статистикийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь**

Монгол Улсын Үндсэн хууль, Статистикийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Прокурорын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2015 оны 23 дугаар тогтоол, шүүхийн хэмжээнд “Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам”, прокурорын байгууллагын хэмжээнд “Дотоод ажлын аргачилсан заавар”, “Үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх аргачилсан заавар”, “Мэдээлэл, мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах журам, хууль зүйн салбарын хэмжээнд “Салбарын статистик мэдээллийн сан бүрдүүлэх, эрхлэн хөтлөх журам”, “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам”, авлигатай тэмцэх, тагнуул, цагдаагийн байгууллагын хэмжээнд “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягыг нөхөх, мэдээллийн санд төвлөрүүлэх журам”, цагдаагийн байгууллагын хэмжээнд “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх журам”, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд “Нэгдсэн тоо бүртгэл хөтлөлтийн заавар” зэрэг эрх зүйн актаар гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг зохицуулж байна.

Гэмт хэргийн статистикийн үндсэн эрх зүйн эх сурвалж бол Үндсэн хууль мөн. Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөг хангах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой заалтуудын хэрэгжилтийг хэмжих хэмжүүр үзүүлэлт нь гэмт хэргийн статистикийн мэдээлэл юм. Үүнд иргэнийхээ аюулгүй орчинд амьдрах баталгааг хангах, гэмт халдлагад өртөхгүй байх нөхцөлийг хангах үйл ажиллагаа гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай зайлшгүй уялдана.

Монгол Улсад сүүлийн 10 жилд, гэмт хэргийн улмаас төр засаг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нийт 400 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирч, 16 мянган иргэн нас барж, нийт найман мянган хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтсэн байна. Үүнээс үзэхэд, гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, түүнд программ хангамж ашиглах, статистикийн мэдээлэл гаргах, дүн шинжилгээ хийх ажлын эрх зүйн үндэс нь Үндсэн хууль бөгөөд түүний хэрэгжилтийг хэмжих хэрэгсэл гэмт хэргийн статистик болно.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагын хэрэгжүүлэх гол хууль бол Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль.

Цаашид Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэхдээ гэмт хэргийн талаархи тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистикийн мэдээлэл эрхлэн гаргах, дүн шинжилгээ хийж, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах чиг үүргийг тодорхойлсон заалтыг тусгайлан оруулж хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын хэрэгжүүлэх үйл ажиллагааг хуульчлах, түүнчлэн Статистикийн тухай, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын салбар институтийн харилцааг зохицуулсан хуулиудад энэ талын тодорхой зохицуулалтыг нэг мөр ойлголт, тодорхой томъёоллоор оруулах шаардлагатай.

## **VI. НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

Үндсэн хуулийн зарим заалтуудыг хэрэгжилтийг хэмжих нэг үзүүлэлт болон гэмт хэргийн статистикийн тулгамдсан асуудлыг судалж, дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хүн төрөлхтөн өнө эрт үеэс хүн ам, мал, эд хөрөнгө, эд зүйлээ тоолж бүртгэж эхэлсэн бөгөөд Монгол Улсад 1924 оноос статистикийн байгууллага албан ёсоор үүсэн бий болж, хөгжиж иржээ. Гэмт хэргийн статистикийн тухайд 1921 оноос өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага тооцдог баримт байгаа бөгөөд 1926 оноос 1966 он хүртэл гэмт хэргийн тоо бүртгэл хөтөлж, судалгаа тоон мэдээлэл гаргадаг байсан ч төдийлөн нийтэд ил болгодоггүй байжээ.

Харин 1967 оноос Монгол Улс гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаа албан ёсоор хөтлөгдөж эхэлсэн нь гэмт хэргийн статистикийн тогтолцоо бүрдэх эхлэл тавигдсан байна.

2. Монгол Улсын гэмт хэргийн статистикийн үзэл баримтлал, арга зүй, түүний хэрэглээ, тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг эрдэмтэн, судлаачид цогц байдлаар судлаагүй, онолын түвшинд зарим нэр томъёог тодорхойлоогүй байв.

Гэмт хэргийн статистик зүйн онол, арга зүйг бий болгон хөгжүүлснээр статистик, хууль зүй, криминологи, виктимологийн мэдлэгийн салбар шинэ ойлголтоор баяжиж, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэл сайжирна.

3. Гэмт хэргийн статистикийн практикт тулгамдсан асуудлыг шинжлэх ухаанч хандлагаар шийдвэрлэх онол, арга зүйн талын дэмжлэг дутмаг явж иржээ. Гэмт хэргийн статистикийн практикт тулгамдсан олон асуудлыг судалгааны явцад тогтоов.

4. Монгол Улсын хэмжээнд гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааг эрхлэх оновчтой тогтолцоо бүрдээгүй, арга зүй уялдаагүй, нэгдсэн аргачлал байхгүй байна.

Тухайлбал, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын гэмт хэргийн статистикийн арга зүй уялдаагүй, үндэсний хэмжээнд нэгдсэн байдлаар мөрдөгдөх аргачлал байхгүй байна.

Үндэсний статистик, хууль зүй, дотоод хэргийн салбар, аюулгүй байдлын болон шүүх эрх мэдлийн байгууллагын гэмт хэргийн бүртгэлийн арга зүйн болон цахим орон зайн нэгдмэл байдлыг хангаж байгаагаараа статистик үнэн, бодитой, ил тод, нээлттэй, шуурхай байх нөхцлийг бүрдүүлэх оновчтой тогтолцоо бүрдээгүй байна.

5. Монгол Улсын хөгжлийн зарим бодлогыг тодорхойлох, түүний хэрэгжилтийг хэмжих, улмаар олон улсын түвшинд улсын хөгжил, аюулгүй байдлын түвшинг харьцуулахад гэмт хэргийн статистикийн үзүүлэлтийг хэрэглэж байна. НҮБ-д гэмт хэргийн чиг хандлагын судалгааг бүрэн гаргаж, хүргүүлэхгүй байна.

6. Монгол Улсын гэмт хэргийн статистикийн үзүүлэлт олон улсын хэмжээнд бүрэн харьцуулагдахгүй байна. Тогтвортой хөгжлийн зорилтод тусгагдсан, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудаас хамааран гарах шаардлагатай статистикийн мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлж, аргачлал, арга зүйг бий болгох нь зүйтэй.

7. Гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаанд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тусгайлан боловсруулсан өгөгдөл цуглуулах программ, судалгаа, шинжилгээ хийхэд

зориулагдсан программ хэрэглэхээс гадна үр дүнг тархаах вэб технологи болон бусад программыг хэрэглэж байна.

Гэмт хэргийн статистик зүй дэх мэдээллийн технологийн хэрэглээ, үүн дэх IT хөгжүүлэлт харилцан адилгүй, боловсронгуй бус, мэргэшсэн хүний нөөц дутагдалтай байна.

8. Хууль зүй, статистик болон төрөл бүрийн салбарын эрдэмтэн, судлаач, практик байгууллагаас нуугдмал гэмт явдлыг тодорхойлох оролдлого хийж ирсэн ч авлигын индексийг эс тооцож үзвэл эрдэм шинжилгээний эргэлт болон практик хэрэглээнд хараахан нэвтрээгүй байна.

9. Хууль зүй, криминологи, виктимологийн шинжлэх ухаан дахь математик, статистикийн академик хэрэглээ өсөн нэмэгдэж байна.

Практик байгууллагад гэмт хэргийн статистикийн чиглэлээр ажиллаж буй алба хаагчид мэргэжлийн бус, мэргэшээгүй, зохих сургалтад хамрагдаагүй, ажлын давхардлаас үүдэн ачаалалтай ажилладаг гэсэн судалгааны дүн гарсан.

10. Гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх, статистикийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин ч учир дутагдалтай байна.

## **V. ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

Судалгааны үндсэн үр дүнд туссан дүгнэлт, саналаас гадна дараах тулгамдсан асуудлыг шийдвэрлэх дараах арга замыг онцлон дэвшүүлж байна. Үүнд:

1. “Гэмт хэргийн статистик зүй”-г хууль зүй, статистикийн мэдлэгийн дэд салбар хэмээн төлөөлүүлэн авч үзэж, түүний онол, арга зүйг хөгжүүлэх;

2. Гэмт хэргийн статистикийн тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, арга зүй, аргачлалыг боловсронгуй болгох, хүний нөөцийг хөгжүүлэх;

3. НҮБ-аас баталсан гэмт хэргийн статистикийн олон улсын ангилалд Монгол Улсын гэмт хэргийн статистикийн үзүүлэлтийг нийцүүлэх, Тогтвортой хөгжлийн зорилгын 16-д хамаарах болон НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны үзүүлэлтийг аргачлал, стандартын дагуу бүрэн гаргаж хүргүүлж, мэдээлдэг байх;

4. “Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа”-г 3 жил тутамд НҮБ-ын аргачлалын дагуу явуулж, нуугдмал гэмт явдлыг тодорхойлон, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд ашиглах, тайланг НҮБ-д хүргүүлдэг байх; Уг судалгаанд үндэслэн нуугдмал гэмт явдлыг тодорхойлох аргачлалыг практикт нэвтрүүлж, хөгжүүлэх;

5. Гэмт хэргийн статистикийн мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

6. Гэмт хэргийн статистикийн чиглэлээр ажиллах хүний нөөцийг бэлтгэх болон одоо ажиллаж байгаа ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах зэрэг саналыг дэвшүүлж байна.

## “ХАР ТАМХИТАЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХЭРХЭН ҮР ДҮНТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВЭ?” ЦАХИМ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Б.Алтансүх

ХСИС-ийн багш, Бээжингийн их сургуулийн докторант

О.Уулзахжаргал

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтан, магистр, цагдаагийн ахлах дэслэгч

М.Отгонбаатар

ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын чиглэлийн ахлах мөрдөгч, магистрант, цагдаагийн хошууч

**Товч агуулга:** Энэхүү судалгааг Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэн, БНХАУ-ын Бээжингийн их сургуулиас хэрэгжүүлж буй “Хар тамхитай холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлагын талаар Монгол Улс, БНХАУ-ын харьцуулсан судалгаа” сэдэвт судалгааны ажлын хүрээнд хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх олон нийтийн санал, бодлыг тандан судлах зорилгоор явуулав.

Түүвэрлэлтийн магадлалт системчилсэн төрөл, магадлалт бус түүвэрлэлтийн тохиолдлын төрөл буюу социал медиа (facebook, twitter, wechat), болон цахим хуудаст асуулгыг байршуулан тохиолдлоор сонгосон.

Судалгааг цахим асуулгын (Google Forms ашиглан) аргаар 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 24-ний өдөр хүртэл авсан бөгөөд судалгаанд нийт 512 иргэн оролцсоноос шаардлага хангах 484 асуулгыг сонгон авч дүнг гаргав.

Судалгааны үр дүнг SPSS программ дээр алдааг засварлан үр дүнг нэгтгэн дүгнэсэн.


**Түлхүүр үгс:** Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, гэмт хэрэг.

### СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

#### Судалгаанд оролцогчдын талаар ерөнхий мэдээлэл

Цахим судалгаанд нийт 484 иргэд оролцсон. Үүнээс: 20 хүртэл насны 7 (1.5%), 21-30 насны 294 (60.7%), 31-40 насны 164 (33.8%), 41-50 насны 16 (3.3%), 61-ээс дээш насны 3 (0.6%) хүн оролцсон байна. Эндээс харахад судалгаанд 21-40 насныхан түлхүү хамрагдсан байна.


График 1. Судалгаанд оролцогчдын насаар



Нас	Тоо	Хувь
20 хүртэл	7	1.5
21-30	294	60.7
31-40	164	33.8
41-50	16	3.3
61-ээс дээш	3	0.6

Судалгаанд 192 (39.7%) эрэгтэй, 292 (60.3%) эмэгтэй иргэд хамрагдсан нь хүйсийн тэнцвэрт харьцааг хангасан байна.

График 2. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа



Хүйс	Тоо	Хувь
Эрэгтэй	192	39.7
Эмэгтэй	292	60.3

Судалгаанд оролцогчдыг амьдарч буй улсаар харуулбал, Монгол Улсаас 373, БНХАУ-аас 78, АНУ-аас 12, ОХУ-аас 5, БНСУ-аас 4, Бразил улсаас 3, Унгар улсаас 3, Япон улсаас 2, Австрали улсаас 2, Ирланд улсаас 1, Швед улсаас 1 иргэд хандсан байна.


График 3. Судалгаанд оролцогчдын амьдарч буй улсаар



Амьдарч буй улс	Тоо	Хувь
Монгол улс	373	77.1
Бүгд найрамдах Хятад ард улс	78	16.1
Америкийн нэгдсэн улс	12	2.5
Оросын Холбооны улс	5	1.1
Бүгд найрамдах Солонгос улс	4	0.8
Бразил улс	3	0.6
Унгар улс	3	0.6
Япон улс	2	0.4
Австрали улс	2	0.4
Ирланд улс	1	0.2
Швед улс	1	0.2

Судалгаанд докторын зэрэгтэй – 18 буюу 3.7%, магистр – 185 буюу 38%, бакалавр – 258 буюу 53.3%, бүрэн дунд боловсролтой 23 буюу 4.7% хэрэглэгчид хамрагдсан байна. Графикаас харахад 95% дээд боловсролтой иргэд хамрагдсан байна.

График 4. Судалгаанд оролцогчдын боловсролын зэргээр




Боловсролын зэрэг	Тоо	Хувь
Доктор	18	3.8
Магистр	185	38.2
Бакалавр	258	53.3
Бүрэн дунд	23	4.7

### Хар тамхи, мансууруулах бодисын талаар ерөнхий мэдээлэл

Бид судалгаанд хамрагдагчдын хар тамхи, мансууруулах бодисын талаар ерөнхий ойлголт, судалгаанд хамрагдах чадварыг баталгаажуулах зорилгоор “Хар тамхи, мансууруулах бодисын талаарх таны ойлголт?” гэсэн асуултыг тавьсан бөгөөд үр дүнд нийт 484 оролцогчдын 205 буюу 42.4% нь “мэднэ”, 153 буюу 31.6% “бага зэрэг”, 30 буюу 6.2% нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өгсөн байна. 42.4 хувь нь өөртөө итгэлтэйгээр мэднэ гэж хариулсан нь бидний хувьд хүлээгдээгүй үр дүн байлаа. Нийт оролцогчдын 74 хувь нь “Мэднэ, бага зэрэг мэднэ” гэж хариулсан нь судалгааны үр дүнг илүү бодитой гэдгийг харуулж байна.

График 5. Судалгаанд оролцогчдын хар тамхи, мансууруулах бодисын талаарх ойлголт




Хариулт	Тоо	Хувь
“Мэднэ”	205	42.4
“Бага зэрэг”	153	31.6
“Мэдэхгүй”	30	6.2

Судалгаанд оролцогчдын хар тамхи, мансууруулах бодисын талаарх ойлголтыг насаар ангилж үзвэл, 21-30 насны залуучууд хар тамхи, мансууруулах бодисын талаар мэдлэг, мэдээлэл ихтэй байгаа боловч, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар төдийлөн мэдлэггүй, харин 31-40 насныхан хэрхэн тэмцэх, шалтгаан, нөхцөлийн талаар үнэтэй санал өгсөн байна.

График 6. Судалгаанд оролцогчдын хар тамхи, мансууруулах бодисын талаарх ойлголт, насаар






Нас	Бага зэрэг	Мэднэ	Мэдэхгүй
20 хүртэл	4	2	1
21-30	142	134	18
31-40	92	60	12
41-50	6	10	0
61-ээс дээш	0	3	0

“Монгол Улсад ямар төрлийн хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгдэж байгаа гэж та үзэж байна вэ?” гэсэн асуултын давхардсан хариултыг дараах хүснэгтээр харуулав. Эндээс харахад оролцогчид айс, каннабис, кокайн, героин бодисууд нь Монгол Улсад түлхүү нэвтэрсэн гэж үзэж байна.


График 6. Судалгаанд оролцогчдын Монгол Улсад хэрэглэгдэж байгаа хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис талаарх ойлголт (Давхардсан тоогоор)



Хариулт	Тоо	Хувь
Айс	287	35.17
Каннабис (Өвс)	204	25.0
Кокайн	165	20.22
Героин	116	14.21
Гашиш (шавар)	17	2.08
Марихуан	9	1.10
Weed	8	0.98
LSD	5	0.61
ОХУ-аас орж ирж буй эм	2	0.24
Extacy	2	0.24
Мими	1	0.12

“Монгол Улс хар тамхитай тэмцэж чадаж байна уу?” гэсэн асуултад 72.3% буюу 350 оролцогч “үгүй” – тэмцэж чадахгүй байна, 19.2% буюу 93 оролцогч “тийм” – тэмцэж чадаж байна, 8.5% буюу 41 оролцогч “мэдэхгүй” гэж хариулсан байна. Хариултаас харахад хар тамхитай үр дүнтэй тэмцэж чадахгүй байна гэж оролцогчид үзэж байна.

График 7. Монгол Улс хар тамхитай тэмцэж чадах байгаа эсэх талаарх оролцогчдын хариулт




Хариулт	Тоо	Хувь
“Тийм” – тэмцэж чадахгүй байна	93	19.2
“Үгүй” – тэмцэж чадахгүй байна	350	72.3
“Мэдэхгүй”	41	8.5

- Борлуулагч, тээвэрлэгч, сурталчлагчид гэх мэт гол үндсийг нь илрүүлж чадахгүй байна. Жишээ нь, зарим улс биеэ үнэлэлттэй тэмцэхдээ: Онтологийн хувьд хүний биологийн хэрэгцээг хязгаарлаж бүр мөсөн зогсоож чадахгүйгээс биеэ үнэлэлтийг тодорхой хэмжээнд зөвшөөрч байж хяналтдаа байлгаж болдог, анхнаасаа хууль зөрчсөн хүмүүсийн үйлдэл даамжирдаг, биеэ үнэлэх явцдаа хулгай, залилан, насанд хүрээгүй хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох гэх мэт.

“Монгол Улс дахь хар тамхитай холбоотой гэмт хэрэг гарч буй шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг Та юутай холбон үзэх вэ?” гэсэн асуултын давхардсан хариултыг дараах графикт харуулав. Үүнээс үзэхэд хар тамхи, мансууруулах бодисын гол эх сурвалж болох гадаадын борлуулагч нараас худалдан авалт хийж, хил, гаалиар нэвтрүүлэх төрөл бүрийн аргууд байдаг бөгөөд хяналт шалгалт хангалтгүй байна. Тухайн гэмт хэргийн эсрэг хууль, эрх зүйн орчин сул, хариуцлага, ял оногдуулах чадвар сул байгааг тэмдэглэсэн байна. Мөн зарим оролцогчид энэ төрлийн гэмт хэргийн гол шалтгаан нь дараах хүчин зүйлс, нөхцөлөөс хамааралгүй зөвхөн хувь хүний ухамсар, мэдлэг доройгоос хамааралтай гэж үзэж байна.

График 8. Судалгаанд оролцогчдын Монгол Улсад хар тамхитай холбоотой гэмт хэрэг гарч буй шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийн талаарх ойлголт


(Давхардсан тоогоор)



Хариулт	Тоо	Хувь
Хил, гаалийн хяналт шалгалт хангалтгүй	327	65.6
Тэмцэж буй хууль эрх зүйн орчин сул	278	57.4
Хариуцлагын тогтолцоо сул	208	43.0
Мэргэшсэн хүний нөөц дутмаг	187	38.6
Гадаад улсын болон бүс нутгийн нөлөө	179	36.9
Тэмцэж, урьдчилан сэргийлж буй үйл ажиллагааны үр дүн хангалтгүй	176	36.3
Тэмцэж буй бүтэц, зохион байгуулалт оновчгүй	123	25.4
Хар тамхины агууламжтай өвс ургамал ихээхэн ургадаг	116	24.0
<ul style="list-style-type: none"> <li>– Дээрх бүгд хамааралгүй, зөвхөн хувь хүний ухамсартай холбоотой;</li> <li>– Эрх мэдэл, албан тушаал, мөнгөтэй хүмүүст хууль үйлчлэхгүй байна;</li> <li>– Энэ төрлийн зүйлсэд ихэвчлэн баян, хийх юмгүй хүмүүс холбогдож байна. Нийгмийн ухамсар дорой, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх өөр эерэг зүйл хэрэгтэй байна.</li> </ul>		

Судалгаанд оролцогчид Монгол Улсын хэмжээнд хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэж, урьдчилан сэргийлж буй үйл ажиллагаанд дараах үнэлгээг өгсөн байна.

График 9. Судалгаанд оролцогчдын Монгол Улсын хэмжээнд хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэж, урьдчилан сэргийлж буй үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ



Үзүүлэлт / Үнэлгээ	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Нийт	Үнэлгээ
Тэмцэж буй хууль эрх зүйн орчин	8* <sup>5</sup>	70* <sup>4</sup>	164* <sup>3</sup>	88* <sup>2</sup>	54* <sup>1</sup>	1202	<b>2.48</b>
	3.32 %	23.29 %	40.93 %	14.64 %	4.49 %		
Тэмцэж буй байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, тогтолцоо	6* <sup>5</sup>	80* <sup>4</sup>	258* <sup>3</sup>	98* <sup>2</sup>	42* <sup>1</sup>	1362	<b>2.81</b>
	2.2%	23.49 %	56.83 %	14.39 %	3.08 %		
Хүний нөөцийн чадавх, мэргэшсэн байдал	6* <sup>5</sup>	70* <sup>4</sup>	214* <sup>3</sup>	130* <sup>2</sup>	64* <sup>1</sup>	1276	<b>2.63</b>
	2.35 %	21.94 %	50.31 %	20.38 %	5.02 %		
Техник, технологийн дэвшлийг ашиглаж буй байдал	6* <sup>5</sup>	52* <sup>4</sup>	206* <sup>3</sup>	130* <sup>2</sup>	90* <sup>1</sup>	1206	<b>2.49</b>
	2.49 %	17.25 %	51.24 %	21.56 %	7.46 %		
Хариуцлагын тогтолцоо	4* <sup>5</sup>	46* <sup>4</sup>	196* <sup>3</sup>	106* <sup>2</sup>	132* <sup>1</sup>	1136	<b>2.34</b>
	1.76 %	16.19 %	51.76 %	18.66 %	11.62 %		
Тэмцэж, урьдчилан сэргийлж буй үйл ажиллагааны үр дүн	2* <sup>5</sup>	58* <sup>4</sup>	218* <sup>3</sup>	130* <sup>2</sup>	76* <sup>1</sup>	1223	<b>2.52</b>
	0.82 %	18.95 %	53.47 %	21.26 %	6.21 %		

Хар тамхи, мансууруулах бодисын талаар “мэднэ” гэж хариулсан оролцогчид Монгол Улсын хэмжээнд хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэж, урьдчилан сэргийлж буй үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ дараах үнэлгээг өгсөн байна.

График 10. Хар тамхи, мансууруулах бодисын талаар мэддэг оролцогчдын Монгол Улсын хэмжээнд хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэж, урьдчилан сэргийлж буй үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ



Үзүүлэлт / Үнэлгээ	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Нийт	Үнэлгээ
Тэмцэж буй хууль эрх зүйн орчин	5 <sup>5</sup>	30 <sup>4</sup>	108 <sup>3</sup>	41 <sup>2</sup>	24 <sup>1</sup>	575	<b>5.58</b>
	4.35%	20.87%	56.35%	14.26%	4.17%		
Тэмцэж буй байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, тогтолцоо	2 <sup>5</sup>	42 <sup>4</sup>	98 <sup>3</sup>	47 <sup>2</sup>	17 <sup>1</sup>	583	<b>5.66</b>
	1.72%	28.82%	50.43%	16.12%	2.91%		
Хүний нөөцийн чадавх, мэргэшсэн байдал	2 <sup>5</sup>	33 <sup>4</sup>	81 <sup>3</sup>	56 <sup>2</sup>	34 <sup>1</sup>	531	<b>5.15</b>
	1.88%	24.86%	45.76%	21.09%	6.4%		
Техник, технологийн дэвшлийг ашиглаж буй байдал	4 <sup>5</sup>	41 <sup>4</sup>	53 <sup>3</sup>	72 <sup>2</sup>	38 <sup>1</sup>	525	<b>5.09</b>
	3.81%	31.24%	30.28%	27.43%	7.24%		
Хариуцлагын тогтолцоо	2 <sup>5</sup>	24 <sup>4</sup>	45 <sup>3</sup>	50 <sup>2</sup>	56 <sup>1</sup>	397	<b>3.85</b>
	2.52%	24.18%	34.0%	25.19%	14.1%		
Тэмцэж, урьдчилан сэргийлж буй үйл ажиллагааны үр дүн	0 <sup>5</sup>	30 <sup>4</sup>	81 <sup>3</sup>	69 <sup>2</sup>	28 <sup>1</sup>	529	<b>5.13</b>
	0%	22.68%	45.94%	26.09%	5.29%		

## ДҮГНЭЛТ

Судалгаанд нийт 512 иргэн оролцсоноос шаардлага хангах 484 асуулгыг сонгон авч дүнг гаргасан. Оролцогчдын 60.7 хувийг 21-30 насныхан, 33.8 хувийг 31-40 насныхан, 3.9 хувийг 41-50 насны, 1.5 хувийг 20 хүртэл насныхан, 0.6 хувийг 61-ээс дээш насныхан эзэлж байна. Эндээс харахад судалгаанд 21-40 насныхан түлхүү хамрагдсан байна.

192 (39.7%) эрэгтэй, 292 (60.3%) эмэгтэй иргэд хамрагдсан нь хүйсийн тэнцвэрт харьцааг хангасан байна. Докторын зэрэгтэй – 18 буюу 3.7%, магистр – 185 буюу 38%, бакалавр – 258 буюу 53.3%, бүрэн дунд боловсролтой 23 буюу 4.7% хэрэглэгчид хамрагдсан байна. 95% дээд боловсролтой иргэд хамрагдсан байна.

Судалгаанд оролцогчдыг амьдарч буй улсаар харуулбал, Монгол Улсаас 373, БНХАУ-аас 78, АНУ-аас 12, ОХУ-аас 5, БНСУ-аас 4, Бразил улсаас 3, Унгар улсаас 3, Япон улсаас 2, Австрали улсаас 2, Ирланд улсаас 1, Швед улсаас 1 иргэд хандсан байна.

Хар тамхи, мансууруулах бодисын талаар ерөнхий ойлголт, судалгаанд хамрагдах чадварыг баталгаажуулах зорилгоор “Хар тамхи, мансууруулах бодисын талаарх таны ойлголт?” гэсэн асуултыг тавьсан бөгөөд үр дүнд нийт 484 оролцогчдын 205 буюу 42.4% нь “мэднэ”, 153 буюу 31.6% “бага зэрэг”, 30 буюу 6.2% нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өгсөн байна. 42.4 хувь нь өөртөө итгэлтэйгээр мэднэ гэж хариулсан нь бидний хувьд хүлээгдээгүй үр дүн байлаа. Нийт оролцогчдын 74 хувь нь “Мэднэ, бага зэрэг мэднэ” гэж хариулсан нь судалгааны үр дүнг илүү бодитой гэдгийг харуулж байна.

Оролцогчид Монгол Улс хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэж чадахгүй байна гэж оролцогчид үзэж байна. Тус гэмт хэрэг гарч буй шалтгаан, нөхцөл, хүчин зүйлс нь хар тамхи, мансууруулах бодисын гол эх сурвалж болох гадаадын борлуулагч нараас худалдан авалт хийж, хил, гаалиар нэвтрүүлэх төрөл бүрийн аргууд байдаг бөгөөд хяналт шалгалт хангалтгүй байгаа холбоотой гэж үзэж байна. Тухайн гэмт хэргийн эсрэг хууль, эрх зүйн орчин нь боловсронгуй болоогүй, хариуцлага, ял оногдуулах чадвар сул байгааг тэмдэглэсэн байна. Мөн зарим оролцогчид энэ төрлийн гэмт хэргийн гол шалтгаан нь зөвхөн хувь хүний ухамсар, мэдлэг доройгоос хамааралтай гэж үзэж байна.

## ТАМХИНЫ ГАЖ НӨЛӨӨ БА ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ

*А.Амарсайхан  
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЭЭЗКТ-ийн ахлах багш,  
цагдаагийн дэд хурандаа  
Ө.Хэрлэн  
Мөн сургуулийн 3512 дугаар дамжааны суралцагч,  
цагдаагийн ахлагч*

Тамхидалт болон тамхины эрүүл мэндэд учруулж буй хор хөнөөл хоёрын харилцан хамаарлын талаар сүүлийн хагас зууны туршид хуримтлуулсан баримт нотолгоо нь цаашид авч хэрэгжүүлэх бодлогын чиглэл, арга хэмжээний шинжлэх ухааны баттай үндэслэлийг бүрдүүлж байна.

Тамхины хэрэглээ дэлхий дахинд жил бүр 6 сая орчим хүний үхлийн шалтгаан болж байна. Ийнхүү олон хүний амь насанд хүрч, улмаар дэлхийн улсуудын хөгжилд сөргөөр нөлөөлдөг.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас 2005 онд Тамхины хяналтын суурь конвенцийг баталснаас хойш дэлхий дахинд болон манай улсад тамхины хяналтын үйл ажиллагаанд ахиц гарч, Тамхины хяналтын тухай хуулийг баталсан боловч хүний хүчин зүйлээр бий болсон эрүүл мэндийн энэхүү гамшгаас урьдчилан сэргийлэхийн тулд Монгол Улс шиг бага болон дунд орлоготой орнуудын Засгийн газрууд тамхины хяналтыг хэрэгжүүлэх хүчин чармайлтаа дахин шинэчлэх шаардлагатай байна.

Шинжлэх ухааны баримт нотолгоо нь хүний зан байдалд хүчтэй нөлөөлж чадаж байгаа эсэхэд олон хүн эргэлздэг болсон энэ эрин үед хувь хүн өөрийн амьдралын хэв маягийг сонгох эсвэл төрийн бодлогыг сонгоход аль ч тохиолдолд хүн төрөлхтнийг урагш хөтлөх луужин нь тэдний итгэл үнэмшил, асуудлын учир шалтгаан хэвээр байна гэдэгт би итгэдэг.

Тамхины хяналтыг дэмжих нь хүний эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэгээс зайлсхийх зэрэг хувь хүний ашиг сонирхлыг зардал бууруулах, орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн үр өгөөжийг сайжруулах зэрэг Засгийн газрын эдийн засгийн ашиг сонирхолтой нийцүүлдэг. Хувь хүний эрүүл мэндийг хамгаалах, улс үндэстний орлогыг бүрдүүлэх, нийгмийн сайн сайхан байдлыг бэхжүүлэх зэрэг нь хүчирхэг хөшүүрэг болох нь эргэлзээгүй!

Тамхи татах болон бусдын татаж буй тамхины утаанд өртөхийн аль аль нь өвчлөл үүсгэхийн зэрэгцээ аажмаар үхэлд хүргэдэг гэсэн шулуухан бөгөөд үнэнийг өгүүлсэн мессеж хүмүүст хүрэх ёстой. Бодит баримт нотолгооноос харахад никотин хэмээх тамхинд агуулагдах химийн бодис:

- Донтолт үүсгэдэг ба ихээр хэрэглэвэл хурц хэлбэрийн хордлого үүсгэдэг;
- Тамхи татсанаар өвчний эрсдэл нэмэгдэж хүний бие махбод дахь биологийн олон сувгуудыг идэвхжүүлдэг,
- Жирэмсэн эмэгтэйчүүдийн хувьд ураг амьгүй төрөх, төрөлхийн согогтой төрөх (жишээ нь, сэтэрхий уруул, амтай төрөх) зэрэг эрсдэлийг нэмэгдүүлэн, эхийн болон ургийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг,
- Ургийн бойжилт болон өсвөр насанд тархины хөгжилд сөргөөр нөлөөлдөг байна.

Тамхи татахад ялгарч буй давирхайт тоосонцор, тамхины бохь нь ч хортой болохыг харуулжээ. Эдгээр нь тамхичин хүний уушгийг аажмаар гэмтээдэг. Тамхины дутуу шаталтын улмаас ялгарч буй нүүрстөрөгчийн дутуу исэл хэмээх өнгөгүй, үнэргүй хий нь өрөө тасалгаанд хуримтлагдаж цусны хүчилтөрөгч дамжуулах чадамжийг бууруулдаг. Тамхи татах нь хүний биеийн бараг бүхий л эд эрхтэний өвчлөлтэй холбоотой гэсэн ноцтой мэдээ бидэнд харанга дэлдэж байна.

Тамхины бүтэц дизайн, орц найрлага сүүлийн үед нэлээд өөрчлөгдсөн учраас тамхи татсаны улмаас уушигны хорт хавдар үүсэх эрсдэл 1950-иад оноос хойш нэмэгдсэн гэсэн дүгнэлт хийх хангалттай баримт нотолгоо цугларчээ. Элэгний хорт хавдар, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар, түрүү булчирхайн хорт хавдар гэх мэт хэд хэдэн төрлийн хорт хавдрууд нь тамхидалттай харилцан хамааралтай болохыг нотлох баримтууд байгааг бид тайлбарлан таниулах нь зүйтэй.

Эмфизема, архаг бронхит гэх мэт уушгины архаг бөглөрөлтөт өвчнийг (COPD) үүсгэгч гол шалтгаан нь тамхидалт бөгөөд сүрьеэгээр өвчлөх эрсдлийг мөн нэмэгдүүлдэг байна. Түүнчлэн чихрийн шижин зэрэг нийтлэг тохиолдох өвчнүүд ч тамхи татсаны улмаас үүсдэг болохыг судалгааны үр дүн харуулсаар байгааг таниулах нь зүйтэй. Тамхи идэвхтэй татдаг хүмүүсийн чихрийн шижингээр өвчлөх эрсдэл тамхи татдаггүй хүмүүсийхээс 30-40 хувь илүү өндөр байгаа гэдгийг эрдэмтэд тогтоосон байна. Тамхины эрүүл мэнд болон нийгэмд үзүүлэх хор хөнөөл нь Монгол улс улам бүр нэмэгдсээр байгаа ба тус улсын эрэгтэйчүүдийн 68,5 хувь, эмэгтэйчүүдийн 30,4 хувь нь тамхи татдаг байна.<sup>48</sup>

Монгол Улсын хүн амын тоо

	2015	2016	2017
Хүн ам	3,057,778	3,119,935	3,177,899
Эрэгтэй	1,503,612	1,533,983	1,562,370
Эмэгтэй	1,554,166	1,585,952	1,615,529

Монгол Улсын 13-аас дээш насны хүн амын тоо

нас	2015 он			2016 он			2017 он		
	Нийт	эрэгтэй	эмэгтэй	Нийт	эрэгтэй	эмэгтэй	Нийт	эрэгтэй	эмэгтэй
13	43,530	22,197	21,333	42,952	22,053	20,899	43,034	21,876	21,158
14	45,593	22,981	22,612	43,507	22,179	21,328	42,930	22,041	20,889
15-19	239,910	121,780	118,130	236,400	119,966	116,434	233,001	118,408	114,593
20-24	267,844	135,073	132,771	255,144	128,877	126,267	244,980	123,701	121,279
25-29	313,709	157,118	156,591	314,540	157,575	156,965	310,730	155,846	154,884
30-34	263,538	130,591	132,947	273,997	136,030	137,967	283,360	140,867	142,493
35-39	232,634	114,492	118,142	236,622	116,417	120,205	241,307	118,861	122,446
40-44	208,439	100,801	107,638	214,112	103,502	110,610	217,532	105,370	112,162
45-49	178,411	84,610	93,801	181,405	86,238	95,167	186,765	88,673	98,092
50-54	152,601	71,155	81,446	159,075	74,040	85,035	161,016	74,828	86,188
55-59	115,125	51,524	63,601	119,888	53,671	66,217	128,739	57,844	70,895
60-64	65,496	28,448	37,048	73,940	32,125	41,815	79,856	34,356	45,500
65-69	43,089	17,781	25,308	43,711	17,837	25,874	47,326	19,410	27,916
70+	71,976	27,964	44,012	73,583	28,425	45,158	75,391	28,967	46,424
	<b>2,241,895</b>	<b>1,086,515</b>	<b>1,155,380</b>	<b>2,268,876</b>	<b>1,098,935</b>	<b>1,169,941</b>	<b>2,295,967</b>	<b>1,111,048</b>	<b>1,184,919</b>

Залуучууд, эмэгтэйчүүдийн дунд тамхидалт нэмэгдэж байгаа нь анхаарах асуудал юм. 1999 онд үндэсний хэмжээнд хийсэн судалгаагаар их, дээд сургуулийн оюутнуудын 86.3 хувь нь тамхи татдаг байжээ. Тамхи анх татаж эхлэх нас нь охидуудад 16.7, харин хөвгүүдэд 17.2 байв. 10-13 насны хүүхдүүдийн хувьд хөвгүүд тамхи татах нь охидуудаас 4 дахин их байсан бол 14-20 насны бүлэгт энэхүү ялгаа нь бараг арилдаг байна.<sup>49</sup>

Зүрх судасны зарим өвчин, хорт хавдар зэрэг тамхитай холбоотой өвчлөл нэмэгдэж, Монголын хүн амын нас баралтын тэргүүлэх хоёр шалтгаан нь болоод

<sup>48</sup> Н. Нямдаваа, Ж. Чинбүрэн Элэгний анхдагч өмөнтэй холбоотой хүн амын мэдлэг, хандлага, дадлын судалгаа. УБ. 2003 ([www.moh.mn/moh%20db/HealthReports.nsf](http://www.moh.mn/moh%20db/HealthReports.nsf))

<sup>49</sup> Өсвөр үеийнхний эрүүл мэндийн мэдлэг, дадлага, хандлагын судалгааны тайлан, ЭМЯ ба ДЭМБ, УБ, 1999



байна.<sup>50</sup> Тухайлбал, уушигны өмөн Монгол эрэгтэйчүүдийн хавдрын нас баралтын хоёр дахь, эмэгтэйчүүдийн тав дахь тэргүүлэх шалтгаан болж байна.<sup>51</sup>

Тамхины хяналтыг бодлогын тэргүүлэх чиглэл болгох улс төрийн хүсэл эрмэлзэл Монгол Улсад үгүйлэгдсэн хэвээр байна. Тамхины хяналттай холбоотой бодлогын баримт бичгүүдийн батлагдсан огноог харахад л тамхины хяналтын асуудалд улс төрийн манлайлал хэр чухал болохыг мэдэж болно. Манай улсын тамхины хяналтын талаарх анхны бодлогын баримт бичиг болох Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хууль ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр 1993 онд батлагдсан. 1996 онд тамхины хяналтын талаар бодлогын 4 баримт бичиг батлагджээ.


2000-2004 онд тамхины хяналттай холбоотой 12 бодлогын баримт бичиг, үүн дотор ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц (ТХСК)-д нэгдэн орж, соёрхон баталсан. 2005 онд Мөн Тамхины хяналтын тухай хууль, Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр зэрэг нь батлагдсан.

Нэг хүнд ноогдох тамхины хэрэглээг олохдоо хүн амын тамхи татаж, хэрэглэж болох буюу 13 наснаас дээш насны хүн амын тоог сонгон авч 13 наснаас дээш хүн амын тухайн жилийн нийт гарсан тоог тухайн жилд импортоор орж ирж буй янжуур тамхины сая ширхэг болон дүнсэн тамхины тонн хэмжээг харьцуулан гаргав.


Монгол Улсын хэмжээнд жилд 1 хүнд ноогдох янжуур тамхины хэрэглээ

Нэр төрөл	2015	2016	2017
Янжуур тамхи /ширхэг/	904	990	1264
Янжуур тамхи / хайрцагаар тооцвол/	45	50	63

**Монгол Улсын хэмжээнд жилд 1 хүнд ноогдох янжуур тамхины хэрэглээ / 13 наснаа дээш/**



Монгол Улсын хэмжээнд жилд 1 хүнд ноогдох дүнсэн тамхины хэрэглээ:



Дээрх судалгаанаас үзэхэд жил ирэх тусам 13-аас дээш насны хүн амын тоо буурсан байдал ажиглагдаж байгаа боловч импортоор орж ирсэн янжуур тамхины тоо өссөн байдал харагдаж байна.

<sup>50</sup> Эрүүл мэндийн статистик мэдээ, ЭМЯ, УБ, 2005

<sup>51</sup> Хорт хавдрын статистик мэдээ, Хавдар судлалын төв, УБ, 2005

Хамгийн гол нь бид эрүүл мэндэд нөлөөлж буй шалтгаануудыг тамхинд тавих хяналтын эдийн засгийн асуудалтай холбон авч үзэх шаардлагатай. Америкийн Нэгдсэн Улс болон бусад улс орнуудад тамхидалттай холбоотой үүсэх эдийн засгийн өртөг зардал асар өндөр байгааг сүүлийн үеийн судалгаа нотолжээ. Тамхины татвар болон тамхины хэрэглээг зохицуулах, хянахад чиглэсэн бусад арга хэмжээг хэрэгжүүлснээр гарсан эрүүл мэндийн үр өгөөж нь татвар, үнэ нэмэгдүүлэх зэргээс илүүтэй байгаа төдийгүй бага орлоготой өрхүүдийн хүртэх үр өгөөж нь харьцангуй их болохыг Чилид хийсэн судалгаа болон 2012 онд Филиппинд хийсэн "тамхины татварын шинэчлэлийн" үр дүнгээр бид баталж чадахаар байна. Армени, Колумб, Лесото, Молдав, Нигери, Украин зэрэг улс орнуудад загвар болгон хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд тамхины татварыг нэмэгдүүлснээр үнэ, хэрэглээ, дотоодын орлогын бүрдүүлэлтэнд нөлөөлөх нөлөөллийг найдвартай тооцоолох замаар бодлого боловсруулах үйл явцыг мэдээллээр хангах боломжтой.


Тамхины хяналтын талаарх манай улсын үндэсний бодлогод хамтрагч талуудыг дайчлах, тэдний идэвхитэй оролцоог хангахад зайлшгүй шаардлагатай тамхины хяналтыг зохицуулах үндэсний механизм бүрдүүлэх асуудал тусгагдаагүй. Бодлогын нэг ч баримт бичигт тамхины хяналтын үндэсний зохицуулах механизм байгуулна гэсэн заалт үгүй байна. Засгийн газрын 2002 оны 149-р тогтоолоор байгуулагдсан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хороо нь нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг зохицуулах үүрэгтэй тул тус хороо нь тамхины хяналтыг зохицуулах механизмын үүргийг гүйцэтгэнэ гэж албаны хүмүүс хэлж байгаа боловч Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хороо нь байгуулагдсан цагаасаа хойш тамхины хяналтын асуудлыг хэлэлцээгүй байна. Цаашилбал, 2005 онд Монгол Улс ТХСК-д нэгдсэнээс хойш батлагдсан Тамхины хяналтын тухай хууль нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, стандартчиллын үндэсний зөвлөл зэрэг байгууллагуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлсноор тамхины хяналтын асуудал дахь салбар хоорондын оролцоог хязгаарласан гэж үзэж болохоор байна.

Тамхины хяналтын тухай хуульд онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгөөс бүрдэх эрүүл мэндийг дэмжих сан байгуулж, сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай санд төвлөрүүлнэ гэж заасан нь тамхитай тэмцэх үйл ажиллагааны санхүүжүүлтийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох ач холбогдолтой болжээ.

Тамхины хяналтын тухай хуульд тамхины татварыг тасралтгүй нэмэгдүүлэх замаар тамхины хяналт, хүн амын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тогтвортой санхүүжүүлж, насанд хүрээгүй иргэнийг тамхинд орохоос сэргийлэх, тамхины хэрэглээг бууруулах зарчмыг баримтална гэж заасан нь ТХСК-ийн бодлогыг дэмжсэн байна. Онцгой албан татварын тухай хуулинд 1995, 1997, 1999, 2000, 2001, 2004 онуудад нэмэлт өөрчлөлт оруулах замаар тамхинд ногдуулах онцгой албан татварыг зургаан удаа нэмсэн байна. Одоогийн байдлаар бүх төрлийн янжуур болон бусад тамхинд онцгой албан татвар ногдуулах ба эх орны үйлдвэрийн бараа бол 100 ширхэг тутамд 0,60, импортынх бол 100 ширхэг тутамд 0,30; дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины 1 кг тутамд эх орны үйлдвэрийнх бол 0,30, импортын бол кг тутамд 0,30 ам долларын татвар ногдуулахаар заажээ.


Монгол Улсын Үндэсний Статистикийн хорооны 2016, 2017 оны эцсийн гол нэрийн бүтээгдэхүүний импортын тоон мэдээнээс харахад, 2016 оны жилийн эцсээр **янжуур 2247.1 сая ширхэг, 49998,8 ам.доллар, дүнсэн тамхи 302,5 тн, 1719.4 ам.доллар**, 2017 оны жилийн эцсээр **янжуур 2901,7 сая ширхэг, 56717,4 ам.доллар, дүнсэн тамхи 226,0 тн, 1283,8 ам.доллар** байгаа тухай статистик үзүүлэлт гарсан байна.

### Импортоор орж ирж байгаа янжуур тамхи /ширхэг/



Манай улс дэлхийн 30 гаруй орноос тамхи импортолдог. Үүний ихэнхийг нь Казакстан, Украин, ОХУ, БНСУ, Сингапур зэрэг орноос импортолдог. 2015-2017 оны хооронд нийт импортоор орж ирсэн янжуур тамхины тоо ширхэг / тэрбумаар/.

### Импортоор орж ирж байгаа дүнсэн тамхи /тонно/



2015-2017 оны хооронд нийт импортоор орж ирж байгаа дүнсэн тамхин /тонноор/. Монгол Улсын хэмжээнд сүүлийн 3 жил импортоор орж ирж байгаа дүнсэн болон

янжуур тамхины харьцаа, үнийн дүн ам.доллараар:

Нэр төрөл	2015	2016	2017
Дүнс тамхи /тонн/	302,400	302,500	226,010
Дүнс тамхи үнэ /ам.доллар/	1702,9	1719,4	1283,75
Янжуур тамхи /ширхэг/	2,026,200,000	2,247,100,000	2,901,700,000
Янжуур тамхи үнэ /ам. доллар/	52,239,4	49,998,8	56,717,39

Олон нийтийн газар тамхи татахыг бүрэн хориглоогүй байна. 2005 оны Тамхины хяналтын тухай хуульд нийтийн тээврийн хэрэгсэлд утаат тамхи татахыг хориглосон боловч ажлын байр болон олон нийтийн бусад газруудад тусгайлан заагдсан цэгүүдэд тамхи татахыг зөвшөөрчээ. Мөн нийтийн хоолны газруудад хоёр ба түүнээс дээш үйлчилгээний танхимтай газрууд л тамхи татдаггүй хүмүүст зориулсан тусгай танхим ажиллуулна гэжээ.

Тамхины эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний талаар мэдээллийг тамхины сав баглаан дээр байрлуулахыг шаардсан хууль тогтоомжийн заалтууд хоорондоо зөрчилдөж байна. Тухайлбал, Янжуур тамхины стандартад тамхины хайрцаг, боодол дээр эрүүл мэндэд нөлөөлөх хор хөнөөлийн талаар монгол, англи хэлний аль нэгээр бичдэг. Ингэхдээ янжуурын хайрцгийн ар, өвөр 2 талын нүүрний 20 хувь-иас доошгүй талбайг эзэлсэн цагаан дэвсгэр дээр тод үсгээр бичиж, хараар хүрээлсэн байх ёстой бөгөөд энэ мэдээллийг тамхины хайрцгийг онгойлгох үед гэмтэж болох хэсэгт бичиж болохгүй хэмээн заажээ.

Тамхины хяналтын тухай хуульд тамхи нь эрүүл мэндийн хор нөлөөний тухай монгол хэлээр бичсэн анхааруулгатай байна.<sup>52</sup> Анхааруулга нь тамхины хайрцагны эргэн тойрны гадаргууны гуравны нэгээс багагүй тайлбайг эзэлсэн байх, тамхин бүтээгдэхүүнээс хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөний талаар том хэмжээтэй, харагдахуйц, гаргацтай бичих, зураг буюу дүрсээр харуулах шаардлагыг хангасан байх ёстой ажээ.

<sup>52</sup> Тамхины хяналтын тухай хууль

Тамхины хяналтын тухай хуулинд (2005) тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчдын зүгээс тамхины хорт бодисын агууламж, ялгарах хэмжээг үнэн зөвөөр мэдээлэхийг шаардсан заалт байхгүй.

Эрүүл мэндийн сайдын “Тамхины хор хөнөөлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 1994 оны А/15 тоот тушаал, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 194 тоот тушаалд монгол улсад импортлох, үйлдвэрлэх тамхины найрлага дахь никотин, бохины зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоосон ба тамхинд агуулагдаж буй бохь, никотины хэмжээг тамхины хайрцаг, сав баглаан дээр заасан байна гэжээ.

Тамхины хяналтын хуульд тамхи болон тамхины үйлдвэрийн нэр, тэмдэг, түүнтэй холбоотой зураг ашиглах замаар тамхийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, кино, интернет, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз болон бусад биет байдлаар сурталчлахыг хориглосон. Зар сурталчилгааны тухай хуульд хуулиар сурталчлахыг хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчлах, Олон нийтийн радио телевизийн тухай хуульд олон нийтийн радио телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно гэсэн заалтуудад тамхины зар сурталчилгааг хамааруулж болохоор байна.

Тамхины хяналтын тухай хуулиар хайрцаг, сав, баглаа боодол дээр онцгой албан татварын тэмдэг, үйлдвэрлэсэн улс, он, сар, үйлдвэр, импортлогчийн нэр, Монгол улсад худалдахыг зөвшөөрсөн тухай тэмдэглэлгүй тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдахыг хориглосон. Мөн “Монгол улсад үйлдвэрлэв” гэсэн шошготойгоор бусад улсад үйлдвэрлэсэн тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдахыг хориглосон байна.

Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйлдвэрлэгдэж, хадгалагдаж, худалдаалагдаж буй тамхины хөдөлгөөнийг хянах, баримтжуулах, хянах үндсэн хэрэгслүүд нь тамхины үйлдвэрлэл, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл, тамхинд ногдох онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн татвар байхаар холбогдох хуулиудад тусгасан байна.

2001 оны Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхэлнэ гэж заажээ.

2005 оны Тамхины хяналтын тухай хуульд тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүнс, хөдөө, аж ахуйн, тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Засгийн газар, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сум, дүүргийн засаг дарга олгоно гэсэн нь тамхины үйлдвэрлэл, худалдааг лицензжүүлэх ажлын эрх зүйн орчныг нь бүрдүүлжээ.

Тамхийг хүүхдэд худалдах, тэднээр худалдуулах тухай асуудал өөрөө Монгол улсын нийгмийн хамгийн том гаж зан үйл, зүй бус үзэгдэл юм. Энэ ч үүднээсээ Монголын ирээдүй болсон хойч үе минь жил ирэх тусам тамхи татах, хэрэглэх, бүр байнгын хэрэглээ болгож байгаа нь харамсалтай.

Монгол Улсын Статистикийн үндэсний хорооны жил бүр гаргадаг тоон мэдээлэл дээр үндэслэн өсвөр насны хүүхдүүдийн тоон мэдээлэл болон тэдэнтэй харьцах тамхины хэрэглээг гаргах гэж зорилоо. /Энэ нь мөн л 13-15 насны өсвөр үеийн хүүхэд бүрийг тамхины тодорхой хэмжээний хэрэглээтэй байдаг гэдэг үүднээс хийсвэрлэн гаргасан тоон дүгнэлт болно./

Нийт хүн амд эзлэх 13-15 насны өсвөр насны хүүхдийн тоо

Нэр	2015	2016	2017
Өсвөр насныхан	137,420	132,016	129,448

Импортоор орж ирж буй янжуур тамхи болон дүнсэн тамхины тоон мэдээг 13-аас дээш насны бүх хүн амд харьцуулсан болон зөвхөн 13-15 насны хүн амын тоонд харьцуулсан тоон хүснэгт.

Нэр	2015	2016	2017
Өсвөр насныхан нийт тоо	137,420	132,016	129,448
Янжуур тамхи 1 хүнд ноогдох хэмжээ /ширхэг /	904	990	1264
13-15 насны хүнд жилд ноогдох тамхи	124,227,680	130,695,840	163,622,272

Хүснэгтээс харахад 13-15 насны өсвөр насны хүн ам болгоныг тамхины хэрэглээтэй гэж үзэхэд нэг хүнд ноогдох тоо хэмжээ өссөн үзүүлэлт харагдаж байгаа бөгөөд тухай насны хүн амын тоо жил ирэх тусам буурсан байна.

Тамхины хэрэглээг ширхэгээр болон хайрцгаар авч үзвэл:



Дэлхийн залуучуудын тамхины хэрэглээний судалгаа нь үндэсний хэмжээнд 2014 оны 3-6 саруудад ДЭМБ, Америкийн Нэгдсэн Улсын Өвчин судлалын төвөөс хийсэн судалгааны аргачлалын дагуу Улаанбаатар хот болон хөдөө, орон нутгийн 13-15 насны сурагчид, сургуулийн тамхины хяналтын бодлогын судалгааг сургуулийн ажилтнуудыг оролцуулан хийж гүйцэтгэсэн байна.

Судалгаанд нийт 60 сургууль сонгогдсоноос 100 хувь, 266 анги сонгогдсоноос 100 хувь, нийт 7911 сурагч хамрагдсанаас 7298 нь судалгааны асуумжийг бүрэн хариулсан хамрагдалт 92.3 хувь байна. Судалгааны хураангуй тойм үр дүнгээс дурьдвал, нийт судалгаанд оролцсон сурагчдын **14.3 хувь**, үүнээс хөвгүүдийн **20.3 хувь**, **охидын 8.3 хувь** одоогоор ямар нэгэн тамхин бүтээгдэхүүн хэрэглэж байна. Мөн нийт сурагчдын 5.6 хувь, хөвгүүдийн 8.2 хувь, охидын 2.9 хувь одоогоор **утаат тамхи** татаж байна. Нийт сурагчдын 9.5 хувь, хөвгүүдийн 13.6 хувь, охидын 5.7 хувь одоогоор **утаагүй тамхи** хэрэглэж байна. Янжуур тамхи татагчдын 70.4 хувь нь тамхиа дэлгүүр, гудамжны худалдаачин, ТҮЦ-нээс авдаг. Тамхи худалдан авсан тамхи татдаг сурагчдын 51.4 хувьд тамхи худалдан авахад тэдний нас нь саад болж байгаагүй.

Судалгаанд хамрагдсан 10 сурагчийн 6 нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр тамхины эсрэг сурталчилгааг харсан. 10 сурагчийн 1 нь тамхи худалдаалж буй газарт тамхины зар сурталчилгаа, тамхины хэрэглээг дэмжсэн сурталчилгааг харсан. Мөн 10 сурагчийн нэгд тамхины брэндийн лого бүхий ямар нэгэн зүйл байдаг. Мэдлэг, хандлага нь сурагчдын 36.4 хувь нь бусдын тамхи таталт өөрсдөд нь хортой болох тухай бодож байсан. Сурагчдын 90.3 хувь нь хаалттай олон нийтийн газар тамхи татахыг хориглохыг дэмждэг.<sup>53</sup>

Тамхи татдаг сурагчид тамхинаас гарах, татгалзах оролдлого хийж байсан байна. Тамхи татдаг 10 сурагч тутмын 8 нь сүүлийн 12 сард тамхинаас гарах оролдлого хийсэн байна. Тамхи татдаг 10 сурагчийн 8 нь тамхинаас гарахыг хүсдэг байна. Тамхи татдаг сурагчид тамхинаас гарах, тамхины эсрэг сурталчилгааг харсан байдаг. Үүнээс үзэхэд 10 тамхи татдаг сурагч тутмын 9 нь тамхиа хаяхыг хүсдэг 10 сурагч тутмын 7 оос илүү нь сүүлийн 30 хоногт тамхины эсрэг сурталчилгаа үзсэн, 10 сурагч тутмын 6 нь сүүлийн 30 хоногт тамхины сурталчилгаа бүхий гудамжны самбар харсан, 10 сурагч тутмын 4 нь сонин сэтгүүл дээрээс тамхины сурталчилгааг харсан.<sup>54</sup>

Тамхины хяналтын тухай хуульд 18 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, тэднээр тамхи худалдуулахыг хориглосон бөгөөд энэ заалтыг зөрчсөн иргэн, албан хаагч, хуулийн этгээдийг торгох, тамхи болон хууль бусаар олсон орлогыг хураах зэрэг шийтгэл оногдуулахаар заажээ.

Тамхины хяналтын тухай хуульд тамхийг ширхэглэн худалдах, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдахыг хориглосон байна. **Улсын хэмжээнд 2018 оны эхний 10 сарын байдлаар Тамхины хяналтын тухай хуулиар нийт 469 зөрчил бүртгэгдсэнээс иргэн 450, хуулийн этгээд 2, нийт 103960000 төгрөгний торгуулийн** арга хэмжээ авагдсан тоон мэдээ байна. Өмнөх

<sup>53</sup> Монгол улс, (13-15 насны) үндэсний судалгаа, дэлхийн залуучуудын тамхины хэрэглээний судалгаа (дэтхс) баримтын цомог

<sup>54</sup> Мөн тэнд

онуудын хувьд энэхүү тоон мэдээг гарах боломжгүй бөгөөд энэ оноос эхлэн Цагдаагийн байгууллагын цахим бүртгэл, судалгааны санд өөрчлөлт оруулсанаар тамхины хяналтын тухай хуулийг зөрчлийн хуульд тусгайлан зааж өгснөөр тамхины талаарх зөрчлийн тоон мэдээг харж болох эерэг талтай болсон байна.

### **Дүгнэлт**

Судалгааны дүнгээс үзэхэд, манай улсын тамхины хяналтын үндэсний бодлого ТХСК-ийн зорилт, үндсэн зарчмуудтай нийцэж байгаа ч хуулийн зарим заалтууд тодорхой бус, хоорондоо зөрчилдсөн, тамхины хяналтын бодлогын хэрэгжилт туйлын хангалтгүй байна.

Онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгөөс бүрдэх эрүүл мэндийг дэмжих сан байгуулж, сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай санд төвлөрүүлнэ гэсэн хуулийн заалт байдаг боловч уг сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хомс байна. Олон нийтийн газар тамхи татахыг бүрэн хориглоогүй, ажлын байр болон олон нийтийн бусад газруудад тусгайлан заагдсан цэгүүдэд тамхи татахыг зөвшөөрсөн байна.

Тамхины сурталчилгааг гурван хууль (Тамхины хяналтын тухай, Зар сурталчилгааны тухай, Олон нийтийн радио телевизийн тухай хууль)-иар хориглосон боловч тамхи үйлдвэрлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнийг мэдээллийн бүхий л сувгаар чөлөөтэй сурталчилж, түүнийгээ эрүүл мэндэд хоргүй мэт ташаа мэдээллийг олон нийтэд хүргэсээр байна.

Тамхины хяналтын тухай хуульд 18 нас хүрээгүй хүнд тамхи худалдаалахыг хориглосон байдаг хэдий ч энэ хууль амьдрал дээр хэр хэрэгжиж байгааг Дэлхийн залуучуудын тамхины хэрэглээний судалгаа нь үндэсний хэмжээнд 2014 оны 3-6 сард ДЭМБ, АНУ-ын Өвчин судлалын төвөөс боловсруулсан судалгааны аргачлалын дагуу Улаанбаатар хот болон хөдөө, орон нутгийн 13-15 насны сурагчид, сургуулийн тамхины бодлогын судалгааг сургуулийн ажилтнуудыг оролцуулан хамруулан хийж гүйцэтгэсэн нэгэн агшны судалгааны дүнгээс харагдаж байгаа байх. Өсвөр насны хүн ам тамхи хэрэглэж байгаа нь өөрөө тамхины гаж зан үйл болж байна гэж үзэж байна. Цаашилбал, тамхины хяналтын талаар төрөөс хийж чадах зүйл хомс, хувь хүн өөрөө л тамхи үйлдвэрлэгч, худалдаачдын арганд орохгүй байх нь чухал гэсэн үзэл санааг хүн бүр өөртөө хэрэгжүүлэх нь зүйтэй.

### **Санал**

- Төрийн бодлого, шийдвэр гаргагч нарт чиглэсэн тамхины хяналтын асуудлаар улс төрийн манлайлал бий болгох;
- Тамхины хяналтын бодлогын бичиг баримтуудыг ТХСК болон өөр хооронд нь уялдуулан нийцүүлэх;
- Сургуулийн байгууллагын үйл ажиллагаанд тамхины хяналтын бодлого, хөтөлбөрүүдийг бэхжүүлэх;
- Тамхи үйлдвэрлэгчдийн ташаа, төөрөгдүүлсэн мэдээллийн эсрэг шинжлэх ухааны нотолгоо бүрдүүлэх судалгааны ажлуудыг хийх;
- Тамхины эдийн засгийн үр нөлөөний үнэлгээ хийх;
- Тамхи үйлдвэрлэгчдийн сурталчилгааны талаарх тайланд дүн шинжилгээ хийх;
- Тамхины хяналтыг сайжруулж, хөрш зэргэлдээ орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, гадаадын орнуудын тамхины хэрэглээнээс татгалзаж, хэрэглээгээ багасгасан туршлага, түүхийг судлах.

## ХОРИХ ЯЛ БА АМИА ХОРЛОЛТ (ЯЛТНЫ СЭТГЭЛ ЗҮЙН ОНЦЛОГ)

*С.Эрдэнэболор, Б.Досжан  
Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн  
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш*

### Оршил

Эрүүгийн хариуцлагын зорилго нь МЭӨ үеийн “Амийг амиар, шүдийг шүдээр” гэсэн өр төлөөсийн систем бүхий хариуцлагын тогтолцооноос нийгмийн хөгжлийн явцад татгалзаж ялтанд хүнийхээ хувьд эрх байх ёстой, харин ямар эрхийг нь хэрхэн хязгаарлах вэ гэдгийг эрдэмтдийн судалгааны үр дүнгээр тодорхойлох шаардлагатай гэдэг үзэл хандлага зонхилж байна.

Эрүүгийн хариуцлагын зорилго, түүний мөн чанарыг илэрхийлэх олон онол, сургааль байдаг боловч орчин үед суурь ухагдахуун болгон эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэмээн үзэж байна. Хорих ялын хугацаа болон бүх насаар хоригдох ялтанд ял эдлэх хугацаанд нь олгож буй тодорхой төрлийн эрхүүдээр эрүүгийн хариуцлагын эцсийн зорилгод шууд хүрэх боломжтой юу?

2015 оны Эрүүгийн хуульд тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээд бүх насаар хорих ял шийтгүүлсэн бол түүнд ял эдлүүлэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлийн тусгай нэгжид эдлүүлнэ гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг бүх насаар хорих ойлголт Монгол Улсын хувьд харьцангуй шинэлэг юм.

Бүх насаар хорих ял эдлүүлж буй олон улсын туршлагаас үзвэл, ял эдэлж буй этгээд амиа хорлох байдал ихээхэн тохиолддог байна. Зарим тохиолдолд эвтанази /үхэх эрх/ эрхийг хүлээн зөвшөөрсөн орнуудад ялтан уг эрхээ эдлэхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүсдэг байна. Дээр дурдсан нөхцөл байдлуудыг зөвхөн хууль зүйн шинжлэх ухааны үүднээс судалж, үүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг нь тэмдэглэх нь хангалтгүй бөгөөд уг асуудлыг социологи, психологийн шинжлэх ухаан талаас нь мөн авч үзэх, тодорхой жишээ баримтыг хөндөн тайлбарлах шаардлагатай байна.

### Бүх насаар хорих ял

Дэлхийн улсуудад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын дараах нийтлэг төрлүүд байдаг. Үүнд: эрх хасах, хохирол нөхөн төлүүлэх, эх орноосоо хөөх, нутаг заах, ялтны хувийн эд хөрөнгийг хураах, олсон орлогыг хураах, эрхтнээс нь хагацаах, гэрээр хорих, зорчих эрхийг хязгаарлах, хугацаатай болон хугацаагүй хорих, цаазаар авах зэрэг ялыг хэрэглэж байна. Сүүлийн жилүүдэд улсууд зарим төрлийн ялаас татгалзаж байна. Үүний нэг нь цаазаар авах ял юм. Цаазаар авах ялаас татгалзсан улсууд нь уг ялын оронд бүх насаар хорих (хугацаагүй хорих) ялыг сонгон хэрэглэх болжээ.

Бүх насаар хорих ял анх 1982 онд Хүний Эрхийн Европын конвенцийн 6 дугаар протоколоор цаазаар авах ялыг халснаар<sup>55</sup> 1990 оноос Европын холбооны улсуудад хэрэгжиж эхэлсэн. 2013 оноос өнөөдрийг хүртэл Беларус улсаас бусад Европын холбооны улс орнуудад цаазаар авах ялыг хэрэглэсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.<sup>56</sup>

Дэлхийн ихэнх улс цаазаар авах ялыг халахыг эсэргүүцэж байсан учир уг ялыг орлохуйц хэмжээний ялыг бий болгосноор олон нийтийн санаа бодлыг өөрчлөх боломжтой болсон боловч бүх насаар хорих ялыг хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийн тусгаж өгөөгүй. Сүүлийн 25 жилийн хугацаанд Европын улсуудад бүх насаар хорих ял шийтгэгдсэн ялтнуудын тоо эрс өссөн. 2014 оны байдлаар Европын 22 улсад 27.000 хүн бүх насаар хорих ял шийтгэгдсэн байгаа бөгөөд сүүлийн 10 жилд уг ялыг оногдуулах байдал 66 хувиар өссөн.<sup>57</sup>

Бүх насаар хорих ял нь уг ялаар шийтгэгдсэн этгээдийн үлдсэн амьдралын хугацаа дуусах эсхүл нийтэд аюул заналхийлэл учруулах нөхцөл байдал арилсан гэж үзэн шүүхээс

<sup>55</sup> <https://www.amnesty.mn/files/aim/docs/files/2010/03/file-76.pdf>.

<sup>56</sup> 2016 онд Европын холбооноос бүх насаар хорих ял шийтгүүлсэн ялтангуудын талаар хийгдсэн судалгааны тайлан <https://rm.coe.int/1680727f90>

<sup>57</sup> 2016 онд Европын холбооноос бүх насаар хорих ял шийтгүүлсэн ялтангуудын талаар хийгдсэн судалгааны тайлан <https://rm.coe.int/1680727f90>

суллах хүртэл үргэлжлэх ялын төрөл юм. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн ялтан тодорхой хугацаанд хоригдсоны дараа суллуулах тухай хүсэлтээ шүүхэд гаргана, энэхүү тодорхой хугацаа нь улс болгоны хувьд харилцан адилгүй байдаг бөгөөд хамгийн богино хугацаа 12 жил бөгөөд Дани, Финланд улсад уг хагацааг баримтална. Австри, Бельги, Герман, Швед зэрэг улсад 15 жил, Турк улсад 40 жил<sup>58</sup>, Монгол Улсын хувьд 25 жил байна.<sup>59</sup> Англи Улсын хувьд тодорхой хугацааг хуульд зааж өгөөгүй бөгөөд бүх насаар хорих ял шийтгэсэн шүүгч энэхүү хугацааг шийдвэртээ тусгаж өгөхөөр хуульчилжээ. Болгар, Литви, Мальта, Недерланд, Унгар, Словак зэрэг улсад тодорхой хугацаа зааж өгөөгүй учир бүх насаар хорих ял шийтгүүлсэн ялтан нас барах хүртлээ уг ялыг эдэлдэг байна.

Европын холбооноос бүх насаар хорих ял эдлүүлэх ажиллагааны явцтай танилцах зорилгоор байгуулсан ажлын хэсэг Европт бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн ялтны ял эдэлж буй хорих байгууллагуудад судалгаа хийж, ял эдэлж буй этгээдүүдийн нөхцөл байдалтай танилцахад хорих байгууллага бүр харилцан адилгүй байсан. Тухайлбал, ихэнх улс орнуудад бүх насаар хорих ялаар шийтгэгдсэн ялтныг бусад ялтнуудтай хамт хорьж зарим байдлаараа адилхан эрх, үүрэг эдэлнэ хэмээн хуульчилжээ. Энэ нь тухайн этгээдийг нийгэмшүүлэх зорилгоор хорих байгууллагаас зохион байгуулдаг ажил эрхлэлт, тодорхой төрлийн мэрэгшүүлэх сургалт зэрэгт хамрагдах явдал юм.<sup>60</sup>

Гэвч Армен, Азербайжан, Болгар, Гүрж, Литви, Молдав, Румын, Орос, Турк, Украин зэрэг улс бүх насаар хорих ял шийтгэгдсэн ялтныг ганцаарчилсан хорьж бусад ялтнуудаас тусгаарладаг.<sup>61</sup> Цөөнгүй улсад бүх насаар хорих ял шийтгэгдсэн ялтнуудын эрх зөрчигдөж байгааг тодорхой дурджээ. Тухайлбал, ялтан ганцаарчилсан тасалгаандаа нийт 23 цаг бусад ялтнуудтай үл харьцах байдлаар хорих тасалгааны гадна ажил хөдөлмөр эрхлэх боломжгүйгээр ялаа эдлэх, ганцаарчилсан тасалгаанаас гадагш гаргах тохиолдолд гавалсан байдалтайгаар гарах, ганцаарчилсан тасалгааны хаалга нээгдэх бүрт ялтан өөрийн яллагдсан зүйл ангийг дурдах, бусад ялтнаас өөр өнгийн хувцас өмсөх үүрэгтэй.

Хэдийгээр бүх насаар хорих ял шийтгэгдсэн ялтан аюултай гэмт хэрэгтэн боловч хүн гэдэг утгаараа тодорхой эрхүүд буюу түр болон урт хугацааны уулзалт, захидал илгээх, илгээмж хүлээн авах зэрэг нь бусад ялтнуудтай харьцуулахад хангалтгүй байгааг тодорхойлж, энэ шалтгаан болон дээр дурдсан шалтгаануудаас үүдэн ялтан амиа хорлох байдал гарах болсон гэж Европын холбооноос томилсон ажлын хэсэг үзэж байна.

Турк Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 25 дугаар зүйлд бүх насаар хорих ял эдэлж буй ялтны эрх, үүргийг тусгасан байна. Үүнд: ялтанг ганцаарчилсан тасалгаанд ялыг нь эдлүүлэх, ялтан өдөрт 1 цаг хүртэл хугацаагаар гадааллах, спортоор хичээллэх, ялтны засрал хүмүүжлийн байдлыг харгалзан үзэж гадааллах, спортоор хичээллэх хугацааг нэмэгдүүлж болох бөгөөд үүний нэгэн адил түүнтэй адил нэгид хоригдож буй бусад ялтантай харилцаа холбоо тогтоох эрх эдлүүлэх, ялтан 15 өдөрт нэг удаа 10 минутаар гэр бүлийн гишүүдтэйгээ утсаар ярих, ялтан 15 өдөрт нэг удаа гэр бүлийн гишүүд мөн тэдгээрийг орлох хүмүүстэй нэг удаа 1 цагаас хэтрэхгүйгээр түр хагацааны уулзалт хийх боломжтой, ялтанг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлэх боломжтой.<sup>62</sup>

Дээрх хуульд тусгалаа олсон бүх насаар хорих ял эдэлж буй ялтанд олгосон эрхийг Европын холбооны ажлын хэсэг судалж үзээд, мөн хангалтгүй гэж үзсэн гэвч Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 200 дугаар зүйлд хоригдлыг ганцаарчилсан тасалгаанд хорих бөгөөд шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдүүдийн зөвшилцлийн үндсэн дээр хоригдлыг хоёроор нь хорьж болно, өдөрт 1 цагаас доошгүй хугацаагаар гадаалуулна, зөвхөн хорих ангийг байранд хөдөлмөрлүүлнэ, 180 хоногт 2 удаа түр уулзалт хийх 30 хоногт нэг удаа захидал явуулж, 90 хоногт нэг удаа илгээмж авч болохоор хуульчилжээ<sup>63</sup> энэ зүйл заалт чухам шинжлэх ухааны үндэслэлтэй эсэх нь маргаантай юм.

Цаазаар авах ялыг халж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд бүх насаар хорих ял ноогдуулах болсоноор хүний эрхийн зарим асуудлыг эргэж харах шаардлага зүй ёсоор

<sup>58</sup><https://www.coe.int/it/web/cpt/-/council-of-europe-anti-torture-committee-calls-upon-states-to-review-the-treatment-of-life-sentenced-prisoners>.

<sup>59</sup> <https://www.legalinfo.mn/law/details/12701?lawid=12701>.

<sup>60</sup> [http://aciktoplumvakfi.org.tr/pdf/CISST\\_Agirlastirilmis\\_Muebbet.pdf](http://aciktoplumvakfi.org.tr/pdf/CISST_Agirlastirilmis_Muebbet.pdf)

<sup>61</sup> 2016 онд Европын холбооноос бүх насаар хорих ял шийтгүүлсэн ялтангуудын талаар хийгдсэн судалгааны тайлан <https://rm.coe.int/168072f90>

<sup>62</sup> Турк улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль <https://www.tbmm.gov.tr/kanunlar/k5275.html>.

<sup>63</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль //Төрийн мэдээлэл. №



тавигдаж байна. Нэгэн гүн ухаантны хэлснээр “Хүн бол нийгмийн амьтан юм” тэгвэл хүнийг бүх насаар нь нийгмээс тусгаарлавал хүн гэдэг мөн чанараа алдана. Магадгүй энэхүү мөн чанар алдагдснаар хүн өөрийн амийг хорлох шалтгаан нөхцөл болохыг ч үгүйсгэхгүй. Судлаачид хүний амиа хорлох үзэгдлийг дараах байдлаар авч үзсэн.

### **Амиа хорлох үзэгдлийн социологийн шинжилгээ (Э.Дюркхайм)**

Амиа хорлох үзэгдлийг психологийн үүднээс тайлбарлаж байсан нь XIX зууны сүүл үе нь Өрнө дахины нийгмийн шинжилгээнд, тэр дундаа эдийн засгийн шинжилгээнд хүртэл сэтгэл зүйн хүчин зүйлсийн нөлөө ихээхэн “моод”-нд орж байсан цаг үе байлаа. Ийм цаг үед Дюркхайм “Амиа хорлохуй” хэмээх алдарт бүтээлээ хэвлүүлсэн бөгөөд энэ сэдэв нь магадгүй сэтгэл зүйн хүчин зүйлсээр тайлбарлагдахад хамгийн илүү дөхөмтэй үзэгдэл байсан юм. Хүмүүс амиа хорлолтын шалтгааныг ихэвчлэн тухайн хувь хүмүүсийн сэтгэлийн хэт их гутралтай холбон үзэж, харин тухайн хүмүүсийн бүлэгтэйгээ холбогдсон холбоог нь анзаардаггүй нь харагддаг.

**Амиа хорлолтын хувь:** Хэрвээ та амиа хорлолтын хувийг (тодорхой нэг ангилалд хамаарагдах 100.000 хүн тутмаас амиа хорлосон тохиолдлын тоо) судалж үзвэл, амиа хорлох хандлага хүн бүрт адил биш байдгийг харж болно. Э.Дюркхайм амиа хорлох үзэгдлийг социологийн үүднээс тайлбарласан нь “Амиа хорлохуй” хэмээх бүтээлдээ Э.Дюркхайм янз бүрийн бүлгийн хоорондох амиа хорлолтын хувь өөр, өөр байдгийн учрыг тайлахыг оролдсон байна. Амиа хорлолтын талаарх Дюркхаймын онол нь социологийн үзэл хандлагыг тодорхой судалгаанд хэрэглэсний хамгийн шилдэг жишээний нэг гэгддэг. Дюркхайм социал бүлгүүд дэх амиа хорлолтын хувь нь бодгалийн зөвхөн сэтгэл санааны гутралаар тайлбарлагдах зүйл биш юм гэдгийг харуулахыг зорьсон.<sup>64</sup>

**Амиа хорлолтын төрлүүд:** Эгоист, альтруист, аноми амиа хорлолтын шалтгаан ба онцлог Амиа хорлолтын талаар ихээхэн хэмжээний материал судалсныхаа дараагаар Дюркхайм хэд хэдэн төрлийн амиа хорлолт байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Эгоист амиа хорлолт. Эхний хоёр төрөл болох эгоист ба альтруист амиа хорлолт нь тухайн бодгалийн хувьд учир холбогдол бүхий, хэлхээ холбоонд оршдог тэрхүү бүлэгтэйгээ хэр зэрэг зохицолтой байдгаас нь хамаармал шинжтэй. Хэрвээ бодгаль тэрхүү учир холбогдол бүхий бүлэгтээ дасан зохицож чадаагүй бол тухайн хүн эрэгтэй ч байсан эмэгтэй ч байсан хамаагүй, зорилго нь сарниж, стресст орсон үедээ дэмжлэг авч чаддаггүй байна. Ийнхүү өөрсдийгөө нийгмээс эсвэл бүлгээсээ тусгаарлагдсан хэмээн үзсэнээсээ болж амиа хорлосон хүмүүсийн амиа хорлолт нь эгоист амиа хорлолт гэж нэрлэгддэг. Альтруист амиа хорлолт. Нөгөө талаас бүлэгтээ хэтэрхий ихээр холбогдон дасах явдал ч байна. Бүлэг хичнээн их чухал болох тусам бодгалийн амьдрал төдий чинээ үнэ цэнэ багатай болдог. Хувь амьдралаа (бүлэгтэйгээ харьцуулахад) чухал гэж тооцдоггүйгээсээ болж амиа хорлогсдыг Дюркхайм альтруист амиа хорлолт хэмээн нэрлэжээ. Өөрөөр хэлбэл, хэтэрхий их хэмжээний юмуу эсвэл хэт бага түвшний социал дасан зохицол нь амиа хорлолтод хүргэх нөхцлийг бий болгодог аж.

Дюркхаймын үзэж байснаар, хувь хүмүүсийн өдөр тутмын зан үйлүүд утга учир бүхий зорилго чиглэлтэй байх аваас, мөн тодорхой дүрэм журам хийгээд хэм хэмжээнд захирагдаж байх аваас тэд өөрийн амьдралдаа сэтгэл хангалуун байх аж. Хэрвээ тэрхүү зорилго нь утга учраа алдах юм бол тухайн хүн учраа олохоо больж, амьдрал нь утгагүй болж үүний улмаас амиа хорлох магадлал ихэсдэг. Дюркхайм, нэг бол нийгэм дэх огцом өөрчлөлт эсвэл хувь хүний социал амьдрал дахь огцом өөрчлөлт нь аноми байдал буюу ямар ч эмх журамгүй мэт байдлыг үүсгэж амиа хорлох магадлалыг өсгөдөг болохыг тогтоожээ.

Фаталист амиа хорлолт. Дюркхаймын ангилсан амиа хорлолтын төрлүүдээс харьцангуй бага дурьдагддаг нь фаталист амиа хорлолт юм.

Аномик амиа хорлолт нь зохицуулалт хэтэрхий сул байх үед тохиолддог бол харин зохицуулалт хэтэрхий их үед фаталист амиа хорлолт гарах магадлал ихэсдэг байна. Дюркхайм, “дарангуй дэг журмын улмаас ирээдүй нь ямар ч өршөөлгүйгээр хаагдаж, хүсэл эрмэлзэл нь балмадаар боймлогдсон хүмүүсийн” хувьд фаталист амиа хорлолт ихэсдэгийг

---

<sup>64</sup> Социологи (гарын авлага) Хамтын бүтээл, Дэлхийн банкны <Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл>, 2012 он, УБ хот, 16-18 дахь тал

илрүүлжээ. Үйлдэл болгоныг нь дарангуйлан журамладгаас болоод итгэл найдвар алдсаны улмаас амиа хорлосон боолын жишээг энд эш татаж болох юм<sup>65</sup>.

Дюркхаймын онолоос харахад, амиа хорлох социологийн төрлүүдийн аль нь ч хорих ял эдэлж буй этгээдэд тохиолдож болох хэлбэр байна. Харин ямар шалтгаан, нөхцлөөс болж амиа хорлосон нь түүнээс үүдэх эрх зүйн үр дагаврыг шийдвэрлэх арга зам, зангилаа болох учиртай. Тухайлбал, Эрүүгийн хуульд бусдыг амиа хорлоход хүргэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Гэтэл эрх зүйн зохицуулалт маань өөрөө магадгүй хорих ял эдэлж буй этгээдийг амиа хорлоход хүргэж буй шалтгаан нөхцөл болж байхыг үгүйсгэхгүй. Үүнийг шинжлэх ухааны нарийн судалгааны үндсэн дээр тогтоох буй заа. Дараах дэд сэдвээр хорих ял эдэлж буй этгээдийн амиа хорлох тухай ойлголтыг хөндлөө.

### Хорих ял эдэлж буй этгээд амиа хорлох нь:

Хорих ял эдэлж буй ялтан амиа хорлох асуудалтай холбоотой судалгаа хорих байгууллагын түүхэн хөгжлийн 100 гаруй жилийн явцад ажиглагдаж ирсэн. Жишээлбэл, анх 1913 онд Ж.М.Вүүлей хорих байгууллагад амиа хорлогчдын талаар судалгаа хийсэн. Тэрээр 1902-1911 онд Энэтхэгт бүх насаар хорих ял шийтгэгдсэн ялтнуудын амиа хорлох байдалд ажиглалт хийсэн.<sup>66</sup> Ж.М.Вүүлейгийн ажиглалтаар ялтнуудын амиа хорлох явдлын 43% нь ялтан ял эдэлж эхэлснээс хойш 18 сарын дотор, амиа хорлолтын 90% нь өөрийгөө боймлох байдлаар хэрэгжсэн байна. Тэрээр судалгаандаа ялтнуудын амиа хорлосон шалтгаан нөхцлийг дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд: сахилга бат алдагдах, хорих байгууллагын хэт их ачаалал, дарамт шахалт үзүүлэх, хүнд хөдөлмөр эрхлүүлэх, хорих байгууллагын ажилтны залхаан цээрлүүлэлт, гадаад орчноос бүрэн тусгаарлагдах гэх мэт. Уг шалтгаан, нөхцөл нь хорих байгууллагаас зарим төрлийн хяналтын үйл ажиллагаа болон ялтныг нийгэмшүүлэх ажиллагааг идэвхжүүлснээр буурах боломжтойг тэмдэглэжээ.<sup>67</sup> 105 жилийн өмнө хийгдсэн энэхүү судалгаа мөн амиа хорлолтын шалтгаан, нөхцөл сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгааны тайлангуудтай ижил төстэй байгаа нь судлаачдын анхаарлыг татаж байна.

Дэлхий дээрх хорих байгууллагуудтай холбоотой судалгааг олох нь төвөгтэй боловч 2011 онд хэд хэдэн судлаачийн хийсэн судалгаанаас бидэнд хорих байгууллагад ял эдэлж буй ялтнуудын амиа хорлолтын талаарх ерөнхий мэдээлэл авах боломжийг олгоно.<sup>68</sup>

Улс	Хорих байгууллага дахь амиа хорлолтын тоо	Хорих байгууллага дахь амиа хорлолтын харьцаа (100.000/1)	Нийт хүн амд хамаарах амиа хорлолтын харьцаа (100.000/1)	Хорих байгууллага дахь амиа хорлолт ба хүн амын амиа хорлолтын хоорондын харьцаа
Австрали	69	58	16	3,7
Бельги	50	109	29	3,8
Канад	44	70	21	3,4
Дани	29	147	27	5,4
Их Британи	384	107	17	6,3
Финланд	17	96	31	3,1
Ирланд	10	64	20	3,2
Недерланд	84	108	13	5,7

<sup>65</sup> Социологи (гарын авлага) Хамтын бүтээл, Дэлхийн банкны <Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл>, 2012 он, УБ хот, 16-18 дахь тал

<sup>66</sup> [https://books.google.mn/books?id=AXV3kYohGdwC&pg=PA3&lpg=PA3&dq=J.+M.+Wooley&source=bl&ots=NM03RnDX0I&sig=YGRl-rVvBH8eFFekShtjl4nQPk4&hl=en&sa=X&ved=2ahUKewilkr76r\\_LeAhUNh7wkHTXEBsMQ6AEwB3oECAQAQ#v=onepage&q=J.%20M.%20Wooley&f=false](https://books.google.mn/books?id=AXV3kYohGdwC&pg=PA3&lpg=PA3&dq=J.+M.+Wooley&source=bl&ots=NM03RnDX0I&sig=YGRl-rVvBH8eFFekShtjl4nQPk4&hl=en&sa=X&ved=2ahUKewilkr76r_LeAhUNh7wkHTXEBsMQ6AEwB3oECAQAQ#v=onepage&q=J.%20M.%20Wooley&f=false)

<sup>67</sup> Wooley, J.M. (1913, April). "Suicide Among Indian Convicts Under Transportation." Journal of Mental Science, 59, 335-343 дахь тал

<sup>68</sup> Fazel, S., Grann, M., Kling, B., Hawton, K. (2011). "Prison suicide in 12 countries: An ecological study of 861 suicides during 2003–2007" . Social Psychiatry and Psychiatric Epidemiology, 46(3), 191-195 дахь тал.

Шинэ Зеланд	24	67	19	3,6
Норвеги	19	127	16	7,7
Шотланд	40	117	23	5,1
Швед	40	128	23	5,7

Энэхүү судалгаанаас үзэхэд, хорих байгууллага дахь амиа хорлолт нийт хүн амд хамаарах амиа хорлолтоос илүү байгаа нь анхаарал татаж байна. Судалгаагаар 12 улсын хувьд дунджаар амиа хорлолт 100.000 ялтан тутам тоон хувьд 100-аас илүү байна. Мөн тус улсуудын хүн амд хамаарах амиа хорлолт 100.000 тутамд 21 байна. Энэ нь хорих байгууллага дахь амиа хорлолт хэвийн түвшингээс 5 дахин илүү байгааг харуулж байна. Хамгийн өндөр тоон үзүүлэлт 100.000 ялтан тутмын 147 нь Дани улсад буюу хорих байгууллагад амиа хорлож байгаа бол тус улсад нийт хүн амд хамаарагдах амиа хорлолтын тоон үзүүлэлт мөн өндөр байна. Судалгаан дахь доогуур үзүүлэлт 100.000 ялтан тутмын 58 нь Австрали Улсад буюу хорих байгууллагад амиа хорлож байгаа бол нийт хүн амын 100.000 тутамд ноогдох амиа хорлолтын үзүүлэлтээр бага байна.

Дээрх судалгаагаар улс болгон тоон үзүүлэлтийн хувьд хорих байгууллага дахь амиа хорлолтоор өндөр байна. Тухайлбал, Норвеги улсын хувьд хорих байгууллага дахь амиа хорлолт ба нийт хүн амын амиа хорлолтын хоорондын харьцаа 7.7 байгаа бол Финланд улсын хувьд хувьд хорих байгууллага дахь амиа хорлолт ба нийт хүн амын амиа хорлолтын хоорондын харьцаа 3.1 буюу бусад улстай харьцуулахад доогуур үзүүлэлттэй байна.

Судалгаанд дурдагдаагүй зарим улсын жишээг мөн авч үзэх боломжтой. Тухайлбал, Франц Улс 2005-2010 оны хооронд 100.000 ялтан тутмын 185 нь амиа хорлож байгаа нь нийт хүн амынх нь амиа хорлолтоос 7 дахин илүү байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь дээрх судалгаатай харьцуулахад өндөр тоон үзүүлэлт юм.<sup>69</sup>

АНУ-ын хувьд 2013 онд хорих байгууллага дахь нийт 976 үхлийн шалтгааны 482 нь өвчний улмаас бол 327 нь амиа хорлолт байна.<sup>70</sup>

Хүн ам цөөтэй Монгол Улсад зөвхөн нэг хорих байгууллагын судалгааг авч үзвэл 2006 онд нийт амиа хорлолт 4, 2007 онд нийт амиа хорлолт 2, 2008 онд нийт амиа хорлолт 1, 2014 онд нийт амиа хорлолт 4, 2015 онд нийт амиа хорлолт 2, 2016 онд нийт амиа хорлолт 1, сүүлийн 2 жилд амиа хорлолт бүртгэгдээгүй байгаа нь сайшаалтай хэдий боловч хүн амтай харьцуулахад болон зөвхөн нэг хорих байгууллагын статистик тоогоор авч үзэхэд дээрх тоо тийм ч бага тоо биш байна.

### Дүгнэлт

Хорих байгууллагад ялтнууд амиа хорлох явдал цөөнгүй байгаа нь судалгаагаар нотлогдож байна. Үүний шалтгаан, нөхцлийг тогтооход Дюркхаймын онол дээр тулгуурлан мэргэжлийн хүмүүс судлах шаардлагатай байна. Тухайлбал, сэтгэл гутарлаас болж амиа хорлосон, дарамт шахалт, дасан зохицолт, зохицуулалтын нөлөө, тэр дундаа ял эдэлж буй этгээдийн эрх хязгаарлалтын зохицуулалт (нарлах, утсаар ярих, илгээмж авах, захидал илгээх, түр болон урт хугацааны уулзалт), шинжлэх ухааны ямар онолоор батлагдаж тогтоогдсон хугацаа болохыг эргэн харах шаардлагатай. Мөн Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагын зорилго нь ... гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршдог бөгөөд энэхүү зорилгодоо дээрх зохицуулалт нь хэрхэн нийцэж байгаад анхаарлаа хандуулах шаардлагатай гэж үзэж байна.

Дэлхийд эутанази эрхийг хүлээн зөвшөөрсөн Бельги, Недерланд зэрэг улс байдаг. Эутанази бол амиа хорлолтыг хууль ёсоор зөвшөөрсөн нэг хэлбэр юм. Эутанази эрхийг хэрэгжүүлэх хэд хэдэн шалтгаан, нөхцөл байдаг. Үүнд: тэсвэрлэхэд бэрх өвдөлт бий болгодог өвчин эмгэг туссан, сэтгэл санааны гүн хямрал, сэтгэл гутралд орсон бол эутанази эрхийг хэрэгжүүлж болдог. Мөн уг эрхийг ял эдэлж буй этгээдэд хэрэглэсэн жишиг ч байна. Жишээ нь 1980 онд Бельги улсад бүх насаар хорих ял шийтгэгдсэн этгээд болох Франк Ван Ден 2011-2014 онд эутанази эрхээ эдлэхээр шүүхэд удаа дараа хандаж, эцэст нь түүний хүсэлтийг эрх бүхий байгууллага хүлээн авч шийдвэрлэсэн нь анхны тохиолдол болсон.<sup>71</sup>

<sup>69</sup> Duthe, G., Harzad, A., Kensey, A. (2014). "Trends and risk factors for prisoner suicide in France". Population, English Edition, 69(4), 463–494-р тал.

<sup>70</sup> Bureau of Justice Statistics 2013, <https://www.bjs.gov/index.cfm?ty=pbdetail&iid=5109>.

<sup>71</sup> [https://www.bbc.com/turkce/haberler/2014/09/140915\\_belcika\\_otenazi](https://www.bbc.com/turkce/haberler/2014/09/140915_belcika_otenazi).

Амиа хорлолт нь өөрөө эрх зүйн үр дагаврыг бий болгож байна. Үүний нэг илрэл нь хариуцлагын асуудал юм. Ялтан амиа хорлосон шалтгаан, нөхцлийг Дюркхаймын онолыг үндэслэн тогтоож, хариуцлага хүлээлгэх асуудлыг нарийвчлан тогтоох боломжтой. Өөрөөр хэлбэл, амиа хорлолт бүрт хэн нэгэнд хариуцлага хүлээлгэх нь шударга ёсонд нийцэхгүй.

Хорих байгууллага дахь амиа хорлолтыг багасгах нэг боломж нь ялтныг нийгэмтэй харилцах харилцааг зохих түвшинд нэмэгдүүлснээр буурах бололцоотой гэж дүгнэж байна.

Монгол Улс дахь хорих байгууллагуудын дотоод нөхцөл тэр дундаа ялтан амиа хорлохтой холбоотой асуудал нь судлаачийн хувьд бусад оронтой харьцуулан судлах, дүгнэлт хийхэд бэрхшээлтэй, хаалттай байсныг дурдах хэрэгтэй.

# ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЗАМААР ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОЛОМЖ

Э.Өлзийжаргал  
Хууль сахиулахын их сургуулийн магистрант

## Удиртгал

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын талаар цөөнгүй эрдэмтэн судлаачид судалгаа шинжилгээний ажил хийсэн боловч эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар хийсэн судалгаа ховор байна. Хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуульд эдийн засгийн гэмт хэрэг, түүний төрлүүдийг тодорхойлсон нь аж ахуй нэгж байгууллагын эрх ашиг сонирхлыг хамгаалах, цаашлаад улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад онцгой ач холбогдолтой.

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийн зорилго нь татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг судалж, тодорхой санал дэвшүүлэхэд оршино. Судалгааны ажлын хүрээнд татварын орлогын статистик үзүүлэлт, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн судалгаа, татварын ил тод байдлыг дэмжих талаар төрөөс авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичгүүдэд сүүлийн 5 жилийн дүн шинжилгээ хийсэн болно.

### **1. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг ба эдийн засгийн аюулгүй байдлын хамаарал**

Эдийн засгийн аюулгүй байдал гэж дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх эдийн засгийн чадавхитай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байдлыг хэлнэ<sup>72</sup>. Эдийн засгийн аюулгүй байдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын тулгуур үндэс мөн бөгөөд улсын урсгал төсвийн алдагдал өсөх, Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгийг хамгаалах төрийн бодлого алдагдах нь эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл гэж үздэг.<sup>73</sup>

Улсын урсгал төсвийн алдагдал өсөх нэг шалтгаан нь татвар төлөхөөс зайлсхийх, татвараа бууруулж мэдүүлэх явдал юм. Тиймээс татвар төлөхөөс зайлсхийх үйлдлийг дэлхийн улс орнууд төдийгүй монгол улсын гэмт хэрэгт тооцож өөрийн орны эдийн засгийн аюулгүй байдлаа хангадаг.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг нь шунахайн сэдэлттэй, нуугдмал байх шинжтэй бөгөөд улсын төсөвт материаллаг хор уршиг учруулдаг.

**Татварын гэмт хэргийн шунахайн сэдэлттэй байх шинж** гэж гэмт этгээд өөртөө болон бусад этгээдэд эдийн буюу эдийн бус баялаг олж авах, эсхүл ямар нэгэн үүргийг гүйцэтгэхээс зайлсхийх гэсэн санаа зорилгыг агуулж байдаг. Тухайлбал: татвар төлөхөөс зайлсхийх сэдэлтээр үйлдэгддэг.

**Нуугдмал байх шинж** гэж татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжийн үйл ажиллагаанаас ялгахад хүндрэлтэй байдаг. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн 5 хүрэхгүй хувь нь шүүхээр шийдвэрлэгддэг нь энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал, зохион байгуулалттай байх шинжийг илэрхийлдэг.

**Материаллаг хор уршиг учруулдаг байх шинж** гэж татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн улмаас учирсан хор уршиг нь ихэвчлэн мөнгөн дүнгээр илэрхийлэгддэг боловч хохирогч хүн биш төр, нийт ард иргэдийн эрх ашиг сонирхол байдаг.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг нь улсын төсвийг бүрдүүлэхэд дараах сөрөг үр дагаварыг бий болгодог<sup>74</sup>. Үүнд,

<sup>72</sup> Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал./Төрийн мэдээлэл, УБ., 2010, №5

<sup>73</sup> Ц.Даваадорж. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангах онол, арга зүйн зарим асуудлууд” УБ.,2009, <http://www.nsc.gov.mn/?q=node/237>

<sup>74</sup> Азийн хөгжлийн банк. “Эдийн засгийн гэмт хэрэг” гарын авлага. УБ., 2017, 142-143 дахь тал


- Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрөх мөнгөн хөрөнгийн урсгалыг хааж, улсын орны татварын болон төсвийн бодлогод сөргөөр нөлөөлж, засгийн газрыг мөнгө, санхүүгийн аргаар эдийн засгийг удирдах үр нөлөөг сулруулна;
- Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын цар хүрээ, хэмжээ, хувиарлалт багасах, улмаар ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж эдийн засгийг чадавхыг сулруулах;
- Тодорхой аж ахуй нэгжээс татварын үүргээ бүрэн хэмжээгээр биелүүлээгүйгээс аж ахуйн субъектуудын тэгш бус байдлыг өгөгшлүүлж, зах зээлийн шударга өрсөлдөөний дүр төрхийг өөрчилнө;
- Нийгмийн шударга ёсны зарчим алдагдсанаас өөрийн үүргээ зүй ёсоор биелүүлж байгаа хэн бүхэнд татварын нэмэлт дарамт үүсэх зэрэг болно.

## 2. Улсын төсвийн бүрдүүлэлт ба татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн нөхцөл байдал

### А) Улсын төсөв, бүрдүүлэлт

Улсын төсөв гэдэг нь нийгэм, эдийн засгийн зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл бөгөөд улсын мөнгөн хөрөнгийн төвлөрсөн хуримтлалыг бий болгож хуваарилж буй явдлыг хэлнэ. Улсын төсвийн нийт орлогыг дотор нь урсгал орлого, 2. тусламжийн орлого гэж 2 ангилдаг. Улсын төсвийн урсгал орлого гэдэг нь цэвэр дотоод эх үүсвэрээс бүрдэх бөгөөд а. татварын орлого, б. татварын бус орлого гэж ангилдаг.

Монгол улсын улсын төсвийн орлогын 80 орчим хувийг татварын орлого бүрдүүлж байгаа бөгөөд цаашид өсөх хандлагатай байна. Улсын төсөв бүрдүүлж байгаа татварын орлогыг хүснэгт 1, 2 үзүүлэв.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Татварын нийт орлого 2018 оны эхний хагас жилд 3.7 их наяд төгрөгөөр хэмжигдэж байгаа нь өмнөх оны мөн үеэс 842.6 тэрбум төгрөг буюу 29.9 хувиар өсчээ. Татварын орлогод нөлөөлсөн үзүүлэлтүүдийг дурдвал: Нэмэгдсэн өртгийн албан татвар 240.3 тэрбум төгрөг буюу 33.7 хувь, Орлогын албан татвар 219.6 тэрбум төгрөг буюу 31.2 хувь, Онцгой албан татвар 132.8 тэрбум төгрөг буюу 63 хувь, нийгмийн даатгалын орлого 92.7 тэрбум төгрөг буюу 15.1 хувь гадаад үйл ажиллагааны орлого 89.9 тэрбум төгрөг буюу 41.9 хувь,


бусад татвар, төлбөр хураамжийн орлого 53.4 тэрбум төгрөг буюу 18.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.<sup>75</sup>

Үүнийг тоймловол, улсын нэгдсэн төсвийн орлогын 80.4 хувийг татварын орлого, 10.5 хувийг татварын бус орлого, 2.3 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.<sup>76</sup>

2016 оны байдлаар баталсан төсвийн орлого 7,013 их наяд төгрөг 1.8 их наяд төгрөгөөр тасарч, өнгөрсөн оныхоос 760.3 тэрбум төгрөгөөр бага төвлөрсөн нь татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгтэй зарим талаараа холбоотой.

#### Б) Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн нөхцөл байдал

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг авч үзье<sup>77</sup>.



Дээрх судалгаанаас үзэхэд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг буурах хандлагатай байна. Энэ 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн эрүүгийн хуулийн зохицуулалттай холбоотой байх талтай ч нөгөө талаар энэ төрлийн гэмт нуугдмал болж байх магадлалтай юм.

Түүнчлэн татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг нь бусда төрлийн ялангуяа эдийн засгийн гэмт хэргэгтэй нийлмэл шинжтэйгээр үйлдэгдэх явдал шүүхийн практикт цөөнгүй тохиолдож байгаа нь эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал,

Авилгын хэрэгт хамаарах “Нийтийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах”, “Хахууль авах”, “Хахууль өгөх”, эдийн засгийн гэмт хэрэгт хамаарах “Залилах”, “Хууль бусаар дампуурах”, “эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх”, “Баримт бичиг хуурамчаар үйлдэх, ашиглах” гэх мэт хэргүүдийг нэрлэж болох бөгөөд эдгээр гэмт хэргүүд нь 7 тэрбум орчим төгрөгийн хохиролтой хэргүүд байгаа нь анхаарал татаж байна.

Эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр шилжүүлсэн татварын хэргээс шүүхээр шийдэгдсэн хэрэг харьцангуй цөөн, ихэнхдээ хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэгсэхгүй болгох буюу эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэгдсэн байна. Тухайлбал, өршөөл үзүүлэх тухай 2015 оны хууль батлагдахаас өмнө татварын албанаас нийт 62 татвар төлөгчид холбогдох 98.8 тэрбум төгрөгийн зөрчил бүхий татвар төлөхөөс их хэмжээгээр зайлсхийсэн үйлдэлд дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлснээс 8 татвар төлөгчид холбогдох 4.8 төгрөгийн зөрчил бүхий хэрэгт эрүүгийн үүсгэхээс татгалзаж, 7 татвар төлөгчид холбогдох 11.2 тэрбум төгрөгийн зөрчил бүхий хэргийг хэрэгсэхгүй болгож, 45 татвар төлөгчид холбогдох 82.3 тэрбум төгрөгийн зөрчил бүхий 41 хэрэг эцэслэн шийдэгдээгүй, шийдвэрлэлтийн шатанд хүлээгдэж байгаа бол 2 татвар төлөгчид холбогдох ердөө 169.0 сая төгрөгийн зөрчил бүхий хэргийг төлүүлэхээр шийдвэрлэжээ .

## ДҮГНЭЛТ

<sup>75</sup> Сангийн яам “Төсвийн бүрдүүлэлтийн тайлан мэдээ-2017”, УБ., 2017, 56 дахь тал

<sup>76</sup> Үндэсний статистикийн хороо, Улсын нэгдсэн төсвийн тайлан. УБ., 2018 оны эхний хагас жил.

<sup>77</sup> Цагдаагийн ерөнхий газар, “Мэдээлэл нэгтгэн боловсруулах албаны мэдээ-2018”, УБ., 2018

Эдийн засгийн аюулгүй байдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын тулгуур үндэс мөн бөгөөд улсын урсгал төсвийн алдагдал өсөх, Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгийг хамгаалах төрийн бодлого алдагдах нь эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл гэж үздэг. Улсын урсгал төсвийн алдагдал өсөх нэг шалтгаан нь татвар төлөхөөс зайлсхийх, татвараа бууруулах гэж дүгнэж болно.

Татвараас зайлсхийх гэмт хэрэг улсад учруулах хохирлоороо өндөр үзүүлэлттэй гарч байна. Гагцхүү, улс төр, нийгмийн орчин нөхцөл, энэ гэмт хэргийн талаарх манай улсын ААН, иргэдийн төсөөлөл, ойлголт дутуу байгаагаас шалтгаалж манай улс энэ гэмт хэрэгт өндөр ач холбогдол өгөхгүй байгаа нь харагдаж байна. Татварын өршөөл үзүүлэх арга хэмжээг ойр ойрхон гаргасан нь үүний нотолгоо бөгөөд энэ гэмт хэргийг тэвчих сэтгэл зүй хүмүүст байгаа нь харагдаж байна.

Татвартай холбоотой гэмт хэрэг шүүхээр харьцангуй цөөн шийдвэрлэгдсэн ба дийлэнх хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эсхүл гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон боловч анхны ардчилсан сонгууль болж байнгын ажилгаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хууль болон Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн дагуу хэрэгсэхгүй болгосон тохиолдлууд 2012-2018 оны хооронд хянан шийдвэрлэсэн хэргийн судалгаанаас харагдаж байна.

### **САНАЛ**

1. Татварын ил тод байдлыг дэмжих тухай хууль батлах;
2. Улсын төсвийн бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуй нэгж байгууллагын орлогын хяналтын системийг бүрдүүлэх, ингэснээр 10 сая төгрөгөөс доош орлоготой аж ахуй нэгжүүдийг хянах боломж бүрдэнэ.
3. ЭЗХАХБ-ын Татварын зорилгоор ашиг зувчуулах ба шилжүүлэх (BEPS) санаачилга нь үйл ажиллагааны 15 саналыг агуулдаг ба тэдгээрийн хэд хэдэн нь мэдээлэл солилцох замаар татварын албаны хооронд ил тод байдал, татварын хүрээг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байдаг. (BEPS) үйл ажиллагаа нь байгууллагын ил тод байдлын өнцгөөс илүү хамааралтай бөгөөд энэ нь ил тод байдлыг татвар төлөгчдөд нууцлах үндсэн дээр хийгдэх байсан ч улс орны дотоодын тайлагналын онцлог агуулж байдаг.

### **Ном зүй**

1. Азийн хөгжлийн банк. “Эдийн засгийн гэмт хэрэг” гарын авлага”. УБ., 2017
2. Ц.Даваадорж. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангах онол, арга зүйн зарим асуудлууд” УБ., 2009, <http://www.nsc.gov.mn/?q=node/237>
3. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. //Төрийн мэдээлэл. УБ., 2010. №5
4. Сангийн яам. “Төсвийн бүрдүүлэлтийн тайлан мэдээ-2017”, УБ., 2017,
5. Үндэсний статистикийн хороо, Улсын нэгдсэн төсвийн тайлан. УБ., 2018 оны эхний хагас жил.
6. Цагдаагийн ерөнхий газар. “Мэдээлэл нэгтгэн боловсруулах албаны мэдээ-2018”, УБ., 2018



# МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НЬ МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА БОЛОХ НЬ

Б. Оюунболд

Хууль сахиулахын их сургуулийн магистрант

## 1. Эдийн засгийн аюулгүй байдал ба мөнгө угаах гэмт хэргийн хамаарал:

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”<sup>78</sup> гэсэн заалтын дагуу зах зээлийн эдийн засаг өөрийн дотоод хуулиар хөгжихөд нь төрөөс дэмжин, тэнцвэртэй байдлаа хадгалах, тогтвортой өсөлтийг хангах, хямрал, эрсдэлд өртөхгүй дархлаатай байх нөхцөлүүдийг бүрдүүлэх эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг оновчтой авч байх төрийн зохицуулалтын механизмуудыг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан.

Эдийн засгийн аюулгүй байдлын тухай ойлголт дэлхий нийтээр бүрэн тогтоогүй байгаа, аюулгүй байдалд хандах хандлага ч өөрөө цогц (comprehensive) бөгөөд хамтын (collective), системийн шинжтэй болсон тул аюулгүй байдлын асуудалд<sup>2</sup> ч бүхэлд нь мөн түүний дотор эдийн засгийн аюулгүй байдалд системийн онолын үүднээс хандаж түүний онол, арга зүйг боловсруулах болжээ<sup>79</sup>.

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад мөнгө угаах гэмт хэргийн үзүүлэх сөрөг үр дагаврыг мөнгөн дүнгээр, тоон утгаар илэрхийлэхэд хүндрэлтэй хэдий ч төсөв, төлөвлөгөөнд тусгагдаагүй, технологийн дэвшил, бүтээмжийн өсөлттэй уялдаагүй гэнэтийн их хэмжээтэй мөнгөний урсгал нь төсөв, мөнгөний бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийг гажуудуулж тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангахад сөрөг үр дагавартай болохыг харуулсан судалгааны ажлууд хөгжиж буй орнууд болон өндөр хөгжилтэй орнуудын хувьд хийгдсэн байдаг.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд онцгой анхаарч, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход бодлогын хэмжээнд анхаарч шат дараалсан олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдаг.

Тухайлбал, Монгол Улсын Их хурлаас 2006 онд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 143 дугаар тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, 2017 оны 327 дугаар тогтоолоор “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай байгууллагаас өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г тус тус батлан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байгаа билээ<sup>80</sup>.

Мөн хууль тогтоогчоос 2015 онд баталж, 2017 оны долдугаар сарын 1-нээс мөрдсөн Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан мөнгө угаах гэмт хэргийг олон улсын гэрээ, конвенцийн шаардлагад бүрэн нийцүүлэх байдлаар хуульчилсан нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрэн бүрдэж мөнгө угаах гэмт хэрэг болон түүний суурь гэмт хэргийг мөрдөн шалгаж шүүхээс шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж байна.

Хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаас төрийн бодлого, шийдвэр, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тодорхой ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлэн, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж байгаа хэдий ч нийгмийн хөгжилтэй зэрэгцэн энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд бүлэг, зохион байгуулалтад орж үйлдлийн арга, хэлбэр улам боловсронгуй болж техник, технологийн дэвшлийг ашиглах, гэмт хэргийн улмаас олсон орлогыг улс, орон дамжуулж шилжүүлэх, цахим орчин, криптовалюта ашиглан мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах зэргээр энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлыг хүндрүүлж байна.

## 2. Мөнгө угаах гэмт хэргийн нөхцөл байдал, нөлөөлөх хүчин зүйл

<sup>78</sup> Монгол улсын үндсэн хууль // Төрийн мэдээлэл, УБ., 1992 №1


<sup>79</sup> Ц.Даваадорж, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангах онол, арга зүйн зарим асуудлууд, <http://www.nsc.gov.mn/?q=node/237>

<sup>80</sup> “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ”, 2016 он

Дэлхийн банк болон АНУ-ийн Төрийн департаментын гаргасан тооцоогоор дэлхий дээр угаагдаж буй мөнгөний хэмжээ дэлхийн улс орнуудын ДНБ-ний 2-4 хувьтай тэнцдэг, мөнгөн дүн нь 590 тэрбумаас 1 их наяд 500 тэрбум ам долларт хүрсэн гэсэн тооцоог гаргажээ.<sup>81</sup> Хууль бусаар олсон орлого улсын эдийн засгийн байдлыг тогтворгүйжүүлэх хор уршигтай.

Монгол Улсыг Ази номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх байгууллагаас 2017 онд “эрчимтэй хяналтанд” оруулсан. Энэ нь Монгол Улсын эдийн засгийн байдалд эрсдэл нэмэгдэж буйн илрэл юм. “Эрчимтэй хяналт”-ын дараагийн арга хэмжээ нь “саарал жагсаалт”-д оруулах байдаг. Энэхүү жагсаалтад орох нь санхүүгийн системд ноцтой эрсдэл учруулах, банкны гадаад гүйлгээг зогсоох эрсдэлтэй. Энэ нь улсын эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй юм.

Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудаас сүүлийн 6 жилийн хугацаанд мөнгө угаах зүйл, ангиар хэрэг бүртгэлт, эрүүгийн хэрэг үүсгэсэн 88 гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас шүүхэд шилжсэн 30, анхан шатны шүүхээс ял оногдуулсан 12 хэрэг байна. Үүнийг 1 болон 2 дугаар графикт харуулав.



Дээрх тоон үзүүлэлтээс харахад мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын мөрдөгч, прокурор, шүүгч нар мөнгө угаах гэмт хэргийн талаар нэгдсэн ойлголтгүй, шүүхээс мөнгө угаах гэмт хэрэгтэй холбогдох өндөр эрсдэлтэй эдийн засгийн гэмт хэрэгтэй холбоотой шалгасан мөнгө угаах гэмт хэрэгт ял оногдуулах практик тогтоогүй гэж дүгнэхээр байна.

### **3. Мөнгө угаах гэмт хэргийн шинж эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөх нь:**

Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 18.6.1 дахь хэсэгт Мөнгө угаах гэмт хэргийг “Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол”<sup>82</sup> гэж хуульчилсан.

Энэ зохицуулалттай холбоотойгоор Сүүлийн үед гарч байгаа мэдээллээс харахад хохирол багатай гэмт хэргүүдэд мөнгө угаах зүйл ангиар давхар зүйлчилж байгаа нь сайн хэрэг боловч хохирол ихтэй, олон нийтийн анхааралд өртсөн, зохион байгуулалттай гэмт хэргийг хамруулахгүй байвал Монгол Улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо буруу замаар явж байгааг илэрхийлэх бөгөөд яаралтай засах шаардлагатай байна.

Хэдий олон улсын зөвлөмжид бүх төрлийн гэмт хэргээс олсон орлогыг мөнгө угаах гэж үзэх тухай тусгасан боловч зохион байгуулалттай, олон шатлалт гэмт хэргүүдийг онцгой анхаарч шийдвэрлэхгүй бол Монгол Улсын нэр хүндэд сөргөөр нөлөөлж, олон улсын байгууллагуудын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй асуудал үүсгэхээр байна. Нөгөө талаар олон улсын худалдаа, эдийн засгийн салбарт мөнгөн угаах гэмт хэргийн эрсдэл өндөртэй, саарал жагсаалтад орсон болон энэ төрлийн гэмт хэргийн үзүүлэлт өндөр байгаа улс орнуудтай хөрөнгө оруулалт хийх, худалдааны үйл ажиллагаа явуулах тал дээр хориглолт

<sup>81</sup> Санхүүгийн мэдээллийн алба. Мөнгө угаах гэмт хэрэг гэж юу вэ? /www.mongolbank.mn/listcma.aspx/

<sup>82</sup> Эрүүгийн хууль //Төрийн мэдээлэл. 2015. №5

тогтоодог нь монгол улсын эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх эрсдлийг бий болгож байна.

Олон улсын практик туршлагаас үзэхэд мөнгө угаах болон түүний суурь гэмт хэрэг болох мансууруулах бодис, галт зэвсгийн хууль бус эргэлт, хүн худалдаалах, татвар төлөхөөс зайлсхийх зэрэг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд улс үндэстэн, олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд онцгой ач холбогдол өгч дорвитой арга хэмжээ авч ажиллаж байна. Харин улсад бүртгэгдсэн мөнгө угаах гэмт хэрэг түүний суурь гэмт хэрэг болгож давхар шалгасан хэргүүдэд дүн шинжилгээ хийж зохион байгуулалттай томоохон төрлийн гэмт хэрэг гэхээсээ илүү өмчлөх эрхийн жижиг гэмт хэргүүд хамаарч байна.

Цагдаагийн байгууллагаас 2013-2018 оны эхний хагас жилд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан мөнгө угаах гэмт хэрэг болон суурь гэмт хэргийн бүртгэгдсэн байдалд дүн шинжилгээ хийлээ.<sup>83</sup> Цагдаагийн байгууллагаас сүүлийн 6 жилийн хугацаанд мөнгө угаах зүйл, ангиар хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, эрүүгийн хэрэг үүсгэсэн 60 гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.<sup>84</sup> Бүртгэгдсэн 60 хэргийг суурь гэмт хэргийн төрлөөр нь ангилж үзэхэд:

Д/д	Мөнгө угаах гэмт хэрэг	Суурь гэмт хэргийн төрөл /давхар зүйлчилсэн/	Суурь гэмт хэргийн тоо	Бүртгэгдсэн хэрэгт эзлэх хувь
1	Эрүүгийн хуульд заасан мөнгө угаах гэмт хэрэг /ЭХ-ийн 166 <sup>1</sup> , 18.6/	Залилах /ЭХ-ийн 148, 17.3/	30	50%
2		Хөрөнгө завших /ЭХ-ийн 150, 17.4/	9	15%
3		Хулгайлах /ЭХ-ийн 17.1/	9	15%
4		Дээрэмдэх /ЭХ-ийн 17.2/	3	5%
5		Мал хулгайлах /ЭХ-ийн 17.12/	3	5%
6		Банкны тухай хууль тогтоомж зөрчих /ЭХ-ийн 156/	2	3.3%
7		Татвар төлөхөөс зайлсхийх /ЭХ-ийн 166, 18.3/	2	3.3%
8		Алдаатай гүйлгээ, андуурсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших /ЭХ-ийн 17.5/	1	1.6%
9		Хууль бусаар даатгалын нөхөн төлбөр авах /ЭХ-ийн 18.15/	1	1.6%
Нийт			60	100%

Дээрх хүснэгтээс Цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулсан мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн төрлийг ангилж үзэхэд залилах гэмт хэрэг 30 хувь, хөрөнгө завших, хулгайлах гэмт хэрэг тус бүр 15 хувь, дээрэмдэх, мал хулгайлах гэмт хэрэг тус бүр 5 хувь, бусад гэмт хэргүүд 3,3-1,6 хувийг эзэлж байна.

### Дүгнэлт

1. Мөнгө угаах гэмт хэрэг нь Монгол Улсын санхүүгийн системийн тогтвортой, найдвартай байдалд аюул, заналхийлэл учруулах бөгөөд гэмт этгээд, гэмт бүлэг, зохион байгуулалттай бүлэглэлүүд гэмт хэргээс олсон орлого, хөрөнгөөр дамжуулан санхүүгийн системд өөрийн нөлөөг тогтоох, гэмт үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засагт хор уршигтай үйл ажиллагаа юм.<sup>85</sup> Энэ

<sup>83</sup> Цагдаагийн ерөнхий газрын эрүүгийн цагдаагийн Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх аланы тайлан мэдээ-2017

<sup>84</sup> Улсын дээд шүүх. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тайлан-2017,

<sup>85</sup> "Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ", 2016 он

төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудыг чадавхжуулах нь олон улсын түвшинд төдийгүй Монгол Улсын хувьд ч тулгамдсан асуудал хэвээр байгаа билээ.

2. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад мөнгө угаах гэмт хэргийн үзүүлэх сөрөг үр дагаврыг мөнгөн дүнгээр, тоон утгаар илэрхийлэхэд хүндрэлтэй хэдий ч төсөв, төлөвлөгөөнд тусгагдаагүй, технологийн дэвшил, бүтээмжийн өсөлттэй уялдаагүй гэнэтийн их хэмжээтэй мөнгөний урсгал нь төсөв, мөнгөний бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийг гажуудуулж тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангахад сөрөг үр дагавар үзүүлдэг
3. Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудаас сүүлийн 6 жилийн хугацаанд мөнгө угаах зүйл, ангиар хэрэг бүртгэлт, эрүүгийн хэрэг үүсгэсэн 88 гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас шүүхэд шилжсэн 30, анхан шатны шүүхээс ял оногдуулсан 12 хэрэг байна.
4. Олон улсын туршлагаас үзэхэд, мөнгө угаах болон түүний суурь гэмт хэрэг болох мансууруулах бодис, галт зэвсгийн хууль бус эргэлт, хүн худалдаалах, татвар төлөхөөс зайлсхийх зэрэг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд улс үндэстэн, олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд онцгой ач холбогдол өгч дорвитой арга хэмжээ авч ажиллаж байна. Харин улсад бүртгэгдсэн мөнгө угаах гэмт хэрэг түүний суурь гэмт хэрэг болгож давхар шалгасан хэргүүдэд дүн шинжилгээ хийж зохион байгуулалттай томоохон төрлийн гэмт хэрэг гэхээсээ илүү өмчлөх эрхийн жижиг гэмт хэргүүд хамаарч байна

#### **Санал**

1. “Мөнгө угаах, санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажлын хэсэг”-ийг байгуулж, мэдээлэх үүрэг бүхий этгээдүүдээс Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлдэг сэжигтэй гүйлгээний талаарх мэдээ, мэдээлэл дээр ажиллуулах нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд тодорхой үр дүн өгч байна.
2. Эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг зохион байгуулалттай эдийн засгийн гэмт хэрэг байхаар хуульчилж, жижиг төрлийн гэмт хэрэг үйлдэх замаар олсон орлого, эд хөрөнгийг худалдаж авсан тохиолдолд өмчийн эсрэг гэмт хэрэг байхаар гэмт хэргийн шинжийг зааглан хуульчлах зэрэг болно.

## НИЙСЛЭЛД ҮЙЛДЭГДСЭН ХУЛГАЙЛАХ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

*Д.Цэдэвсүрэн*

*Хууль сахиулахын их сургуулийн магистрант*

Монгол Улс нийгмийн шинэ тогтолцоонд шилжиж ардчилал бэхжиж зах зээлийн харилцаа гүнзгийрэх явцад гэмт хэргийн гаралт урьд байгаагүй өндөр хэмжээнд хүрч, нийгмийн хор аюул нь эрс нэмэгдэж, гэмт хэрэг гаралтын байдал, түвшин, бүтэц, шинж чанарт тоон болон чанарын өөрчлөлт гарч, онц хүнд, хүнд гэмт хэргийн хувийн жин нэмэгдэж, үйлдлийн арга нь улам нарийсч онц ноцтой, жигшүүртэй, зохион байгуулалттай болсон зэрэг нь нийгмийг эмзэглүүлсэн шийдвэрлэвэл зохих асуудлын нэг болоод байна. Нийгэмд үүссэн энэ нөхцөл байдал нь гэмт хэрэгтэй тэмцэх төрийн эрүүгийн бодлогыг шинээр тодорхойлох, улмаар гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүй, ёс суртахууны шинжтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3-т “Иргэд хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, шударгаар олж авах, эзэмших, захиран зарцуулах, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно”<sup>86</sup> гэж заасан нь хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн үндсэн зохицуулалт юм. Бусдын өмчлөх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулж Эрүүгийн хуулийн хамгаалалтанд авсан бөгөөд хэн нэгэн этгээд бусдын өмчлөлийн эд зүйлийг хулгайлах замаар өөрийн эзэмшилд авсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг.

Иргэдийн эд хөрөнгө хувьдаа өмчлөх эрх бол хүн бүрийн эдийн засгийн болон хувийн эрх чөлөөний үндэс тулгуур юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “... хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайлчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”<sup>87</sup> гэж хуульчилсан юм.

Хувийн өмчийн эрхтэй болсон явдал бол Монголчуудын тухайд 1990 оны ардчилсан хувьсгалын нэг бодит үр дүн, 1992 оны Үндсэн хуулиар сэргээн тогтоосон хүний эрхийн гол үнэт зүйл мөн. Учир нь социалист байгууллын эдийн засгийн онолын суурь үзэл баримтлал нь хувийн өмчийг устгах явдал бөгөөд Монгол Улс иргэдийн хувийн өмчийг 1959 он гэхэд бүрэн устгасан байсан билээ.

Хувийн өмч бол хүний маргаашдаа итгэх бодит үнэмшлийг төрүүлж жинхэнэ ёсоор хэнээс ч хараат бус амьдрах нөхцлийг бүрдүүлдэг учраас хүн өөрийгөө хүссэн зоргоороо захирч, эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгон авч, бүх талаар хөгжүүлэх боломжтой болдог байна.

Хувийн өмчийн эрхийг хүний эрхийн үндсэн суурь болдог асуудлыг Үндсэн хуулийн хэм хэмжээнд анх удаа хүний болон иргэний эрхийн тухай Францын Тунхаглалын 17 дугаар зүйлд хувийн өмчийг халдашгүй ариун дархан зүйл хэмээн тунхаглаж байсан байна. Энэхүү тунхаглалыг одоо хүртэл Францын Үндсэн хуулийн нэг хэсэг гэж үздэг.

Орчин үеийн ардчилсан орнуудын Үндсэн хуулийн заалтаас үзэхэд хувийн өмчийг “Ариун дархан” гэдэг төмөөллыг хэрэглэхгүй болсон нь нийгмийн харилцааны, түүний дотор өмчийн харилцааны хөгжлийн бодит тусгал мөн. Учир нь нийгмийн эдийн засгийн хөгжилд төрийн зохицуулах оролцооны хүмүүнлэгийн шаардлагаас үндэслээд “Бүх нийтийн ашиг сонирхол”-ыг хувийн өмчийн эрхтэй тодорхой хэмжээнд холбох зохилдоо аяндаа үүссэн байна. Энэ шаардлагыг иш үндэс болгож Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасан юм.

Өмч гэдэг бол нийгмийн үйлдвэрлэл явуулж, материал баялгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахад чиглэгдсэн хүмүүсийн хоорондын харилцаа бөгөөд тэр нь нийтийн болон хувийн гэсэн хоёр үндсэн хэсэгт ангилагддаг байна. Уг харилцааны илрэх хэлбэр янз

<sup>86</sup> Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он. Төрийн мэдээлэл. №1

<sup>87</sup> Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он. Төрийн мэдээлэл. №1

бүрийн хэлбэр дүрс зориулалт бүхий материаллаг биет зүйл байх бөгөөд түүнийг эд хөрөнгө гэж нэрлэдэг билээ.

Монгол Улсын Иргэний хуульд зааснаар эд хөрөнгийг хөдлөх, үл хөдлөх хөрөнгө гэж ангилдаг.

Хөдлөх эд хөрөнгө гэдэгт нэг байрнаас нөгөөд буюу нэг хэлбэрээс нөгөөд шилждэг бүх төрлийн эд зүйл, мал, амьтан гэх мэт зүйлийг ойлгодог. Түүнчлэн мөнгө хөрөнгө болон үүргийн эрхийн шаардлагыг хангах төлбөрийн хэрэгсэл болох чадвартай үнэт цаас, төлбөрийн гэрчилгээ зэргийг хамааруулан ойлгодог.

Үл хөдлөх хөрөнгө гэдэгт өмчлөгчийн мэдэлд байгаа газар болон байгалийн бусад ашигтай баялаг, тэдгээртэй салшгүй холбогдсон барилга байгууламж, үйлдвэр зэргийг ойлгоно.

Төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчлөх эрхийн гол агуулга нь материаллаг үнэт зүйл, эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахад оршино.

Эзэмших эрх гэдэг бол өмчлөгч тухайн эд хөрөнгийг бүрэн эрхшээлдээ оруулсан байх явдал юм.


Ашиглах гэж эзэмшиж байгаа эд хөрөнгийг зориулалтаар нь хэрэглэж, түүний ашиг шимийг үйлдвэрлэлийн болон хувийн хэрэгцээнд зориулах боломжтой байх эрхийг хэлдэг.

Захиран зарцуулах гэдэг нь өөрийн эзэмшилд байгаа эд зүйлийн хувь заяаг худалдах, бэлэглэх зэргээс эхлээд устгах хүртэл шийдвэрлэх бүрэн эрхээр хангагдсан байхад оршино<sup>88</sup>.

Сүүлийн 5 жилийн судалгаанаас үзвэл хулгайлах гэмт хэрэг нь Монгол улс дахь гэмт явдлын бүтцэд дангаараа 31.34 хувийг эзэлж, нийт үйлдэгдсэн хулгайлах гэмт хэргийн 53 хувь нь Улаанбаатар хотод, 47 орчим хувь нь хөдөө орон нутагт үйлдэгдсэн байна. Хулгайлах гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учруулж буй хохирлын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа шунахайн сэдэлтэй нийтлэг үйлдэгддэг гэмт хэрэг болоод байна.<sup>89</sup>

Нийслэлийн хэмжээнд 2018 оны 3 дугаар улиралд албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс 28206 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 7794 буюу 27.6 хувь нь хулгайлах төрлийн гомдол, мэдээлэл, 7975 гэмт хэрэг бүртгэгдсэний 3293 буюу 41.2 хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байна<sup>90</sup>. Бүртгэгдсэн гэмт хэрэг урьд оны мөн үеийнхээс 1948 хэргээр буюу 2.3 дахин өссөн байна.

Хулгайлах гэмт хэрэг, нийт хэрэгт эзлэх хувийг цагдаагийн хэлтэс тус бүрээр нь графикаар үзүүлвэл:



Хулгайлах гэмт хэргийг гарсан газраар нь авч үзвэл:

Гэр орон сууцанд нийт хэргийн 1546 буюу 46,9 хувь үйлдэгдсэнийг хүснэгтээр харуулбал:

<sup>88</sup> Г.Совд "Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх". УБ. 1999 он. 154-156 дахь тал

<sup>89</sup> Б.Болдбаатар Бусдын өмчийг хулгайлах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зарим асуудал". УБ 2004 он. 84-86 дахь тал

Нийслэлийн цагдаагийн газрын хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс. УБ 2018 он. Нөхцөл байдал мэдээ

№	Гэмт хэрэг үйлдэгдсэн газар	Нийт хэргийн тоо	Нийт хэргийн хувь
1	Гэрт	458	29,6
2	Орон сууц байр	293	18,9
3	Зуслангийн байшин буюу хаус	70	4,5
4	Хувийн байшин	553	35,7
5	Нийтийн байр	60	3,8
6	Граж	16	1,0
7	Амбаар агуулах	17	1,0
8	Орц подвальд	28	1,8
9	Бусад газар	39	2,5
10	<b>Нийт</b>	<b>1546</b>	<b>46,9</b>

Гудамж талбайд нийт гэмт хэргийн 604 буюу 18,3 хувь үйлдэгдсэнийг хүснэгтээр харуулбал:

№	Гэмт хэрэг үйлдэгдсэн газар	Нийт хэргийн тоо	Нийт хэргийн хувь
1	Гэр хорооллийн гудамж	71	11,5
2	Орон сууцны хороллийн гудам	160	26,4
3	Ил зогсоол	166	27,4
4	Автобусны буудал	117	19,3
5	Бусад газар	90	14,9
6	<b>Нийт</b>	<b>604</b>	<b>18,3</b>

Олон нийт газар нийт хэргийн 558 буюу 16,9 хувь үйлдэгдсэнийг хүснэгтээр харуулбал:

№	Гэмт хэрэг үйлдэгдсэн газар	Нийт хэргийн тоо	Нийт хэргийн хувь
1	Нийтийн зах, үзвэрийн газар, бөөний худалдааны төв, дэлгүүр, түц	265	47,4
2	Зочид буудал	74	13,2
3	Саун баар	79	14,1
4	Зоогийн газар ресторан	34	6,9
5	Бусад	107	19,1
6	<b>нийт</b>	<b>558</b>	<b>16,9</b>

Нийтийн тээвэрт нийт хэргийн 68 буюу 2,0 хувь үйлдэгдсэнийг хүснэгтээр харуулбал:

№	Гэмт хэрэг үйлдэгдсэн газар	Нийт хэргийн тоо	Нийт хэргийн хувь
1	том оврын автобусанд	48	70,5
2	микро автобусанд		
3	таксид	9	13,2
4	Бусад	5	7,3
5	<b>Нийт</b>	<b>68</b>	<b>2,0</b>

Төрийн байгууллагад нийт хэргийн 12 хэрэг буюу 0.03 хувь, төрийн бус байгууллагад 23 хэрэг буюу 0.6 хувь, аж ахуйн нэгжид 264 хэрэг буюу 8.0 хувь, бусад газар 212 хэрэг буюу 6.4 хувийг нь эзэлж байна.

Гэмт хэргийг гарсан цаг, гарагаар нь авч үзвэл:

Гэмт хэргийн 876 буюу 26.6 хувь нь 06:00-14:00 цагт, 1094 буюу 33.2хувь нь 14:00-19:00 цаг буюу ажлын цагаар, 467 буюу 14.1 хувь нь 19:00-22:00 цагт, 856 буюу 25.9 хувь нь 22:00-06:00 цагт буюу шөнө оройн цагаар үйлдэгдэж, 512 хэрэг буюу 15.5 хувь нь даваа гарагт, 523 хэрэг буюу 15.8 хувь нь мягмар гарагт, 480 хэрэг буюу 14.5 хувь нь лхагва гарагт, 479 хэрэг буюу 14.5 хувь нь пүрэв гарагт, 486 хэрэг буюу 14.7 хувь нь баасан гарагт, 430 хэрэг буюу 13.0 хувь нь бямба гарагт, 383 хэрэг буюу 11.6 хувь нь ням гарагт бүртгэгдсэн байна.

Хэрэг бүртгэлтийн 3257 хэргээс 162 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж гэмт хэргийн илрүүлэлт 5.0 хувьтай. Урьд оны мөн үетэй харьцуулахад илрүүлэлт - 40.2 хувиар буурсан.

Нийслэлийн хэмжээнд	ЭХ-ийн 17.1-р зүйлд заасан гэмт хэрэг							
	Бүх хэрэг		Хэрэг бүртгэлтийн хэрэг		Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг		Илрүүлэлт хувь	
	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он	2017 он	2018 он
	1345	3293	1306	3257	590	162	45,2%	5%

Хулгайлах гэмт хэргийн 19 буюу 0.5 хувийг мал хулгайлах, 109 буюу 3.3 хувийг авто тээврийн хэрэгсэл хулгайлах, 264 буюу 8 хувийг аж ахуйн нэгжид үйлдэгдсэн хулгайлах, 429 буюу 13 хувийг автомашины эд анги хулгайлах, 214 буюу 6,5 хувийг алт мөнгө, үнэт эдлэл хулгайлах, 437 буюу 13,3 хувийг зурагт хулгайлах, 219 буюу 7 хувийг компьютер хулгайлах, 125 буюу 3,8 хувийг автомашинаас эд зүйл хулгайлах, 41 буюу 1,3 хувийг гэрийн тэжээмэл амьтан хулгайлах гэмт хэрэг тус тус эзэлж байна. Эртний эдлэл хулгайлах, галт зэвсэг хулгайлах гэмт хэрэг нийслэлийн хэмжээнд бүртгэгдээгүй байна.

Хүснэгтээр харуулбал:

№	Цагдаагийн хэлтэс	Нийт бүртгэгдсэн хулгайлах гэмт хэрэг	Үүнээс										
			Автомашин ы эд анги хулгайлсан	ААНБ-д үйлдэгдсэн хабаас	Алт, мөнгө, үнэт эдлэл хулгайлах	Зурагтын хулгай	Компьютери йн хулгай	Алдагдсан гад хяас	Автомашин ы хулгай	Автомашин ас эд зүйл	Малын хулгай	Шилмэл үүлдрийн	
1	БГД	I	291	30	32	16	21	30	47	4	12	-	
2		II	280	75	30	13	23	18	45	31	25	-	1
3	БЗД	I	346	34	21	25	31	15	43	8	21	-	
4		II	443	43	29	21	47	23	37	15	5	-	
5		III	269	29	6	17	51	21	29	7	9	3	4
6	СХД	I	247	63	8	22	30	12	37	12	11	3	16
7		II	172	26	2	15	57	17	28	8	6	1	
8		III	146	45	7	13	25	15	46	2	13	-	
9	СБД	I	209	10	44	2	4	9	52	2	2	-	
10		II	296	30	11	12	48	12	36	6	8	4	
11	ХУД	I	84	10	6	5	3	16	33	5	1	-	
12		II	124	19	7	19	24	10	29	2	6	2	20
13	ЧД	I	140	8	11	8	15	11	49	2	6	-	
14		II	170	6	4	23	51	10	38	2	1	-	
15	НД		54	-	-	2	7	-	24	3	-	4	
16	БНД		19	1	2	1	-	-	11	-	-	2	
17	БХД		3	-	-	-	-	-	2	-	-	-	
Нийт			3293	429	264	214	437	219	586	109	125	19	41



1. Автомашинь эд анги хулгайлах гэмт хэрэг 429 бүртгэгдсэнээс эрүүгийн хэрэг үүсгэсэн 72, зөрчлийн хэрэг нээсэн 135, хэрэг нээхээс татгалзсан 214 байна. Гэмт хэргийн улмаас аккумулятор 113, дугуй 35, зөөлөн яндан 10, толь 75, хучлага 50, гупер 8, копуд 5, бусад 112 тус тус алдагдсан байна.

Энэ төрлийн гэмт хэрэг Баянгол дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн нутаг дэвсгэрт 75 буюу 17,5 хувь, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 63 буюу 14,7 хувь, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэст 45 буюу 10,5 хувь тус тус бүртгэгдсэн байна. Дээрх хэргүүд ихэвчлэн харуул хамгаалалтгүй, хяналтын камергүй, гэрэлтүүлэг муутай гудамж, талбайд Баасан, Бямба, Ням гаригуудын 22:00-06:00 цагийн хооронд бүртгэгдсэн байна<sup>91</sup>.

2. Аж ахуй нэгж, байгууллагад үйлдэгдсэн хулгайн гэмт хэрэг 264 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 150 нэгжээр буюу 2,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: эрүүгийн хэрэг үүсгэсэн 179, зөрчлийн хэрэг нээсэн 30, хэрэг нээхээс татгалзсан 13 байна. Гэмт хэргийн улмаас иргэдэд 15,282,000 төгрөгний хохирол учирч, 179 хэрэгт 36 этгээдийг холбогдуулан шалгаж байна.

Энэ төрлийн гэмт хэрэг Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн нутаг дэвсгэрт 44 буюу 16,6 хувь, Баянгол дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтэст 32 буюу 12,1 хувь, Баянгол дүүргийн хоёрдугаар хэлтэст 30 буюу 11,3 хувь тус тус бүртгэгдсэн байна. Дээрх хэргүүд ихэвчлэн харуул хамгаалалтгүй, хяналтын камергүй дэлгүүр, эмнэлэг, зах, худалдааны төв зэрэг албан байгууллагуудад иргэдийн сонор сэрэмжгүй байдлыг далимдуулан үйлдэгдсэн байна.

3. Алт, мөнгө, үнэт эдлэл хулгайлах гэмт хэрэг 214 бүртгэгдсэнээс эрүүгийн хэрэг үүсгэсэн 156, зөрчлийн хэрэг нээсэн 2, хэрэг нээхээс татгалзсан 55 байна. Энэ төрлийн гэмт хэрэг 12 этгээдийг холбогдуулан шалгаж байна.

Энэ төрлийн гэмт хэрэг Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн нутаг дэвсгэрт 25 буюу 11,7 хувь, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэст 23 буюу 10,8 хувь, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэст 22 буюу 10,3 хувь тус тус бүртгэгдсэн байна. Дээрх төрлийн гэмт хэргийг эрхэлсэн тодорхой аижлгүй, амьдралын эх үүсвэргүй иргэд хялбар аргаар мөнгө олох зорилгоор үйлдэж, Нарантуул, Хар хорин, Хүчит шонхор зэрэг худалдааны төв, томоохон захын гадна зогсдог чинжүүд болон алт, мөнгөний дархан, ломбардуудад зарагдаж байна.

4. Зурагт хулгайлах гэмт хэрэг 437 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14 нэгж буюу 3,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ төрлийн гэмт хэрэг Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хоёр, гурав, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн нутаг дэвсгэрт тус тус буурсан нь “Сонор” арга хэмжээний хүрээнд эргүүл шалгалтыг оновчтой зохион байгуулсаны үр дүн харагдаж байна. “Сонор” арга хэмжээний хүрээнд 12 удаагийн үйлдлийг халуун мөрөөр нь илрүүлэн ажилласан.

5. Компьютер хулгайлах гэмт хэрэг, үйлдэл 219 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 нэгж буюу 9,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: эрүүгийн хэрэг үүсгэсэн 212, хэрэг нээхээс татгалзсан 7 байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас иргэдэд 15,000,000 төгрөгний хохирол учирч, хэрэг бүртгэлтийн 3 хэрэгт 5 этгээдийг холбогдуулан шалгаж байна. Дээрх хэргүүд нь аж ахуй нэгж байгууллагын харуул хамгаалалт сул, гэрэлтүүлэг, хяналтын камергүй, иргэдийн анхаарал болгоомжгүй байдлаас шалтгаалж байна.

6. Эртний эдлэлийн хулгай бүртгэгдээгүй ба орон байр болон халаасны хулгай, дээрмийн гэмт хэргийн улмаас 586 ширхэг гар утас алдагдсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 72,8 хувь нь гудамж талбай, аж ахуй нэгжид 08:00-15:00 цагийн хооронд, 1,1 хувь нь 22:00-06:00 цагийн хооронд иргэдийн орон байранд нэвтэрч эд зүйл алдагдах явцад, 26,1 хувь нь бусдын эд зүйлийг дээрэмдэх, залилан мэхлэх аргаар үйлдэгдсэн байна. Алдагдсан гар утсыг төрлөөр нь үзвэл. Samsung маркийн гар утас 248 буюу 43%, I phone маркийн гар утас 148 буюу 25%, LG маркийн гар утас 45 буюу 8%, Nokia маркийн гар утас 28 буюу 5%, бусад маркийн гар утас 110 буюу 19% эзэлж байна. Алдагдсан гар утсууд ихэвчлэн барьцаалан зээлдүүлэх газар болон зах, худалдаа үйлчилгээний төвлөрсөн цэгүүдэд ажиллаж байгаа эд зүйл худалдан авч, борлуулдаг “ченж” гэх иргэдийн дамжин

<sup>91</sup> Нийслэлийн цагдаагийн газрын хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс. УБ 2018 он. Нөхцөл байдал мэдээ

зах зээлд гарч, хууль бус нийлүүлэлт үүсгэж байгаа бөгөөд адил төстэй бараа, бүтээгдэхүүнээс бага үнэтэй худалдагддаг тул эрэлт нийлүүлэлт их байна гэж дүгнэж байна.

7. Галт зэвсэг хулгайлах гэмт хэрэг нийслэлийн хэмжээнд 2018 оны 03 дугаар улиралд бүртгэгдээгүй байна. 2018 оны 03 дугаар улирлын байдлаар алба хаагчдаас “Эрэн сурвалжлах ажлын АСАП систем”-д 29 мэдээллийг бүртгэлд оруулан зарлан мэдээлж, 16 хүн, мал, эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон байна. Сангийн ашиглалт, бүрдүүлэлтийн явц урьд оны мөн үетэй харьцуулахад 15,3 хувиар буурсан, 29 хүн, мал эд зүйлийн мэдээллийг эрэн сурвалжлах санд зарласан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 68,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

8. Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 109 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 84 нэгжээр буюу 4.4 дахин өсч, илрүүлэлт 6.7 хувьтай өмнөх оны мөн үеэс илрүүлэлт - 14.3 хувиар буурсан. Алдагдсан автомашины 46 нь олдсон байна. Энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлахад 39,8 хувь нь ах дүү, найз нөхөд, гэр бүлийн хоорондын эд хөрөнгийн маргаан, 15 хувь нь эзэмшигч нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгслээ хаана тавьсанаа мэдэхгүй байх, 31 хувь нь сэжигтэй этгээд автомашинаар сэлгүүцэх, 14,2 хувь нь хулгайлсан тээврийн хэрэгслийн эд ангийг зарах шалтгаанаар үйлдэгдсэн байна. Автомашин хулгайлах гэмт хэрэг Баянгол дүүрэг дэх цагдаагийн нэг, хоёр, Баянзүрх дүүргийн цагдаагийн нэг хоёр, Сүхбаатар дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтсүүдийн хариуцсан нутаг дэвсгэрт ихэвчлэн үйлдэгдсэн байна.

9. Автомашинаас эд зүйл хулгайлах гэмт хэрэг 125 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 12 нэгж буюу 9,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: эрүүгийн хэрэг үүсгэсэн 49, зөрчлийн хэрэг нээсэн 46, хэрэг нээхээс татгалзсан 21 байна. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас иргэдэд 11,650,000 төгрөгний хохирол учирч, хэрэг бүртгэлтийн 49 хэрэгт 18 этгээдийг холбогдуулан шалгаж байна.

10. Малын хулгайн гэмт хэрэг 19 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 6 нэгжээр буюу 1.5 дахин өсч, илрүүлэлт 5.6 хувьтай байна. Сонгинохайрхайн дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс 3 нэгж буюу 50 хувь, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэс 1 нэгж буюу 25,7 хувиар буурсан, налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс 4 хэрэг, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс 4, Сонгинохайрхайн дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс 1 хэрэг бүртгэгдсэн байна. Яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар 2 хэрэг, хэрэгсэхгүй болгох саналтайгаар 1 хэргийг прокурорт шилжүүлж, ажиллагаанд 16 хэрэг байна.

11. Шилмэл үүлдрийн гэрийн тэжээмэл амьтан хулгайлах 41 бүртгэгдсэн байна. Гэмт хэргийн улмаас нохой 21, гахай 3, тахиа 17 алдагдсан байна. Энэ төрлийн гэмт хэрэг Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Хан –Уул дүүргүүдийн нутаг дэвсгэрт бүртгэгджээ.

Хулгайлах гэмт хэргийн улмаас алдагдсан эд зүйлийг хүснэгтээр харуулбал:

№	Алдагдаж буй эд зүйлсийн төрөл	Алдагдаж буй эд зүйлс	Алдагдсан эд зүйлсийн тоо, ширхэг	
			2017 оны 3 дугаар улирал	2018 оны 3 дугаар улирал
1	Автомашин	Автомашин		109
2	Авто машины эд анги	Толь		75
3		Дугуй		35
4		Гэрэл, дохио		-
5		Гупер		8
6		Аккумулятор, зай		113
7		Копут		5
8		Хучлага		50
9		Гарутас	Гарутас	
10	Компьютер	Компьютер		219

11	Шилмэл үүлдрийн гэрийн тэжээмэл амьтан		41
12	Зурагт		437

Хулгайлах гэмт хэргийн улмаас 2857 иргэнд 3,466,107,610 төгрөгийн хохирол учирсны 294,147,350 төгрөг буюу 8.5 хувийг нь нөхөн төлүүлжээ.

**Хоёр. Нийслэлд хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хийсэн ажлын талаар:**

Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, хэргийн илрүүлэлтийг дээшлүүлэх, дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүд болон бусад төрөл мэргэжлийн албадын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 5 удаа зохион явуулж, үр дүнг Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн газрын дарга, Мөрдөн шалгах газрын дарга нарт тухай бүр танилцуулж ажилласан. Үүнд:

1.“Сонор” хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс 09 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд зохион байгуулж, арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөний дагуу тус газрын Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн алба хаагчид, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны хамгаалалтын газрын 20 алба хаагч, замын цагдаагийн 8 алба хаагч, дүүргүүд дэх цагдаагийн хэв журмын 13 алба хаагч нийт 41 алба хаагчид ажиллаж, нийслэл хотын нутаг дэвсгэрт байрлах төвлөрсөн зах худалдааны төв, хулгайн эд зүйлс худалдан авч болзошгүй аж ахуйн нэгж болон барьцаалан зээлдүүлэх газруудын орчим ажлын болон амралтын өдрүүдийн 09 цагаас 19:00 цагийн хооронд хяналт тавьж үүрэг гүйцэтгэсэн. Арга хэмжээний хүрээнд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид давхардсан тоогоор хулгайн эд зүйлс худалдан авч болзошгүй барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газар 340, алт мөнгө үнэт эдлэл зарж борлуулдаг газар, дарханы цэг 250, хулгайн эд зүйлс тээвэрлэн явж болзошгүй сэжигтэй тээврийн хэрэгсэл 15100, овор ихтэй сэжиг бүхий эд зүйлс авч явсан 240 иргэнийг Цагдаагийн байгууллагын нэгдсэн лавлагаанаас шалгаж, хяналт тавьж ажиллаж, орон сууцнаас хулгайла 7, автомашины хучлага хулгайла 2, халаасны хулгай 7, урьд цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй хэргээс 3 тус тус нийт 19 гэмт хэргийг шуурхай илрүүлэн, тухай бүрд нь хариуцсан дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд шилжүүлсэн. Мөн Цагдаагийн байгууллагын “ASAP” санд эрэн сурвалжлагдаж байсан гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 11 олж тогтоон ажилласан<sup>92</sup>.

Тус арга хэмжээний хугацаанд хулгайлах гэмт хэргийн гаралт буураагүй боловч гэмт хэргийн улмаас хамгийн ихээр алдагддаг зурагт, цахилгаан бараа / арга хэмжээ эхлэхээс өмнө хоногт 8-12 ширхэг алдагдаж байсан бөгөөд арга хэмжээ эхлэснээс хойш 3-5 ширхэг алдагдах болсон/ алдагдах байдал багассан байна. Энэ нь цахилгаан бараа худалдан авдаг барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газрууд, худалдааны төвүүдэд тавих хяналт, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулсаны үр дүн харагдаж байна.

2.“Илрүүлэлт-Оргодол” нэгдсэн арга хэмжээ зохион явуулах удирдамж, төлөвлөгөөний дагуу 2018 оны 07 дуаар сарын 15-ны өдрөөс 2018 оны 09 дүгээр сарын 12-нийг хүртэлх хугацаанд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах, гэмт хэрэг үйлдээд оргон зайлсан этгээдүүдийг олж баривчлах ажлын үр дүнг сайжруулах, мэдээллийн сангийн зөрчлийг арилгах, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлэх зорилгоор нийслэл хотын хэмжээнд зохион явуулж, үр дүнг тооцон дүн мэдээг нэгтгэж Нийслэлийн цагдаагийн газрын дэд бөгөөд Мөрдөн шалгах газрын даргад танилцуулж, Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга, Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн газрын дарга нарт хүргүүлсэн.

“Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд урьд цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй 628 хэрэг, тухайн оны 97 хэрэг, урьд онд үйлдэгдсэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 536, халуун мөрөөр нь үйлдэл дээр нь илрүүлсэн 237 хэрэг нийт 1498 хэргийг нөхөн илрүүлж, асап санд эрэн сурвалжлагдсан оргодол 37, сэрдэгдсэн этгээд 690, нийт 727 этгээдийг эрэн сурвалжилж олж тогтоосон ба урьд оны мөн үетэй харьцуулахад хулгайлах гэмт хэрэг 67 нэгж буюу 14,7 хувиар буурсан үр дүн гарсан байна.

<sup>92</sup> Нийслэлийн цагдаагийн газрын Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс. УБ 2018 он. Нөхцөл байдал мэдээ

3. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа автомашинаас эд зүйл, эд анги, аккумулятор хулгайлах гэмт хэргүүдийг илрүүлэх, таслан зогсоох, тээврийн хэрэгслийн эд анги худалдан авч, зарж борлуулдаг цэгүүдэд хяналт тавих, тэдгээрийг бүртгэн нэгдсэн санд оруулах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, эргүүл, хяналт шалгалтын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Автомашин, Аккумулятор” хэсэгчилсэн арга хэмжээг Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүргүүдийн нутаг дэвсгэрт 2018 оны 07 дугаар сарын 01-14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Арга хэмжээнд Мөрдөн шалгах газрын 56, НХЖХ, ОНАБХА-ын хамгаалалтын газрын 100, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүргийн нийт 850 алба хаагч, 49 автомашинтайгаар оролцож, 12 гэмт хэргийг үйлдэл дээр нь илрүүлж, эрэн сурвалжлагдаж байсан оргодол этгээд 4 баривчлан, эрэн сурвалжлалтыг зогсоож, гэмт хэрэгт сэрдэгдсэн 10 иргэнийг олж тогтоон, нийт 2989 хүн, 2755 тээврийн хэрэгсэл, 712 аж ахуй нэгж, байгууллага, 273 эд зүйл, 220 дэн буудал, 40 барьцаалан зээлдүүлэх газар, 241 хүнсний дэлгүүр, 24 хоёрдогч түүхий эд авах цэг, 123 баар, караоке, 8 саун массажны газрыг шалгаж, нийт 57 зөрчил илрүүлж, 55 хүнийг 2,680,000 төгрөгөөр торгож, 9 хүнийг 103-т, 77 хүнийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, 33 хүнийг саатуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 4 иргэнийг Замын цагдаагийн албанд шилжүүлсэн. Эрүүгийн нөхцөл байдлыг зөв тодорхойлж хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан нь үр дүнгээ өгч, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт 50 хувь, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг 17 хувиар тус тус буурсан үр дүн гарсан байна.

### **Дүгнэлт**

Нийслэлийн хэмжээнд 2018 оны 3 дугаар улиралд албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс 28206 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 7794 буюу 27.6 хувь нь хулгайлах төрлийн гомдол, мэдээлэл, 7975 гэмт хэрэг бүртгэгдсэний 3293 буюу 41.2 хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байна. Урьд оны мөн үеийнхээс 1948 хэргээр буюу 2.3 дахин өссөн байна.

Дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдээс Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт хамгийн их хулгайлах гэмт хэрэг буюу нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 13,5 хувь нь үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн судалгаанаас харахад аж ахуй нэгж, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 2,3 хувь, автомашин хулгайлах гэмт хэрэг 4,4 дахин, мал хулгайлах гэмт хэрэг 1,5 дахин, автомашинаас эд зүйл хулгайлах гэмт хэрэг 9,6 хувиар, компьютер хулгайлах гэмт хэрэг 9,8 хувиар тус тус өссөн, зурагт хулгайлах гэмт хэрэг 4,7 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

### **Санал**

Нийслэлийн хэмжээнд 2018 оны 03 дугаар улиралд 7975 гэмт хэрэг бүртгэгдсэний 3293 буюу 41.2 хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байна. Бүртгэгдсэн хулгайлах гэмт хэрэг урьд оны мөн үеийнхээс 1948 хэргээр буюу 2.3 дахин өссөн байх тул урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй зохион байгуулж үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил, арга хэмжээ зохион явуулах;

Нийслэл хотын хэмжээнд хулгайлах гэмт хэрэг гэр орон сууцанд өглөөний 06:00-14:00, өдрийн 14:00-19:00 цагуудад хамгийн ихээр бүртгэгдсэн байх тул эргүүлийн чиглэл маршрутыг зөв тодорхойлж, хяналт шалгалтыг сайжруулах;

Аж ахуй нэгж, байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, автомашин хулгайлах, мал хулгайлах, автомашинаас эд зүйл хулгайлах, компьютер хулгайлах гэмт хэргүүд өссөн үзүүлэлттэй байх тул дээрх хэргүүдээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, зурагт хуудас тараах, цахим сүлжээгээр иргэдэд анхааруулга түгээх зэрэг саналыг дэвшүүлж байна.

# ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

*О.Амарсайхан  
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,  
криминологийн тэнхимийн ахлах багш,  
цагдаагийн дэд хурандаа*

**Товч агуулга:** Хулгайлах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох талаар санал, дүгнэлт боловсруулсан.

**Түлхүүр үг:** Сэдэлт, эрүүгийн хариуцлага, хууль бусаар авах, эд хөрөнгө.

Хуулийг боловсронгуй болгох явдал бол тасралтгүй явагдах зүй тогтолт үйл явц билээ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нэг төрөл болох хулгайлах гэмт хэргийн шинж /бүрэлдэхүүн/-ийг тогтоосон Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн зарим хэм хэмжээ бүрхэг, ойлгомжгүй, түүнийг хууль хэрэгжүүлэгч субъектүүд нэг мөр ойлгож зөв хэрэглэх явдал учир дутагдалтай байгаа, энэ гэмт хэргийн шинжийг хэрхэн ойлгох талаар Улсын дээд шүүхээс өнөөг хүртэл албан ёсны тайлбар гаргаагүй байгаа, түүнчлэн нийгмийн нөхцөл байдал, амьдралын түвшин, иргэдийн эрх зүйн ухамсар өөрчлөгдсөнөөс гэмт хэрэг, эрүүгийн хариуцлагын тухай асуудлыг хурцаар мэдэрч үнэлэн сонирхох болсон зэрэг нь түүнийг боловсронгуй болгох шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Дээрх байдлуудаас үндэслэн хулгайлах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн асуудлыг харьцангуй цогц байдлаар тухайлбал, энэхүү гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн хууль цаазын уламжлал, хулгайлах гэмт хэргийн ойлголт, нийгмийн хор аюул, эрүүгийн эрх зүйн шинж, зүйлчлэлийн асуудал, хулгайлах гэмт хэрэгт ял оногдуулж буй байдал, ялын бодлогын өөрчлөлт, үр дүнг авч үзсэний үндсэн дээр энэхүү гэмт хэргийг хуульчилсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн хэм хэмжээг боловсронгуй болгох талаар дараах асуудлуудыг дэвшүүлэн тавьж байна. Үүнд:

Нэг. Хулгайлах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын үйлдлийн онцлогтой холбоотой түүний гол шинж бол бусдын эд хөрөнгийг ашиглах шамшигдуулах<sup>93</sup> буюу заавал шунахай сэдэлт, зорилготойгоор үйлдэгддэг явдал юм. Өөрөөр хэлбэл хулгайлах гэмт хэрэг нь заавал шунахай сэдэлт, зорилготойгоор үйлдэгдэж байж субъектив талын шинж бүрддэг. Гэтэл хууль тогтоогчийн зүгээс шунахай сэдэлт, зорилгыг хулгайлах гэмт хэргийн диспозицид шууд үгчлэн зааж өгөөгүй нь энэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоох, зүйлчлэхэд хүндрэл учруулж байна.

Шунахайрах сэдэлт, зорилгыг зөв тодорхойлохын тулд сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс хүний сэтгэц, түүний процессын талаар авч үзэх шаардлагатай. Сэтгэц нь сэтгэл санааны бүх цогц бүрдлийг илэрхийлэх үйлдэл бөгөөд түүний агуулгад сэрэхүй, сэтгэхүй, зохион бодохуй, авир араншин, зан төлөв, авъяас билиг, чадвар дадал, сонирхол зэрэг хүний хувийн шинжүүд хамаарна.<sup>94</sup>

Сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс авч үзвэл гэмт хэрэг нь хүний зориг үйлдлийн ажиллагааны нэг хэлбэр бөгөөд энэхүү зориг үйлдлийн явцыг дотор нь:

а/ Зориг үйлдлийн бэлтгэл үе

б/ Зориг үйлдлийн шийдвэрийн үе

в/Зоригийн үйлдэл буюу хэрэг явдал үйлдэх үе<sup>95</sup> гэж хоорондоо харилцан уялдаа бүхий 3 үе шатанд авч үздэг.

Эдгээр үе шатуудын эхний хоёр нь гэмт сэдэлт, зорилгыг тодорхойлдог. Тодруулбал, зориг үйлдлийн бэлтгэх үе хүнийг ямар нэг үйл ажиллагаа, хэрэг явдал руу чиглүүлэн хөтөлсөн түлхэц

<sup>93</sup> Ж.Болдбаатар. Эрүүгийн эрх зүйн тулгуур ойлголтууд /тусгай анги/. УБ., 2002. 25 дахь тал

<sup>94</sup> С.Жанцан. Хууль зүйн сэтгэл судлал. УБ., 2001.14 дэх тал

<sup>95</sup> Д.Санжжав, Б.Бор. Сэтгэл судлал. УБ., 1990. 216 дахь тал

хүчин зүйл болох хүсэл, хэрэгцээ зэрэг илрэл бүхий сэдэлт төрөх явдлаар илэрдэг.<sup>96</sup> Ийнхүү төрж үүссэн сэдэлт дээр тулгуурласан ямар нэг үйлдэл хийхэд чиглэсэн зорилго, төлөвлөгөө, арга, үр дагаварыг нь урьдчилан тооцсон бодол санаанууд болон нэг нь нөгөөгөө дэмжсэн буюу үгүйсгэсэн агуулгатай хэд хэдэн үйлдлийн сэдэлтүүд төрж, эцэст нь энэ бүхнийг дүгнэж цэгнэсний үр дүнд аль нэг үйлдлийг сонгож авснаар эцсийн шийдвэр гардаг.

Дээр өгүүлсэн "сэдэлт"-ийн эрүүгийн эрх зүй дэх тусгал нь гэмт сэдэлт, зорилго билээ. Гэмт хэргийн сэдэлт сэтгэл зүйн дурьдсан асуудалтай харьцуулахад бие даасан тусгай ойлголт учраас хууль тогтоогчийн зүгээс сэдэлт, зорилгыг гэмт хэрэг бүрийн заавал тогтоох шинжээр зааж өгөөгүй.

Гэмт сэдэлт нь хүнийг гэмт хэрэгт өдөөн түлхэж буй сэтгэхүйн үйл ажиллагаа /өдүүлбэр/ юм. Сэдэлт төрснөөр буй болдог зорилго нь гэмт этгээдийн өөрийн хэрэгжүүлэх гэж буй үйл ажиллагааны эцэст буй болох үр дагаврын талаарх урьдчилсан төсөөлөл байдаг.

Профессор Н.Жанцан "Шунахайн гэмт явдлын үндсэн шинж чанар нь сэдэлтийн өвөрмөц онцлогт байдаг. Энэ сэдэлт нь аливаа материаллаг ашгийг гэмт замаар олж авах гэсэн шунахай сэдэлт юм. Шунахай сэдэлтээр гэмт хэрэг үйлдэгдэхэд халдлагын янз бүрийн объектын эдийн засгийн үр ашиг халдлагад өртөж болно<sup>97</sup> гэж шунахай сэдэлтийн мөн чанарыг оновчтой тодорхойлсон.

Энэ байдлаас ургуулан авч үзвэл,:

Хулгайлах гэмт хэрэг үйлдэхэд түлхэц болж буй шунахайрах сэдэлт гэдгийг, бусдын өмчлөх эрхэд хууль бусаар халдаж, өмчлөл, эзэмшилд байгаа эд зүйлийг нь өмчлөгч болон хариуцаж байгаа этгээдийн зөвшөөрөлгүйгээр, хариу нөхөн төлбөргүй, бүрмөсөн өөрийн өмчлөлд хууль бусаар шилжүүлэн авахад өдөөн түлхэж буй сэтгэхүйн хүчин зүйл юм гэж тодорхойлж болно.

Шунахайрах сэдэлт үүссэний үндсэн дээр буй болох гэмт зорилго нь дээрх сэдэлт үүссэний үндсэн дээр, бусдын өмчлөх эрхэд сэм, нууц далд аргаар, хүч хэрэглэхгүй болон хүч хэрэглэхээр заналхийлэлгүйгээр халдаж эд зүйлийг хууль бусаар өөрийн эзэмшилд авах талаар урьдчилан тооцож буй төсөөллөөр тайлбарлагдана.

Иймд хулгайлах гэмт хэргийн шинжид шунахайрах сэдэлтийг хуульчлах нь бусдын эд хөрөнгийг бүрмөсөн авах санаагүйгээр авах бусад үйлдлээс /бусдын эд хөрөнгийг тоглоомоор авах, айлгаж авах гэх мэт... /, түүнчлэн, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.8 дугаар зүйлд заасан эд хөрөнгө устгах, гэмтээх гэмт хэргээс ялгах гол шинж байх тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн диспозицид " шунахай сэдэлтээр" гэсэн нэр томъёог нэмж хуульчлах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

**Хоёр:** Хулгайлах гэмт хэргийн заавал байх нэг шинж бол тухайн эд хөрөнгийг үнэ төлбөргүй авсан байх явдал байдаг.

Үнэ төлбөргүй авах гэдэг нь гэмт этгээд тухайн эд хөрөнгийг ямар ч үнэ төлбөргүй /хариу төлбөргүй, зохих үнийг төлөлгүй/, эсхүл зохих үнийг хэлбэрийн төдий төлж /1 сая төгрөгийн эд хөрөнгийн үнэд 10000 төгрөг төлөх гэх мэт/ авсан байхыг ойлгодог.

Бусдын эд хөрөнгийг үнэ төлбөргүй авсан байх нь хулгайлах гэмт хэргийн гол шинж болох тухай, түүнийг шүүхийн практикт харгалзан үзэж шийдвэрлэж байх тухай Улсын дээд шүүхээс удаа дараа тогтоож байсан ба хамгийн сүүлд Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолд хулгайлах гэмт хэргийн шинжид "бусдын эд хөрөнгийг үнэ төлбөргүй авсан" байх явдлыг оруулан зааж байлаа.

Гэтэл хулгайлах гэмт хэргийг хуульчилсан одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн диспозицид энэ шинжийг тодорхойлон заагаагүй байна.

Бидний хувьд хулгайлах гэмт хэргийн шинжид "бусдын эд хөрөнгийг үнэ төлбөргүй авсан" байх явдлыг хамааруулахыг дэмжиж байгаа бөгөөд ингэснээр нөгөө талын хүсэл зоригийг харгалзахгүй, хариу төлбөртэй хийсэн иргэний эрх зүйн хэлцлээс хулгайлах гэмт хэрэг ялгагдана гэж үзэж байгаа тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1

<sup>96</sup> Б.Болдбаатар. Дурьдсан зохиол. УБ., 2004. 87 дахь тал

<sup>97</sup> Н.Жанцан. Шунахайн гэмт явдал. прокурорын ном. УБ., 2001.137 дахь тал

дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн диспозицид “үнэ төлбөргүй” гэсэн нэр томъёог нэмж хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.

**Гурав.** Хулгайлах гэмт хэргийн төгсөх үеийг оновчтой зөв тодорхойлох нь энэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоох, улмаар гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял оногдуулахад чухал ач холбогдолтой.

Хулгайлах гэмт хэргийн төгсгөлийн талаар эрдэмтэд, судлаачид өөр өөр үзэл баримтлалтай байдаг. Олонхи судлаачид, практик ажилтнууд хулгайч эд хөрөнгийг нууц аргаар бусдын эзэмшлээс авч, улмаар өөрийнхөө үзэмжээр захиран зарцуулах боломжтой болгосноор энэ гэмт хэрэг төгсөнө гэж үзэж байхад, зарим судлаачид эд хөрөнгийг эзэмшилдээ авсан үеэс хулгайлах гэмт хэрэг төгссөнд тооцогдоно гэж үздэг байна.

Түүхэн уламжлалын үүднээс авч үзвэл Улсын дээд шүүхийн 1997 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 259 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн 4-д “Хулгайлах гэмт хэрэг нь гэмт этгээд авсан зүйлээ өөрийн дураар эзэмших буюу захиран зарцуулах боломж бүрдсэн үеэс төгс үйлдэгдсэнд тооцогдоно”<sup>98</sup> гэж тайлбарлаж байсан нь тухайн үедээ хулгайлах гэмт хэргийн шинж, Эрүүгийн хуулийн заалттай зөрчилдсөн, хууль хэрэглэгч субъектүүдийг төөрөгдөлд оруулсан буруу тайлбар байсныг зориуд дурдах ёстой.

2002 оны Эрүүгийн хууль батлагдан мөрдөгдөж улмаар Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол...” гэж энэ гэмт хэргийг үйлдэл хийснээр төгссөн байхаар хоёрдмол утгагүй, хэн бүхэнд ойлгомжтойгоор хуульчилсан байхад Улсын дээд шүүх “Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай” 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолдоо “Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэдгийг бусдын эд хөрөнгийг нууц далд аргаар, шунахай сэдэлтээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авч бүр мөсөн, үнэ төлбөргүй өөрийн өмчийн адил захиран зарцуулах боломж бүрдүүлсэн буюу захиран зарцуулсан шууд санаатай үйлдлийг ойлгоно”<sup>99</sup> гэж тайлбарласан нь хулгайлсан, өөрөөр хэлбэл эд зүйлийг авснаар төгссөн байх Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулгад илт нийцэхгүй тайлбар болж байсан юм.

Бидний үзэж байгаагаар, хулгайлах нь материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг бөгөөд хулгайч өмчлөгч, эзэмшигчийн өмчилж, эзэмшиж байсан эд хөрөнгийг өөрийн эзэмшилд авсан, бусдын өмчлөх, эзэмших эрх зөрчигдсэн тэр үеэс төгссөн гэмт хэрэг болно.

Хулгайлах гэмт хэргийг хулгайч хулгайлж авсан зүйлээ өөрийн үзэмжээр захиран зарцуулах боломжтой болсон үеэс төгсөнө гэж үзэх нь үндэслэлгүй байр суурь бөгөөд хулгайлах гэмт хэрэгтэй явуулах тэмцлийг сулруулах аюултай.

Энэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол...” гэж үйл үгийн өнгөрсөн цаг дээр томъёолсон байгаагаар няцаагдаж байна. Эндээс бусдын эд хөрөнгийг хулгайлах гэдэг нь бусдын өмчлөл, эзэмшилд байгаа эд хөрөнгийг нууц, далд аргаар хариу төлбөргүйгээр, шунахай сэдэлтээр зөвхөн өөрийн эзэмшилд авсан идэвхитэй үйлдэл юм.

Энэ талаар “Хулгайч бусдын эд хөрөнгийг зарцуулах боломж бүрдээгүй бол бэлтгэсэн, завдсанаар хариуцлага хүлээлгэх нь зөв юм”<sup>100</sup> гэж 1982 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн тайлбар зохиогчдын үзэл бодлыг доктор /Sc.D/, профессор С.Жанцан, доктор (Ph.D) Б.Болдбаатар нар дэмжсэнийг өнөөгийн нөхцөлд бид хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж байна.

Эдгээрээс үндэслэн энэхүү гэмт хэргийн төгсөх үеийг зөв тодорхойлохын тулд “Хулгайлах гэмт хэрэг нь гэмт этгээд тухайн эд хөрөнгийг өөрийн эзэмшилд авсан үеэс төгс үйлдэгдсэнд тооцогдоно” гэсэн тайлбарыг Улсын Дээд Шүүхээс гаргах шаардлагатай гэж үзэж байна.

**Дөрөв.** Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан хулгайлах гэмт хэргийг мөн хуулийн тусгай ангийн 17.7 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл учирч байна.

Учир нь авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Авто тээврийн хэрэгслийг завших

<sup>98</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл. УБ., 2004. 122 дахь тал

<sup>99</sup> Улсын Дээд Шүүхийн 2006 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 28 дугаар тогтоол

<sup>100</sup> С.Жанцан, Ж.Халиунсүрэн. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага, криминологийн асуудал. УБ. 2008. 44 дэх тал

зорилгогүйгээр өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр авч явсан нь хулгайлах, дээрэмдэх гэмт хэргийн шинжгүй бол ... ” гэж заасан юм. Авто тээврийн хэрэгслийг завших зорилгогүй, хулгайлах, дээрэмдэх гэмт хэргийн шинжгүйгээр авч явах боломжгүй, өөрөөр хэлбэл авто тээврийн хэрэгслийг нууцаар авбал хулгайлах, илээр авбал дээрэмдэх гэмт хэргийн шинжтэй болох учир энэ хоёр гэмт хэргийг ялган зүйлчлэх боломжгүй байгаа юм.

Авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах гэмт хэргийн гол агуулга нь авто тээврийн хэрэгслийг завших<sup>101</sup> зорилгогүйгээр өөрөөр хэлбэл хөл дайх, унаж тодорхой газар хүрэх зорилгоор хууль бусаар эзэмшсэн байхыг хэлнэ.

Иймд энэхүү гэмт хэргийг хулгайлах, дээрэмдэх гэмт хэргээс ялган зүйлчлэх боломжийг хангахын тулд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “”Авто тээврийн хэрэгслийг завших зорилгогүйгээр өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр авч явсан бол ... ” гэж өөрчлөн томъёолох шаардлагатай гэж үзэж байна.

**Тав.** Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 17.1 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хохирлын хэмжээг бага хэмжээнээс дээш буюу 300,000 төгрөгөөс дээш тогтоох нь зүйтэй. Ингэснээр гэмт хэрэг болон зөрчлийг нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээгээр нь ялгах боломж бүрдэнэ.

**Зургаа.** Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.4-т “учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол ...” гэж заажээ.

Энэ нь гэмт этгээдийн өөрийн гэмт үйл ажиллагааг хөнгөвчлөх, түргэтгэх, үйлдлээ хялбарчлах, эд хөрөнгийг зөөж тээвэрлэх /хулгайлах үйлдэл төгссөний дараа түүнийг зөөж тээвэрлэх, хэргийн газраас зайлуулах зэрэгт машин механизм ашигласныг энэ ойлголтод хамааруулахгүй байна/ зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн, машин механизм ашигласан хулгайлах үйлдлийг энэ заалтаар зүйлчлэх боломжгүй болгож байна.

Бид зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл, машин механизмыг ямар зорилгоор хэрэглэсэн, ашигласан нь хариуцлагыг хүндрүүлэх үндэслэл болохгүй, гагцхүү тэдгээрийг хэрэглэсэн, ашигласан байх нь хариуцлагыг хүндрүүлэх үндэслэл болох ёстой бөгөөд дээрх заалт нь хэт явцуу, гэмт этгээдийн хулгайлах үйлдлийн нийгмийн аюулын шинж чанарыг бодитой илэрхийлэх оновчтой зохицуулалт биш гэж үзэж байна.

Иймд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.4 дэх заалтаас “учрах саадыг арилгах зорилгоор” гэсэн үгийг хасч “зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол” гэж өөрчлөн томъёолох нь зүйтэй.

**Долоо.** Хулгайлах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалттай холбоотой өөр нэг асуудал бол уг хэргийн хөөн хэлэлцэх хугацааны тухай асуудал юм.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд: Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй:

- энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;

- энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

- энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн;

- энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг арван хоёр жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн гэж заасан.

Гэтэл хулгайлах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн болох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн санкцид “хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл

<sup>101</sup> “Завших” гэдэг үг нь бусдын юмыг өөрийн болгох, хувьдаа ашиглах гэсэн утгатай. Монгол хэлний их тайлбар толь.



хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан ба энэхүү ялын төрөл, хэмжээ нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан 1, 5, 12, 20 жилийн хөөн хэлэлцэх хугацааны алинд нь ч хамаарахгүй байгаа юм<sup>102</sup>.

Эндээс үзэхэд, хулгайлах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн болох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн санкцид заасан ялын төрөл, хэмжээ нь тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлох, тогтоох /хэдэн жилийн хөөн хэлэлцэх хугацаатай гэмт хэрэг вэ гэдгийг илэрхийлэх/ оновчтой зохицуулалт болж чадаагүй байх бөгөөд энэ нь тухайн гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд хүндрэл учруулж байгаа тул Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн санкцид заасан ялын төрөл, хэмжээ болон хөөн хэлэлцэх хугацааг тогтоосон мөн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хэм хэмжээний уялдаа холбоог хангасан зохицуулалтыг яаралтай хийх шаардлагатай байна.

Бидний үзэж байгаагаар, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн”<sup>103</sup> гэсэн заалт нэмж, мөн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн санкцыг дээрх хэм хэмжээнд нийцүүлэн “хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж өөрчилбөл энэхүү ойлгомжгүй, тодорхойгүй асуудлыг бүрэн дүүрэн шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

---

<sup>102</sup> Бидний Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацаанд хийсэн судалгаагаар хөөн хэлэлцэх хугацааг нь тодорхойлох боломжгүй байдлаар ялын төрөл, хэмжээ нь хуульчлагдсан 54 гэмт хэргийн бүрэлдэхүүн байгаа юм.

<sup>103</sup> Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд энэ заалтыг нэмэх тухай заасан боловч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн санкцыг өөрчлөх тухай заагаагүй байна.

## ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙ ЗҮЙЛЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

*Т.Мөнхдалай*

*Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн  
ахлах багш, докторант*

**Товч агуулга:** Гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээгээр тодорхойлогдох бөгөөд бага хэмжээний хохирол учруулсан нь ялимгүйн учир нийгэмд аюул багатай үйлдэл, эс үйлдэхүйгээр гэмт хэргийн шинж үгүйсгэгдэх тул гэмт хэрэгт тооцохгүй байх явдал нь онолын болон практикийн ач холбогдолтой.

**Түлхүүр үгс:** Гэмт хэрэг, гэмт үйлдэл, гэмт эс үйлдэхүй, нийгмийн хор аюул, хор уршиг, хохирол, бага хэмжээний хохирол.

Улсын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хангах ажлын хүрээнд тулгамдаж байгаа олон асуудлуудын нэг нь хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх явдал бөгөөд 2015 оны Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх үйл явцтай холбоотойгоор сүүлийн жилүүдэд бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн тоон үзүүлэлт өсөн нэмэгдсээр байгаа явдал бол батлан гаргасан эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээг зөв ойлгож, зөв хэрэглэж чадаагүй, хулгайлах гэмт хэргийг зүйлчлэх ажиллагаа буруу хийгдэж байгаа үйл явдалтай холбоотой.

2015 оны Эрүүгийн хуульд<sup>104</sup> хулгайлах гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүнд гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинжийг харгалзан торгох ял оногдуулахгүйгээр нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялаас сонгон оногдуулахаар тусгайлан авч үзэж, хулгайлах гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатган авч үзэхийг хууль тогтоогчоос эрхэмлэсэн хэдий ч Үндсэн хууль болон Эрүүгийн хуулийн үзэл баримтлал, зорилт, агуулгыг нэг мөр ойлгох, тайлбарлах, хэрэглэхэд хүндрэл учраад байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Хуулийн зарим нэг хэм хэмжээ, зүйл заалт, тайлбарууд нь өөр хоорондоо зөрчилдсөн, ойлгомжгүй байгаа нь эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж улмаар хүний эрхийг ноцтой зөрчихөд хүргэж байна.

Криминологийн сонгодог сургаалыг үндэслэгч Чезаре Беккариа өөрийн бүтээлдээ “Хуулийг тайлбарлах нь нүгэл гэвч түүнийг тайлбарлахаас зайлсхийж бүрхэг тодорхойгүй хэвээр үлдээж байгаа нь мөн л нүгэл. Харь улсын хэлээр хуулийг бичиж нийтийн зүйлийг хувийн болгож, ард олныг өөрийн эрх чөлөөний хэмжээ хязгаарыг шүүн хэлэлцэх боломжийг хязгаарлаж, хувь хүний эрх чөлөөг хэдхэн хүнээс хамааралтай болгож байгаа нь энэ нүгэл туйлдаа хүрсэний жишээ”<sup>105</sup> хэмээн тэмдэглэсэн байдаг.

Үүнийг тэрлэгч миний бие мөрдөгч, прокурор, шүүгчээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийн холбогдох зүйл заалтыг Үндсэн хууль болон Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зүйл заалтанд нийцүүлэн хэрэглэж гэмт хэргийг зөв зүйлчлэх нь шударга ёсны зарчмын илрэл болох талаар судлаач та бүхэнтэй өөрийн санаа бодлыг хуваалцахыг хүссэн болно.

Амьдралд үйлдэгдэн гарсан эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтоох, гэм буруутай хүн, хуулийн этгээдэд оногдуулах ял шийтгэлийг тодорхойлоход гэмт хэргийн зүйлчлэл чухал бөгөөд энэ талаар гавъяат хуульч, академич С.Нарангэрэл өөрийн бүтээлдээ “Гэмт хэргийн зүйлчлэл гэдэг нь гэмт этгээдийн үйлдсэн нийгэмд аюултай хэрэг, эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой хэм хэмжээнд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүхий л шинжтэй нарийн нийцэж байгааг тогтоох ба байцаан шийтгэх ажиллагаанд бэхжүүлэх явдал мөн”<sup>106</sup> гэж тэмдэглэсэн бол Оросын эрдэмтэн В.Н.Кудрявцев “Гэмт хэргийн зүйлчлэл бол эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнд заагдсан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжүүд болон гэмт үйлдлийн шинж тэмдгүүд хоорондын зохицлыг яв цав тогтоож, хууль зүйн үүднээс бэхжүүлэх явдал”<sup>107</sup> гэж тус тус тодорхойлжээ.

<sup>104</sup> Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2017 он.№23

<sup>105</sup> Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай./Г.Эрдэнэбатын орчуулга/УБ.2009. 33 дах тал

<sup>106</sup> С.Нарангэрэл “Гэмт хэргийн зүйлчлэлийн шинжлэх ухааны үндэс” УБ 1988 он

<sup>107</sup> В.Н.Кудрявцев “Общая теория квалификаций преступлений” М.1999г.стр 7

Хулгайлах гэмт хэргийн үндсэн шинж нь бүрэн хангагдсаны дараа уг гэмт хэргийн хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзэж хуулийн холбогдох зүйл заалтаар зүйлчлэх ажиллагааг хийж тухайн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Хууль зөрчсөн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрүүгийн хуульд заасан хохирол учруулаагүй бол гэмт хэргийн үндсэн шинж үгүйсгэгдэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэх үндэслэлээр зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулдаг.

Хулгайлах гэмт хэргийг өмчлөх эрхийн эсрэг бусад төсөөтэй хэргээс ялган зүйлчлэх гол үндэслэл нь түүний үндсэн шинж бөгөөд энэ талаар эрдэмтэн судлаачид тодорхойлоходоо “Үндсэн хууль болон Эрүүгийн хуулиар хамгаалагдсан бусдын өмчлөх эрхэнд хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар халдаж хохирол, хор уршиг учруулдаг хулгайлах гэмт хэргийн үндсэн шинж нь бусдын өмчлөх эрхэнд **бага хэмжээнээс дээш хэмжээний хохирол** учруулж, бусдын эд хөрөнгийг захиран зарцуулах боломж бүрдүүлсэн буюу захиран зарцуулснаар төгсдөг материаллаг шинжтэй гэмт хэрэг юм”<sup>108</sup> гэжээ.

Бага хэмжээний хохирол гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг<sup>109</sup>, хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна<sup>110</sup> гэж Эрүүгийн хуульд хуульчилсан.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн тайлбарт “энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдийн улмаас **бага хэмжээний хохирол** учирсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2,3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж хуульчилсан нь онол, практикийн хувьд буруу шийдвэр болсон гэж зарим судлаачдийн зүгээс үздэг ба энэ үзэл онолыг судлаач миний бие дэмждэг болно.

Хулгайлах гэмт хэргийн ердийн буюу үндсэн шинжийг хуулийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.1 дэх хэсэгт тайлбарын хамт маш тодорхой, ойлгомжтой авч үзсэн мөртлөө мөн зүйлийн хүндрүүлэх, онц хүндрүүлэх шинжид нь бага хэмжээний хохирол учирсан эсэхийг үл харгалзан гэмт хэрэгт тооцохоор тайлбарлаж<sup>111</sup> хуульчилсан нь буруу бөгөөд тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн үндсэн шинжийг хангаж байж хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцлийг хэрэглэх боломжийг бүрдүүлдэг.

Тодруулбал: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.2, 17.1.3 дахь хэсэгт **“энэ гэмт хэргийг”** үйлдсэн бол хүндрүүлэх, онц хүндрүүлэн үзэхээр хуульчилсан бөгөөд хуульд заасан “энэ гэмт хэрэг” гэсэн ойлголт нь 17.1-д заасан гэмт хэргийн бүх шинжийг агуулсан буюу “бусдын хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсны улмаас 300.000 төгрөгнөөс дээш хэмжээний хохирлыг учруулсан байх нь хулгайлах гэмт хэргийн гол үндсэн шинж хэмээн хуульчилсан атлаа “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тайлбар нь 2.3 дахь хэсэгт хамаарахгүй” гэж тайлбарласан нь “энэ гэмт хэрэг” гэсэн нэр томъёог хэрэглэх ёстой байтал огт хэрэглээгүй, хуулийн зүйл заалтыг буруу тайлбарласан нь Эрүүгийн хуулийн нэгдүгээр бүлэгт заасан хууль ёсны зарчмын “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно”, “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй” гэсэн хуулийн заалттай тус тус зөрчилдөж байна.

Хууль тогтоогчоос шударга, хууль ёсны зарчмуудыг Эрүүгийн хуульд хуульчлан тодорхойлсон атлаа түүнийг хэрэгжүүлэх, мөрдөн сахихад хуулийн тусгай ангийн зүйл заалтууд өөр хоорондоо зөрчилдсөн хэм хэмжээг агуулсан байгаа нь хүний тэгш эрхийн зарчмыг зөрчсөн үйл ажиллагаа болно.

**Шигтгээ:** эрүүгийн 18090333333 дугаартай хэргийн яллагдагч Н.Б нь 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороонд иргэн Б.Нямын монгол гэрийн хаалганы цоожийг хөшиж орж, “Монел” загварын 32 инчийн зурагтыг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч Б.Нямд 160,000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэж шүүхээр шийтгүүлсэн.

**Шигтгээ:** эрүүгийн 18090333325 дугаартай хэргийн яллагдагч Д.Б, Н.Л нар нь 2018 оны 10 дугаар сард Цагаан-Уул суманд иргэн Б.Төртогтохын дэлгүүрт хууль бусаар нэвтрэн орж 180,000 төгрөгийн үнэ бүхий архи, пиво хулгайлан авч эд хөрөнгийн хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэж шүүхээр шийтгүүлсэн байна.

<sup>108</sup> С.Гантулга, Б.Энхболд “Эрүүгийн эрх зүй” тусгай анги.УБ.2018.179 дэх тал

<sup>109</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015 он. 2 дугаар бүлэг. 2.5 дугаар зүйлийн 2.5.4.3 дах хэсэг

<sup>110</sup> Дурьдсан хуулийн 5 дугаар бүлэг, 5.3 дугаар зүйлийн 5.3.3 дах хэсэг

<sup>111</sup> Дурьдсан хуулийн 17 дугаар бүлгийн 17.1 дэх хэсгийн тайлбар “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тайлбар нь 2.3 дахь хэсэгт хамаарахгүй” гэжээ.

Дээр дурьдсан хоёр тохиолдол нь эрүүгийн хуулийн тухайн бүлгийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.2.1-д заасан “хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч үйлдсэн” үйлдэлд учруулсан хохирлын хэмжээг үл харгалзан гэмт хэрэг үйлдсэнд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй нь шударга ёсны зарчмыг зөрчсөн хэрэг бөгөөд “... хууль шүүхийн өмнө хүн бүр эрх тэгш байна”, “хүнийг ... нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажлаар ... нь ялгаварлан гадуурхаж үл болно”<sup>112</sup> гэсэн Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалтай зөрчилдсөн явдал болох юм.

Тухайн хүн хэдийгээр хулгай хийсэн гэм буруутай ч, бусдын өмчлөлд байгаа хөрөнгө болох 300.000 төгрөгнөөс доош хохиролтой эд зүйлийг орон байр агуулах саванд нэвтрэн орж хулгайлан авсан үйлдэлдээ учруулсан хохирлын хэмжээг үл харгалзан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй, ял шийтгэл хүлээж байгаа нь “хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”, “хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй”<sup>113</sup> гэсэн хуулийн зарчим, заалтуудыг зөрчиж байгаа асуудал болно.

Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэргийн үндсэн болон хөнгөрүүлэх, хүндрүүлэх, онц хүндрүүлэх нөхцөл шинжүүдийн хоорондын харилцан уялдаа, хамаарлыг авч үзэхдээ логикийн хуулийг зөрчиж ойлгомжгүйгээр хуульчилсан нь хуулийг хэрэглэхэд хүндрэл учруулж, улмаар хуулийг төсөөтэй хэрэглэх боломжийг бий болгож уг чанартаа хүний эрхийг хамгаалах биш ноцтой хохирооход хүргэж байна.

Гэм буруутай хүн бусдын орон байр, агуулах саванд хууль бусаар нэвтэрч 300.000 төгрөгнөөс доош хэмжээний хохирол учруулсан байхад түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж ял шийтгэх нь хуулийг буруу хэрэглэж байгаа явдал бөгөөд зүй нь “бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг албадан сургалтанд хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна”<sup>114</sup> гэсэн хуулийн заалтыг баримтлах нь онол, практикийн ач холбогдолтой болно. Түүнчлэн, шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан “Гэмт этгээд /гэм буруутай хүн/ үнэ цэнэтэй эд зүйлийг хулгайлан авахаар санаархсан боловч үнэн хэрэг дээрээ хулгайлж авсан эд зүйл нь бага үнэтэй байсан бол үйлдлийг эрүүгийн хуулийн /2002 оны/ 32 дугаар зүйлийн 32.3 дах хэсгийг журамлан 145 дугаар зүйлийн 145.1 дэх хэсгээр зүйлчлэх нь зүйтэй”<sup>115</sup> гэж тодорхойлсон нь гэмт хэргийн улмаас учирсан бодит хохирлын хэмжээгээр зүйлчлэх нь зүйтэйг тэмдэглэсэн байна.

Хулгайлах гэмт хэргийг хуулийн тохирох зүйл ангиар шалгаж шийдвэрлэхэд зүйлчлэлийн асуудал чухал бөгөөд дээр дурьдсан хоёр тохиолдолд шүүхээс оногдуулсан хорих ял нь нэгдүгээр бүлэгт заасан шударга ёсны зарчмын “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна”<sup>116</sup>, хоёрдугаар бүлэгт заасан “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний ... эд хөрөнгөнд **шууд** учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно”<sup>117</sup> гэсэн хуулийн заалттай тус тус зөрчилдөж байна.

“Гэмт хэрэг ба ял хоорондоо тохирсон байх ёстой”.<sup>118</sup> Хулгайлах гэмт хэрэгт шүүхээс ял оногдуулахдаа шүүгдэгчийн үйлдсэн хэргийн нийгмийн хор аюулын шинж, хэр хэмжээ, шүүгдэгчийн хувийн байдал, хэрэг үйлдэх үеийн бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж шүүгдэгчийн гэм буруу, учруулсан хохиролд нь таарч тохирсон ялыг оногдуулах нь шударга ёсны хэмжүүр болох юм.

Хулгайлах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах, шийдвэрлэх, урьдчилан сэргийлэхэд тухайн гэмт хэрэг үйлдэгдэн гарч буй бүхий л арга болон оролцогч нэг бүрийн үйлдэл, оролцооны талаар нарийвчлан судлаж, энэ талын гүнзгий мэдлэгтэй

<sup>112</sup> Монгол Улсын Үндсэн хууль 1992 он, II бүлэг, XIX зүйл

<sup>113</sup> Дурьдсан хуулийн 1 дүгээр бүлгийн 1.3. дугаар зүйлийн 1.3.2 дах заалт

<sup>114</sup> Монгол Улсын “Зөрчлийн тухай хууль” 8.6 дугаар зүйл

<sup>115</sup> С.Жанцан. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй” тусгай анги/схемчилсэн тайлбар, зүйлчлэл/ УБ. 2003. 149 дэх тал

<sup>116</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015 он. 1 дүгээр бүлэг. 1.3 дугаар зүйлийн 1.3.1 дэх хэсэг

<sup>117</sup> Дурьдсан хуулийн 2 дугаар бүлгийн 2.5 дугаар зүйлийн 2.5.1 дэх заалт

<sup>118</sup> Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай./Г.Эрдэнэбатын орчуулга/УБ.2009. 35 дах тал

байх нь онол, практикийн чухал ач холбогдолтой бөгөөд хэргийг зөв зүйлчлэж, шалгаж шийдвэрлэхэд дөхөм болно.

“Хулгайлах гэмт хэрэг, түүний зүйлчлэлийн зарим” асуудал сэдвийн хүрээнд дараахи саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хулгайлах гэмт хэргийн үндсэн шинжид буюу ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.2.1 дэх хэсэгт заасан хулгайлах үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учирсан бол гэмт хэрэгт тооцохгүй байх, зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцох
2. ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн тайлбараас “Энэ зүйлийн 2.3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэсэн хэсгийг хуулиас хасах зэрэг болно.

## **ХҮН БАРЬЦААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*Д.Сундуйсүрэн  
ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн  
профессор, цагдаагийн хурандаа*

**Товч агуулга:** Хүн барьцаалах гэмт явдал балар эртний овгуудад үйлдэгдэж байсан бөгөөд ёс заншил хэлбэрээр олон мянганы туршид уг үндсээ хадгалж ирсэн. Ромчууд энэ аргыг нэлээд түгээмэл ашиглаж, алслагдсан мужуудын хүн амыг барьцаалах замаар тэдгээр улсуудад эрхшээлээ тогтоодог байжээ. Цаг улиран одох тутам хүн барьцаалахтай төстэй гэмт явдлын арга, хэлбэрүүд өөрчлөгдөж, түүнтэй тэмцэх чиглэлээр хууль цааз батлагдсаар иржээ.

**Түлхүүр үг:** Барьцаа, хүн барьцаалах, барьцааны хүн, гэрээ, хувийн аюулгүй байдал, боол, дээрэм хийх, барих, хорих, эрх чөлөөг нь хязгаарлах, болзол тавих

### **Оршил**

Орчин үед дэлхийн улсууд гэмт явдалтай тэмцэх хамтын ажиллагаандаа олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх явдлыг багтаан оруулжээ. “Хүн барьцаалах” гэмт хэрэг сүүлийн жилүүдэд цөөнгүй үйлдэгдэх болсон ба энэ нь цоо шинээр гарч буй үзэгдэл биш юм.

Хүн барьцаалах үйлдлийн нэн эртний хэлбэр бол далайн дээрмийн ажиллагаа байлаа. Хэдийгээр хүмүүсийг барьцаалах нь ихэнхдээ тэднийг боол болгон худалдах зорилготой ч барьцааны мөнгө нэхэх ба олзлогсодоор солих зорилго ч цөөнгүй удаа тавигддаг байв. Энэ тухай түүхэн олон баримт бий.

Эртний алдартай далайн дээрэмчид нь европын иргэншлийг үндэслэгч Грекчүүд байжээ. Аугаа Ахиллес өөрөө далайн дээрэмчин байсан. Гомерийн “Одиссейд” өөрийн хүмүүсийн хамт Исмарт бууж “эрчүүдийг нь алж, эхнэрүүдийг нь олзолж, эд хөрөнгийг тонон, хотыг цөллөсөн” тухайгаа Алкиной хаанд ярьсан Одиссей түүнтэй адил байсан юм.<sup>119</sup> Египетийн фараон III Рамзест түүний нарийн бичгийн даргын барьсан мэдээлэлд Газар дундын тэнгэсийн зүүн хэсэгт, далайн хөл хөдөлгөөнтэй замын ойролцоо довтлоход тохиромжтой газрууд (булан, арлууд) байдаг. Тэнд далайн дээрэмчид нуугдан дээрэм тонуул хийдэг төдийгүй хүмүүсийг ангуучлан боол болгодог тухай дурьджээ. Финикчүүд далайн худалдааг далайн дээрэм, хүн ангуучилж боол болгохтой сүрхий хослуулдаг байв. Хожим далай дээр ноёрхохын төлөө финикчүүдтэй далайн тонуул, хүн хулгайлах явдлыг цөөнгүй хийдэг Грекүүд дайтах болжээ. Фокейчууд, этрускууд, мөн карфагенчууд ч далайн дээрэм хийдэг байж. Далайн зарим дээрэмчид хүмүүсийг хулгайлан дараагаар нь боол болгон<sup>120</sup> худалдаалахад мэргэшсэн гэж хэлж болохоор байв. Эгийн тэнгэсийн Делос арал

<sup>119</sup> Уилсон К. Мир криминалистики. В 2 т. / Пер.с англ. –Смоленск: Русич, 1977. Т.1- С.123-140

<sup>120</sup> Резепкин О.Ю.,Журавлев И. А. Захват заложника. Уголовно-правовая регламентация проблемы. М.,2003.С.6.

дээр МЭӨ 69 он буюу түүнийг сүйрч сөнөх хүртэл өдөр бүр мянга илүү хүнийг боол болгон зардаг боолын том зах ажиллаж байжээ.<sup>121</sup>

Далайн дээрэм бол Аугаа Ромын эзэнт улсын жинхэнэ гай зовлон байлаа. Нэгэн баримтанд өгүүлснээр Римээс Родос арал рүү залуухан Гай Юлий Цезарь суун хөвж явсан хөлөг рүү кикийн далайн дээрэмчид довтолжээ. Тэд олзлогдсон Цезарийн төлөөсөнд эхлээд 10, дараа нь 20 талант нэхжээ. Өөрийнх нь төлөө бага мөнгө шаардсанд гомдсон Цезарь тэдэнд 50 талант санал болгосон бөгөөд суллагдсан даруйдаа тэднийг олзлон цаазлана гэж амлажээ. Барьцааны хүний сүрдүүлгийг үл тоомсорлосон дээрэмчид 50 талант аваад түүнийг суллажээ. Барьцаанд 38 хоног өнгөрөөсөн Цезарь чөлөөлөгдсөнийхөө маргааш гэхэд 4 хөлөг онгоц бүхий 500 цэргээр Фармакусса арал дээрх дээрэмчид рүү довтолсон 350 хүнийг олзлон тэр даруй цаазалжээ. Энэ явдлын тухай Цезарын түүхч Плутарх, Светоны нар бичжээ.

“Барьцааны хүн” гэдэг ойлголт нь өөрөө ёс мэт цэрэг дайны ажиллагаатай, эсвэл түүний үр дүнтэй холбоотойгоор байгуулагдсан гэрээний биелэлттэй холбогддог гэдгийг янз бүрийн толь бичигт, тодорхой харуулдаг. 1894 онд К.К.Арсеньев, Е.Е.Петрушевский нарын редакторлосон “Нэвтэрхий толь бичиг”-т “барьцаалагдагч” гэдэг нь “гэрээний биелэлтийг хангахаар барьцаанд тавьсан эсвэл барьцаанд авсан хүн” юм гэж тодорхойлжээ.<sup>122</sup> Энэ тодорхойлолт нь иргэний хуулийн “барьцаа” гэсэн ойлголттой агуулгын хувьд тохирч байна.

1952 оны “Зөвлөлтийн их нэвтэрхий толь бичиг”-т “барьцааны хүмүүс” гэдгийг “цэргийн аюулгүй байдлыг хангах болон ямар нэгэн амлалтыг биелүүлэх болзол болгож байлдаж буй талуудын аль нэг нь хүчээр саатуулсан нөгөө талын иргэд” гэж тодорхойлжээ.

1972 оны мөн энэ нэвтэрхий тольд барьцааны хүний тухай ойлголтыг мөн л цэргийн мөргөлдөөнтэй холбон: “барьцааны хүмүүс бол эзлэгдсэн нутаг дэвсгэрийн оршин суугчдын эсэргүүцлээс сэргийлэх зорилгоор байлдагч талууд хууль бусаар саатуулсан хүмүүс мөн” гэж томъёолжээ.<sup>123</sup>

С.И.Ожеговын 1978, 1988, 1990 онуудад хэвлэсэн Орос хэлний толь бичигт барьцааны хүний тухай ойлголт дайнтай холбогдоогүй байна. “Барьцааны хүн гэж ямар нэгэн шаардлагын (түүнийг суллуулах сонирхолтой талд тавьсан) биелэлтийг хангахын тулд хүчээр саатуулагдсан хүнийг хэлнэ” гэсэн тодорхойлолт илүү оновчтой болсон гэж үзэж болно.

1984 оны Дипломатын толь бичигт барьцааны хүний тухай өгсөн тодорхойлолт “Барьцааны хүмүүс гэж гуравдагч этгээдээр аливаа нэг үйлдлийг хийлгүүлэх, эсвэл түүнээс татгалзуулах зорилгоор чөлөөлөх, шууд болон дам болзол тавьж хулгайлагдсан, үхлийн аюул, бэртээж гэмтээх заналхийлэл дор баригдаж саатуулагдсан хүмүүсийг хэлнэ”<sup>124</sup> гэсэн нь хүн барьцаалахтай тэмцэх тухай Олон улсын конвенцийн тодорхойлолттой агуулгын хувьд ойролцоо байна.

1990 оны Зөвлөлтийн нэвтэрхий толь бичигт барьцааны хүмүүст “улс, байгууллага буюу бусад этгээдэд тодорхой шаардлага, эсвэл үүргийг биелүүлэхийг тулгах зорилгоор хүчээр саатуулагдсан хүмүүсийг” хамааруулжээ.<sup>125</sup>

Хүн барьцаалах (англ. seizure of hostages; ор.захват заложника) - ыг, аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс мөнгө, бусад эд хөрөнгө гаргуулах буюу өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, эсхүл үйлдэл гүйцэтгэхээс татгалзуулах болзол тавьж хүнийг барьцаалсан<sup>126</sup> байхыг ойлгохоор маш оновчтой тодорхойлсон.

Толь бичиг, нэвтэрхий толийн сүүлийн жилүүдийн хэвлэлд барьцааны хүний тухай орсон тодорхойлолт энэ үзэгдлийн орчин үеийн ойлголттой илүүтэй тохирч байгаа юм.

### **а) Хүн барьцаалахтай төстэй гэмт явдалтай тэмцэж ирсэн зан заншлын эрх зүйн үе (МЭ III–XII зуун)**

Монгол Улс нь 2300-аад жилийн тэртээгээс төр улсаа байгуулж, түүхэн цаг үеүдэд олон тооны цааз, засаг хууль тогтоож нийгмийн харилцааг зохицуулж ирсэн, төв азийн эртний соёлт ард түмний нэг билээ. Монголчуудын төр, хууль цааз нь тэдгээрийн аж

<sup>122</sup> Энциклопедический словарь. Арсеньев К.К. и Петрушевский Е.Е. СПб., 1894. Т. XII. С. 192

<sup>123</sup> Большая советская энциклопедия. М., 1972. Т. 9. С. 316

<sup>124</sup> Дипломатический словарь. М., 1984. Т. 1. С. 375

<sup>125</sup> Советский энциклопедический словарь. М., 1990. С. 452

<sup>126</sup> С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2007. 560 дахь тал

амьдралын хэвшил, зан заншил, шашин шүтлэг болоод ертөнцийг үзэх үзэлтэй салшгүй холбоотой үүсч, хөгжиж иржээ.

Монгол туургатны төрт ёс, хууль цаазны уламжлал, сэтгэлгээ нь эртний Хүннүгийн үеэс эх улбаатай. МЭ III зууны сүүлч IV зууны эхэн үед монгол нутгийн төв ба өмнөд хэсгээр амьдарч байсан нүүдлийн малчин хүннү нарын 24 аймаг нэгдэж холбоо байгуулснаар Хүннү улс үүссэн гэдэг. Хүннүгийн эрх зүйн хэм хэмжээний уг гарал нь зан заншлын ёс горимууд байсан билээ. Иймд Хүннүгийн эрх зүйн эх сурвалж (хэлбэр) бол бичигдмэл бус, овгийн байгууллаас уламжлалтай аливаа хориглох заншилд дулдуйдсан заншлын эрх зүйн хэм хэмжээний шинжийг агуулж байсан гэж үзэх үндэстэй юм.<sup>127</sup>

Хүннү болон түүнээс хойшхи үеийн эртний төрт улсын үед хэв хуулиар нийгмийн харилцааг зохицуулж ирсэн гэсэн дүгнэлтийг судлаачид бүтээлдээ олонтаа тусгасан байна. Тухайлбал; Хүннү, Кидан гүрний үед нийгмийн харилцааг зан заншлын хэм хэмжээгээр зохицуулж байсан нь хаадын зарлиг, хад чулуу, хашаанд сийлсэн бичиг, сэлтээр батлагдана гэж тэмдэглэсэн байна.

Хүннүгээс эхэлсэн нүүдэлчдийн зан заншил, хууль ёс, соёлыг МЭ-ний III-IV зуунд Сяньби, V-VI зуунд Жужан, VI-VIII зуунд эртний Түрэгүүд, VIII-IX зуунд Уйгарууд, IX-X зуунд Кидан, X-XI зуунд Монгол аймгууд уламжлан хөгжүүлсэн<sup>128,129</sup> байна.

Монгол газар нутагт төр улс байгуулан зонхилж явсан Түрэг угсаатны (VI-IX зууны үе) дараа төв Азийн түүхэнд язгуурын Монголчууд үүсэх түүхийн шинэ үе эхэлжээ.

VII-VIII зууны үед Монгол хэмээх нэр түүхийн эх сурвалжид дурьдагдах болсон.

Язгуурын Монгол аймгууд барагцаалбал XI-XII зууны заагт ураг төрлийн байгууллагыг туулан давж эзэн боолын нийгмийн харилцааг хэвшлийн төдий заримдаг үзэж, феодалын нийгмийн харилцаанд шилжих хөгжлийн шатнаа хүрч “Хамаг Монгол” нэртэй улсыг байгуулжээ.

XI-XII зууны Монголын нийгмийн бүх хэрэг явдал Хамаг Монгол улсын дотоод зөрчил, Хамаг Монгол ба бусад Монгол аймаг, ханлигийн хоорондын харилцаагаар шийдвэрлэгдэж байв.

Хамаг Монгол нэртэй улс үүсэн бэхжиж түүнд түшиглүүлэн нийт эсгий туургатныг нэгтгэсэн тулгар төр улс тогтоосон нь Монголын нийгмийн хөгжлийн шаардлагаас урган гарсан түүхэн үзэгдэл<sup>130</sup> юм.

## **б) Хүн барьцаалахтай төстэй гэмт явдалтай бичмэл, нэгдмэл, төрөлжсөн хуулиар тэмцсэн үе (XII-XX зууны эхэн)**

Нэгдсэн Монгол Улс байгуулагдсан тэр түүхэн алтан үеэс Монголын нийгмийн харилцааг зохицуулж байсан хэм хэмжээ нь төрөөс батлан гаргасан хууль цааз, журам, ард иргэдийн дунд төдний зан заншлын харилцааг зохицуулдаг ёс горим, хэв хуулийн шинжтэй үйлчилж байжээ.

Энэ цаг үед төрийн хууль цаазыг зөрчвөл гэмт хэрэг хэмээн үзэх бодлого боловсорч, эрүүгийн эрх зүйн харилцаа үүсчээ. Үүнтэй холбогдсон эрүүгийн бодлого, гэмт хэрэг, ял, түүнийг оногдуулах эдлүүлэхтэй холбогдсон харилцаа эл үеийн эрүүгийн эрх зүйн харилцааны хүрээнд бүрэлдэн тогтжээ.

Чингисийн хаант улсын үед боловсорсон эрх зүйн үндсэн сурвалж нь “Их засаг” хэмээгдсэн төрийн хууль болохыг эрдэмтэн судлаачид санал нэгтгэйгээр цохон тэмдэглэсэн байна.

Чингис хаан Их засаг хуулийг анх удаа 1189 онд, дараа нь 1206 онд буюу Чингис хаан их ор суух үед хуралдуулсан хуралдаанаар батлан тунхаглажээ. Чингис хаан тэр цагт хуучин хуулиудыг тэр бүр үүнээс хойш даган мөрдөж болохгүй тул урьд эдүгээгийн хуулийг хянан хэлэлцэж шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж зарлигджээ.<sup>131</sup>

Их засаг хуульд эрдэнэт хүмүүний амь бие, эрүүл мэндийг хамгаалахад ихээхэн анхаарч, зөрчвөл ялын дээд хэмжээ оноож байв. Тухайлбал; “Хүн алсныг алмой”, “гажуу

<sup>127</sup> Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал” УБ., 2011. 25 дахь тал

<sup>128</sup> Н.Сэр-Оджав. Монголын эртний түүх. УБ., 1977.13 дахь тал

<sup>130</sup> Г.Баярхүү “Хүннү гүрэн болон монголын нэгдсэн төр, дараа үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь” (МЭӨ 209-МЭ XIII-XX зуун). УБ., 2011. 7 дахь тал

<sup>131</sup> Эзэн богд Чингисийн Их засаг. УБ., 1995. 55 дахь тал

солгой аргаар бусдыг хорлогсдыг алмой”, “бусдыг хүчирхэн заалдагсдыг алмой”<sup>132</sup> гэх мэтээр заасан байдаг.

Их засаг хууль бол дэлхийн соёл иргэншлийн түүхнээ бүхэл бүтэн нийгэм, улс төрийн байгуулал бүрэлдэн төлөвшихэд томоохон үүрэг гүйцэтгэсэн эртний Вавилоны Хаммурапийн хууль, Энэтхэгийн Манугийн хууль зэрэг алдартай хуулиудтай эн зэрэгцэхүйц ач холбогдолтой, цааз-эрхэмжийн нэн чухал баримт бичиг юм. Учир нь эл хуулийн зарчим, үзэл санаа зөвхөн Монгол нутагт төдийгүй, ертөнцийн талыг эзэгнэсэн их гүрний хэмжээнд үйлчилж байсны хувьд дэлхийн хууль цаазны түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээсэн бүлгээ.<sup>133</sup>

Их засаг хуулийн дараа Их Юаны нэвтэрхий хууль, Арван буянт номын цагаан түүх, Их Юан улсын цаазын бичиг, Ертөнцийг засах магад хууль, Хутугтай Сэцэн хунтайжийн шашны цааз, Алтан хааны цааз бичиг, Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн 18 хууль, Монгол-Ойрадын хууль зэрэг цаазын бичгүүд дараалан хүчин төгөлдөр мөрдөгдөж байв.

Дээрх цааз бичгүүдэд хүнийг барьцаалах гэмт хэргийн талаар тодорхой заалт байсан эсэх нь одоогоор тодорхойгүй байна. Гэвч дээрх цаазууд үйлчилж байх үед овог, аймгууд эмс охидоо харилцан булааж авах, хоорондоо дайтахгүйн баталгаа болгож эмс охидоо хатан болгож өгөх, элч төлөөлөгч, төрөл садны хүмүүсээ барьцаа болгож бусдын нутагт суулгах зэрэг хэв заншлын шинжтэй үйлдлүүд хийдэг байсан бөгөөд зөрчвөл харилцан хүмүүсээ хулгайлалцах, дайтаж тулалддаг байсан тухай түүхэнд тэмдэглэсэн байдаг.

Эдгээр хуулийг манай нэрт хуульч эрдэмтэд “Монгол хууль” хэмээн нэрлэсэн нь монгол хүний оюун санаа, монгол ахуйн хэрэгцээнээс урган гарч, тэдгээрийн үзэл бодол, зан заншлын хэм хэмжээтэй хослон үйлчилж ердийн амьдралын хэвшил болсонтой холбоотой.<sup>134</sup> Үүний тод илрэл нь Оросын эрдэмтэн, монгол цаазыг судлаач И.М Майский: “Великая яса” буюу “Их засаг хууль” нь тэр үеийн Их Монгол Улсын Үндсэн хууль<sup>135</sup>, Ж.А.Жувейни: “Чингис хаан үйл хэрэг болгонд тохирсон дүрэм, тухайн нөхцөл болгонд тохирсон хууль, гэм буруу болгонд оногдуулбал зохих ял шийтгэл боловсруулан мөрдүүлж эхлэв”<sup>136</sup> хэмээсэн тэмдэглэл юм.

Английн түүхч Горальд Лэмбийн эмхтгэсэн 22 зүйл бүхий Чингис хааны хуульд: “Эзэнт гүрний хэмжээнд хэн ч гэсэн монгол хүнийг боол .... болгож үл болно”<sup>137</sup>, хэмээсэн нь монгол хүнийг албадан хөдөлмөрлүүлэх, барьцаалах явдлаас сэргийлсэн монгол хүний эрхийг хамгаалсан, өнөө ч ач холбогдлоо алдахааргүй заалт байсан болох нь харагдаж байна.

Алтан хааны цааз бичигт: “Цэргийн эхнэр, эцэг эхийг дэргэд суух цагт охин төрвөл цэрэг байхгүйд оронд нь эцэг, эх охиныг тэтгэн үйлдээд охин хүүд өгвөөс тооцохгүй. Охин бусад буй бээр түүнд өг, охин үгүй бөгөөс эд руу санг сандан бээр охины хуримын идээг тэр охины цаазанд өгч цаазны эдийг төлнө”<sup>138</sup>, “Хулгайчийн алж идсэн махны үлдэгдлийг авбаас хүн, тэмээ алин болохоор өрд ав”<sup>139</sup>, Халхын үйсэн дээр бичсэн цаазууд (1603)-ын нэг дэх хэсэг буюу “Зургаан хошууны цааз”-д: “Хулгай хийсэн хүнийг золио гэхүлийг тэр золигч хүнийг еслөө. Хулгайч хүний золиг нь эмийг нь ав”<sup>140</sup> хэмээн хүнийг үүргийн гүйцэтгэлд тооцож байсан бол тав дахь хэсэг буюу “Төмөр гахай жилийн өчүүхэн цааз”-д (1611): “Ноён хүнийг сүйтийг нь аваад хүнд өгвөөс тэр хүнээс анз аваад тэр эмийг хариулж өг”, ес дэх хэсэг буюу “Модон барс жилийн намрын цааз” –д (1620) “Хэн хүн эм босговоос эмийн эр нь авбаас оргүй. “Охин хүн, хөвүүнгүй эм, боол эд гурвыг хулгайтай болов”<sup>141</sup> гэж

<sup>132</sup> Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал” УБ., 2011. 94 дэх тал

<sup>133</sup> Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал” УБ., 2011.94 дэх тал

<sup>134</sup> Э.Авирмэд, Д.Дагшцэдэн, Г.Совд. Монгол хууль (Уламжлал, шинэчлэл Монголын төр эрх зүйн түүхэн сэдэв)

УБ.,1997. 3 дахь Майский. И.М. Чингис хаан. Вопросы истории. 1962.

<sup>135</sup> Майский. И.М. Чингис хаан. Вопросы истории. 1962. 5 дахь тал

<sup>136</sup> С.Бадарчи. Их Монгол улсын цагдаа. Цагдаа судлал онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл. 2011. №1 (01). 9 дэх тал

<sup>137</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимид нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. I боть (1206-1910 он). УБ., 2010. 43 дахь тал

<sup>138</sup> Монголын төр, эрх зүйн түүх (дээж бичиг). I дэвтэр. Эмхтгэсэн Б.Баярсайхан.УБ., 2006. 15 дахь тал

<sup>139</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимид нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл I боть (1206-1910 он). УБ., 2010. 85 дахь тал

<sup>140</sup> Мөн тэнд, 89 дэх тал

<sup>141</sup> Мөн тэнд, 98 дахь тал



тэмдэглэснээс үзэхэд, Эзэнт гүрний хэмжээнд хүн хулгайлах, барьцаалах гэмт хэргийн шинжтэй үйлдэл байжээ гэж үзэх үндэстэй байна.

Мөн Энх-Амгалангийн<sup>142</sup> зургаадугаар оны хуучин засгийн бичигт нэмж тогтоосон засгийн бичигт (1667), “Харц хүн хатад лугаа нэгдвээс явалдсан эрийг огтчин алму. Хатныг чавчиж алму. Явалдсан хүний ах дүүгээс эм хүүхдийг нь зарц өгмү”<sup>143</sup> гэснээс үзэхэд ялыг халдаан хэрэглэж, хүүхдийн эрхийг ноцтой зөрчих явдлыг хуульчилсанаар хүн барьцаалахтай төстэй гэмт хэргийг хуулиар баталгаажуулсан түүхийн нэгээхэн үе байжээ гэж үзэж байна.

ХҮI зууны II хагас ХҮII зууны эхэн үеийн Монгол хууль цаазын үнэт дурсгалын нэг бол “Цааз эрхэмжийн 18 хууль” юм. Уг хуулийг ХҮI зууны II хагасаас ХҮII зууны 40-өөд он хүртэлх хугацаанд халхын дөрвөн хошуу, зургаан хошуу, долоон хошууны ноёдын 18 удаагийн чуулганаар хэлэлцэж баталсан байна. Уг цаазын бичигт хүнийг барьцаалахтай төстэй үйлдэлд хариуцлага хүлээлгэх заалт байсан байна. Тухайлбал: “Дайн гэж дүрвээнд морь унаж явж үхвээс мөн гурван ес ав, “Хүнийг хулгай хийж авбаас мөн хүний анзаар болов”<sup>144</sup> гэх мэтээр заажээ.

ХҮII зууны үед үйлчилж эхэлсэн монгол хууль цаазын томоохон дурсгалт бичиг бол аргын улирлын 1640 оны 8 дугаар сарын эхээр дөрвөн ойрдын нутаг Тарвагтайн улаан бураа гэдэг газар халх, ойрдын бүх ноёдын их чуулганаар хэлэлцэж баталсан Монгол-Ойрдын Их цааз юм.

Их цаазыг батлагчид түүнийг дөчин дөрвөн хоёрын цааз гэж нэрлэсэн бөгөөд хожмын эрдэмтэд, судлаач нар Монгол-Ойрдын их цааз, Монгол-Ойрдын цааз, Их цааз, Монгол-Ойрдын хууль, Халх-Ойрдын цаазын бичиг гэх зэргээр нэрлэж иржээ.<sup>145</sup>

Монгол-Ойрдын их цаазад хүн хулгайлах, барьцаалахтай төстэй явдалд хариуцлага хүлээлгэх заалт байжээ.Тухайлбал; уг цаазын ижил мөрний халимагуудын оруулсан нэмэлт нөхвөрт “Хүн хулгайлбал алсны ёсоор тал, хулгайч хүн дийлж зэв зэвсгээр хүн шархдуулбал хүн ав”<sup>146</sup> гэх зэргээр хуульчилж байснаас үзвэл хүнийг хулгайлж авсан бол хүн алсантай ижил ял ногдуулж байсан төдийгүй хүнийг барьцаа болгон өгч байжээ.

ХҮII-ХҮIII зууны үед монгол нутагт мөрдөгдөж байсан монголын феодалын хууль цаазны хамгийн шилдэг дурсгал бичиг бол “Халх журам” юм. Халх журам нь “Баруун хүрээний халх журам”, “Их хүрээний шавь яамны халх журмын дүрэм” гэсэн 2 янз байна. “Халх журам”- ыг 1709-1796 оны хооронд халхын хаад, ноёд өөр өөр газар бүгд 14 удаа хуралдаж хэлэлцэн тогтоосон байна.<sup>147</sup>

Халх журам хуульд хүний эрх чөлөө, халдашгүй байдлыг бататгаж, зөрчигдөхөөс хамгаалсан шинжтэй, хүнийг барих, хорих, барьцаалахтай төстэй хэргүүд байжээ. Тухайлбал; “Хүний эм охидыг хүн аваад (эмэгтэй хүнийг хулгайлан авч явах) дээр хоргодвоос халуун амь үл хагацах (эр, эм хоёрыг үл салгах) тул эмийн худалдаа найман адуу, долоон үхэр, дөчин хонь өг. Малгүй бол эрийг эм дээр нь барьж өг. Хүнээ өгөх дургүй бол ноён нь энэ малыг гүйцээж өг. Мал нас цөм шүдлэн”<sup>148</sup>, “хүнийг зовчивоос таван ест, нууваас гурван ест гэж бусдын мэдлийн хүнийг дур мэдэн өөр газар зайлуулж явуулахыг хэлж буй”<sup>149</sup> гэх мэтийг дурдаж болно.

Манжийн “Монгол цаазын бичиг”-ийг 1795 онд “Зарлигаар тогтоосон гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг” хэмээн нэрлэн 1811 онд барлан хэвлэсэн байна.

“Монгол цаазын бичиг”-т “Аливаа алах ял тогтоосон ялт хүнийг булаах бол тэргүүн, дэдийг үл ялган цавчиж ал. Гянданд хорьж хүлээ. Алахад хүрэхгүй ялт хүнийг булаах бол тэргүүлсэн хүнээс гурван есний мал, бусдаас нэгэн есний тал ав”<sup>150</sup> гэж, “Аливаа монголчууд

<sup>142</sup> Манжийн хаан Энх-Амгаланг хэлж буй

<sup>143</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимид нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл I боть (1206-1910 он). УБ., 2010. 127 дахь тал

<sup>144</sup> Т.Алтангэрэл “ХҮI-ХҮII зууны үеийн Монгол цаазын бичгүүд” УБ., 1999. 59 дэх тал

<sup>145</sup> Т.Алтангэрэл “Монгол-Ойрдын Их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь” УБ., 2001. 17, 18 дахь тал.

<sup>146</sup> Т.Алтангэрэл “Монгол-Ойрдын Их цааз, түүний судалгаа” УБ.,1998. 78 дахь тал

<sup>147</sup> Э.Авирмэд, Д.Дашцэдэв, Г.Совд “Монгол хууль” УБ.,1997. 72 дахь тал

<sup>148</sup> Халх журам.Ред.С.Жалан-Аажав.УБ.,1995. 25 дахь тал

<sup>149</sup> Мөн тэнд 37 дахь тал

<sup>150</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимид нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл I боть (1206-1910). УБ ., 2010. 240 дэх тал

дотроон аргадаж зүгээр хүнийг боол, шивэгчин эм, бага эм, хөвгүүн ач болгон худалдвал худалдсан ба эс худалдсаныг ялгалгүй зуу ташуурдаж, гурван есөөр торго. Аргадсан хүнийг зуу ташуурд<sup>151</sup> гэж, “гадаад монголчууд дотоод газрын эр, эм ба нуган охиныг аргадан авч одоод худалдах ба эсвэл эм ба бага эм, боол шивэгчин болговол зүгээр хүн боол, шивэгчин худалдсан ба эс худалдсаныг ялгалгүй ер аргадаж авч одоход аргадагдсан хүн учрыг үл мэдэх бол тэргүүлсэн хүнийг хөвчдөж алах ял торгож, гянданд хорьж хүлээ. Дэд хүнийг ташуурдаж, гурван есөөр торго. Аргадагдсан хүнийг үл торгоно. Ганц нэг хүн боловч мөн хөвчдөж алах ялаар торго. Хэрэв үгсэж аргадан боол, шивэгчин эм, бага эм, хөвгүүн ач болгон худалдахад аргадагдсан хүн учрыг мэдвэл худалдсан ба эс худалдсаныг ялгалгүй зуу ташуурдаж гурван есөөр торго. Аргадагдсан хүнийг зуу ташуурд<sup>152</sup> хэмээн хуульчилснаас харахад Манжийн үед “хүн барьцаалах” гэсэн нэр томъёо байгаагүй ч анх удаа хүн барьцаалахтай төстэй гэмт хэрэг “хүн хулгайлах”, “хүн булаах”, “хүнийг барьж саатуулах”, “хүн худалдаалах” гэсэн нэр томъёог хэрэглэж эхэлсэн байна. Дээр дурдсан эртний хууль цаазууд дахь хэм хэмжээнүүдэд монгол хүнийг барьцаа болгох, булаах, худалдаалах, хулгайлах явдлыг цаазлан хориглож, уг гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект, халдлагад өртөгчийг ялгамжтай байдлаар хуульчлахын зэрэгцээ гэнэдүүлэн авч (хууран мэхлэн барьж саатуулах) аргадан худалдах (ая байдлыг дагуулан найр тавих, ухуулж таниулах) гэхчилэн гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжийг тодорхойлсон ба гэнэдүүлэн аваачсанаар гэмт хэрэг төгсөхөөр заасан байна. Тэргүүлсэн хүн, дэд болж явсан хүнд ялыг ялгамжтай оногдуулж байснаас үзэхэд, XIX зуунд эрүүгийн эрх зүйн үндсэн ойлголтууд болох ял, түүний төрөл, гэмт хэрэгт хамтран оролцогчид, гэмт хэрэг үйлдэх үе шатны ойлголт өндөр хөгжсөн байсныг илтгэнэ.

Нөгөө талаар хүнийг хууран мэхэлж, хулгайлсан, барьж саатуулан барьцаалахад тэргүүлсэн, дэд болж явсан хүнд ялыг ялгамжтай оногдуулж байсан нь эрүүгийн эрх зүй дэх шударга ёсны зарчмын агуулгатай нийцэж байгаа ба хөвчдөн алах, ташуур занчих, гурван есөн мал авах зэргээр яллаж, ялыг дангаар нь болон давхар оногдуулж байсан нь ялын бодлогын хувьд хатуу чанга байсныг харуулж байна.

1811 оны Зарлигаар тогтоосон гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичгийн “Ураг бололцох ёслол” хэмээх хорин тавдугаар дэвтрийн “Бусдын богтолсон гэргийг аргалж авах нь” 845 дугаар зүйлд: “Засаг ба засаг бус ван, бэйл, бэйс, гүн, тайж, тавнан<sup>153</sup> аргалж бусад богтлон тогтсон гэргийг авбаас хэрэг гарч ирсний хойно авсан, өгсөн хоёр этгээдэд ван, бэйл, бэйс, гүн болбоос арваад өрх, тайж тавнан болбоос тавиад өрх, харъяат түшмэд болбоос таваа есөн мал, харц хүн болбоос гурваад есөн мал торгож, цөм уг богтлон тогтсон хүнд өг. Зоригоор авсан гэргийг салгаад язгуур нөхөрт өгч, агуулах гэхийг түүний дураар болгогтун<sup>154</sup>.” Иргэн, монгол эмс, охидыг гэргий болгон авах нь” хэмээх 846 дугаар зүйлд: “Дотоод газрын иргэд ... монгол эмс, охидыг гэргий болгон авч болохгүй. Зоригоор өгөх ба авах нь буй бөгөөс хүнд гэрчлэн гаргаваас авсан гэргийг нөхрөөс хагацуулж төрхөмд эгүүл. Эзэрхэж ураг бололцуулсан монгол хуулиас зөрсөн иргэнийг өөр өөрийн гурваад сарын дөнгө дөнгөлүүлж, өдөр дүүрсний хойно зуугаад ташуур занчиж, иргэнийг дам дамаар уг нутагт хүргүүл. Харъяат захирах тайжийг гурван есөн мал ав. Харъяат засгийг байцаахыг алдсан хууль ёсоор зургаан сарын пүнлүү хас. Хэрэв харъяат тайж, засаг өөрөө байцаан гаргасан нь болбоос хэлэлцэхийг хэлтрүүлэгтүн” гэжээ. Үүнээс үзэхэд Манжийн засгаас монгол эмэгтэйчүүдийг хулгайлах, барьцаалах явдалтай тэмцэх асуудалд онцгойлон анхаарч, төрийн бодлогын түвшинд тууштай тэмцэж байсан нь үндэсний аюулгүй байдал, удмын сантай холбоотой маш зөв бодлого байжээ.

Хууль зүйлийн бичигт заасан “Өөр данс бүхий хүн” гэж ноёдын хамжлага буюу засаг ба засаг бус ван, бэйл, гүн тайж, хутагт нарын хамжлага албат, шавь ард, гэрийн боолыг, “Албат ард” гэж хэн нэгний харьяалалгүй “суман ард”-ыг хэлж буй талаар эрдэмтэд<sup>155</sup> тэмдэглэсэн байна. Хэрэв ийнхүү ойлговол тухайн үед өөрийн харъяат албат

<sup>151</sup> Мөн тэнд 250 дахь тал

<sup>152</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимид нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. I боть (1206-1910). УБ., 2010. 250 дэх тал

<sup>153</sup> Тавнан -1, Хаад ноёдын хүргэн, 2 Манжийн хаанаас гүнж авсан хүн. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь IV боть. Ерөнхий редактор Л.Болд, Шинжлэх ухааны академи. УБ., 2008. 1878 дэх тал.

<sup>154</sup> Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимид нар Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. I боть (1206-1910 он). УБ., 2010. 412-413 дахь тал.

<sup>155</sup> Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн. Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). УБ., 2011., 58 дахь тал

ардыг бусдад хууль ёсоор худалдаж барьцаа болгон өгөх боломжтой байсан уу гэсэн асуулт зүй ёсоор урган гарах ба дээрх зохицуулалтаас хамжлагаа худалдах, барьцаа болгох боломж байсан гэж үзэж болохоор байна.

Монгол дахь хүн барьцаалах шинжтэй гэмт хэргийн талаар Монголоор аялан явагсад, сонирхогчдын дурсамж хийгээд эзэнт гүрний янз бүрийн хэсэгт аж төрж асан хүмүүсийн бичиж үлдээсэн хийгээд домог ярианаас сурвалжилсан тэмдэглэлд: “Чингис хаан жил бүр эсвэл жил алгасаад нэг удаа бүх татар нутгаас охид сонгуулин авчирч байсан бөгөөд үзэж тоосноо өөртөө үлдээж, үлдсэнийг нь өөрийн сайд түшмэддээ тав таваар нь шагнаж хайрладаг.”<sup>156</sup> Архивын материалаас үзэхэд, Түшээт хан аймгийн Түшээт вангийн хошууны нэгэн дансанд 1747 оны байдлаар 157, 1855 онд 42 гэрийн боол байсан тухай тэмдэглэсэн байна.<sup>157</sup>

Тухайн үед боол болгох ял шийтгэгдэх, өөрийгөө худалдах, эсхүл худалдагдах, дайн, тулааны үед хүчинд автан олзлогдох, язгууртны хуримын инжинд өгөгдөх замаар боол болдог байжээ. Эдгээрийн дотроос малаа бараад амьдралын аргагүй байдлаас өөрийгөө худалдаж гэрийн боол болох тохиолдолд хошууны тамгын газарт мэдүүлж батлуулдаг байжээ.<sup>158</sup> Ийнхүү Эртний Грек, Римд хэрэгжиж байсан сонгодог утгаараа бус ч дундад Зууны нийтлэг жишгийн дагуу боол, хамжлагийн ёс монгол газарт үе улиран олон зууны туршид бодитойгоор оршиж байсныг харуулж байна.

XIX-XX зууны үед Их шавийн яаманд хэрэг шийтгэсэн “Улаан хацарт” хэмээх хуулга данс нь тухайн цаг үеийн ард түмний зан заншил, аж ахуй, соёл ухамсар, төрийн эрүүгийн бодлого зэргийг судлахад түүхэн ач холбогдолтой. Улаан хацарт нь тухайн үеийн албан тушаалтан хүчин төгөлдөр хууль тогтоомж хэрэглэн, эцэслэн шийдвэрлэсэн гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийг шийдвэрлэсэн хэргийн данс буюу эмхтгэл, нөгөө талаасаа орчин цагийн жишиг<sup>159</sup> байж болох талтай. Хүн барьцаалсан этгээдэд хариуцлага хүлээлгэн шийтгэсэн хэд хэдэн тохиолдлыг “Улаан хацарт”-д дансалсан байна. Тухайлбал: “Мөн он (1849) илүү дөрвөн сард өөрийн хүүхэн Дугаржавыг нэгэн шавь хар Буяндэлгэрт эм болгон өгөөд зоригоор гэдрэг буцаан аваачсан шүүлэнгэ Гончигжавыг анз нэгэн есөн ял торгожээ”<sup>160</sup>, Лам Цэрэндашид эм богтлон өгсөн гэлэн Сономцэрэнг хуулийн нэгэн есөн мал торгож шийтгэжээ<sup>161</sup>, “Мөн он (1864) гурван сард өөрийн байшинд хүүхэн хүн агуулсан хиа лам Самбууг тушаалаас байлгаж хуулийн таван мал торгож шийтгэжээ<sup>162</sup>, “Мөн он (1864) арван сард төрлийн эмс охидыг хүрээний газраа агуулсан хаалгач Лувсандаш, лам Дамчогдорж нарыг тус бүр анз таван ял торгож шийтгэжээ. Байцаан эс гаргасан гэвхүй Арьяаг хуулийн гурван мал торгож шийтгэжээ<sup>163</sup>, “Мэргэн хамба ламтны сангийн хашаанд эмсээр охидоор цас арилгуулсан нярав Жамсранг хуулийн таван мал торгож шийтгэжээ.<sup>164</sup> Үүнээс үзэхэд, Монголын эртний хууль цаазад Монгол хүнийг хулгайлах, барих, хорих, богтлох, барьцаа болгох явдлыг цаазлан хориглож, энэ төрлийн гэмт хэрэгт хамтран оролцогчид болон хамаарагсдад ялыг ялгамжтайгаар оногдуулж ирсэн хууль цаазын уламжлал хадгалагдаж үлджээ.

## Дүгнэлт

1. Хүн барьцаалах гэмт явдал эртнээс үйлдэгдэж, эртний болон дундад зууны үед эвлэрлийн болон энх тайваны гэрээний хэрэгжилтийн баталгаа болгож язгуур угсаатай хүмүүсийг эсрэг талд орхидог, барьцааны хүмүүсийг солилцдог, эсвэл тэд сайн дураараа үлддэг байсан байна. Түүхэн цаг хугацаанд үйлдлийн арга, зорилго өөрчлөгдөж, хүмүүсийг

<sup>156</sup> Плано Карпини, Вилгельм де Рубрук. Монголд жуулчилсан тэмдэглэл. Орчуулсан Гэрэлцогт. ӨМСХХХ., 1983. 109 дэх тал

<sup>157</sup> Улсын түүхийн төв архив. М-17-1-67, 202 дахь тал

<sup>158</sup> Б.Баярсайхан. Монгол цаазын бичиг /харьцуулсан судалгаа/. УБ., 2001.95 дахь тал

<sup>159</sup> Доктор /Ph/ Б.Баярсайхан “Улаан хацарт” хэмээх хуулга дансыг шүүхийн жишиг болгон ашиглаж байсан гэж үзэх үндэслэлтэй талаар тэмдэглэсэн

<sup>160</sup> Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав. Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ. (Улаан хацарт). УБ., 2010. 70 дахь тал

<sup>161</sup> Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав. Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ. (Улаан хацарт). УБ., 2010. 79 дахь тал

<sup>162</sup> Мөн тэнд, 76 дахь тал

<sup>163</sup> Мөн тэнд, 78 дахь тал

<sup>164</sup> Мөн тэнд, 78 дахь тал

барьцаалах буюу өөрийн аюулгүй байдлыг хангахын тулд эзлэгдсэн газар орны оршин суугчдыг цэргийн хүчээр барьцаанд байлгах, хүн барьцаалах аргаар нөгөө улсын гадаад болон дотоод бодлогод нөлөөлөх, түрэмгийлэл болон хариу үйлдлийг тогтоон барих, гэрээний хэрэгжилтийг баталгаажуулах, хувийн аюулгүй байдал, эд хөрөнгө, орон байр, хот, суурингийн аюулгүй байдлыг хангах, мөнгө, эд хөрөнгийг хууль бусаар олж авах (барьцааны мөнгө нэхэх), хорих газраас ялтныг суллуулах, олзлогсодыг солилцох зэрэг үйлдлээр уг үзэгдэл баяжсаар ирсэн байна.

2.Эртний цааз бичгүүдэд хүн барьцаалах гэмт хэргийн талаар тодорхой заалт байсан эсэх нь одоогоор тодорхойгүй байна. Гэвч дээрх цаазууд үйлчилж байх үед овог, аймгууд эмс охидоо харилцан булааж авах, хоорондоо дайтахгүйн баталгаа болгож эмс охидоо хатан болгож өгөх, элч төлөөлөгч, төрөл садны хүмүүсээ барьцаа болгож бусдын нутагт суулгах зэрэг хэв заншлын шинжтэй үйлдлүүд хийдэг байсан бөгөөд зөрчвөл харилцан хүмүүсээ хулгайлалцах, дайтаж тулалддаг байсан тухай тэмдэглэсэн байдаг.

3.Нэгдсэн Монгол Улс байгуулагдсан үеэс монголын нийгмийн харилцааг зохицуулж байсан хэм хэмжээ нь төрөөс баталсан хууль цааз, журам, ард иргэдийн дунд тэдний зан заншлын харилцааг зохицуулдаг ёс горим, хэв хуулийн шинжтэй үйлчилж ирсэн, тухайн цаг үед төрийн хууль цаазыг зөрчвөл гэмт хэрэг хэмээн үзэх бодлого боловсорч, эрүүгийн эрх зүйн харилцаа үүсчээ. Түүнчлэн, эрүүгийн бодлого, гэмт хэрэг, ял, түүнийг оногдуулах эдлүүлэхтэй холбогдсон харилцаа эл үеийн эрүүгийн эрх зүйн харилцааны хүрээнд бүрэлдэн тогтсон байна.

## ЭРҮҮГИЙН ХУУЛИАР ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТҮҮНИЙ ТӨЛӨӨЛЛИЙН АСУУДАЛ

*Б.Одонгэрэл*

*Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүгчийн хараат бус байдлыг  
хамгаалах хэлтсийн дарга, докторант*

**Товч агуулга:** Эрх зүйн олон бүтээл, судалгааг үндэслэвэл хуулийн этгээд нь эрх зүйн харилцаанд бие даан субъект болж оролцох боломж нь нэг талаас Олон Улсын гэрээ, Үндсэн хуульд заасанчлан хүмүүс эрхээ хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хамтран явуулахдаа алив нэгэн байгууллагад нэгдэх, хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, тухайн субъект нь хуулийн дагуу хариуцлага хүлээх үндэслэлийг хуульчлах нөхцөлөөр тодорхойлогдоно.Түүнчлэн энэхүү бие даасан эрх зүйн субъект болохын хувьд хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх нь дэлхий нийтэд түгээмэл болж, Монгол Улс ч жишгийн дагуу үүнийг хуульчлан мөрдүүлж байна. Энэхүү өгүүлэлд бид Монгол Улсын Эрүүгийн хуульд зааснаар эрүүгийн хариуцлага оногдуулах хуулийн этгээдийн тухай ойлголт, түүний төлөөллийн асуудлаар харьцуулан судалж зарим саналыг дэвшүүлээ.

**Түлхүүр үг:** Хуулийн этгээд, эрүүгийн хариуцлага, төлөөлөл

### Удиртгал

Хуулийн этгээд бол эрх зүйн субъектийн хамгийн сонгодог хэлбэр төдийгүй иргэний эрх зүйн шалгуураар түүний мөн чанар нь тодорхойлогдож байсан хэдий ч орчин үед хуулийн этгээдийн явуулж буй үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж нэмэгдэхийн хирээр түүнд хүлээлгэх хариуцлага ч зөвхөн иргэний болон захиргааны эрх зүйгээр тогтохгүй эрх зүйн хариуцлагын хамгийн хүнд хэлбэр болох эрүүгийн хариуцлагыг оногдуулах асуудлыг дэлхий нийтээр дэвшүүлэх боллоо.

Хуулийн этгээд нь бүх салбар эрх зүйн харилцаанд субъект болж оролцох чадвартай тул ямар ч хариуцлагыг мөн адил хүлээх чадвартай (С.Кенни, Д.Кортни, Ф.Стивен, М.Ёокояма, И.Кенсүкэ, А.С.Никифоров, Ц.Хуэйлинь) гэж үзэх хандлага өсөн нэмэгдсээр ирлээ. Монгол Улсад сүүлийн жилүүдэд эрдэмтэн судлаачид “хуулийн этгээд”, “компанийн гэмт хэрэг”, “хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага” гэх мэт судлагдахуунаар онолын үндэслэл, олон улсын эрх зүйн чиг хандлага, хууль тогтоомжуудыг судалсны үндсэн дээр хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг дэвшүүлж, үүний үр дүн 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс Монгол Улсын Эрүүгийн хуульд биеллээ олсон.

Энэхүү хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах гэсэн эрх зүйн шинэ тутам асуудлыг нэг мөр ойлгох, хэрэглэх, жишиг тогтоох шаардлага тулгамдаж байгаа нь хуулийн заалт хүчин төгөлдөр мөрдөгдсөнөөс хойш компанийг эрүүгийн хариуцлагад татсан шүүхийн шийдвэр маш цөөхөн<sup>165</sup> байгаагаар илэрч байна. Иймд эрүүгийн хариуцлага хуулийн этгээд, түүний төлөөллийн асуудлыг харьцуулсан судлалын үүднээс тодруулахаар зорилоо.

#### 1. Хуулийн этгээдийн тухай ойлголт

“Хуулийн этгээд” гэх ойлголтыг танин мэдэх уг сурвалж нь Ромын эрх зүйгээс үүдэлтэй бөгөөд үүнийг иргэний эрх зүйн институт болгон авч үзэх хандлага уламжлагдаж ирсэн нь чухамдаа Ромын сонгодог эрх зүйн зарчим, үнэт зүйлстэй холбоотой юм. “Хуулийн этгээд” гэх нэр томъёо нь латини “UNIVERSITATES” буюу хамтран байгуулах, хамтран бий болгох, цогц бүрдэл гэх утгыг илэрхийлдэг байна.

Монгол Улсад хуулийн этгээд гэх ойлголтыг анх 1926 оны Иргэний хуулийн 3 дугаар ангид “Аливаа эвлэл, хоршоо буюу энгийн хүмүүсийн хоршоолон байгуулсан худалдаа

<sup>165</sup> Тухайлбал, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 22.5 дугаар зүйлээр хуулийн этгээдэд торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэр 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдөр гарсан. Тус хуулийн этгээдийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар олон улсын ачаа тээвэр, зуучийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасч, 120.000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 120.000.000 /нэг зуун хорин сая/ төгрөгийн торгох ялаар тус тус шийтгэсэн бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчдэгч хувь хүний хамтаар явагдаж “Шүүгдэгч Н-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар нийтийн албанд томилогдох эрхийг 2 /хоёр/ жилийн хугацаагаар хасч, 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 3.000.000 /гурван сая/ төгрөгийн торгох ялаар шийтгэсэн байна.

<http://new.shuukh.mn/erwuqianhan/21782/view> сайтаас үзэх боломжтой.

үйлдвэрийн газруудын эрхийн тухай” гээд “энэхүү газрууд болбоос ард олны боловсролын хэрэг ба аливаа худалдаа үйлдвэрийн зэрэг явдлыг гол болгосон бодлого бүхий тул анх хоршоолсон хүмүүсийн завсартаан байгуулж хууль ёсоор батлуулсан дүрэм буюу гэрээ бичгийг баримталж элдэв хэрэгт бүрэн эрхтэй *ард лугаа нэгэн адил үүргийг эдлэвээс зохимой*” гэж заасан.<sup>166</sup> Энэ заалт нь хуулийн этгээдийн үндсэн шинжийг өөрийн удирдлага, бүтэцтэй, зохион байгуулалтын нэгдэл байна гэж тодорхойлсон нь “*хоршоолсон хүмүүсийн завсартаан байгуулж*” гэдгээс харагдаж байна гэж судлаачид тайлбарлажээ.<sup>167</sup> Түүнчлэн “*элдэв хэрэгт бүрэн эрхтэй, ард лугаа нэгэн адил үүргийг эдэлнэ*” гэсэн нь хуулийн этгээд нь эрх зүйн харилцаанд хувь хүний нэгэн адил эрх, үүргийг эдэлнэ гэдгийг тодорхойлжээ. “Ард олны боловсролын хэрэг ба аливаа худалдаа үйлдвэрийн зэрэг явдлыг гол болгосон бодлого бүхий” гэсэн нь хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон буюу нийтийн (ашгийн бус) болон хувийн (ашгийн төлөө) гэсэн ангиллыг гаргах зорилгыг агуулсан гэж үзэж болох байна.

1952 оны Иргэний хуульд<sup>168</sup> “Хуулийн этгээд нь бие дааж эд хөрөнгийн эрхийг олж чадах, үүрэг авах, түүнээ хариуцах ба өөрийн эрхийн тухай шүүхэд маргаж чадах хүмүүсийн нэгдэл, албан газар ба байгууллага этгээдүүд болно.” гэжээ. Дээрх заалт нь хуулийн этгээдийг зөвхөн ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах хүмүүсийн нэгдэл байхаас гадна албан газар, байгууллага байхаар тодорхойлсноороо нэлээд өвөрмөц зохицуулалт байсан байна.

Дэлхийн улс орнуудын туршлагаас үзэхэд хуулийн этгээд гэдэг ойлголтод зөвхөн ашгийн төлөө компани, корпорац зэрэг этгээдээс гадна ашгийн төлөө бус төрийн байгууллага, төрийн өмчит компани түүнчлэн төрийн байгууллагыг ч хамруулан үзэх нь бий. Тухайлбал, БНХАУ-д хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал 1979 оноос яригдаж эхэлсэн асуудал боловч 1997 оныг хүртэл энэ талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байсан юм. Хятад улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ойлголт нь “нэгжийн гэмт хэрэг” гэсэн ойлголтоор илэрхийлэгддэг бөгөөд “нэгж”-д зөвхөн корпорац төдийгүй бусад этгээдүүдийг хамруулан заасан байдаг. БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 30 дугаар зүйлд “компани, аж ахуйн нэгж, байгууллага зэрэг этгээдүүд нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн ба тэрхүү гэмт хэргийг нь хуульд тэдгээр нэгжүүдийн үйлдэх гэмт хэрэг гэж тодорхойлсон бол тэдэнд эрүүгийн хариуцлага оногдуулна” гэсэн байна.<sup>169</sup>

1963 оны БНМАУ-ын Иргэний хуулийн 18-26 дугаар зүйлд “өөртөө тусгайлан эзэмшсэн эд хөрөнгөтэй, өөрийнхөө нэрийн өмнөөс эд хөрөнгийн ба түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бус эрх олох, үүрэг бий болгож чадах, мөн шүүх, арбитрын газар нэхэмжлэгч, хариуцагч байж чадах байгууллагыг хуулийн этгээд гэнэ.” гэжээ. Онцлог зохицуулалт нь “*хэрэв тус улсын хуульд заасан бол энэ зүйлд дурдсан улсын төсөвтэй байгууллага хуулийн этгээдийн хувиар бус харин БНМАУ-ын нэрийн өмнөөс ажиллаж болох*”-ыг заасан байна. Энэ хуулиар хуулийн этгээдийг төрийн өмчид тулгуурласан байхыг шаарддаг байсан нь тухайн үеийн нийгмийн үзэл сурталтай холбоотой гэж үзэж байна. Түүнчлэн, хуульд хуулийн этгээдийн салбар байгууллага, төлөөлөгчийн газар, хуулийн этгээдийн хүлээх хариуцлага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох болон татан буулгах үндэслэл зэрэг эрх зүйн хариуцлагыг дурджээ.<sup>170</sup>

2002 оны Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ” гэж заасан төдийгүй хуулийн этгээдийг ашгийн төлөө (компани, нөхөрлөл), ашгийн төлөө бус (холбоо, сан, хоршоо) гэж ангилсан.

Харин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1-т “Улсын бүртгэлийн байгууллага нөхөрлөл, компани, хоршоо, төрийн бус байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, төрийн байгууллага, албан газар,

<sup>166</sup> Г.Баярхүү, Н.Цэдэнбалжир, “Бизнесийн эрх зүй”, УБ, 2014, 11 дэх тал.

<sup>167</sup> Мөн тэнд.

<sup>168</sup> БНМАУ-ын Иргэний хууль, 1956 он, 3 дугаар бүлэг, 13 дугаар зүйл.

<sup>169</sup> Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал”, 2010 оны 9 сард “Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагын асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээни хуралд хэлэлцүүлсэн илтгэл.

<sup>170</sup> Г.Баярхүү, Н.Цэдэнбалжир, “Бизнесийн эрх зүй”, УБ, 2014, 11 дэх тал.

улсын төсөвт үйлдвэрийн газар, шашны байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, соёл боловсрол, сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн байгууллага, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар зэрэг хуулийн этгээдийг бүртгэнэ” гэжээ. Түүнчлэн, “хуулийн этгээд” гэж Иргэний хуулийн 25.1-д заасан шинжийг агуулсан зохион байгуулалтын нэгдлийг хэлнэ<sup>171</sup> гэжээ.

Тэгвэл олон улсад хуулийн этгээдийг түүний эрх зүйн чадвар, үүсгэн байгуулах журам, үйл ажиллагааны мөн чанарын онцлогийг харгалзан:

- Иргэний эрх зүйн хуулийн этгээд,
- Нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж хоёр ангилдаг.<sup>172</sup>

Нийтийн эрх зүйн олонх хуулийн этгээд нь төр, засаглалын бүрэн эрхтэй байдаг. Тэдгээрт улсын сан хөмрөгийн хувьд эд хөрөнгийн харилцаанд оролцож байгаа төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, (аймаг, нийслэл, сум дүүрэг) хамаарна. Нийтийн эрх зүйн хэм хэмжээн дээр үндэслэн байгуулагдсан, шинжлэх ухаан, соёл гэгээрлийн, шашны болон төр засаг, нийгэмд тустай чиг үүрэг бүхий бусад байгууллага. албан газар нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна. Эдгээрийн тоонд академи, их сургууль, дунд сургууль, музей, эмнэлэг, халамжийн газар, худалдааны танхим, номын сан, шашны байгууллага зэрэг багтана.<sup>173</sup>

Тэгвэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 28 зүйлд заасан гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээх хуулийн этгээд гэсэн ойлголтод Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасан ашгийн төлөө зорилготой компани, нөхөрлөл, хоршоо, ашгийн төлөө бус хууль буюу дүрэмд заасан зорилготой хуулийн этгээдээс гадна Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээд хамрах уу гэдгийг тодруулах нь зүйтэй.

Судлаачдын ихэнх нь иргэний буюу хувийн хуулийн этгээд эрүүгийн хариуцлагын гол субъект болохтой санал нийлдэг боловч төр болон нийтийн хуулийн этгээд энд хамаарах эсэхэд эргэлзээтэй байдаг. Өөрөөр хэлбэл, иргэний хуулийн этгээд буюу Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д<sup>174</sup> тодорхойлсон субъект нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн субъект болох талаар харьцангуй маргаангүй бол Засгийн газар буюу төрийн байгууллага хуулийн этгээдэд хамаарах уу гэсэн асуудал үлдэж байна. Зарим улсад нийтийн хуулийн этгээд буюу ассоциац, холбоо, сан, нам, болон нэгдэл зэрэг нь хуулийн этгээдийн хариуцлагаас мултран үлдэх ёсгүй, учир нь тэд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ тэрхүү байгууллагын үүрэг, зорилго, бодлого, үйл ажиллагааны дагуу үйлдлээ хийсэн байдаг гэж үздэг.<sup>175</sup>

Тухайлбал, АНУ-д 1922 онд “холбоо”-д эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр шийдэж байжээ. Улсын дээд шүүхээс Юнайтэд Майн Вокэрс болон Коронадо Көүл компанийн хэргийг шийдэхдээ Худалдааны холбоо Эрүүгийн хуулийг зөрчсөн гэж үзээд эрүүгийн хариуцлага оногдуулсан байдаг. Харин Францад Эрүүгийн хуулийн 121-2 дахь хэсэгт “...төрөөс бусад хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээнэ...” гэж хуульчилжээ. Түүнчлэн ихэнх нийтийн хуулийн этгээд ч эрүүгийн хариуцлагын субъект болдог байна.<sup>176</sup>

Нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс оронд тухайлбал, Англид төр, Засгийн газар, яамд нь гэмт хэргийн субъект болдоггүй бөгөөд АНУ-ын “Ял шийтгэлийн загвар хууль”-д Засгийн газрын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлдсэн төрийн байгууллагын гэмт хэргийн шинжтэй үйлдэлд эрүүгийн хариуцлага оногдуулахгүй гэж заасан байдаг.

Англи, Канад, Австрали, Шинэ Зеланд зэрэг нийтийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудад зөвхөн компани гэлтгүй нөхөрлөл, ашгийн төлөө бус байгууллага, сайн дурын нэгдэл, төр-хувийн хэвшил бүхий нөхөрлөл зэргийг эрүүгийн хариуцлага хүлээх хуулийн этгээдэд тооцдог байна. Канадын Эрүүгийн хуулийн 2004 оны нэмэлт өөрчлөлтөөр “байгууллага” гэдэгт төрийн байгууллага, корпорац, компани, нийгэмлэг, фирм, нөхөрлөл, нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг нэгдлүүдийг хамруулан ойлгоно гэж заажээ.

<sup>171</sup> Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.1 дэх хэсэг, 2018 он.

<sup>172</sup> Эдийн засгийн гэмт хэрэг, гарын авлага, Азийн хөгжлийн банк, Шүүхийн ерөнхий зөвлөл, УБ, 2017 он.

<sup>173</sup> Мөн тэнд.

<sup>174</sup> Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.

<sup>175</sup> Anca Iulia Pop, Criminal Liability of Corporations- Comparative Jurisprudence, [www.law.msu.edu](http://www.law.msu.edu)

<sup>176</sup> Мөн тэнд.

Англид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах тусгай хуулиар “байгууллага” гэдэг нь засгийн газрын агентлаг, яам, газрууд, цагдаагийн хүчин, бусад төрийн байгууллага гэж тодорхой заасан байдаг.<sup>177</sup>

## 2. Төлөөлөл, төлөөлөх эрх бүхий этгээд

Хуулийн этгээд нь хийсвэр бөгөөд өөрөө бие-сэтгэхүйн хувьд гэмт хэрэг үйлдсэн байх боломжгүй нь маргаангүй хэдий ч түүнийг төлөөлөн үйлдэл хийж буй хувь хүн, тэдгээрийн нэгдэл нь тухайн хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, түүний ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн байдаг нь түүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог билээ. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн *mens rea* (гэм буруугийн элемент)-г нотлох боломжгүй тул түүнчлэн түүнийг “no ass to kick, no soul to dawn” буюу физиологийн биет бус учраас шийтгэх боломжгүй гэж үзэх хандлага байгааг тэмдэглэх нь зүйтэй.<sup>178</sup>

Иймд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл нь түүний төлөөллийн асуудалтай байнга холбогдон тайлбарлагдах төдийгүй түүний процессын асуудлыг төлөөллөөр дамжуулан явуулдаг. Тухайлбал, Дэлхийн Эрүүгийн загвар хуульд хуулийн этгээд дараах тохиолдолд гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээнэ гээд:

а.Хуулийн этгээдийн нэр дээр, нэрийн өмнөөс эсвэл түүний ашиг тусын төлөө гэмт хэрэг үйлдэгдсэн,

б.Хуулийн этгээд болох байгууллагын бүлэг хүмүүс түүнчлэн ганцаарчилсан хувь хүнээр үйлдэгдсэн байх бөгөөд тэрхүү этгээд нь тухайн хуулийн этгээдийн хувьд менежментийн болон хяналтын байр суурьтай байх.Үүнд:

1.Хуулийн этгээдийг төлөөлөх эрх мэдэл бүхий этгээд;

2.Хуулийн этгээдийн өмнөөс шийдвэр гаргах албан тушаалтан;

3.Хуулийн этгээдийн дотоодод хяналт тавих албан тушаалтан.

Хуулийн этгээд нь хувь хүнээр хяналт тавих үйл ажиллагаа алдагдсанаас үүссэн гэмт хэргийн хувьд эрүүгийн хариуцлага хүлээж болно. Ингэхдээ хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэрэг байна.<sup>179</sup>

Ер нь олон улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ 3 загвар онолыг баримталдаг. Эдгээр нь а.төлөөлөн хүлээлгэх (*vicarious liability*), б.адилгалын хариуцлага (*identification theory*) болон в.байгууллагын хариуцлага (*organization theory*) болно.

Төлөөлөн хүлээлгэх хариуцлага нь тухайн компани ямар ч ажилтныхаа өмнөөс эрүүгийн хариуцлага хүлээдэг. Тухайлбал АНУ корпорацид эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ тухайн компанийн ямар ч ажилтан гэмт хэрэг үйлдсэн түүний өмнөөс эрүүгийн хариуцлага хүлээдэг байна. Тэгэхдээ тухайн ажилтан нь өөрийн ажлын цар хүрээний дотор, тухайн компанийн ашиг тусын төлөө, санаатайгаар гэмт хэрэг үйлдсэн байвал корпораци эрүүгийн хариуцлага хүлээнэ гэсэн үзэл баримтлалыг мөрдөж байна.<sup>180</sup>

Адилтгалын хариуцлага нь зөвхөн удирдах төвшний ажилтны хийсэн үйлдэлд компани хариуцлага хүлээдэг. Жишээ нь: Англи, Канад гэх зэрэг зарим улс зөвхөн гүйцэтгэх захирал болон ахлах менежер зэрэг удирдах төвшний ажилтны гэмт үйлдлийн төлөө корпораци эрүүгийн хариуцлага хүлээдгээрээ харьцангуй хязгаарлагдмал шинжтэй гэж үзэж болох юм. Байгууллагын хариуцлага гэдэг нь тухайн компанийн бодлого, эрх хэмжээ, үйл ажиллагаа, хандлага гэх мэт зүйлс дээр тулгуурлан тухайн компанид эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Дээрх хэсэгт өгүүлсэн онолын чиг хандлагуудад дүн шинжилгээ хийж үзвэл, Монгол Улс адилтгалын загварыг (Англи) хуульчилсан нь Эрүүгийн хуульд заасан “хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан өөрөө эсвэл зөвшөөрөл өгч бусдаар үйлдүүлсэн” гэсэн заалтаас харагдаж байна. Тэгвэл нэгдүгээрт, хуульд заасан хуулийн этгээдийн удирдлага буюу төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий этгээд гэж хэн байх вэ гэсэн асуулт урган гарч байна.

<sup>177</sup> Корпорацийн хүний амины гэмт хэргийн тухай хууль, 2007 он, 19 дүгээр зүйл.

<sup>178</sup> Хуулийн этгээд бие даан санаатай үйлдэл хийх боломжгүй заавал бодгаль хүний үйлдлээр дамжиж үйлдэл хийгдэх бөгөөд хуулийн этгээдийн хийсэн хийсэн гэмт үйлдлийн сэдэлтийг тогтоох гэх асуудал бараг байхгүй. Иймд асуудлыг шийдвэрлэхийн тулд хариуцсан дээд албан тушаалтны гэм бурууг хуулийн этгээдийнхтэй жиших ойлголт үүссэн.Зох.

<sup>179</sup> Дэлхийн Эрүүгийн загвар хууль.

<sup>180</sup> Төлөөлөн хүлээлгэх ба адилтгалын хариуцлага нь үүсмэл хариуцлагын төрөл болдог. Б.Одонгэрэл, “Монгол Улсад хуулийн этгээд болох компанид эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал”, Хуулийн этгээдийн эрх зүйн байдал, хариуцлага: Харьцуулсан эрх зүйн асуудал, ОУЭШБХ-ын эмхэтгэл, УБ, 2010 он.



Хуулийн этгээдийн удирдах байгууллагуудын бүрэн эрхийг хуулиар тодорхойлсон байдгаас гадна хуулиар зохицуулагдаагүй асуудлыг үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно. Тухайлбал: Төрийн бус байгууллагын тухай хуульд зааснаар удирдах дээд байгууллага нь гишүүдийн хурал байж болох боловч тухайн хуулийн этгээдийн дүрэмд заасан бол удирдах дээд байгууллага нь удирдах зөвлөл байж болно. Энэ тохиолдолд удирдах зөвлөлийн бүрэн эрхийг уг байгууллагын дүрэмд зааснаар тодорхойлно гэсэн үг.

Ашгийн төлөө хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт түүний эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зорилго, төрлүүдийг заасан байдаг. Түүнчлэн хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа явуулж, хэлцэл хийх эрхтэй. Өөрөөр хэлбэл ашгийн төлөө хуулийн этгээд бол эрх зүйн ерөнхий чадвартай байна.

Компанийн тухай хуульд гүйцэтгэх удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой зааж өгсөн бөгөөд компанийн дүрэмд гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх талаар тусгайлан заагаагүй тохиолдолд хувь хүн хэрэгжүүлнэ гэж хуульчилж өгсөн байна. Өөрөөр хэлбэл компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тулгарах асуудлыг зохистой шийдвэрлэх чадвартай хувь хүн, эсхүл баг компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлнэ.

Хэрвээ хувь хүн компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд компанийн гүйцэтгэх захирал байна. Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-д “Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна” гэж тодорхой хуульчилж өгсөн байна. Харин гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэхэд компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.9-д “Гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх тохиолдолд компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор багийн гишүүдийн ажиллах дотоод журмыг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр баталж мөрдөнө” гэж хуульчилж өгсөн байна.

Тэгэхлээр эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийг шүүхэд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд нь ТУЗ-ын дарга, ерөнхий захирал, гүйцэтгэх захирал байх ба итгэмжлэл олгох замаар өөр этгээдээр төлөөлүүлж болно.<sup>181</sup> Өөрөөр хэлбэл ТУЗ-ын дарга, ерөнхий захирал, гүйцэтгэх захирлын компанийг төлөөлөн хийсэн үйлдэл бол уг хувь хүний үйлдэл биш, тухайн компани буюу хуулийн этгээдийн үйлдэл гэж тооцогдож болох юм.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар бүлэгт заасан хуулийн этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нь түүнийг төлөөлөх эрх бүхий хувь хүн байхыг тодорхойлсон төдийгүй тухайн хуулийн этгээдийг хуулийн этгээдийн эсрэг шүүх хуралдаанд гэрчээр оролцож байгаа бол, хуулийн этгээдийг төлөөлөх хүн нь тухайн хэргийн яллагдагч бол төлөөлүүлж болохгүйг заасан байна. Хэдийгээр тийм боловч яллагдагчаас өөр тухайн хуулийн этгээдийг төлөөлөх хүн байхгүй тохиолдолд дээрх заалт хамаарахгүйг хуульчилжээ.

### **Дүгнэлт**

Харьцуулсан судлалын үүднээс авч үзвэл, эрүүгийн хариуцлага хүлээх хуулийн этгээд ойлголтыг нэгдүгээрт ямар нэгэн тодорхойлолт, хязгаарлалтгүйгээр авч үздэг, хоёрдугаарт эрүүгийн хариуцлага хүлээх хуулийн этгээдийн төрлийг жагсаасан, гуравдугаарт, иргэний хуулиар хуулийн этгээд гэж тодорхойлогдсон тодорхой статустай тэдгээр байгууллагад эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн 3 чиг хандлага байдаг. Нэгдүгээр чиг хандлагын тухайд, Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг тодорхойлсон боловч “ямар” байгууллага байхыг заагаагүй ерөнхийлөн зохицуулсан байдаг. Тухайлбал, Австралийн 1995 оны Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай хуульчлахдаа “хуулийн этгээд” нь хэн байхыг тусгайлан зохицуулаагүй байдаг. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээд гэж ямар төрлийн байгууллага байхыг онцгойлон тодорхойлохоос зайлсхийж, хуулийн 12.1 дэх хэсэгт “хуулийн этгээдэд хувь хүний нэгэн адилаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн байх ба “хуулийн этгээд” гэж “хэн” байхыг тодорхойлоогүй.

<sup>181</sup>[https://docs.google.com/file/d/1fwVz\\_US6sXKXk7c10kTyThjeQGf8sVF0/view?fbclid=IwAR1S1oetvNjZFwFITEqYuX9HNbMAI8BrC7O3RbBxOEBjIY5ocTfhHTLav3o](https://docs.google.com/file/d/1fwVz_US6sXKXk7c10kTyThjeQGf8sVF0/view?fbclid=IwAR1S1oetvNjZFwFITEqYuX9HNbMAI8BrC7O3RbBxOEBjIY5ocTfhHTLav3o) сүүлд зочилсон 2018.11.30

Монгол Улсын хувьд үүнтэй адилаар “хуулийн этгээд” гэж хэнийг хамруулж ойлгохыг Эрүүгийн хуулиар тодорхойлоогүйгээр “Хуулийн этгээдэд гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж, хохирол, хор уршгийн хэмжээг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж ерөнхийлөн заасан тул эрүүгийн хариуцлага хүлээх хуулийн этгээд гэдгийг иргэний хуулийн этгээд буюу Монгол Улсын Иргэний хуулийн 25.1 дүгээр зүйлд зааснаар ойлгож хэвших нь зүйтэй болов уу гэсэн саналыг дэвшүүлж байна.

Харин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан<sup>182</sup> төрийн байгууллага болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагын субъектэд тооцохгүй байж цаашид эдгээр хуулийн этгээдийг хамруулах шаардлагатай гэсэн судлаачдын саналыг авч үзэх нь зүйтэй.<sup>183</sup>

Хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийн асуудал дараах 2 асуудалд ач холбогдолтойг хуульчид анхаарч, нэг мөр ойлголтод хүрэх нь зүйтэй.

Нэгдүгээрт, Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлд зааснаар хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлд төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргасан байх<sup>184</sup> гэсэн заалт байгаа тул энд ямар эрх бүхий албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй байхыг тодорхойлох.

Хоёрдугаарт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1 дүгээр зүйлд зааснаар процессын ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлөх этгээдийг тодорхойлох. Иргэний процессын ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлөх этгээдийг 2 ангилж үзэх ба итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээд нь ТУЗ-ын дарга, ерөнхий захирал, гүйцэтгэх захирал байх ба итгэмжлэл олгох замаар өөр этгээдээр төлөөлүүлж болдог.<sup>185</sup> Дээрхээс үзвэл ТУЗ-ын дарга, ерөнхий захирал, гүйцэтгэх захирлын компанийг төлөөлөн хийсэн гэмт үйлдэл бол уг хувь хүний үйлдэл биш, тухайн компани буюу хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг гэж тооцогдож болохоор харагдаж байна.

## Ном зүй

### Монгол Улсын хууль тогтоомж:

- Эрүүгийн хууль, 2015
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2015
- Иргэний хууль, 2002
- Компанийн тухай хууль, 2011
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2018

### Ном сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл:

- О.Амархүү, “Эрх зүйн онолын арван таван сэдэв”, УБ, 2008
- Д.Баярсайхан, “Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага”, УБ, 2012
- Г.Баярхүү, Н.Цэдэнбалжир, “Бизнесийн эрх зүй”, УБ, 2014

### Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл:

- Гантөмөр Г. “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйгээр хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлага, боломж, хэрэгжүүлэх арга зам”, Хуулийн этгээдийн эрх зүйн байдал, хариуцлага: Харьцуулсан эрх зүйн асуудал сэдэвт ОУБХ-д хэлэлцүүлсэн илтгэл

<sup>182</sup> Улсын бүртгэл байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар төлөөлөгчийн газрыг бүртгэнэ: 1.нөхөрлөл, 2.компани, 3.холбоо (төрийн бус байгууллага), 4.сан, 5.хоршоо, 6.шашны байгууллага, 7.нийтийн эрх зүйн хуулийн этгээд, 8.төрийн байгууллага, албан газар, 9.улсын төсөвт үйлдвэрийн газар, 10.аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар.

<sup>183</sup> Доктор Ч.Нямсүрэн “Хуулийн этгээд нь эрүүгийн эрх зүйн агуулгаар төрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлж байгаа байгууллагуудаас бусад төрийн болон төрийн бус бүхий л байгууллагуудыг хамааруулан авч үзэх нь зүйтэй”<sup>183</sup> гэсэн байна.

<sup>184</sup> Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно.” гэсэн байна.

<sup>185</sup> [https://docs.google.com/file/d/1fwVz\\_US6sXKXk7c10kTyThjeQGf8sVF0/view?fbclid=IwAR1S1oetvNjZFwFITEqYUx9HNBMAI8BrC7O3RbbxOEBjIY5ocTfhHTLav3o](https://docs.google.com/file/d/1fwVz_US6sXKXk7c10kTyThjeQGf8sVF0/view?fbclid=IwAR1S1oetvNjZFwFITEqYUx9HNBMAI8BrC7O3RbbxOEBjIY5ocTfhHTLav3o) сүүлд зочилсон 2018.11.30

- Ч.Нямсүрэн, “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал”, Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал” ОУЭШБХ-ын эмхэтгэл, УБ, 2017
- Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал”, 2010 оны 9 сард “Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагын асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээни хуралд хэлэлцүүлсэн илтгэл.
- Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд ял оногдуулах олон улсын жишиг хандлага”, Шүүх эрх мэдэл сэтгүүлийн 2017 оны №3
- Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар Эрүүгийн хуулийн чиг хандлага”, Хууль дээдлэх ёс сэтгүүлийн 2018 оны 1 дугаарт (цуврал 66)
- Эдийн засгийн гэмт хэрэг, гарын авлага, Азийн хөгжлийн банк, Шүүхийн ерөнхий зөвлөл, УБ, 2017
- Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал” ОУЭШБХ-ын эмхэтгэл, УБ, 2017

#### **Гадаад улсын хууль тогтоомж:**

- АНУ-ын Ял шийтгэлийн удирдамж, 2008
- Австралийн Эрүүгийн хууль, 1995
- Францын Эрүүгийн хууль, 1994
- Anca Iulia Pop, Criminal Liability of Corporations- Comparative Jurisprudence, [www.law.msu.edu](http://www.law.msu.edu)

## **МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Б.Баярмаа  
Монгол Улсын Их Хурлын  
Хууль зүйн байнгын хорооны  
зөвлөл*

**Товч агуулга:** Монгол Улсын 2 дахь удаагийн Харилцан үнэлгээний тайлан, түүний үр дагавар, Үндэсний зөвлөлийн чиг үүрэг, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, эрх зүйн шинэчлэлийн талаар дурдсан.

**Түлхүүр үг:** Мөнгө угаах, терроризм, Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ), Дэлхийн санхүүгийн мэдээллийн албадын олон улсын нийгэмлэг (EGMONT), харилцан үнэлгээний тайлан, “Хар жагсаалт”, “Саарал жагсаалт”

#### **Монгол Улс гишүүн орон нь болсон Олон улсын байгууллагууд:**

Монгол Улс Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага ФАТФ-ын Ази, Номхон далайн бүсийн бүлэг (АНДББ)-ийн гишүүнээр 2004 оны 6 дугаар сард элссэн байдаг. ФАТФ нь анх 1989 онд “Их долоо” гэгдэх улс орнуудаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх, үүнд бусад улс орныг хамруулах, хүчийг нэгтгэх зорилгоор үүсгэн байгуулагдаж байжээ.

ФАТФ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын стандартыг багтаасан зөвлөмж болох бодлогын баримт бичгийг боловсруулан гаргадаг бөгөөд анхны зөвлөмжийг 1990 онд гаргаж, 1996, 2001, 2003, 2012 онд шинэчлэн гаргаж байжээ. Түүнчлэн, ФАТФ нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа эсэхэд тодорхой хугацааны давтамжтай хяналт, шалгалт хийж, тухайн улсын мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тогтолцоог үнэлэх Харилцан үнэлгээг хийдэг байна. Харилцан үнэлгээний үр дүнд хангалтгүй үнэлгээ авсан улсыг нийтэд зарлах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо сайжруулах арга хэмжээ авахгүй байгаа улсыг “саарал, хар жагсаалт”-д оруулан тэдгээрийн эсрэг хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бусад гишүүн улсад уриалдаг.

Монгол Улс ФАТФ-ын бүс нутгийг хариуцсан салбар байгууллага болох Ази, Номхон далайн бүсийн бүлэг /АНДББ/-ийн гишүүнээр 2004 онд элссэн бөгөөд 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /цаашид МУТСТ гэх/ тухай хууль баталснаар СМА-ыг байгуулж, МУТСТ, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эхлүүлж ФАТФ-ын 40 зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

Монгол Улс нь Дэлхийн санхүүгийн мэдээллийн албадын олон улсын нийгэмлэг /EGMONT/-т 2009 оны 5 дугаар сард гишүүнээр элссэн. Тус байгууллага нь нийт 155 гишүүн улс орны санхүүгийн мэдээллийн албадаас бүрддэг бөгөөд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартын дагуу санхүүгийн мэдээллийн албадууд хамтран ажиллаж, хоорондоо баталгаатай мэдээлэл солилцох боломжийг олгодог юм. Түүнчлэн, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын конвенцид 2008 оны 5 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсныг соёрхон баталсан юм.

Монгол Улс МУТСТ тогтолцоог улам боловсронгуй болгох зорилгоор ФАТФ, Ази, Номхон далайн бүсийн бүлгээс гадна ОУВС, АХБ гэм мэт олон улсын бусад байгууллагатай нягт холбоотой ажиллаж байна.

### ***Монгол Улсын 2 дах удаагийн Харилцан үнэлгээний тайлан:***

ФАТФ-ын АНДББ нь 2016 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн байдлаарх МУТСТ Монгол Улсын тогтолцоонд 2 дахь удаагийн Харилцан үнэлгээг хийж, 2017 оны 7 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Шри-Ланка Улсын Коломбо хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн 20 дахь удаагийн хурлаар Харилцан үнэлгээний тайланг баталгаажуулж, 2017 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр цахим хуудастаа албан ёсоор байршуулжээ.

Энэ харилцан үнэлгээ нь ФАТФ-аас 2012 онд шинэчлэн баталсан 40 зөвлөмжийн дагуу тус зөвлөмжийн техникийн хэрэгжилтийг төдийгүй МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг давхар үнэлснээрээ онцлогтой юм.

### ***Монгол Улсын МУТСТ тогтолцооны одоогийн нөхцөл байдал: Техник хэрэгжилт***

Техникийн хэрэгжилтийг үнэлэх нь ФАТФ-ын зөвлөмжид тусгасан тодорхой заалт тус бүр хууль, эрх зүй, байгууллагын тогтолцооны хүрээнд хэрхэн шийдэгдэж эрх бүхий байгууллагын эрх мэдэл, үйл ажиллагаатай хэрхэн холбогдож байгааг дүгнэдэг.

Монгол Улсын МУТСТ тогтолцооны 2 дахь удаагийн үнэлгээний Техникийн хэрэгжилтийн 40 зөвлөмжөөс 5 хангалтгүй, 15 зарим нь хангалттай, 15 дийлэнх хангалттай, 5 хангалттай гэсэн үзүүлэлттэй гарсан.

Техникийн хэрэгжилтийн зөвлөмжөөс 8 буюу түүнээс дээш хангалтгүй/зарим нь хангалттай, эсвэл чухал нөлөө бүхий зөвлөмжүүдээс аль нэгийг эсвэл бүгдийг нь хангалтгүй/зарим нь хангалттай гэсэн үнэлгээ авсан тохиолдолд "эрчимтэй хяналт"-д ордог байгаа юм. Иймд манай улс Техникийн хэрэгжилтийн үнэлгээний 50%-ийг хангасан гэж үзэн "эрчимтэй хяналт"-д орох болзлыг хангасан байна.

### ***Монгол Улсын МУТСТ тогтолцооны одоогийн нөхцөл байдал: Үр дүнтэй байдлын үнэлгээ***

Харин Харилцан үнэлгээний Үр дүнтэй байдлын үнэлгээний хувьд нийт 11 шалгуураас 2 шалгуурыг хэрэгжүүлэх түвшин дунд зэргийн, 9 шалгуурыг хэрэгжүүлэх түвшин бага гэсэн үр дүнтэй гарсан байна.

Үр дүнтэй байдлын үнэлгээнээс 7 эсвэл түүнээс их шалгуурыг муу эсвэл дунд зэргийн түвшинд хангаж байгаа тохиолдолд мөн "эрчимтэй хяналт"-д ордог, иймээс Монгол Улсын хувьд үр дүнтэй байдлын үнэлгээ муу байгаа нь тус хяналтад орох бас нэг шалтгаан болсон юм.

МУТСТ тухай хуулийн дагуу Санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нараас нотариатч болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын болон хуульч, нягтлан бодогч, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нарыг хамруулах, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалт байхгүй, хяналтыг нь зохих түвшинд зохион байгуулж хэрэгжүүлээгүй нь Монгол Улсын үнэлгээг доошлуулах томоохон үндэс болсон. Мөн НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг болон бусад хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн бус

байгууллагуудыг МУТСТ үйл ажиллагаанд хамруулах хууль, эрх зүйн зохицуулалт тодорхой бус байсан нь үнэлгээ ийнхүү муу гарах шалтгаан болсон байна.

***Үндэсний зөвлөлийн танилцуулга:***

Монгол Улсын МУТСТ тогтолцоог бэхжүүлэх, ФАТФ-ын 2016-2017 оны харилцан үнэлгээний үр дүнтэй байдлын үнэлгээг хангах үүднээс Ерөнхий сайдын 2017 оны 4-р сарын 20-ны өдрийн 70 дугаартай захирамжийн дагуу Үндэсний зөвлөлийг байгуулсан.

Үндэсний зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар ахлуулан, Сангийн дэд сайд, Гадаад харилцааны дэд сайд, Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Улсын ерөнхий прокурорын орлогч, Авлигатай тэмцэх газрын дэд дарга, Тагнуулын ерөнхий газрын тэргүүн дэд дарга, Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга, Гаалийн ерөнхий газрын дэд дарга, Татварын ерөнхий газрын дэд дарга, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан ба төрөөс Монгол Улсын МУТСТ Үндэсний зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх, харилцан үнэлгээний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах, эрх зүйн орчныг Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас тогтоосон олон улсын стандарт, зөвлөмжтэй нийцүүлэх ажлыг зохион байгуулж, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлд оруулсан байна.

***Үндэсний зөвлөлийн чиг үүрэг:***

Тус зөвлөл нь ФАТФ-аас Монгол Улсын МУТСТ тогтолцоог тодорхой давтамжтайгаар үнэлэх харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, Засгийн газраас баталсан МУТСТ 2018-2020 онуудад хэрэгжих дунд хугацааны үндэсний стратеги хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг удирдан зохион байгуулах, МУТСТ тогтолцооны хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох болон Монгол Улсын МУТСТ үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулж ялдуулах үүрэгтэй юм.

***“Саарал жагсаалт”-д орох үр дагавар:***

Монгол Улс 2013 онд Монгол Улс ФАТФ-ын “Саарал жагсаалт”-д орж байсан. Монгол Улсын Улсын Их Хурал, Засгийн газраас шуурхай арга хэмжээ авч МУТСТ тухай хууль, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан холбогдох журам, зааврыг богино хугацаанд батлуулсны үр дүнд 2014 оны 6 сард энэ жагсаалтаас гарч байв. Тухайн үед Монгол Улсын эдийн засаг өндөр өсөлттэй байсан, гадаад нэр хүнд сайн байсан зэрэг шалтгаанаас эдийн засагт учруулсан бодит хохирол бага байсан. Монгол Улсын ДНБ-ий хэмжээ 2013 онтой харьцуулахад үлэмж нэмэгдсэн, эдийн засгийн гадаад харилцаа ихээхэн тэлсэн тул энэ удаа “саарал жагсаалтад” орох нь хавьгүй ноцтой сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй байсан ба 2017 оны 7 дугаар сард хуралдсан АНДББ-ын жилийн чуулганы үеэр Монгол улсын Техникийн хэрэгжилт болон Үр дүнтэй байдлын үнэлгээг хэлэлцэж Монгол Улсыг “эрчимтэй хяналтад” оруулсныг дээр танилцуулсан. Монгол Улс МУТСТ хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулж хэрэгжилтийг нь 2018 оны 10 сараас өмнө хангах үүрэг хүлээгээд байсан.

Монгол Улс энэхүү үүргийг хангалтгүй биелүүлвэл “эрчимтэй хяналт”-аас ФАТФ-ын “саарал жагсаалтад” орох нь тодорхой байсан. “Саарал жагсаалтад” орох нь санхүүгийн системийн, улмаар нийт эдийн засгийн хэвийн үйл ажиллагааг уналтанд оруулах ноцтой аюулыг дагуулж байгаа юм. Тухайлбал, Монгол улсын зээлжих зэрэглэл буурах, гадаад зах зээлээс хөрөнгө босгох боломж хумигдах, ААН-үүдийн хөрөнгө татах зардал нэмэгдэх, банкуудын гадаад гүйлгээ зогсох, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ханш өсөх зэрэг үр дагаварыг дурдаж болно.

Монгол Улс “Ажиглалтын хугацаанд” хийж буй ажлаа АНДББ-д тогтмол тайлагнах үүрэгтэй байдаг.

***Харилцан үнэлгээний тайлантай холбоотойгоор манай улсад тулгарч буй асуудлууд:***

АНДББ-ийн Жилийн чуулганы үеэр Монгол Улсыг “эрчимтэй хяналтад” оруулсан нь Монгол Улсын эдийн засаг, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөх эрсдэл нэмэгдэж байгааг харуулсан ба Монгол Улс “эрчимтэй хяналтад” байх хугацаандаа “саарал жагсаалтад” орохоос зайлсхийх зорилгоор дараах асуудлуудыг шийдэх шаардлагатай байсан:

1.МУТСТ тогтолцоог ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлэх. Энэ чиглэлээр нэн тэргүүнд хийх ажил болох хууль эрх зүйн орчныг шинэчлэх;

2.Бодлогын түвшинд МУТСТ-тэй холбоотой хийгдэх ажлыг зангидах. МУТСТ-тэй тэмцэх үйл ажиллагааг бодлогын түвшинд зангидах, холбогдох төрийн байгууллагуудын удирдлагын түвшин дэх уялдаа, холбоог сайжруулах зорилгоор бид Үндэсний зөвлөл байгуулах;

3.Санхүүгийн хөрөнгийн орох-гарах урсгалыг хэвийн байлгаж бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор корреспондент банкуудтай харилцах харилцааг алдахгүй байх нь нэн чухал болж байна. Энэ асуудлыг шийдэх зорилгоор банкууд өөрийн комплаенсийн үйл ажиллагааг бэхжүүлэх, олон улсын санхүүгийн системийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх;

4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн тухай ойлголтыг олон нийтэд таниулах, энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлийг хэрхэн бууруулах талаар олон нийтэд мэдээлэх, холбогдох эрх бүхий байгууллагууд хамтын ажиллагаа, уялдаа холбоогоо сайжруулах, гадаадын ижил төрлийн байгууллагуудтай харилцаагаа эрчимжүүлэх.

***Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга:***

Дээрх шаардлага, нөхцлийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Дээрх хуулийг Улсын Их Хурал 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, баталсан ба 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Энэхүү хуулиар Харилцан үнэлгээний тайлангийн зөвлөмжид заасан Санхүүгийн мэдээллийн албаны эрх зүйн байдал, үйл ажиллагааны чадамжийг бэхжүүлэх, санхүүгийн үйлчилгээний хөгжил, техник технологийн өөрчлөлтөд нийцүүлэн “мэдээлэх үүрэгтэй этгээд”-ийн хүрээг өргөжүүлэх, тэдгээртэй холбоотой зохицуулалтыг нийцүүлэх, мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавих хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хэлбэрт оруулах нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн харилцаанд орж байгаа аливаа хөрөнгийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг үнэн зөв, бодитоор бүртгэх тогтолцоог бүртгэлийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх, хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог сайжруулах, Нэгдсэн үндэстний байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, терроризмыг санхүүжүүлэхээс гадна үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтыг тусгах, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл Засгийн газрын түвшинд ажиллах зэрэг асуудлыг хуульд шинээр болон холбогдох заалтуудыг өөрчлөн найруулж хуульчилсан. Тухайлбал,

Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хүрээг өргөжүүлэх, тэдгээртэй холбоотой зохицуулалтыг нийцүүлэх, тэдгээрт тавих хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хэлбэрт оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлэн хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөл үйлчилгээ үзүүлэгч, үнэт металл, үнэт эдлэл эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нарыг мэдээлэх үүрэгтэй байхаар тусгасан.

Мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавих хяналт шалгалтын тогтолцоог эрсдэлд суурилсан хэлбэрт оруулах нөхцөлийг бүрдүүлж, мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналтын хөтөлбөр болон харилцагчийг таньж мэдэх талаарх зохицуулалтыг боловсронгуй болгосон. Түүнчлэн, эдийн засгийн харилцаанд орж байгаа аливаа хөрөнгийн эцсийн өмчлөгчийн

мэдээллийг үнэн зөв, бодитоор бүртгэх тогтолцоог бүртгэлийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх зорилгоор эцсийн өмчлөгчийг шалган тогтоох дараалалын асуудлыг нарийвчлан тусгаж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан “эцсийн эзэмшигч” гэх зөрүүтэй нэр томъёог нийцүүлэн хуульчилсан.

Эцсийн өмчлөгчийг тогтоох, харилцагчийг таньж мэдэх ажиллагаа, уг ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэхэд тавигдах шаардлага, эрсдлийн үнэлгээ, дотоод хяналтын хөтөлбөр, хориг арга хэмжээний жагсаалт гэх зэрэг зохицуулалтыг хуульд тусгаж, үүнтэй холбоотой нарийвчилсан ажиллагааг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-аар зохицуулах асуудлыг тусгахдаа төсөв, санхүүгийн асуудал эрхлэсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн журмыг баталдаг байхаар өөрчилсөн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, терроризмыг санхүүжүүлэхээс гадна үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтыг тусгахдаа энэ төрлийн гэмт хэрэгт мөн адил хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хуульд холбогдох өөрчлөлтийг тусгасан.

Засгийн газрын түвшинд Үндэстний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар тусгасан. Хамтын ажиллагааны зөвлөл хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог хангаж ажиллахад анхаарах бол, Үндэстний зөвлөл үндэстний хэмжээнд нэгдсэн бодлогыг тодорхойлох, уг бодлогын хэрэгжилтийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

Хуулийн нэр томъёоны зарим тодорхойлолтыг ФАТФ-ын 40 зөвлөмжид заасан стандартад нийцүүлсэн. Тухайлбал, “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг ойлгохоор шинээр тусгасан.

Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх аливаа зохицуулалт нь “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх”-д нэг адил үйлчлэх талаар хуульчилсан. Ингэхдээ терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх асуудалд тагнуулын байгууллага, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудалд Санхүүгийн мэдээллийн алба хуульд заасны дагуу хяналт тавихаар тусгасан.

Мэдээллийн нууцлалыг хадгалах зохицуулалтыг Харилцан үнэлгээний тайлангийн зөвлөмжид нийцүүлэхээс гадна хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуультай уялдуулсан.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг Улсын Их Хурал 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр мөн баталсан.

***Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар:***

ФАТФ-ын “Саарал жагсаалт”-д орох эрсдэлээс урьдчилан сэргийлж чадсанаар санхүүгийн системийн гадаад харилцаанд шууд нөлөөлж түншийн харилцаа зогсонги байдалд орох, хөрөнгө татах боломж буурах буюу хязгаарлагдах, банкуудын гадаад гүйлгээ зогсох гэх мэт манай улсын эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалд шууд нөлөөлөх сөрөг үр дагавраас сэргийлж чадах ач холбогдолтой.

# ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## ЦАГДААГИЙН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАГВАР

*Б.Баянмөнх  
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн  
ЦЭЗТ-ийн дэд профессор,  
цагдаагийн хошууч*

**Товч агуулга:** Цагдаагийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагааны үр дүн нь олон хүчин зүйлээс хамаарах бөгөөд цагдаагийн хэсгийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтын оновчтой загварчлал тодорхой хэмжээгээр нөлөөлнө.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь эдийн засаг, соёл, ёс суртахуун, тухайн нийгмийн түүхэн тодорхой нөхцөл, хүмүүсийн аж амьдралын түвшин, хуулийн хэрэгжилт, улс төрийн удирдлагын чадвар зэрэг олон талын хамааралтай байдаг.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагааг засаг захиргааны анхан шатны нэгж дээр зохион байгуулж, түүнийхээ хэрэгжилтийг хангадаг ажилтан бол хэсгийн байцаагч билээ. Иймд цагдаагийн хэсэг ба хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтын оновчтой загварчлалын талаар энэхүү өгүүлэлд товч авч үзсэн болно.

**Түлхүүр үг:** Бүтэц, зохион байгуулалт, загвар

Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиг хандлагыг цагдаа судлаач Роберт Пийл тодорхойлохдоо чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц гэсэн үндсэн асуудлыг хөндөж тависан байдаг.

Мөн судлаач Дэвид Бейлий орчин үеийн цагдаа гэж нийтийн эрх ашигт нийцсэн, тусгай чиг үүрэг бүхий, мэргэжлийн байгууллага гэж томъёолсон.

Харин бодлого арга зүйн хувьд нийгмийн өмнө тулгамдсан тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, олон нийтийн туслалцаа дэмжлэгийг авах, хуулиар хүлээлгэсэн эрх, үүрэг бүрийг нэгбүрчлэн биелүүлэх, мэдээлэлд суурилсан үйл ажиллагаа явуулах зэрэг цагдаагийн үйл ажиллагааны стратеги хэлбэрүүд төлөвшин хөгжиж өнөөг хүрсэн.

Эдгээрийг нэгтгэж дүгнэвэл “reactive” буюу гомдол мэдээлэлд тулгуурласан үйл ажиллагаа, “Proactive” буюу өөрсдийн идэвхи санаачилгаар чиг үүргээ биелүүлэх үйл ажиллагаа гэсэн 2 хэсэгт хувааж болно.

Орчин үеийн цагдаа болж хөгжих зорилго тависан бол өөрсдийн идэвхи санаачилгаар нийгмийн сөрөг үзэгдэл дунд нэвтэрч тэдгээрийн мөн чанарыг цаг алдалгүй танин мэдэх “Proactive” үйл ажиллагаа бидэнд хэрэгтэй.

Хууль хамгаалах байгууллагуудын нэг чухал зорилт бол гэмт хэрэг нэг бүрийг илрүүлж, гэм буруутай этгээдэд зохих хариуцлагыг шударгаар оногдуулахын хамт гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгааныг илрүүлж, цаг тухайд нь арилгуулах замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бүх аргаар зохиоход оршино.<sup>186</sup>

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын ажил нь хууль зүйн уламжлал, шинэчлэл нэвт шингэсэн, практикт хэрэгжиж болохуйц, тодорхой зорилго, хүрэх үр дүнгээ урьдчилан тооцсон дэвшүүлсэн, хү гарахаар төлөвлөгдсөн байвал ажлын үр дүн шаардлагатай.

Бид өнөөдөр нийгмийн өөрчлөлтийг соргогоор мэдэрч, цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг нийгмийн хөгжлийн зүй тогтолтой уялдуулан байнга шинэчилж байх, түүнийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын оновчтой арга, тактикийг боловсронгуй болгох арга замыг бий болгоход анхаарлаа хандуулах шаардлага бий болж байна.

<sup>186</sup> Ж. Авхиа. Гэмт явдал, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал. УБ. 1997. 159 дэх тал



Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн тэргүүлэх чиглэл нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил байх бөгөөд энэ чиг үүргийг хэрэгжүүлэхэд цагдаагийн анхан шатны нэгж болсон хэсэг, тэр дундаа хэсгийн байцаагч онцгой чухал үүрэг гүйцэтгэнэ.

Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчил олноор гарч, түүнээс иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид учруулах хохирол нэмэгдсээр байгаа нь гэмт хэрэг, зөрчилтэй хийх тэмцлийг улам хүчтэй болгохын зэрэгцээ шинэлэг арга барилаар ажиллах шаардлага зүй ёсоор гарч байна.

Нийгмийн хэв журам хамгаалах, нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль ёс, эрх зүйн дэг журмыг бэхжүүлэх нь зөвхөн цагдаагийн төдийгүй, төр, олон нийтийн бусад байгууллага, албан тушаалтан, бүх хүнд хамааралтай нийгмийн өргөн хүрээтэй ажил юм.<sup>187</sup>

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын эцсийн зорилго нь ноцтой, аюултай үйлдэл болох гэмт хэрэг, зөрчлийг багасгах, улмаар түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг арилгах, ард иргэдийн амгалан тайван байдал, ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх асуудал байдаг билээ.<sup>188</sup>

Энэ бүхнээс харахад цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын гол ачааг нуруундаа үүрч явдаг хүн бол яахын аргагүй хэсгийн байцаагч юм.

Хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэртээ цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг засаг захиргааны анхан шатны нэгж дээр бие даан зохион байгуулж байгаа гол хүч юм.

Гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчил хаана олноор гарч, согтуугаар үйлдэгдэж байна, тэнд согтуурах явдалтай хийх тэмцэл сул, зохиосон ажлын үр нөлөө хангалтгүй байгаагийн баримт юм.<sup>189</sup>


Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд явуулж буй бүхий л үйл ажиллагааг дотор нь үндсэн болон дэмжлэг үзүүлэх гэж 2 ангилан авч үзэж болно. Тухайлбал:

- **Үндсэн үйл ажиллагаа:**

Цагдаагийн байгууллагын хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах болон захиргааны хяналтын чиг үүрэгт орсон ажиллагаанууд хамаарч байна.

- **Дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа:**

Энэхүү үйл ажиллагаанд үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай бүх ажиллагаанууд хамаарна. Тухайлбал: ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, ур чадвар олгох мэргэшүүлэх, давтан сургалт зохион байгуулах, хүний нөөцийн сонгон шалгаруулалт явуулах, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт боловсруулах, албаны үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчил илрүүлсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагуудтай харилцан, хамтран ажиллах гэрээ байгуулах, хурал зөвлөлгөөн зохион байгуулах гэх мэт үндсэн үйл ажиллагаанд хамаарахгүй ч дэмжлэг үзүүлж байгаа үйл ажиллагаанууд хамаарна.




<sup>187</sup> Ж. Долгорсүрэн. Монгол улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 261 дэх тал

<sup>188</sup> Д. Таванжин. Цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх ажил, түүний үр нөлөөг дээшлүүлэх зарим асуудал. УБ. 2002. 19 дэх тал

<sup>189</sup> Ж. Долгорсүрэн. Согтууралтай хийх ажилд иж бүрэн хандах асуудал. УБ. 1988. 67 дах тал

Хэсгийн байцаагч өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт гарсан тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоож арилгахын тулд тухайн нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тухайн нутаг дэвсгэрийн объект болон субъектын судалгаа, гэмт хэргийн өсөлт бууралт, гэмт хэрэг, зөрчил гарч буй цаг хугацаа зэргийг нарийн тогтоож, түүний эсрэг нарийн бодож төлөвлөсөн иж бүрэн арга хэмжээг боловсруулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй татан оролцуулснаар нэг талаар олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа сайжрах, нөгөө талаа энэ ажил цагдаа иргэдийг хооронд нь ойртуулах гүүр болох юм.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын бүтцийн бүдүүвч зургийг дараахь байдлаар тодорхойлж болохоор байна.



Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад хэсгийн байцаагч онцгой чухал үүрэгтэй байдаг. Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, ажлын удирдлага, зохион байгуулалтын оновчтой арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох, өнөөгийн ажлын арга барилд дүн шинжилгээ хийж, сайжруулах арга замыг судлан тодорхойлох шаардлага бий болсон байна.

Өнөөдөр хэсгийн байцаагчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах ажлын арга барил шинэчлэгдэхгүй, удирдлага, зохион байгуулалтын оновчгүй хэлбэрт баригдан ажлын үр нөлөө төдийлөн дээшлэхгүй байна.

Түүнчлэн хэсгийн байцаагч бүр хариуцсан хороо, нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах чиглэлээр хийж буй ажил нь бодит байдал дээр удирдлага, зохион байгуулалт муутай, нэг хэвийн байдлаар явагддаг учраас өнөөгийн нийгэм тэднээс шинэлэг олон санаа сэдэж, олон зүйл хийж ажиллахыг

шаардаж буйг үндэслэн, практик үйл ажиллагааны ололт, дутагдалд дүн шинжилгээ хийж, тавьсан зорилтыг ханган биелүүлж, ирээдүй хэтийн зорилгодоо хүрэх зарим арга замыг судлан тодорхойлоход дэмжлэг үзүүлэх нь чухал байна.

Нөгөө талаараа Төрийн албаны тухай Монгол Улсын хуульд тодорхойлогдсон төрийн алба нь мэргэшсэн тогтвортой байх зарчим алдагдаж байгаа, түүнчлэн цагдаагийн байгууллагын бүтэц ойр ойрхон өөрчлөгдөж байгаагаас гадна удирдах ажилтнуудын томилгоо, халаа сэлгээ богино хугацаанд олон давтамжтай хийгдэж байгаа нь алба хаагчдын идэвхи санаачлагыг бууруулж, ямар нэг хүлээлт үүсэх нөхцөл байдлыг бий болгож байна.

Цагдаагийн байгууллагын тухайн үеийн удирдлага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлын бүтээмжийг дээшлүүлэх, цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, зохион байгууллалтын бүтэц, орон тоог бий болгох зайлшгүй шаардлагатай байгааг харгалзан ЦЕГ-ын даргын 2008 оны 12.30-ны өдрийн 652 дугаар тушаалаар хэсгийн байцаагч нарын орон тоог дунджаар 4000 иргэнд 1 хэсгийн байцаагч байхаар тооцож, Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээ ихсэж, хүн амын хот рүү чиглэсэн их нүүдэл, түүнчлэн аж ахуйн нэгж ихээр байгуулагдаж байгаатай холбогдуулан хүн ам, аж ахуйн нэгжийн нягтаршил ихтэй зарим хороодод 3, бусад хороодод 2, аймгийн төвүүдэд хүн ам, аж ахуйн төвлөрөл, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалтай харгалзан зохион байгуулалтыг хийсэн ч энэ нь бодит байдал дээрээ өнөөдөр хэрэгжиж чадаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолд заасан 15000 хүн тутамд эргүүлийн 2 чиглэлд 4 алба хаагч ажиллах жишиг нормативаар нийслэлийн 152 хороонд амьдарч байгаа 1.380.792 хүн амд ойролцоогоор эргүүлийн 200 чиглэлд 400 алба хаагч ажиллах шаардлагатай байгаа боловч нийслэлийн хэмжээнд хэв журмын эргүүлд 120 орчим алба хаагч ажиллаж байна.

Гэвч дээрх алба хаагчдыг дэд хэсгийн жижүүр, албадан саатуулах болон конторын цагдаагийн дутуу орон тоонд үүрэг гүйцэтгүүлж байгаа нь Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолд заасан 50000 хүн ам тутамд 1 цагдаагийн тасаг, 4000 хүн тутамд 1 хэсгийн байцаагч, 15000 хүн ам тутамд 1-ээс доошгүй автомашин, 2-оос доошгүй хэв журмын эргүүл, хороо бүрт эргүүлийн цагдаа ажиллуулахаар заасан шаардлагатай хүн хүч, техник хэрэгсэлгүй байгаагаас шалтгаалжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор баталсан жишиг нормативын дагуу Улаанбаатар хотод 271, орон нутаг 121, улсын хэмжээнд нийт 392 хэсгийн байцаагч ажиллаж байсан бол өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод 154, орон нутагт 122, нийт 276 болж, 116 хэсгийн байцаагчийн орон тоо хасагдаж, 138 хороо хариуцсан цагдаагийн орон тоо нэмэгдсэн байна.

Зөвхөн Баянзүрх дүүргийн цагдаагийн I хэлтсийн хэсгийн байцаагч нарын хариуцсан нутаг дэвсгэр, өрх, хүн ам болон бусад явуулсан үйл ажиллагааг авч үзвэл:

№	Хороо	Хэсэг	Өрх	Хүн ам	Аж ахуйн нэгж, байгууллага	Захирааны хяналтанд байгаа мал	Гэмт хэрэг үйлдэж болзошгүй иргэд	Эмзэг цэг	Улсын онц чухал объект	2017 онд гарсан гэмт хэрэг	Цагдаагийн хэлтэст ирж буй дуудлага, мэдээллийн хувь	Өргөдөл гомдол	Үйлдэгдэж буй зөрчлийн хувь	Гудамж	Орон сууц
1.															
2.	1	2,4,6,8	1525	4115	60	-	-	-	3	115	60%	75%	75%	-	34
3.		1,3,5,7	1243	4251		2	12	5		92	40%	25%	25%	-	24
4.		<b>8</b>	<b>2768</b>	<b>8366</b>	<b>60</b>	<b>2</b>	<b>12</b>	<b>5</b>	<b>3</b>	<b>207</b>	<b>3724</b>	<b>1615</b>	<b>100%</b>	<b>-</b>	<b>58</b>
5.	2	1а,1б, залуус хотхон	1407	4105	32	1	16	5	-	53%	50%	56%	46%	12	29

6.		12, 5, 2a	818	4001	49	2	20	3	-	25%	25%	22 %	36%	24	-
7.		26, 3, 4, 12	989	3363	12	2	13	7	1	22%	25%	22 %	22%	14	-
8.		<b>18</b>	<b>3214</b>	<b>1146 9</b>	<b>93</b>	<b>5</b>	<b>49</b>	<b>15</b>	<b>1</b>	<b>243</b>	<b>4931</b>	<b>209 3</b>	<b>100</b>	<b>50</b>	<b>29</b>
9.	3	4,5,7	795	4017	140		15	1	1	134	80%	70 %	80%		22
10.		1,2,3 ,6	196	2924	66		25	2		64	20%	30 %	20%		22
11.		<b>7</b>	<b>991</b>	<b>6941</b>	<b>206</b>		<b>40</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>198</b>	<b>3087</b>	<b>134 2</b>	<b>100 %</b>		<b>44</b>
12.	4	1,2,3 ,4	1202	4410	47	2	2	5	1	30%	21%	32 %	39%	19	7
13.		5,6,7 ,8	1028	4128	40	4	3	5	1	16%	14%	13%	11%	32	10
14.		9,10, 11,12	1134	4314	48	2	3	5	1	20%	27%	25 %	20%	25	9
15.		13,14 ,15,1 6	1037	4788	55	2	7	5	2	21%	24%	18%	17%	24	8
16.		<b>16</b>	<b>4401</b>	<b>1764 0</b>	<b>190</b>	<b>10</b>	<b>15</b>	<b>20</b>	<b>5</b>	<b>359</b>	<b>7185</b>	<b>290 7</b>	<b>100</b>	<b>81</b>	<b>34</b>
17.	5	1,2,3 ,4	1339	466 8	63	1	4	5		30%	21%	32 %	39%		36
18.		5,6,7 ,8	1412	4243	16	1	4	4		16%	14%	13%	11%	18	24
19.		9,10, 11,12	1041	446 4	9	2	6	5		20%	27%	25 %	20%	19	
20.		13,14 ,15,1 6	1212	4216	24	6	7	3		21%	24%	18%	17%	17	
21.		17,18 ,19,2 0	1226	408 8	58	1	6	4		13%	12%	12%	13%	27	4
22.		<b>20</b>	<b>623 0</b>	<b>2167 9</b>	<b>170</b>	<b>11</b>	<b>27</b>	<b>21</b>		<b>359</b>	<b>7185</b>	<b>290 7</b>	<b>100 %</b>	<b>81</b>	<b>64</b>
23.	6	1,2,3	634	400 4	54		4	1	1	30%	30%	30 %	30%		21
24.		4,5, 6	628	400 0	52		6	2		50%	50%	50 %	50%		7
25.		7,8,9	645	1598	56		11	1		20%	20%	20 %	20%		26
26.		<b>9</b>	<b>1907</b>	<b>960 2</b>	<b>162</b>		<b>21</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>262</b>	<b>4075</b>	<b>181 0</b>	<b>100</b>		<b>54</b>
27.	7	1,2,3 ,4	830	408 6	157		8	4		56%	60%	56 %	56%		14
28.		5,6,7 ,8	822	1883	48	1	2	6		44%	40%	44 %	44%		9
29.		<b>8</b>	<b>1652</b>	<b>596 9</b>	<b>205</b>	<b>1</b>	<b>10</b>	<b>10</b>		<b>266</b>	<b>4053</b>	<b>189 7</b>	<b>100</b>		<b>23</b>
30.	15	3,4, 5,7	902	4091	78	1		2		75	65%	75%	75%		12
31.		1,2,6 ,8	1040	3275	75			2	1	118	35%	25 %	25%		14
32.		<b>8</b>	<b>1942</b>	<b>7366</b>	<b>153</b>	<b>1</b>		<b>4</b>	<b>1</b>	<b>193</b>	<b>1778</b>	<b>913</b>	<b>100</b>		<b>26</b>
33.	18	1,2,3 ,7	987	4025	26	1	3	4		55	31%	31%	23%		9
34.		5,8, 9,10	1003	400 9	53		8	6		92	40%	40 %	55%		18
35.		4,5,1 1	978	3743	15		4	3		45	29%	29 %	22%		14
36.		<b>11</b>	<b>296 8</b>	<b>1177 7</b>	<b>94</b>	<b>1</b>	<b>15</b>	<b>13</b>		<b>192</b>	<b>2882</b>	<b>1312</b>	<b>100 %</b>		<b>41</b>
37.	21	1,2,3 ,4,5, 6,7	1062	4052	13	2	4	3		62	20	33	20	18	
38.		8,9,1 0,11,	1038	404 8	23	1	8	2	2	53	50	45	50	12	

		12,13 .14													
39		Дуга аргү й	1005	4195	20	3	1	2		69	30	22	30	14	
40		<b>14</b>	<b>3105</b>	<b>1229 5</b>	<b>56</b>	<b>6</b>	<b>13</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>184</b>	<b>3043</b>	<b>1167</b>	<b>100</b>	<b>44</b>	
41		1,2,3 .4,5, 6,18	1452	4239	46	8	8	2		29	30	29	30	26	
42	27	7,8,9 .10,11 .12	1207	4188	26	9	12	1		40	40	40	40	18	
43		13,14 .15,1 6 17	1101	4115	35	6	21	1		31	30	31	30	30	
44		<b>18</b>	<b>3760</b>	<b>1254 2</b>	<b>107</b>	<b>23</b>	<b>41</b>	<b>4</b>		<b>204</b>	<b>3506</b>	<b>144 5</b>	<b>100</b>	<b>74</b>	

Энэ нь хэсгийн байцаагчийн хариуцаж нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, урьдчилан сэргийлэх ажил явуулах байгууллага, аж ахуйн нэгжийн тоо ямар их байгааг харж болохоор байна. үүнийг өөрчлөн нэгдсэн нэг стандарт хэмжээ тогтоож, үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлох шаардлага бий болсон байна.

Хэсгийн байцаагчийн ажлын заавар батлагдан хэрэгжээд даруй 15 жил өнгөрсөн бөгөөд хууль, эрх зүйн орчин шинэчлэгдсэн, хэсгийн байцаагчийн ажлын чиг үүрэгт өөрчлөлт орсноор зарим заалт нь бодит байдалтай нийцэхгүй байгааг анхаарч шинэчлэн батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ыг боловсруулж, батлуулах шаардлагатай байна.

Түүнчлэн хэсгийн байцаагч нарт дээд шатны олон дарга нараас өгч буй үүрэг, даалгаварын давхардлыг арилгах, нэгдсэн нэг удирдлагаар хангаж өгөхгүй бол үйл ажиллагааны үр нөлөө буурах сөрөг нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал цагдаагийн газар, хэлтэс, тасаг, дэд хэсэг, нутаг дэвсгэрийн хэлтэс, тасаг, хэсгийн дарга гэх мэтчилэн маш олон шат дамжлагын дарга нь өөрсдийнхөө чиглэлээр олон үүрэг даалгавар өгдөг, тэр нь хоорондоо давхарддаг, маш олон судалгаа, ажил үүргийг нэхдэг байдал өнөөдөр байсаар байна.

Үүний зэрэгцээ хэсгийн байцаагчийн үндсэн ажил үүргээс гадуур маш олон ажилд татагдан оролцдог байдлыг өөрчлөх шаардлагатай байна. Тухайлбал гадаадын өндөр хэмжээний зочин төлөөлөгчдийн хамгаалалт мөн нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтанд байнга татагдан оролцдог нь үндсэн ажлын үр нөлөөг бууруулах нэг хүчин зүйл болж байна..

Хэсгийн байцаагчийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны үндсэн чиглэл нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил гэдэг боловч тэр чиглэлийн ажил харьцангуй бага хийж байна. Мөн хэсгийн байцаагчийн ажлын байрны нэгдсэн нэг тодорхойлолт нэг боловч нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, түүний удирдлага тухайн газар орны онцлогоос хамааруулан өөр өөрийнхөөрөө нэмэгдэл үүрэг даалгавар өгч ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.

Өнөөдөр цагдаагийн хэсгийн байцаагчийн ажил үүргийн хуваарийн дагуу явагдаж чаддаггүй, ажлын ажлын байрны орчин нөхцөл харилцан адилгүй байгаа, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь өнөөгийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна, ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт бодитой бус байгааг хэсгийн байцаагч нар хэлж байна.

Судалгааны ажлын хүрээнд хийсэн судалгааны дүнгээс харвал хэсгийн байцаагчийг нэг хороонд тогтвор суурьшилтай ажиллуулдаггүй, 1-3 жил тутамд өөрчлөн томилдогос тухайн алба хаагчид хариуцсан хорооныхоо эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг бүрэн мэдэрч чаддаггүй, хийвэл зохих бүртгэл судалгааг эхлэлийн төдий хийж, дараагийн алба хаагчид шилжүүлдэг нь тэдний ажлын үр дүнд муугаар нөлөөлдөг байдал өнөөдөр хүртэл байсаар байна.

Түүнчлэн хэсгийн байцаагч нь түүний ажлын зааварт заасан үндсэн үүргээ биелүүлэхийн зэрэгцээ зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулж байгаа нь тэднийг хариуцсан нутаг дэвсгэртээ ажиллах, ард иргэдтэй ойр дотно байж хамтран ажиллах нөхцөл боломжийг бууруулж байгаа, объектын судалгаа хийх боломж хомс болгож байгаа нь

бодитой бөгөөд ажлын ачаалал нь гагцхүү өргөдөл, гомдол, мэдээлэл болон зөрчлийн хэрэг шалгахад чиглэгдэж байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсгэж байна.

Өнөөдөр цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг дараах хэлбэр лүү шилжүүлэх шаардлага бий болсон байна гэж үзэж байна.

Энэ нь хороо хариуцсан мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарыг цагдаагийн хэсгийн байранд байршуулан ажиллуулах замаар хэсгийн байцаагч, цагдаа нартай хамтран ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Учир нь хороо хариуцсан мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нар нь төв дээрээ, харин хэсгийн байцаагч, цагдаа нар хороон дээрээ байгаа нь тэдний хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болж байна гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил бөгөөд үүнийг хороон дээрээ гардан хэрэгжүүлдэг хэсгийн байцаагч нь хэсгийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, харин түүний цалингийн шатлалыг ТТ-10 болгох замаар ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх боломж байгааг харж болно.

Иймээс дээрхи алба хаагчдыг нэг байранд байрлуулан ажиллах шаардлага хангасан хэсгийн байрны загвар гаргаж, тэднийг хороон дээр ажиллах, гарсан өргөдөл, гомдлыг газар дээр нь шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлсэнээр цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг биелэгдэх нэг нөхцөл бүрдэнэ гэж судлаачийн хувьд үзэж байна..

Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх үүднээс дараах саналуудыг гаргаж байна. Үүнд:

1. Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолын дагуу цагдаагийн газар, хэлтсийг бүтэц, орон тоогоор нь ажиллуулах асуудлыг яаралтай шийдвэрлэж, цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийг хамгаалж, бүтэц орон тоог нэмэгдүүлэх асуудлыг Засгийн газрын түвшинд авч шийдвэрлүүлэх;
2. Нэгдмэл хэсгийн загвар бүхий үйл ажиллагааны бүтцийн загварыг гаргах, хороо хариуцсан мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарыг хороон дээр нь ажиллуулах боломж нөхцлийг судалж, туршиж үзэх;
3. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 429 дүгээр тушаалаар "Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс, дэд хэсгийн байранд тавигдах ерөнхий шаардлага" CS11-0244:2014 стандартыг хэрэгжүүлж, илүү цаг, амралтын болон бүх нийтийн баярын өдөр ажилласан алба хаагчдад хуульд заасан нэмэгдэл цалинг заавал олгож хэвших, шаардагдах төсвийг баталж өгөх;

## ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧААС ГАЛТ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

*Ш.Чулуун*  
*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Албаны тусгай бэлтгэлийн*  
*тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа*

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн<sup>190</sup> бөгөөд энэхүү үүргээ гүйцэтгэхийн тулд шаардлагатай тохиолдолд тусгай албадлага хэрэглэдэг.

Энэ нь гэмт хэрэг үйлдэж байгаа болон сэжиглэгдэж буй этгээдийг баривчлах, нийгмийн хэв журам зөрчсөн этгээдэд захиргааны таслан зогсоох тусгай албадлага хэрэглэх үед галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх, ашиглах байдлаар илэрдэг.

Галт зэвсэгтэй албан үүргээ гүйцэтгэж буй алба хаагч хуульд заасан галт зэвсэг хэрэглэх үндэслэл журам бий болсон тохиолдолд холбогдох хууль, заавар, журмын дагуу галт зэвсэг ашиглаж, хэрэглэж болно. Энэ бол хуулиар олгогдсон эрх байдаг.

Галт зэвсэг хэрэглэх ажиллагаа нь цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх захиргааны таслан зогсоох тусгай албадлага бөгөөд захиргааны таслан зогсоох албадлага нь эрх зүйн зөрчил үйлдэгдсэнтэй холбоотойгоор түүнийг үргэлжлэн гаргахгүй болгох, учирч болзошгүй аюулыг зайлуулах зорилготой төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хуульд заасан үндэслэлээр хэрэглэж байгаа шууд албадах ажиллагаа<sup>191</sup> учир хүний эрх, эрх чөлөө хөндөгддөг онцгой арга хэмжээ юм.

Энэ нь хуулийн хүрээнд хийгдсэн тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг хөндсөн гэж үзэхгүй. Цагдаагийн алба хаагч нь галт зэвсэг хэрэглэх онцгой эрхийг хуулиар эдэлдэг байна.

Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг гүйцэтгэх үедээ өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой аюул бодитойгоор тулгарсан үед галт зэвсэг хэрэглэнэ.

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь дээрхи чиг үүргийг гүйцэтгэхдээ “Албаны зориулалтаар шинээр галт зэвсэг, тусгай хэрэгслийг худалдан авах, албан хэрэгцээнд оруулахаас өмнө хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан танилцуулж, зөвшөөрөл авна”,... бүртгэгдээгүй галт зэвсэг, тусгай хэрэгсэл, сумыг алба хаагчид тавьж олгох, хэрэглэхийг хориглоно<sup>192</sup>, мөн хуульд зааснаас гадуурх, Цагдаагийн ерөнхий газрын зөвшөөрөлгүй дуурайлган хийсэн галт зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэхийг хориглосон байдаг.

Галт зэвсгийг хууль тогтоомжид заасан журам, заавар болон үйлдвэрлэгчээс гаргасан ашиглах зааврын дагуу хэрэглэх бөгөөд үйлдвэрлэгчийн зааврыг хавсралт болгож хэрэглэнэ, цагдаагийн алба хаагч өөрт олгогдсон галт зэвсэг, бүх төрлийн тусгай хэрэгслийг ашиглахын өмнө үйлдвэрлэгчийн заавартай сайтар танилцаж, хэрэглэж сурсан байх шаардлагатай юм.

Галт зэвсэг хэрэглэсний улмаас хүний эрүүл мэнд хохирсон бол аюулгүй байдлаа хангаж ажилласны дараа түүнд эмнэлгийн тусламж яаралтай үзүүлэх үүрэгтэй.

Хууль сахиулах байгууллага, хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтныг зохих журмын дагуу шалгаруулж авах, тэдгээр нь өөрийн үүргийг амжилттай гүйцэтгэх ёс зүй, зан суртахуун, сэтгэл санаа, эрүүл мэнд, бие бялдрын зохих бэлтгэлтэй байх нь зүйтэй юм.

Галт зэвсгийг хууль зөрчиж хэрэглэх нь хүний эрхийн наад захын үндсэн зарчим болох хүний халдашгүй эрхийг хамгаалах заалтыг ноцтой зөрчсөн үйлдэл болдог.

Цагдаагийн алба хаагч нь доорх тохиолдолд хүч хэрэглэхдээ Монгол Улсын “Эрүүгийн хууль”-д<sup>193</sup> заасан холбогдох заалтыг баримталж ажиллана.

– Өөрийгөө хамгаалах

<sup>190</sup> 2017.02.09-ны өдөр шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 4-р зүйлийн 4.1 дэх хэсэг

<sup>191</sup> Ж.Долгорсүрэн. “Цагдаагийн эрх зүй”, УБ хот, 2004., 242 дахь тал

<sup>192</sup> 2017.02.09-ны өдөр шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 48-р зүйлийн 48.3 дахь хэсэг

<sup>193</sup> 2015.12.03-ны өдрийн шинэчлэн баталсан “Эрүүгийн хууль”-ийн 4-р бүлгийн 4.1, 4.2, 4.3-р зүйл

- Бусдыг хамгаалах
  - Тодорхой гэмт хэргийг таслан зогсоох
- Цагдаагийн алба хаагч “Цагдаагийн албаны тухай хууль”-д зааснаар дараах тохиолдолд галт зэвсэг хэрэглэх эрхтэй байна.<sup>194</sup> Үүнд:
1. Өөрийнх нь, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон, тээврийн хэрэгсэл унаж зугтаан бусдын амь нас, эд хөрөнгөд бодит аюул бий болгосон;
  2. Цагдаагийн байгууллагад зэвсэглэн, эсхүл бүлэглэн халдсан, эсхүл цагдаагийн алба хаагчийн галт зэвсгийг булаахаар довтолсон;
  3. Төрийн тусгай болон эрх бүхий байгууллагын хамгаалалтад байгаа хүн болон бүс, объектод зэвсэг хэрэглэж, эсхүл бүлэглэн довтолсон;
  4. Хулгайлагдсан, барьцаанд байгаа хүнийг суллах;
  5. Галт зэвсэг, эсхүл хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн хүн зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;
  6. Хуяглан хүргэж яваа сэжиг бүхий этгээд, яллагдагч, шүүгдэгч, яланг суллахаар зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;
  7. Саатуулах, хорих, цагдан хорих байранд эмх замбараагүй байдал үүсч хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах нөхцөл байдал бий болсон;
  8. Бусдын албаны болон орон байранд зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон хүний дайралтыг таслан зогсоох, эзлэн авсныг чөлөөлөх;
  9. Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед галт зэвсэг хэрэглэн довтолсон, хамгаалсан;
  10. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор уршиг учруулж болзошгүй болон учруулж байгаа амьтныг устгах;
  11. Зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хүнийг баривчлах;
  12. Хоригдож байгаа этгээд, хоригдол оргон зугтсан, эсхүл зэвсэглэсэн хоригдлыг баривчлах.

Цагдаагийн алба хаагч хуульд заасан үндэслэл бүхий нөхцөл байдал бий болсон үед галт зэвсгийг дараах журмын дагуу хэрэглэнэ гэжээ.<sup>195</sup> Үүнд:

- Галт зэвсэг хэрэглэх үндэслэлийн /1-12-т/ заасан тохиолдол бий болсон үед галт зэвсгээ бэлэн байдалд авах;
- Тухайн этгээдэд галт зэвсэг хэрэглэх тухай сануулах, тодорхой зай байрлал тогтоох, хууль бус үйлдлээ зогсоохыг шаардах, эсхүл идэвхтэй үйлдэл хийхийг хориглох;
- Галт зэвсэг хэрэглэх тухай сануулах, тодорхой зай байрлал тогтоох, хууль бус үйлдлээ зогсоохыг шаардах, эсхүл идэвхтэй үйлдэл хийхийг хориглохыг сануулсны дараа тухайн этгээд үйлдлээ үргэлжлүүлсэн тохиолдолд галт зэвсэг хэрэглэх;

Цаг хугацаа, нөхцөл байдлын хувьд хууль тогтоомжид заасан журмыг хэрэгжүүлэх боломжгүй, эсхүл өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд аюул тулгарсан тохиолдолд цагдаагийн алба хаагч тусгай хэрэгсэл, галт зэвсгийг шууд сонгон хэрэглэж болно.

Галт зэвсэг биедээ авч яваа цагдаагийн алба хаагчийн баривчилсан, эсхүл саатуулсан этгээд цагдаагийн алба хаагчийн галт зэвсгийг булаахаар довтолсон бол галт зэвсэг шууд хэрэглэж болно<sup>196</sup> гэж хуулинд тодорхой нарийвчлан тусгаж өгсөн байна.

Галт зэвсэг хэрэглэсний улмаас хүн гэмтсэн тохиолдолд эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх арга хэмжээ авч эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ.

Галт зэвсэг хэрэглэсний улмаас хүн нас барсан тохиолдолд прокурор, эрх бүхий албан тушаалтан ирэх хүртэл цогцос, хэргийн газрыг хамгаалалтад авна.

Цагдаагийн алба хаагч галт зэвсэг хэрэглэсэн үндэслэл, хүний биед учирсан гэмтэл, үзүүлсэн тусламж, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдсэн тухай шууд захирах даргадаа нэн даруй танилцуулж, бичгээр тайлбар үйлдэх бөгөөд шууд захирах дарга нь прокурорт мэдэгдэнэ. Харин хүний амь насанд аюултайгаар зэвсэглэн эсэргүүцсэн, довтолсон, бүлэглэн дайрснаас бусад тохиолдолд жирэмсэн эмэгтэй, насанд хүрээгүй болох нь тодорхой, эсхүл

<sup>194</sup> 2017.02.09-ны өдөр шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 57-р зүйлийн 57.1 дэх хэсэг

<sup>195</sup> Чулуун.Ш., “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”, УБ хот., 2015., 24 дэх тал

<sup>196</sup> 2017.02.09-ны өдөр шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 58-р зүйлийн 58.4 дэх заалт



бие махбодийн хөгжлийн бэрхшээлтэй нь илт мэдэгдэж байгаа этгээдэд тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхийг хориглоно.

Тухайн этгээд аюулгүй болсон тохиолдолд цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно.

Мөн Цагдаагийн албаны тухай хуулинд цагдаагийн алба хаагч хүний бичиг баримтыг шалгах, эд зүйл, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, баривчлах, түр саатуулах үед галт зэвсэг хэрэглэх үндэслэлийн /1-12-т/ заасан тохиолдол үүсэх үндэслэл бүхий сэжиг тогтоогдвол галт зэвсэг хэрэглэж болзошгүй тухай сануулж болно. Цагдаагийн алба хаагч хуульд заасан үндэслэлээр галт зэвсэг хэрэглэж болзошгүй тухай сануулсныг галт зэвсэг хэрэглэсэнд тооцохгүй<sup>197</sup> гэж тусгайлан заажээ.

Цагдаагийн алба хаагч хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй<sup>198</sup> гэсэн нь цагдаагийн байгууллага, алба хаагчийн албан үүргээ хэвийн гүйцэтгэх, ажлаа хийснээс аливаа нэг сөрөг үр дагаварт өртөхгүй байх, алба хаагчийн аюулгүй байдлыг хангаж өгөх гэх зэрэг нөхцлийг бүрдүүлж өгсөн чухал эрх зүйн баталгаа болж өгсөн юм.

Монгол улсын Үндсэн хуулинд “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх”<sup>199</sup> тухай тодорхой заажээ.

Энэхүү чиг үүргийг Цагдаагийн байгууллага нь хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудыг удирдлага болгон үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

Цагдаагийн байгууллага, алба хаагч галт зэвсэг хэрэглэхдээ Цагдаагийн албаны тухай хууль<sup>200</sup>, Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот хамтарсан тушаалыг<sup>201</sup> баримтлан түүнд нийцүүлэн үйл ажиллагаа явуулж байна.

Галт зэвсгийн тухай ойлголт тодорхойлолтыг хууль болон эрдэмтэн судлаачид дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал:

Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” бичигт: Галт зэвсэг гэж /галаар тэсрүүлэх зэвсэг; галт бөмбөг; галт буу/<sup>202</sup> гэжээ.

Харин судлаач З.Цэрэнбат “Цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх тактик” номондоо “Зэвсэг” гэдэгт юу ч орж болох юм. Жишээ нь: Галт болон хүйтэн зэвсэг. Харин “Цагдаагийн зэвсэг” гэж гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын тодорхой үүрэг гүйцэтгэх үед шаардагдах цагдаагийн байгууллагаас олгогдсон, цагдаагийн алба хаагч биедээ авч явах эрх бүхий, Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасан тохиолдлуудад хэрэглэж болох галт болон бусад зэвсэг юм<sup>203</sup> гэжээ.

Монгол Улсын “Галт зэвсгийн тухай хууль”-д: “Галт зэвсэг” гэж даринь шаталтаас үүссэн өндөр даралтын хүчээр сумны хошуу болон үрэл гол төмрөөс шидэгдэж амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах зориулалт бүхий буудлагын хэргэслийг<sup>204</sup> хэлнэ гэжээ.

Харин АНУ-д хүчийг Аминд хүрэх зэвсэг ба Аминд үл хүрэх зэвсэг гэж ангилдаг байна. Аминд хүрэх зэвсэгт галт зэвсэг, харин аминд үл хүрэх зэвсэг нь хүний бие, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учрах хохирол, гэмтлийг багасгах замаар бие хүн болон материал хэрэгслийг чадамжгүй болгох зорилгоор бүтээгдсэн зэвсгийн цогцолбор систем юм<sup>205</sup> гэж тодорхойлжээ.

Тус аминд үл хүрэх зэвсгийг хэрэглэснээр огт хүний амь насыг хохироох, биед гэмтэл учруулахгүй гэсэн баталгаа байхгүй юм. Зөв зохистой, холбогдох заавар журмын

<sup>197</sup> 2017.02.09-ны өдөр шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 58-р зүйлийн 58.7, 58.8 дахь заалт

<sup>198</sup> 2017.02.09-ны өдөр шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 48-р зүйлийн 48.4 дэх заалт

<sup>199</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалт

<sup>200</sup> 2017.02.09-ны өдөр шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 5-р бүлгийн 57, 58-р зүйл

<sup>201</sup> 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”

<sup>202</sup> Цэвэл.Я., Монгол хэлний товч тайлбар толь., УБ хот., 1966., 135 дахь тал

<sup>203</sup> Цэрэнбат.З., “Цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх тактик” 2006, УБ хот, 8 дахь тал

<sup>204</sup> 2015.08.07-ны өдөр шинэчлэн баталсан “Галт зэвсгийн тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэг

<sup>205</sup> Зэвсэгт хүчний жанжин штаб, АНУ-ын сургагч багш нарын хамтарсан “Аминд үл хүрэх зэвсэг” сургалт 2010 он

дагуу хэрэглэснээр амь насаа алдах, ноцтой бэртэл гэмтэл учрах эрсдлийг бууруулах нөхцлийг бүрдүүлж өгдөг байна.

Цагдаагийн байгууллагын албадлагын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд аминд үл хүрэх зэвсгийг үхэлд хүргэх зэвсэгтэй цуг ашиглаж болох бөгөөд уг зэвсгийг цагдаагийн алба хаагч эсрэг талын үйл ажиллагааг өөрөөр хэлбэл гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоохын тулд үхэлд хүргэх хүчийг хэрэглэх нь зохистой шийдвэр биш үед хэрэглэдэг байна.

Цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон өөрөөр хэлбэл гэмт үйлдлийг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол онцгой тохиолдолд галт зэвсгийг хэрэглэнэ.

Энэхүү нөхцөл байдлыг Б.Пүрэвийн “Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар”-т: Амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах аюул бодитой байхын дээр зодох, шалбалах төдий биш ноцтой хохирол /алах, тахир дутуу болгох, хордуулах, мансууруулах гэх мэт/ учруулахаар довтолсон байвал галт зэвсэг хэрэглэж болно<sup>206</sup> гэж заасан байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас батлан гаргасан **“Галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчим”** эрх зүйн баримт бичигт<sup>207</sup> “...албан хаагчид галт зэвсгийг зөвхөн өөрийгөө хамгаалах, эсвэл амь насаа алдах, эсвэл хүнд гэмтэл бэртэл авах эрсдэлд байгаа хүмүүсийг аврахаас бусад тохиолдолд хэрэглэж болохгүй”...хүмүүсийн амь насанд шууд аюул учруулж буй онц хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ийм гэмт хэрэгтнийг баривчлахад”, “ийм үр дүнд хүрэхэд өөр аюулгүй арга хэмжээ үр дүнгүй байгаа тохиолдолд галт зэвсэг хэрэглэнэ гэж заажээ.

Мөн “Аль ч тохиолдолд хүний амийг аврахад зайлшгүй шаардлагатай үед галт зэвсгийг ашиглаж болно” гэжээ. “Цагдаагийн алба хаагч бол хүний амийг авдаг биш, авардаг байх ёстой” гэсэн энэ үгийг цагдаагийн алба хаагчид тэр дундаа гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулдаг албан тушаалтан бүр ямагт санаж байх нь чухал юм.

Цагдаагийн байгууллага, алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхэд дараах нийтлэг шаардлагыг баримтална гэжээ.<sup>208</sup>

а/ Зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх.

б/ Нэн тэргүүнд хэрэглэхгүй байх.

в/Тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх.

Хуулиар эрх олгогдсон цагдаагийн алба хаагч хууль ёсны албан үүргээ биелүүлэхдээ хүчийг тохируулан хэрэглэх ур чадвар, нарийн мэдрэмжтэй байхын тулд дараах зүйлийг зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай юм.Үүнд:

- Зөрчилдөөнийг уян хатан шийдвэрлэх арга
- Ятгах, ойлгуулан ухамсарлуулах
- Өөрийгөө хамгаалах
- Хамгаалалтын хэрэгсэл ашиглах
- Хүний амь насанд аюулгүй хэрэгсэл ашиглах
- Галт зэвсэг хэрэглэх
- Нийтийн эмх замбараагүй байдлыг зөв үнэлэх, олон нийтийн хандлагыг ойлгох
- Өөрийн сэтгэл зүйд гарч байгаа өөрчлөлт, хувийн зан чанараа зохицуулан удирдах чадвараа дээшлүүлэх
- Анхны тусламж үзүүлэх зэрэг зүйлүүдийг сурсан байх зайлшгүй шаардлагатай юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн өөрийн болон бусдын амь нас аюултай байдалд орсон нөхцөлд галт зэвсэг хэрэглэх шаардлагатай боловч аль болох түүнээс зайлсхийж, бусад амь насанд аюулгүй арга замыг эрэлхийлэх нь чухал юм.

<sup>206</sup> Пүрэв.Б., Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар, УБ, 1997, 102 дахь тал

<sup>207</sup> НҮБ-аас 1990 онд баталсан “Галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчим”-ын 9-р зүйл

<sup>208</sup>2017.02.09-ны өдөр шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 48-р зүйлийн 48.1 дэх заалт

Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлэхгүй байх эсвэл эсэргүүцэх тохиолдолд зөв үнэлэлт дүгнэлт өгч, тухайн нөхцөлд үндэслэлтэй зайлшгүй тохирох хэмжээний хүчийг хэрэглэх ёстой.

Тодорхой нөхцөл байдалд хүч хэрэглэх эрх мэдлийг цагдаад олгодог боловч түүнтэй хамт энэхүү эрх, үүргээ хуулийн хүрээнд, үр дүнтэй биелүүлэх өндөр хариуцлага мөн ноогддог.

Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үедээ биедээ галт зэвсэг авч явах эрхээ урвуулан ашиглах, ан гөрөө хийх, хувийн асуудлаас болж бусадтай маргалдан зөрчилдөх, сэтгэл хөдлөл, айж сандрах үедээ өөрийн хийсвэр төсөөллөөр албаны галт зэвсгийг ашиглаж хэрхэвч болохгүйг ямагт анхаарах хэрэгтэй юм.

Энэхүү хариуцлагаа ухамсарлан ойлгоход алба хаагчийн ёс зүйн асуудал чухал үүрэгтэй гэдгийг байнга санах хэрэгтэй билээ.

### **Дүгнэлт**

Цагдаагийн алба хаагч нарт албаны галт зэвсгийг биедээ авч явах, аюулгүй байдлыг хангах, хэрэглэх үндэслэл, журам болон холбогдох хууль эрх зүйн актын талаар эрх зүйн баримт бичиг шинэчлэгдсэн, өөрчлөгдсөн тохиолдол бүрт түргэн шуурхай албаны сургалтыг зохион байгуулж тэдний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх шаардлагатай байна.

Ялангуяа галт зэвсэг байнга биедээ авч явах эрх бүхий алба хаагч нарт холбогдох хууль тогтоомжинд заасан хугацаанд сургалтыг тогтмол үр дүнтэй явуулж албаны бэлэн байдлыг хангах шаардлагатай байна.

### **Санал**

- Цагдаагийн алба хаагч тэр дундаа албан үүргээ биелүүлэхдээ галт зэвсгийг биедээ авч явдаг, хэрэглэх эрхтэй алба хаагчдад энэ чиглэлийн дотоодын хууль тогтоомж шинэчлэгдсэн тохиолдолд тухай бүр түүнийг судлуулж, хэрэглэх үндэслэл журмын талаархи онолын мэдлэгийг олгох, түүнийг бататгах
- Манай улс НҮБ-ын гишүүн улс, орноор нэгдэн орсон тул Ерөнхий Ассамблейгээс батлан гаргасан Галт зэвсэг хэрэглэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулах ингэснээр олон улсын жишиг стандартыг баримтлах
- Цагдаагийн алба хаагчийн албаны бэлэн байдал, аюулгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд сургалт, дадлагыг төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь тухай бүр үр дүнтэй явуулж галт зэвсэгтэй харьцах ур чадвар, дадлыг алба хаагчдад бий болгох ингэснээр аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх
- Галт зэвсэг хэрэглэх нь хүний эрх, эрх чөлөөнд халддаг албадлагын онцгой арга хэмжээ тул олон улсын болон дотоодын хүний эрхийн байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах ингэснээр алба хаагчид галт зэвсгийг хуулийн хүрээнд зөв хэрэглэх, нөгөө талаас хүний эрхийг дээдлэх, хөхүүлэн дэмжих, хууль бус үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлэн чухал арга хэмжээ болох юм.

### **Ном зүй**

#### **Монгол Улсын хууль тогтоомж:**

- Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017
- Галт зэвсгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2015
- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 2015
- ХЗДХ-ийн сайд, УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 дугаар тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”

#### **Ном, сурах бичиг, гарын авлага:**

- Ж.Долгорсүрэн.“Цагдаагийн эрх зүй”., УБ., 2004
- Ш.Чулуун.“Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”., УБ., 2015
- Пүрэв.Б., “Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар”, УБ хот., 1997 он
- НҮБ-аас “Галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчим” 1990 он

- Цэвэл.Я., “Монгол хэлний товч тайлбар толь” УБ хот., 1966 он
- Цэрэнбат.З., “Цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх тактик” УБ хот., 2006 он
- Ганбадрал.Н., “Цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ хот., 2002 он
- Аминд халгүй зэвсэг-2010 сургалт /Зэвсэгт хүчний жанжин штаб, АНУ-ын тэнгисийн явган цэргийн сургагч багш нарын хамтарсан/

# ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ЗӨВШИЛЦӨХ ТУХАЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ БУСАД ХУУЛЬД ХЭРХЭН ХЭРЭГЛЭСЭН ТАЛААР

Б.Түвшинтөгс

*УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
Ажлын албаны зөвлөх*

**Товч агуулга:** Монгол Улсын Үндсэн хуульд хэрэглэсэн “зөвшилцөн, зөвшилцөж” гэсэн нэр томъёог хэрхэн ойлгож хэрэгжүүлж ирсэн талаар түүнчлэн бусад хууль (Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль)-д энэ нэр томъёог хэрхэн хэрэглэж зохицуулсан, энэ нь Үндсэн хууль дахь агуулгатай нийцэж байгаа эсэхийг тодорхойлоход илтгэлийг гол зорилго оршино.

**Түлхүүр үг:** Зөвших, зөвшилцөх, Монгол Улсын Их Хурлыг тараах асуудлаар зөвшилцөх, тодорхой албан тушаалд нэр дэвшүүлэх этгээдийг зөвшилцөх, заавал соёрхон батлах Монгол Улсын олон улсын гэрээг Улсын Их Хуралтай зөвшилцөх, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний талаар зөвшилцөх.

### Нэг.Зөвшилцөх гэдэг үгийн утга, түүний тайлбар

Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд “зөвших” гэж аливаа хэрэг явдлыг санал солилцон, шүүмжлэн хэлэлцэх гэж тайлбарласан бөгөөд зөвшилцөх гэдэг нь олноороо зөвших, зөвлөлдөх утгатай гэжээ<sup>209</sup>.

Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар номонд зөвшилцөх гэдэг нэр томъёо бол төр, засгийн дээд байгууллага, албан тушаалтнуудын хооронд болон олон улсын харилцаанд ямар нэг асуудлыг шийдвэрлэхийн тулд урьдчилан хэлэлцээр хийж харилцан санал нэгдэх аргыг илэрхийлдэг Үндсэн хуулийн эрх зүйн болон олон улсын нийтийн эрх зүйд хэвшин тогтсон ухагдахуун юм<sup>210</sup> гэжээ.

С.Нарангэрэлийн Эрх зүйн эх толь бичигт “Зөвшилцөх гэж санал хураалтад хэлэлцэгч талууд буюу гишүүд татгалзах санал гаргахгүйгээр шийдвэрт хүрэх үйл явц. Санал нэгтгэйгээр буюу эсрэг саналгүйгээр шийдэлд хүрнэ гэсэнтэй ойролцоо утгатай<sup>211</sup>” гэжээ.

Монгол Улсын Дээд шүүхээс 1996 оны 06 дугаар сарын 26-ны өдөр гаргасан 216 дугаар тогтоолд Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан “зөвшилцөх” гэдгийг хууль тогтоомжид өөрөөр тодорхойлоогүй бол Ерөнхийлөгч, Улсын Их Хурал буюу Ерөнхий сайд тодорхой бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль бүрэн эрхэд хамаарах асуудлаар өөрийн гаргах гэж байгаа шийдвэр, авах гэж байгаа арга хэмжээнийхээ талаар хуульд заасан байгууллага, албан тушаалтантай санал солилцохыг ойлгоно гэж тайлбарласан байна.

Эдгээр судлаачдын тайлбараас дүгнэн үзвэл аливаа асуудал, хэрэг явдлыг зөвшилцөх гэдэг нь хоёр буюу түүнээс дээш тооны этгээд тухайн асуудлын талаар санал солилцох, хэлэлцэх, зөвлөлдөх зэрэг хэлбэрээр тухайн зүйлийн талаар өөрийн байр суурийг илэрхийлэх, санал нэгдэх гэсэн утга агуулгатай гэж үзэхээр байна.

Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар дахь “санал солилцох” гэдэг нь тодорхой үйлдлийг илэрхийлсэн бие даасан нэр томъёо тул зөвшилцөх ухагдахуун биш зөвшилцөхийн тулд хийгддэг үе шат бүхий үйл ажиллагааны процесс. Зөвшилцөлд хүрэхийн тулд хэдэн ч удаагийн санал солилцох уулзалт, хэлэлцээр хийж болдог<sup>212</sup> гэсэнтэй судлаачийн хувьд санал нэгтэй байна. Зөвшилцөх гэдэг нь дан ганц санал солилцохоор хязгаарлагдахгүй, зөвшилцөх үйл явцын цаана талууд санал нэгдэх, нэгдсэн тохиролцоонд хүрэх агуулгатай болох нь өгүүллэгийн дараагийн хэсэгт илүү тодорхой харагдана.

<sup>209</sup> Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,1966. 278 дугаар тал

<sup>210</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2000, 169 дүгээр тал

<sup>211</sup> С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг, 219 дүгээр тал

<sup>212</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2000, 172 дугаар тал

## **Хоёр.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиуд дахь зохицуулалт**

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд “зөвшилцөж” гэж 3 удаа, “зөвшилцөн” гэж 8 удаа, “зөвшилцсөн” гэж 1 удаа тус тус хэрэглэсэн байна.<sup>213</sup> Эдгээрийг агуулгаар нь задлан үзвэл Улсын Их Хурлыг тараах<sup>214</sup>, тодорхой албан тушаалд томилохоор нэр дэвшүүлэх субъектийг тохирох<sup>215</sup>, Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах<sup>216</sup>, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтийн талаарх санал<sup>217</sup> зэрэг асуудлаар шийдвэр гаргахад төрийн зарим байгууллага, албан тушаалтан хоорондоо зөвшилцөхөөр заасан байна.

### **2.1. Монгол Улсын Их Хурлыг тараах асуудлаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх**

Монгол Улсын Үндсэн хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж Ерөнхийлөгч үзвэл энэ талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж заасан.

Улсын Дээд шүүхийн 1996 оны 216 дугаар тогтоолоор баталсан тайлбарт “Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж өөрөө тарах шийдвэр гаргахыг Улсын Их Хуралд санал болгох тухайгаа зөвшилцөх ...” гэдэг нь Ерөнхийлөгч энэ тухай саналаа Улсын Их Хурлын даргад бичгээр мэдэгдэж бичгээр хариу аван санал солилцох журмаар явагдана гэсэн байна. Дээд шүүхийн тайлбараас харахад тухайн асуудлаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын хооронд бичгээр санал солилцох хэлбэрээр зөвшилцөх үйл явц явагдах бөгөөд нэгдсэн саналд хүрсэн байх шаардлагатай эсэхийг тодорхойлоогүй, Ерөнхийлөгчийн бичгээр өгсөн мэдэгдэлд бичгээр хариуг өгсөн байх шаардлагыг тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл Улсын Дээд шүүх зөвшилцөх агуулгад бус хэлбэрийн талаас нь тайлбарласан гэж үзэхээр байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт Улсын Их Хурлын дарга уул саналыг зөвшөөрөөгүй нь Ерөнхийлөгч саналаа Улсын Их Хуралд оруулахад саад болохгүй гэжээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн энэ хэсгээс харахад Улсын Их Хурлын даргатай нэгдсэн саналд хүрээгүй байх нь Ерөнхийлөгчийг уул асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд саад болохооргүй байна. Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгчийн саналд Улсын Их Хурлын дарга дэмжихгүй байгаа тухайгаа бичгээр хариу өгөхөд энэ асуудлыг цааш өргөн мэдүүлж хэлэлцүүлэх Ерөнхийлөгчийн бүрэн эрх нээлттэй байна.

Гэвч Монгол Улсын Их Хурлын тухай хуульд дээрх асуудлаар “зөвшилцөнө” гэдэг нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга санал нэгдсэн байна гэж үзэж зохицуулжээ<sup>218</sup>. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2-т “Ерөнхийлөгч Монгол Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал нэгдэж Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж хугацаанаас нь өмнө тараах тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг ....” гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар бүтээлд<sup>219</sup> “...Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал нэгдэж Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж ...” гэснээс үзэхэд Улсын Их Хурлыг тараах асуудлаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргатай санал нэгдсэн байх агуулгатай байхаар үзжээ.

Дээрх зүйлүүдээс дүгнэн үзвэл Үндсэн хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгох” зохицуулалтыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд тус тус өөр агуулгаар хэрэглэн зохицуулсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль дахь зохицуулалтын агуулга нь “зөвшилцөх гэдгийг санал солилцох утгаар”, Монгол Улсын Их

<sup>213</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн үгсийн чуулган, УБ., 2011, 133 дугаар тал

<sup>214</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

<sup>215</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн зүйлийн 5 дахь хэсэг, 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

<sup>216</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 9 дэх хэсэг

<sup>217</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

<sup>218</sup> Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт

<sup>219</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2009 он, 123 дугаар тал

Хурлын тухай хууль дахь зохицуулалтын агуулга нь “зөвшилцөх гэдгийг санал нэгдэх” гэсэн агуулгаар зохицуулсан байна.

Улсын Их Хурлыг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж өөрөө тарах шийдвэр гаргахыг Улсын Их Хуралд санал болгох тухай асуудлыг зөвшилцөхөөр 2018 оны 10 дугаар сарын 29-нд Улсын Их Хурлын даргад албан бичгээ гардуулан өгсөн<sup>220</sup>. Улсын Их Хурлын дарга зөвшилцөх тухай албан бичигт энэ талаар Ерөнхийлөгчтэй санал нийлэхгүй байгаа тухай хариу өгсөн<sup>221</sup> бөгөөд энэ асуудал цааш хэрхэн үргэлжлэхийг харах л үлдэж байна.

## **2.2. Тодорхой албан тушаалд томилохоор нэр дэвшүүлэх субъектыг зөвшилцөх**

а/ Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн **хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах**” үндсэн бүрэн эрхийг Ерөнхийлөгчид олгосон. Энэхүү заалтыг 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчлөн найруулсан юм. Анхны заалт нь “Улсын Их Хуралд олонхи суудал авсан намтай, аль ч нам олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах” гэж байжээ.

Үндсэн хуулийн анхны заалт болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг /2001.06.21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулахаас өмнөх/-т заасныг Ерөнхийлөгч намуудтай Ерөнхий сайдаар нэр дэвшүүлэх субъектыг зөвшилцөн гэж ойлгож хэрэглэж ирснийг Улсын Дээд Шүүхийн 2016 дугаар тогтоолд тайлбарласнаас харж болно. Улсын Дээд Шүүхийн 216 дугаар тогтоолд Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2<sup>222</sup> дахь хэсгийн “... нам буюу намуудын сонгуулийн эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд оруулна” гэдгийг Ерөнхийлөгч Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх хүнийхээ тухай өөрийн саналыг тухайн нам буюу намуудад бичгээр оруулж нам бүрээс бичгээр саналыг нь авахыг ойлгоно гэж тайлбарласан байна.

2000 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар зөвшилцөх талуудыг Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл байхаар тогтоож, тэдгээрийн зөвшилцөлийн дүнд нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах бүрэн эрхийг Ерөнхийлөгчид олгосон байна.

1996-2000 онд олонх болсон улс төрийн намаас Ерөнхий сайдад нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийг 7 удаа буцааж байснаас “зөвшилцөх” гэсэн нэр томъёог хэрхэн ойлгож хэрэглэх талаар судлаач, улс төрчид өөрийн байр суурийг илэрхийлж байсан. Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлах талаар хөндөх болсон нь дээрх үйл явдлаас санаа авсан гэж үзсэн байдаг.<sup>223</sup>

<sup>220</sup> <http://parliament.mn/n/17ko>

<sup>221</sup> <http://parliament.mn/n/hpko>

<sup>222</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

2.Засгийн газар огцорсон, Улсын Их Хурал Ерөнхий сайдыг огцруулах буюу хүсэлтээр нь чөлөөлөх тухай шийдвэр гаргасан, Улсын Их Хурлын анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын дарга сонгогдсон, Ерөнхий сайд нас нөгчсөнөөс хойш 14 хоногийн дотор Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам буюу намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам” гэх/-тэй, аль ч нам олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд оруулна. Хэрэв Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөж нэгдсэн саналд хүрч чадаагүй бол санал нэгдсэн бөгөөд Улсын Их Хуралд авсан суудлын нийлбэр нь Улсын Их Хурлын нийт суудлын 50-иас дээш хувийг эзэлж байгаа намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд оруулна.

<sup>223</sup> Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ., 2016 оны, 101 дүгээр тал

**6/**Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүн, Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг тус тус томилоход Улсын Их Хуралтай зөвшилцдөг.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42, 43, 44 дүгээр зүйлүүдэд дээрх албан тушаалтныг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх дэгийг зохицуулжээ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дахь зохицуулалтын агуулгаас үзэхэд Ерөнхийлөгчийн нэр дэвшүүлсэн этгээд чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал авч чадаагүй тохиолдолд өөр хүнийг санал болгохоор заажээ<sup>224</sup>. Ерөнхийлөгчийн санал болгосон этгээд чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал авна гэдэг нь тухайн томилгооны талаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч санал нэгдсэн байна гэсэн агуулгыг илэрхийлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт “Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг томилох тухай саналаа Улсын Их Хуралд оруулна. Улсын Их Хурал уг саналыг татгалзсан бол өөр хүнийг санал болгоно.” гэж зааснаас мөн адил Улсын Их Хурал, Ерөнхийлөгч томилогдох субъектын талаар санал нэгдсэн байх агуулгыг илэрхийлжээ.

Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудлаар Улсын Их Хуралтай зөвшилцөхөд тухайн нэр дэвшигчийг нийт гишүүдийн олонхын дэмжлэг авсан байх шаардлагыг 1997 оноос хуулиар нэмсэн байна. Үүнээс өмнө нэр дэвшигчийг нийт гишүүдийн олонхын дэмжлэг авсан байхыг шаарддаггүй байжээ. Тухайлбал: 1992 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурал гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудлаар нууц санал хураалт явуулж дүнг Ерөнхийлөгчид өргөн барина гэжээ. Энэ үед зөвшилцөх процесст санал нэгдсэн байх шаардлага тавиагүй байх бөгөөд саналаа танилцуулах агуулгатай байсан нь дараах асуудлыг хэлэлцсэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэлээс илүү тодорхой харагддаг. 1994 оны хаврын чуулганы нэгдсэн хуралдааны 7 дугаар сарын 8-ны өдрийн тэмдэглэлээс<sup>225</sup>:

*Д.Лүндээжанцан: Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат Дагвын Цахилгааныг Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суух Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдаар томилох асуудлыг УИХ-тай зөвшилцөхөөр оруулсныг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж, дараах санал дүгнэлтийг УИХ-ын чуулганы хуралдаанд оруулж байна.*

*Монгол Улсаас БНХАУ-д суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдаар Дагвын Цахилгааныг томилох талаар Ерөнхийлөгчийн зөвшилцөхөөр ирүүлсэн саналыг тус байнгын хороо дэмжиж байна.*

.....

*Н.Багабанди: Дагвын Цахилгааныг Монгол Улсаас БНХАУ-д суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдаар томилох асуудлыг зөвшөөрч, Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцье гэсэн санал хураалт явууъя.*

*Зөвшөөрсөн 21*

*Татгалзсан 31*

*Бүгд 52 59,6 хувийн саналаар УИХ зөвшөөрөл өгөхгүй байна.*

*Р.Гончигдорж: Зөвшөөрөл өгөхгүй байна УИХ гэдэг таны томьёолол Улсын Их Хурлын протоколд орж болохгүй байх шүү.*

*Н.Багабанди: Зөвшөөрсөн хувь 40,4, Татгалзсан хувь нь 59,6*

Улсын Их Хурлаас зөвшөөрөөгүй боловч Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 114 дүгээр зарлигаар Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Дагвын Цахилгааныг томилсон байна.

Хэдийгээр Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонхын дэмжлэг аваагүй нэр дэвшигчийг тухайн нэр дэвшүүлсэн албан тушаалд томилсон практик байдаг ч, 1997 оноос хойш энэ төрлийн зөвшилцөлд нэр дэвшигч олонхын дэмжлэг авсан байх шаардлага нэг мөр хуульчлагдсан байна.

<sup>224</sup> Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.4, 43.3, 44.3 дахь хэсгүүд

<sup>225</sup> Монгол Улсын Их Хурлын 1994 оны хаврын V чуулганы 7 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны товч болон дэлгэрэнгүй тэмдэглэл, боть 63, 88 дугаар хуудас



### **2.3. Заавал соёрхон батлах Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах асуудлыг зөвшилцөх**

Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилдэг бөгөөд Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах асуудал нь Монгол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаардаг. Монгол Улсын Ерөнхийлөгч болон Засгийн газар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Монгол Улсын нэрийн өмнөөс улс хоорондын олон улсын гэрээ байгуулах эрхтэй.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан заавал соёрхон батлах олон улсын гэрээний төслийн талаар хэлэлцээ хийх, олон улсын гэрээнд гарын үсэг зурах шийдвэр гаргахын өмнө Улсын Их Хуралтай зөвшилцөнө. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28, 28<sup>1</sup> дугаар зүйлүүдэд олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг Улсын Их Хуралтай хэрхэн зөвшилцөх талаар зохицуулжээ. Гэрээ байгуулах санал, гэрээний төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн олонхын саналаар дараах санал, дүгнэлт гаргадаг. Үүнд:

1. Олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг бүхэлд нь зөвшөөрч, олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхийг Ерөнхийлөгч, Засгийн газарт олгох;

2. Олон улсын гэрээний төсөлтэй холбогдуулан зарчмын шинжтэй тодорхой засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах санал, дүгнэлт гаргах;

3. Олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг дэмжээгүй бол шалтгааныг тайлбарласан санал, дүгнэлтийг хүргүүлэх.

Тухайн олон улсын гэрээний агуулга, ач холбогдлыг харгалзан Байнгын хорооноос төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж болно<sup>226</sup>. Хэрэв Байнгын хорооноос олон улсын гэрээний төсөлтэй холбогдуулан зарчмын шинжтэй тодорхой засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах санал, дүгнэлт хүргүүлсэн бол Ерөнхийлөгч, Засгийн газар гэрээний нөгөө тал, эсхүл бусад талтай хэлэлцээ хийж, хэлэлцээний үр дүнг олон улсын гэрээний шинэчилсэн төслийн хамт зөвшилцөхөөр Улсын Их Хуралд дахин ирүүлнэ. Эндээс олон улсын гэрээ байгуулах асуудлыг зөвшилцөхөд талууд нэгдсэн саналд хүрсэн байх агуулгатай болох нь харагдаж байна.

2007 оны Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль үйлчилж эхлэхээс өмнөх дэгээр Байнгын хорооноос гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт гаргавал Засгийн газар гэрээний төслийн талаар нөгөө талтай эцэслэн тохиролцоходоо тэдгээрийг тусгах чиглэлээр ажиллаж дүнг Байнгын хороонд танилцуулж байхаар зохицуулдаг байжээ<sup>227</sup>. Өөрөөр хэлбэл УИХ-аас гаргасан саналыг гэрээний төсөлд тусгах талаар ажиллах боловч саналыг тусгасан гэрээний төслийг дахин зөвшилцөх талаар зохицуулаагүй байна.

Улсын Их Хурал олон улсын гэрээ байгуулах санал, төслийг зөвшөөрсний үндсэн дээр Ерөнхийлөгч, Засгийн газарт олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхийг олгодог тул “олон улсын гэрээ байгуулах асуудлаар Улсын Их Хуралтай зөвшилцөнө” гэдэг нь зөвшилцөх талууд гэрээний төсөлтэй санал нэгдэж, тохиролцсон агуулгатай болох нь харагдаж байна.

### **2.4. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний талаар зөвшилцөх**

Дараагийн зөвшилцөх тухай асуудал бол Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн түүнд оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд мэдүүлэх юм.

2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Ерөнхий сайдад Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний асуудлаар Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлэх эрхийг өгсөн. Үүний үр дүнд Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчийн

<sup>226</sup> Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсэг

<sup>227</sup> Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Эх сурвалж, харьцуулсан судалгаа 1990-2017/, УБ., 2018 он, 413 дугаар тал

оролцоогүйгээр өргөн мэдүүлэх бололцоотой болсноор Засгийн газрыг шуурхай бүрдүүлдэг болсон<sup>228</sup> гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дээрх томъёоллоос “зөвшилцөнө” гэдэг нь талууд санал нэгдсэнийг ойлгоно гэсэн логик дүгнэлтийг хийж болохоор байна. Учир нь “зөвшилцөлд хүрч чадаагүй бол ...” гэсэн гипотез нь “зөвшилцөл”-ийг санал солилцох идэвхгүй хэлбэр гэж үзээгүй болохыг илэрхийлж байна.

Хамгийн сүүлд 2016 онд Ерөнхий сайд У.Хүрэлсүх Засгийн газар шинээр эмхлэн байгуулж байгаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад “Санал хүргүүлэх тухай” албан бичиг илгээсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч зөвшилцөх тухай саналын хариуг албан бичгээр хүргүүлэхдээ Сангийн сайдад Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарыг томилох саналыг хүлээн авах боломжгүй байгаагаа дурдсан байдаг боловч Ерөнхий сайд Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилуулах тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шинэ Засгийн газрын гишүүдийг томилуулсан билээ.

### **Дүгнэлт**

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурлыг тараах<sup>229</sup>, тодорхой албан тушаалд томилохоор нэр дэвшүүлэх субъектийг тохирох<sup>230</sup>, Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах<sup>231</sup>, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтийн талаарх санал<sup>232</sup>-ыг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгч хоорондоо зөвшилцөхөөр тус тус заасан байдаг.

Улсын Их Хурлыг тараах тухай асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөнө гэдэг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын тухай хуульд зөрүүтэй байдлаар ойлгогдохоор хэрэглэсэн байна. Харин тодорхой албан тушаалд томилохоор нэр дэвшүүлэх субъектыг Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай, Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулахад Ерөнхийлөгч, Засгийн газар Улсын Их Хуралтай, Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний талаар Монгол Улсын Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй тус тус зөвшилцөх харилцааг зохицуулсан хуулиудад “зөвшилцөх” гэдгийг “санал нэгдэх, тохиролцоонд хүрэх” гэсэн утга агуулгаар хэрэглэсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуульд хэдийгээр заагаагүй боловч Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд “зөвшилцөх” тухай зохицуулалтыг өргөн хэрэглэсэн байна. Тухайлбал, Засаг даргыг өөр ажилд томилох, Хурлын төлөөлөгчийг ажлаас өөрчлөхөд Хурлын тэргүүлэгчидтэй урьдчилан зөвшилцөх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх, хуульд заасан тохиолдолд тухайн нутаг дэвсгэр дэх төрийн байгууллагын ажилтанг холбогдох дээд байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилох, чөлөөлөх зэргээр хэрэглэсэн байна. Энэ хуульд хэрэглэсэн зөвшилцөх тухай зохицуулалтууд нь практикт хэрхэн хэрэгждэг, ямар агуулгаар хэрэглэгдэж байгаа, Үндсэн хуульд хэрэглэсэн “зөвшилцөх” агуулгатай нийцэж байгаа эсэхийг цаашид судлах шаардлагатай юм.

### **Ном зүй**

#### **1. Монгол эх сурвалж**

- Г.Совд нар Монгол Улсын үндсэн хуулийн тайлбар, Улаанбаатар., 2000 он
- Монгол Улсын Үндсэн хуулийн үгсийн чуулган, Улаанбаатар., 2011он
- С.Нарангэрэл Эрх зүйн эх толь бичиг, Улаанбаатар., 2011 он
- Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, Улаанбаатар., 2016 он

<sup>228</sup> Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар, УБ., 20017 он, 87 дугаар тал

<sup>229</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

<sup>230</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн зүйлийн 5 дахь хэсэг, 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

<sup>231</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 9 дэх хэсэг

<sup>232</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

- Б.Чимид Үндсэн хуулийн үзэл баримтлал, Улаанбаатар.,2017 он
- Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Улаанбаатар., 2009 он
- У.Товуусүрэн Үндсэн хуулиа ойлгохуй, Улаанбаатар., 2017 он
- Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Эх сурвалж, харьцуулсаг судалгаа 1990-2017 он/, Улаанбаатар., 2018 он

## **2. Эрх зүйн эх сурвалж**

- Монгол Улсын Үндсэн хууль (1992)
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2006)
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2007)
- Олон улсын гэрээний тухай хууль (2016)
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль (1993)
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль (1993)

## ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

О.Хишигмөнх

Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн  
нийтийн эрх зүйн тэнхимийн багш, докторант

### Удиртгал

Монголын ард түмний түүх, соёлын өвийн нэг хэсэг нь шашин, шашны зан үйлтэй холбогддог. Өнөөг хүртэл дэлхийн аль ч улс шашнаас ангид байж сүм хийдийн үйл ажиллагааг хориглосон тохиолдол цөөн. Учир нь хуулиар зохицуулагдахгүй нийгмийн харилцааны орон зайн нэг хэсгийг шашны зөв үзэл номлол зохицуулах боломжтой байдагтай салшгүй холбоотой.

Монгол Улс нь ардчилалын замыг сонгож хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн нийгмийн суурь үндсийг тавих зорилгоор ардчилсан тодотголтой шинэ Үндсэн хуулиа 1992 онд батлан өнөөг хүртэл дагаж мөрдөж байна. Үндсэн хуулиараа шашин төрийн эрхлэх үйл ажиллагаа салангид тусдаа байх, төр, сүм хийдийн харилцааг тусдаа хуулиар зохицуулахаар заасны дагуу 1993 онд төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг батласан боловч шашны үйл ажиллагаа өргөн дэлгэрсэн өнөө үед үүргээ хангалттай гүйцэтгэж чадахгүй болсон учир шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудал 2003 оноос<sup>233</sup> хойш яригдаж одоог хүртэл нэг мөр болоогүй байна. Тиймээс цаг үеийн болон нийгмийн шаардлагаар энэ хууль өөрчлөгдөх хэрэгцээ байгаа боловч нийгмийн үндэс суурь болсон ард түмний соёл уламжлал хийгээд хуулийн үндэс болсон Үндсэн хуулийн үзэл баримтлалдаа нийцүүлэх, үндэсний аюулгүй байдал талаас харах асуудал чухал байна.

### Үндсэн ойлголт, эрх зүйн зохицуулалт

Шашин нь religion холбоо харилцаа гэсэн утгатай латин үгнээс гаралтай, англи хэлний religion буюу шашин шүтлэг гэсэн утгыг илэрхийлэдэг. Шашны үйл ажиллагааг аль ч улсад сүм, хийд эрхлэн гүйцэтгэдэг. Сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг шашны байгууллагыг<sup>234</sup> сүм хийд гэж нэрлэдэг. Хүн төрөлхтөн шашин нь сэтгэл, ёс сурахуун, оюун санааг эзэмддэг нийгэм, соёлын үзэгдэл төдийгүй хүний хэрэгцээ юм гэдгийг хүлээн зөвшөөрч улс бүр хуулиараа бататган бэхжүүлсэн. Дэлхийн улсууд нийтлэг байдлаар төр, шашины хоорондын харилцааг тогтоосон байдлаар нь авч үзвэл нэгдүгээрт шашин сүм хийд хоорондоо ялгаатай, заагтай байх ёстой хоёрдугаарт төр, шашин нь холбоотой байх ёстой, гуравдугаарт тэгш хандах ёстой гэсэн үзэл баримтлалаар ханддаг байна. Монгол Улс нь Үндсэн хуулиндаа Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ, Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй<sup>235</sup> гэж зааснаар төр, шашин ялгаа, заагтай байхаар тогтоосон. Монголын түүхэнд гүйцэтгэсэн шашны үүргийг болон өв уламжлал, соёлын онцлогоо харгалзан буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзэх<sup>236</sup>-ээр заасан нь хүн амын ихэнх буддын шашин шүтдэгтэй холбоотой.

Орчин үеийн хүний тархийг эрх чөлөөнд хүргэсэн эрин зуунд хүний оюун ухаан болон мэдлэгийг эрхэмлэн хөгжлийн төлөө урагшилж байгаа боловч хүний хөгжилд тулгамдсан асуудал байсаар л байна. Хүний эзэмших гурван чухал чадварт оюун ухааны, сэтгэл хөдлөлийн, хайрын чадвар<sup>237</sup> байдаг бөгөөд суралцах замаар боловсролоор дамжуулж оюун ухааны чадварыг эзэмшиж болох боловч сэтгэл хөдлөлийн чадвар, хайрын

<sup>233</sup> 2003 оны Улсын Их Хурлын №41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2.1.7 төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг боловсронгуй болгож, улмаар сүм хийд байгуулах зөвшөөрлийн тогтолцоог сайжруулж үндэслэл, журмыг боловсронгуй болгох, Мөн 2008 оны Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт “Төр, сүм хийдийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, хүн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэх эрх зүйн баталгааг Үндсэн хуульд нийцүүлэн төгөлдөржүүлэх арга хэмжээ авна” гэж тусгасан.

<sup>234</sup> Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль (1993) 6

<sup>235</sup> Монгол Улсын Үндсэн хууль (1992) 9.1, 9.2

<sup>236</sup> Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль (1993) 4.2

<sup>237</sup> <https://www.youtube.com/watch?v=EV-YNN6YV88&t=2s> Алибаба группын үүсгэн байгуулагч Жак Магийн илтгэлийн хэсгээс.

чадварыг боловсролтой болсноороо гагцхүү эзэмших боломжгүй<sup>238</sup> байдаг тул зөв хүн болгож төлөвшүүлэх, ёс суртахуунтай иргэнлэг нийгмийг бий болгоход шашин чухал үүрэгтэй. Тийм ч учраас шашны зан үйлээ мөрдлөг болгодог шашиндаа үнэнч байдал нь нийгэмийн аюулын шинжийг бууруулдаг эерэг үр дагавартай. Америкийн нэгдсэн улсын ерөнхийлөгч тангараг өргөхдөө, шүүхэд дуудагдсан гэрч мэдүүлэг өгөхдөө библийн судар дээр гараа тавьж тангараг өргөдөг, зарим шашны хүмүүс гэрлэхдээ сүмд гэрлэж бие биедээ үнэнч байхаа бурханы өмнө илэрхийлдэг нь хариуцлагатай, шудрага байдлыг бий болгодог. Шашин шүтлэг нь хүний дотоод итгэл үнэмшил бөгөөд шашны зөв номлол нь зөв, ёс суртахуунтай байх шинжийг хувь хүнд төлөвшүүлэх хүнлэг, энэрэнгүй ёсыг номлож сайн үйлийг дэлгэрүүлэх чухал үүрэгтэй бөгөөд энэхүү шинж нь аль ч шашны номлолд бий. Дэлхий дахинд будда, христ, ислам, хинди, католик, үнэн алдартан, баптист, лютеран, апостол, пресвитериан долл дахь өдрийн адвентист, методист гэх мэт олон шашнууд зэргэцэн оршиж байна. Дэлхийн хүн амын наян дөрвөн хувь ямар нэгэн шашин шүтдэг<sup>239</sup> байна. Сүүлийн үед олон улсад шашин хоорондын мөргөлдөөн гарах, иргэд хоорондоо сөргөлдөх байдал газар авч байгаа нь төрөөс шашны талаар баримтлах бодлогоо тодорхой болгох, зохицуулалт нэн чухал шаардлагатайг гэрчилнэ.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа зөвшөөрөлтэй 800 орчим, зөвшөөрөлгүй 200 орчим нийт 1000 орчим<sup>240</sup> сүм хийдүүд байна гэсэн бол Үндэсний статистикийн газраас гаргасан судалгаагаар 2017 онд нийт 344<sup>241</sup> сүм хийд, үүнээс христ 180, будда 136, ислам 21, бусад 7, лам санваартан 1529 байна гэсэн судалгаа байна. Зөвхөн Нийслэлийн хэмжээнд албан ёсны зөвшөөрөлтэй 296 шашны байгууллага<sup>242</sup> үйл ажиллагаа явуулдаг гэж мэдээлсэн бөгөөд шашны байгууллагын тоо хоорондоо хэт зөрүүтэй байгаа байдал нь бүртгэлгүй үйл ажиллагаа явуулдаг байдал бүртгэлийн журмын ялгаатай байдлаас хамаарч зөвшөөрлөө сунгуулж чаддаггүй, зөвшөөрөл авалгүй үйл ажиллагаа явуулдаг байдлуудаас хамаарч байна.

Харин Монгол Улсын нийт хүн амын 71 хувь шашин шүтлэгтэй<sup>243</sup> гэж 2017 онд хийсэн судалгааны тайланд дурьдсан бол Монгол Улсын хүн амын нэгдсэн тооллогыг 2010 онд явуулж анх удаа шашин шүтлэгийн талаарх мэдээллийг авахад 15 түүнээс дээш насны хүн амын 64.4 хувь нь ямар нэгэн шашин шүтдэг бөгөөд үүний 86.2 хувь нь будда, 4.9 хувь нь ислам, 3.5 хувь нь христ, 4.7 хувь нь бөө, үлдсэн 0.6 хувь нь бусад шашин шүтэж байна<sup>244</sup> гэсэн дүн гарсан. Шашин шүтлэгээс төрийн үйл ажиллагаа ангид байх давуу тал болон сул талыг үндэсний аюулгүй байдлаас тодорхойлох нь шашны талаар баримтлах төрийн бодлогыг нэг мөр болгоход чухал ач холбогдолтой. 1924 оны анхдугаар Үндсэн хуулиас эхэлж шашин төрийн үйл ажиллагааг тусдаа эрхлэхээр зохицуулж бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн бүрдсэн. Улмаар Монгол Улс нь ардчилсан нийгмийн хөгжлийн замыг сонгож хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч бэхжүүлэх зорилгоор эрх зүйн тогтолцоогоо үндсээр шинэчлэсэнтэй холбогдуулж иргэний шашин шүтэх, эс шүтэх олон улсын хэм хэмжээгээр баталгаажсан эрхийг эдлүүлэхийн тулд хүлээн зөвшөөрч холбогдох хууль тогтоомжоороо бататган бэхжүүлсэн. Төр, шашны хоорондын эрх зүйн харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж<sup>245</sup>оор зохицуулсан бол иргэний шашин шүтэх, эс шүтэх эрхийг дээрх хуулиудас гадна хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт гэсэн хэм хэмжээгээр зохицуулж баталгаажуулсан.

Төр, сүм хийдийн тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулиар зарлан тунхагласан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах баталгааг тогтоож, төр, сүм хийдийн хоорондын харилцааг зохицуулна<sup>246</sup> гэж заасан нь уг хуулийн зорилт нэгдүгээрт, иргэний

<sup>238</sup> <https://www.youtube.com/watch?v=M93Eucal2WE> Эрдэнэзуу хийдийн хамба лам Х.Баасансүрэнгийн лекцийн хэсэгт зүрхний эрдэм гэж тодорхойлж, мэдлэгээр хайрлах чадварыг бий болгодоггүй гэж өгүүлсэн.

<sup>239</sup> <https://www.lds.org/liahona/2017/06/religions-vital-global-role?lang=mon> Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүксийн шашны дэлхий дахинд үзүүлэх нөлөө илтгэлээс дэлгэрэнгүйг үзнэ үү.

<sup>240</sup> Төр сүм хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан байдлаар.

<sup>241</sup> [https://www.1212.mn/stat.aspx?LIST\\_ID=976\\_L20\\_3](https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L20_3)

<sup>242</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газрын олон нийт, хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэсийн мэдээлснээр.

<sup>243</sup> <http://www.mmccg.mn/posts/post/2727> Win/Gallup International олон улсын байгууллага Үндэсний судалгааны байгууллага болох MMCG судалгааны компанийн 2017 онд хийсэн судалгаанаас дэлгэрэнгүйг үзнэ үү.

<sup>244</sup> <http://www.nso.gov.mn/content/217#.W8L7-dczblU>

<sup>245</sup> Үндсэн хууль, Төр сүм хийдийн харилцааны тухай хуулиас гадна 11 хуулиар зохицуулсан байна.

<sup>246</sup> Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль (1993) 1

шашин шүтэх эрхийг баталгаажуулах, хоёрдугаарт, төр ба сүм хийдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах үүрэгтэй байна.

Өнгөрсөн хугацаанд иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрхийг ялангуяа төр зөрчсөн талаар ямар нэг асуудал шүүхийн шатанд цөөн шийдвэрлэгдсэн<sup>247</sup> нь хүний эрх талаасаа харьцангуй хүлээн зөвшөөрөгдсөн гэж үзэж болохоор байна. Харин төр, сүм хийдийн харилцааг уг хуулиар ерөнхийд нь зохицуулсан, Үндсэн хуулийн төр, сүм хийдийн эрхлэх үйл ажиллагаа тусдаа байх, төр нь сүм хийдийн харилцаанд ямар үүрэгтэй оролцох, шашны ямар төрлийн үйл ажиллагааг эрхлэхгүй байхыг тодорхой зохицуулаагүй дутагдалтай талууд байна. Хүний эрх талаасаа шашны үйл ажиллагаа иргэний сайн дурын хүсэл зориг, дотоод итгэл үнэмшлийн үндсэн дээр хүссэн шашны шүтэх эрхтэй бөгөөд Хүний эрхийн түгээмэл тунхаглалд "Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй"<sup>248</sup>. Энэхүү эрхэнд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө хамаардаг.

Төр, сүм хийдийн харилцааг тодорхойлох, зохицуулах асуудлыг төр, сүм хийдийн тухай хуулиар<sup>249</sup> төрөөс шашин, сүм хийдийн талаар баримтлах бодлогын үндсийг Монгол Улсын Их Хурал тодорхойлно, ард түмний эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцүүлэн төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааг Монгол Улсын Ерөнхийлөгч зохицуулахаар, төрөөс сүм хийдтэй харилцах харилцааг зохион байгуулж хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус эрхлэн гүйцэтгэхээр тусгасан тул бусад хуулиар уг асуудлыг хэрхэн зохицуулсныг авч үзье. Засгийн газрын тухай хуулиар төрөөс сүм хийдтэй харилцах асуудал нь хууль зүйн сайдын эрхлэх асуудалд<sup>250</sup>, Улсын Их Хурлын тухай хуульд төр, сүм хийдийн харилцаа нь төрийн байгуулалтын хороонд<sup>251</sup> хамаарахаар, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд ...сүм хийдтэй харилцах асуудал нь хурлын тэргүүлэгчдийн бүрэн эрхэд<sup>252</sup> хамаарахаар тус тус зааснаас өөр зохицуулалтгүй байгаа нь төр, сүм хийдийн хоорондын харилцааг зохицуулсан зохицуулалт хэт ерөнхий гэж үзэх үндэслэлтэй байна. Одоогийн байгаа эрх зүйн зохицуулалтаар Улсын Их Хурал нь төрөөс сүм хийдийн талаар баримтлах бодлогын үндсийг тодорхойлох эрхтэйгээс байгаагаас үзэхэд зохицуулалтыг нэг мөр зохицуулах, хэн юуг хийх талаар тодорхой бүрэн эрх болон заагийг тодорхойлох шаардлага байна. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч зургаан удаа<sup>253</sup> шашин болон сүм хийдтэй холбоотой асуудлаар зарлиг гаргасан бөгөөд үүнээс нэг нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хүчингүй болсон байна.

Цаашид дэлхийн хүн амын шашин шүтлэгийн хувь жил ирэх тусам нэмэгдэнэ тэр тусмаа мусулман болон христ, хинди шашинтны тоо өсөхөөр<sup>254</sup> байгаа тул шашны нөлөөлөл нэмэгдэхийг анхаарч баримтлах бодлогоо тодорхой болгох, эрх зүйн зохицуулалтыг нэг мөр болгох, хяналт тавих механизмыг сайжруулах нь дотоодын үймээн самуун гарахгүй байх улмаар хүмүүнлэг иргэний нийгмийн үндэс бүрэлдэн тогтноход чухал ач холбогдолтой. Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам

Монгол Улсын Үндсэн хуулиар олж авсан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрхийг хөндөхгүй байх үүднээс шашныг ялгаварлан гадуурхахгүй байхын зэрэгцээ хэн ч бай шашин шүтлэгээсээ болж гадуурхалт өртөхгүй байхаар хуульчилсан нь ололтой боловч эрх зүйн зохицуулалтын хувьд дутагдалтай байгаа асуудлууд байна. Тухайлбал,

<sup>247</sup> Үндсэн хуулийн цэцийн 1994.01.12ны өдрийн №2 дүгнэлтээр төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоосон.

<sup>248</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1946) 18

<sup>249</sup> Төр, сүм хийдийн тухай хууль (1993) 5

<sup>250</sup> Засгийн газрын тухай хууль (1993) 20.5.7

<sup>251</sup> Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2006) 20.5.7

<sup>252</sup> Монгол Улсын нутаг дэвсгэр засаг, захиргааны нэгж түүний удирдлагын тухай хууль (2006) 20.1.10

<sup>253</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дугаар 71 Зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах тухай зарлиг, 2007 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дугаар 129 Очирвани шүтээнийг бүтээн залах тухай зарлиг, 1999 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн дугаар 114 XXI зууныг угтаж хэрэгжүүлэх үндэсний ерөнхий хөтөлбөр санаачлах тухай зарлиг, 2001 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн дугаар 108 Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай зарлиг, Төрийн тахилгатай уул, овооны тэнгэрийг тайх тахилгын ёслолын журам. Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг 2009.№32, Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг "Монгол төрийн галийг бадрах тухай" 2011.12.26 №239

<sup>254</sup> <http://www.pewforum.org/2015/04/02/religious-projections-2010-2050/> дэлгэрэнгүйг үзнэ үү.

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллага болох сүм хийдүүдийн талаарх тоо баримт судалгаа бүрт харилцан адилгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт дутмаг, орон нутаг бүрт өөр өөр журмаар бүртгэлийн асуудлыг шийдэж байгаатай холбоотой. Хуулийн төсөлд дурьдснаар бүртгэлтэй, бүртгэлгүй 1000 орчим сүм, хийд байгаа бол 3 сая хүнд үзүүлэх нөлөөлөх, нийгмийн сөрөг үр дагаврыг тооцох цэгцлэх цаг нь болсныг нотолж байна.
- Шинжлэх ухаанлаг бус, мэдлэгийн үнэ цэнийг үнэгүйдүүлсэн эдийн засгийн хэрэгцээгээ хангах зорилгоор иргэдийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх замаар ашиг орлого олдог лам, бөө, үзмэрч нар ихэссэн нь иргэдийг эд мөнгө болон бие махбодийн хувьд хохироож байгаа нь хяналтгүй байдлыг илтгэнэ.
- Мөн төр тахилгат уул, овоо<sup>255</sup>, гал тахих<sup>256</sup>, даншиг наадам<sup>257</sup> хийх зэрэг ажлуудыг хийсээр байгаа нь төрийн байгууллага шашны үйл ажиллагаа явуулж болохгүй гэсэн нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаатай холбоотой. Энэ нь эргээд шүүмжлэлд өртөх, зарим талаараа дэмжих, эс дэмжих гэсэн харилцан адилгүй байр суурьтай явж ирсэн нь цаашид тодорхой болгож шаардлагатайг харуулж байна.
- Монгол Улсад шашны олон урсгал түрэн орж ирж, төрийн бус байгууллагын статустай үйл ажиллагаа явуулдаг гэж байгаа ч иргэний хуулинд сүм хийд нь иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаархи хуулийн заалтыг мөрдөнө<sup>258</sup> гэж заасан, мөн төрийн бус байгууллагын тухай хуулинд энэ хууль нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс бусад төрийн бус байгууллагад хамаарна гэж заасан зөрүүтэй зохицуулалт байсаар байна.
- Гадаадын хөрөнгө оруулалтай сүм хийдүүд санхүүгийн давуу байдал дээр тулгуурлаж иргэдэд үнэгүй эд материал тараах, гадаад хэл, хөгжмийн сургалт явуулах, эмнэлэгийн үзлэг, оношлогоо үнэ төлбөргүй хийх зэргээр хүүхэд, залуучуудыг татах замаар шүтэгчдийн тоогоо нэмэгдүүлж байгаа нь цаашид үндэсний аюулгүй байдал талаасаа хэр тохиромжтой эсэхийг харгалзан үзэх шаардлага байна.
- Мөн Монгол Улсад байгаа сүм хийдүүдийн тоог нарийвчлан гаргаж, эрхэлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих хэрэгтэй байна.
- Шашин шүтлэг нь тухайн иргэний хувьд өдөр бүр дагаж мөрддөг зан үйлийн шинжтэй хэвшсэн дотоод итгэл үнэмшил байх шаардлагатай боловч бодит байдал дээр шашин шүтдэг иргэдийн ихэнх нь дээрх шаардлагыг хангахгүй юм. Тухайлбал хэрэгтэй үедээ бурхандаа залбирдаг, өвдсөн эсхүл ажил бүтэхгүй үедээ ламд ханддаг, аргаа барьсан үедээ дэмжлэг хайх замаар тарни уншдаг байх нь жинхэнэ буддын шашинтан гэж үзэх боломжгүй бөгөөд өвөг дээдсээс уламжлагдан учраас хүндэтгэлтэй ханддаг энэ шашныг шүтдэг гэж бодож байгаа нь нийтлэг үзэгдэл болсон нь жинхэнэ шашны мөн чанар, номлолыг ойлгож таниагүй иргэд их байгаа нь буддын шашнаа зөв талаас таниулах, ойлгуулах ажил буддын шашны үйл ажиллагаа явуулдаг сүм хийдүүдэд дутмаг байгааг, зөвхөн утга учир нь ойлгогдохгүй ном унших, хандив авах төдийхэнээр хязгаарлагдаж байгаатай холбоотой.

### Дүгнэлт

Төр, сүм хийдийн тухай хуулийн 4. 8 дугаар зүйлд лам санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлыг төрөөс хянан зохицуулна гэж заасан боловч бодит байдал дээрээ хянаж чадахгүй байгаа нь цаашид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байгааг илтгэж байна.

Сүм хийдийн тоо хүн амын тоотой харьцуулахад их байх, ихэссэх нь үндэсний аюулгүй байдал талаасаа болгоомжлох, шашин хоорондын үзэл суртлын сөргөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх нь амар амаглан хүмүүнлэг

<sup>255</sup> Төрийн тахилгатай уул, овооны тэнгэрийг тайх тахилгын ёслолын журам. Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг 2009.№32

<sup>256</sup> Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг "Монгол төрийн галийг бадрах тухай" 2011.12.26 №239

<sup>257</sup> Нийслэлийн засаг, даргын тамгын газар, Монголын бурхан шашны төв гандантэгчилэн хийдтэй хамтран зохион байгуулдаг уламжлал тогтсон.

<sup>258</sup> Иргэний хууль (2002) 36.6



нийгмийн үндсээ бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой тул бүртгэл болон зөвшөөрөл олгодог тогтолцоогоо нэгдсэн зохицуулалтай болгох, ижил шалгуурыг баримтлах шаардлагатай байна. Мөн төрийн бус байгууллагын тухай хуулинд энэ хууль нь нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс бусад төрийн бус байгууллагад хамаарна гэж байхад сүм хийдүүд төрийн бус байгууллагаар бүртгүүлж байгааг анхаарах хэрэгтэй.

Төр нь шашны байгууллагын ямар үйл ажиллагаанд ямар үүрэгтэй оролцох, ямар үйл ажиллагаа эрхлэхийг хориглох тухай зохицуулалтыг нарийвчлан оруулах хэрэгтэй байна. 2018 оны хаврын чуулганаар хэлэлцэгдэх хуулийн төсөлд уг асуудлыг хэрхэн зохицуулах талаар тодорхойгүй орхигдуулсан нь цаашид хуулийн төсөл батлагдсан ч хуулийн зохицуулалтыг зорилго бүрэн биелэгдэхгүй байх, төр ямар оролцоотойгоо ойлгохгүй Үндсэн хууль зөрчихөд хүргэж болзошгүй юм. Төр сүм хийдийн харилцааны тухай хууль нь 13 зүйл 40 гаруйхан заалттай ба хуулийн төслөөр уг хуулийн 7 зүйлд 11 нэмэлт, 15 орчим өөрчлөлт оруулахаар байна. Хууль тогтоомжийн тухай хуулинд<sup>259</sup> зааснаас харахад нэмэлт, өөрчлөлт бус шинэчлэн найруулгыг хэмжээнд хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж байгааг анхаарч үзэх. Мөн бусад хуулийн зохицуулалтанд байгаа зарим заалтуудад төр, сүм хийдийн тухай хуулиар тодорхой болгох шаардлага байна. Тухайлбал, гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хуульд гадаадын иргэнд Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно, тус улсын үндэсний эв нэгдлийн эсрэг сурталчилгаа явуулах, үндэсний, зан заншилд хохирол учруулж болох хүмүүнлэг бус шашны урсгал, хүчирхийллийн аливаа хэлбэр, садар самуун, мансууруулах бодисыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хэрэглэх<sup>260</sup>, Харьяатын тухай хуульд Монгол Улсын харьяат болгохоос татгалзах үндэслэл нь Монгол үндэсний ёс заншил, хуульд харш шашны урсгалыг сурталчилсан бол<sup>261</sup> гэж заасан боловч үндэсний зан заншилд хохирол учруулж болох хүмүүнлэг бус, хуульд харш шашны урсгал гэж ямар шашны урсгалыг хэлэх вэ гэдэг асуудал тодорхойгүйгээс дээрх хуулийн заалтыг хэрэглэх боломж хязгаарлагдмал байна.

Нэгэнт ард түмний өв уламжлал, зан заншил, нийтлэг шүтлэгийг нь хүндэтгэх үүднээс буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзэхээр заасан бол тухайн шашны нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг тодорхой болгох, нийгмийн оюун санааг гэгээрүүлэх, шашны урсгалаа зөв талаас нь таниулах, зөв ухамсар, соёлтой иргэнийг төлөвшүүлэхэд оролцооны ямар үүрэгтэй болохыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Энэ нь хуулиар зохицуулах боломжгүй нийгмийн харилцааны орон зайг шашны хэм хэмжээгээр зохицуулах, өөртөө бий болгосон дотоод итгэл үнэмшлээрээ өөрийн амьдралын орон зайг бий болгох, улмаар хуулийг зөрчихгүй оюун санааны хувьд зөв төлөвшсөн иргэн болоход чухал үүрэгтэй.

### Ном зүй

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1946
- Монгол Улсын Үндсэн хууль 1992
- Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль 1993
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль 1993
- Харьяатын тухай хууль 1995
- Иргэний хууль 2002
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль 2006
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль 2010
- Хууль тогтоомжийн тухай хууль 2015
- 2003 оны Улсын Их Хурлын №41 дүгээр тогтоол
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 1997 № 71
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 1999 №108
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 1999 №114
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2007 № 129
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2011 №239

<sup>259</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.2.хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол шинэчлэн найруулга.

<sup>260</sup> Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (2010) 8.1.4

<sup>261</sup> Харьяатын тухай хууль (1995) 10.1.7



- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2009 №32
- Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт 1994 №2

